- Байгаль орчны тухай хууль <https://www.skklab.com2>
- Байгаль орчны стандарт <https://www.skklab.com3>
- Дотоод хэрэг харилцаа холбооны яам <https://www.soumu.go.jp/kouchoi/>
- <https://www.env.go.jp/policy/hakusyo/h07/9724.html>

ХҮНСНИЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БҮЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), О.Билгүүтэй,
Б.Батцэцэг, Р.Оргилмаа, Дөлгөөнномун,
С.Золжаргал, Б.Мөнгөнсүвд*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ САЛБАРЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ
ЛАВЛАГАА

1.1 Хүнсний хангамж

1.2 Хүнсний тухай хууль, эрх зүйн орчин холбогдох хууль тогтоомж, бодлогын
баримт бичиг

1.3 Хууль эрх зүйн зохицуулалт

1.4 Хүнсний стандарт

1.5 Хүнсний хяналтын байгууллагууд

БҮЛЭГ 2. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХҮНСНИЙ ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН,
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ТУРШЛАГА

2.1.АНУ

2.1.1 Хууль, эрх зүйн зохицуулалт

2.1.2 Хариуцах албан байгууллага

2.1.3 Төрөөс баримталж буй бодлого стратеги

2.2.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

2.2.1 БНСУ-ын хүнсний тухай хууль тогтоомж, дүрэм журам

2.2.2 БНСУ-ын хүнсний аюулгүй байдал, хяналтын байгууллага

2.2.3 БНСУ-ын хүнсний аюулгүй байдлын систем

2.3.ЯПОН УЛС

2.3.1 Хууль эрх зүйн зохицуулалт

2.3.2 Хүнсний аюулгүй байдлын Комисс

2.3.3 Төрөөс баримталж буй бодлого стратеги

2.4.ИБУИНХУ

2.4.1 ИБУИНХУ-ын хүнсний тухай хууль тогтоомж, дүрэм журам

2.4.2 ИБУИНХУ-ын Хүнсний стандарт, аюулгүй байдал, хяналтын байгууллага

2.5.АВСТРАЛИ, ШИНЭ ЗЕЛАНД

2.5.1 Хүнсний стандарт Австрали - Шинэ Зеланд (FSANZ)

2.5.2 Хүнсний аюулгүй байдлын хяналтын байгууллагууд

2.5.3 Хүнсний тухай хууль тогтоомж

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ



УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Хүнсний харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин, бусад орнуудын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн хэрэгцээнд зориулан бусад орнуудын хүнсний харилцааг зохицуулж буй бодлого, эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тогтолцоог харьцуулан судалж, Монгол Улсын нөхцөл байдалтай харьцуулан үнэлэх.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд хүнсний эрх зүйн харилцаа, аюулгүй байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах систем харьцангуй өдөр хөгжсөн БНСУ, АНУ, Япон, Их Британи, Австрали зэрэг өндөр хөгжилтэй орнуудыг хамруулав. Түүнчлэн Монгол Улсын хүнсний харилцааны бодлого, эрх зүйн орчин, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын тогтолцооны талаарх мэдээллийг хамруулав.

Судалгааны тайлангийн бүтэц: Судалгааны мэдээллийг дараах 2 бүлэг асуудлын хүрээнд боловсруулсан:

1-р бүлэг. Монгол Улсын хүнсний салбарын бодлого, эрх зүйн орчны лавлагаа;

2-р бүлэг. Гадаадын зарим орны хүнсний харилцааны эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилтийг хангах тогтолцооны талаарх туршлага.

Судалгаанд ашигласан Монгол Улсын мэдээллийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болон Гаалийн ерөнхий газрын Гаалийн хорио цээрийн газраас авсан болно. Мөн судалгаанд тухайн сэдвийн хүрээнд хийгдсэн олон улсын судалгааны тайлан, холбогдох бусад мэдээллийг ашиглав.

Судалгааны захиалгад дурдсан Монгол Улсын Хүнсний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг УИХ-ын хяналт шалгалтын ажлын хэсэг болон Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газраас Засгийн газар болон, холбогдох байгууллагуудын хүрээнд явуулсан хяналт шалгалт, албан ёсны мэдээлэлд тулгуурлан тусгайлсан арга зүйн дагуу гаргадаг тул энэхүү судалгаанд зөвхөн Монгол Улсын эрх зүйн орчны хүрээг гадаадын зарим орны эрх зүйн орчин, тогтолцоотой харьцуулан харуулахыг зорьсон болно.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хүнсний салбарын бодлогын хувьд, судалгаанд авагдсан орнуудад нийтлэг байдлаар дараах асуудлуудыг бодлогын түвшинд анхаарч, тодорхой хэмжээнд урт, богино хугацааны бодлого, хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна. Тухайлбал:

- Хүнсний аюулгүй байдал
- Хүнсний хангамжийн тогтвортой байдал
- Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих үндэсний бодлого
- Хүнсний чанар, стандартыг хянах үндэсний тогтолцоог бүрдүүлэх

Монгол Улсад хүнсний аюулгүй байдлын асуудлыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичиг, Хүнсний үйлдвэрийн салбарын бодлого гэх мэт бодлогын баримт бичгүүдээр зохицуулж байна. Бусад орнуудын бодлогын чиг хандлагыг авч үзвэл тухайн орны онцлог, тэргүүлэх

зорилгоосоо хамааран ихэвчлэн хүнсний аюулгүй байдлыг хангах, хортой хүнснээс урьдчилан сэргийлэх, хүнсний хангамжийн тогтвортой тогтолцоог бий болгох, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хүнсний бодлого хэрэгжүүлэх, технологийн шинэчлэлд тулгуурлан хүнсний чанар, аюулгүй байдлыг хянах тогтолцоо, стандартыг шинэчлэхэд чиглэсэн стратеги, бодлогын хөтөлбөрүүд байгаа нь харагдаж байна.

Хүнсний салбарын эрх зүйн орчны хүрээг авч үзвэл, судалгаанд авагдсан орнуудтай Монгол Улсыг харьцуулахад эрх зүйн орчны цар хүрээ, батлагдсан хууль тогтоомж, стандартын тоо харьцангуй олон байна. Эрх зүйн орчны хүрээгээр нь авч үзвэл ихэнх орнуудад нийтлэг байдлаар дараах чиглэлийн хуулиудыг батлан мөрдүүлж байна. Тухайлбал:

- Хүнсний код, Хүнсний нэмэлт орчны код, Хүнсний баяжуулсан бүтээгдэхүүний код, Бараа, тэмдэгтийн тухай стандарт (БНСУ), Хүнс болон эмийн код (АНУ), Хүнсний стандарт, Хүнсний стандартын дүрэм (Австрали, Шинэ Зеланд)
- Хүнс, хөдөө аж ахуйн тухай суурь хууль (Япон), Хүнсний ерөнхий хууль (Их Британи), Хүнсний тухай хууль (Австрали, Их Британи), Махны хяналтын тухай хууль (АНУ)
- Хүнс, эм, гоо сайхны бүтээгдэхүүний тухай хууль (АНУ)
- Хүнсний аюулгүй байдлын тухай хууль (БНСУ, Япон, Их Британи, Умард Ирланд) Хүнсний аюулгүй байдлын шинэчлэлийн тухай хууль (АНУ)
- Хүнсний чанарыг хамгаалах тухай хууль (АНУ)
- Хүнсний ариун цэвэр, эрүүл ахуйн тухай хууль (БНСУ, ЕХ, Умард Ирланд) Малын гаралтай бүтээгдэхүүний ариун цэврийн тухай хууль (БНСУ, Их Британи), Хүнсний эрүүл ахуйн тухай хууль (Япон), Мал амьтны тэжээлийн эрүүл ахуйн тухай хууль (Их Британи)
- Импортын хүнсний аюулгүй байдлын тухай хууль (БНСУ, Австрали), Хөдөө аж ахуйн экспортын шинэ хууль (Австрали)
- Хүүхдийн хүнсний зохистой хэрэглээний тухай хууль
- Хүнсийг ариун цэврийн шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэх тухай хууль (АНУ)
- Хуурамч хүнсний хяналтын хууль (АНУ)
- Хэрэглэгчдэд хүнсний тухай мэдээлэл олгох журам (Их Британи)

Монгол Улсын хүнсний харилцааны эрх зүйн орчны хүрээнд дээрх асуудлуудыг ерөнхийд нь хамруулан зохицуулсан байгаа боловч бусад орнуудын туршлагад тулгуурлан зарим асуудлуудыг эрх зүйн орчны хүрээнд зохицуулах эсэх асуудлыг авч үзэх нь зүйтэй болов уу. Тухайлбал, хүнсний экспорт, импортын (ялангуяа шувууны мах, өндөг) хяналтын асуудал, хүнсний ариун цэврийн чанарын шаардлага хангасан тээвэрлэлтийн асуудал, хуурамч хүнсний хяналт, мал, амьтны тэжээлийн эрүүл ахуй, хэрэглэгчдэд хүнсний тухай мэдээлэл олгох гэх мэт. Судалгаанаас үзэхэд эрх зүйн орчны хүрээнд ихэнх асуудлыг Монгол Улсын хууль тогтоомж, стандартаар зохицуулсан мэт харагдаж байгаа боловч хуулийн хэрэгжилтийг хангуулах үр ашигтай тогтолцоо буюу хяналтын шинэлэг систем хангалтгүй байгаа нь харагдаж байна. (Тухайлбал БНСУ-ын Hazard Analysis Critical Control Point)

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тогтолцооны хувьд, Монгол Улсад Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Гаалийн хорио цээрийн газар, Гаалийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллагууд тус тусын чиг үүргийн хүрээнд хүнсний салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналтыг

хариуцан ажиллаж байгаа бол бусад орнуудад мөн ялгаагүй салбарын яамд, хяналтын чиг үүрэг бүхий агентлагууд хариуцан ажиллаж байна.

Зарим дэвшилтэт туршлагаас дурдвал, БНСУ-ын Хүнс, эмийн аюулгүй байдлын яам (MFDS)-ны харьяанд Хортой хүнснээс урьдчилан сэргийлэх цахим систем (Hazard Analysis Critical Control Point System) ажиллуулдаг. Энэхүү систем нь хүнс, эмийн бүтээгдэхүүнийг бүртгэлжүүлэх, хэрэглэгчдэд сургалт сурталчилгаа явуулах, техникийн дэмжлэг үзүүлэх, магадлан итгэмжлэлийн гэрчилгээ олгоход зориулагдсан систем юм.

Хүнсний аюулгүй байдлын хяналт нь улс орнуудын хувьд үндэсний аюулгүй байдлын хэмжээний чухал асуудал учраас зарим орнуудад Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын дэргэд уг асуудлыг хариуцсан комисс, хороо ажиллаж байгаа туршлага байна. Тухайлбал: АНУ-ын Ерөнхийлөгчийн дэргэд Хүнсний аюулгүй байдлын зөвлөл (President's Council on Food Safety), Хүнсний аюулгүй байдлын хороо (Food Safety Commission) ажилладаг бол Австрали, Шинэ Зеландад Хүнсний зохицуулалтын сайд нарын зөвлөл (ANZFRMC), Японд Хүнсний аюулгүй байдлын Комисс (Food Safety Commission of Japan) ажилладаг байна.

Түлхүүр үг: *Хүнсний тухай хуулийн зохицуулалт, Хүнсний аюулгүй байдал, Импортын хүнсний бүтээгдэхүүний зохицуулалт*

Keywords: *Food and beverage legislation and regulations, Food safety, Food sanitation act, Imported food safety management*

СУДАЛГААНД АВАГДСАН ОРНУУДЫН ТУРШЛАГЫН ТАЛААРХ ХУРААНГУЙ ХҮСНЭГТ

Улс	Хүнсний хэрэгцээгээ дотооддоо хангах түвшин	Хүнсний тухай хууль, эрх зүйн орчин	Төрөөс баримталж буй бодлого стратеги	Хяналтын байгууллага, агентлаг
(МОНГОЛ)	Монгол Улсын өрхийн хэрэглээний 45.1 хувийг хүнсний хэрэгцээ эзэлж байна. 2020 оны статистикаас үзэхэд, Монгол Улс жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, махан бүтээгдэхүүнээр 97.0 хувь, төмсөөр 100.0 хувь, гурилаар 98.3 хувь, хүнсний ногоогоор 60.7 хувийг хангаж байна.	<ul style="list-style-type: none"> - Хүнсний тухай хууль - Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль - Органик хүнсний тухай хууль - Баяжуулсан хүнсний тухай хууль - Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль - Хувиоргасан амьд организмын тухай хууль - Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль - Төрийн хяналт шалгалтын тухай хууль - Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хууль - Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль 	<ul style="list-style-type: none"> - Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал - “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичиг - Хүнсний үйлдвэрийн салбарын бодлого - Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих бодлого 	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Гаалийн хорио цээрийн газар, Гаалийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллагууд тус тусын чиглэлээр хариуцан хүнстэй холбогдох харилцааг зохицуулж байна.
(БНСУ)	Солонгосын иргэдийн 90 гаруй хувь нь томоохон хотуудад амьдардаг ба хүнсний хэрэгцээний 45 хувийг дотоодын үйлдвэрлэл нь хангадаг. ⁷⁵	Хүнсний ариун цэврийн тухай хууль ⁷⁶ (The Food Sanitation Act), Импортын хүнсний аюулгүй байдлын удирдлагын тухай тусгай хууль, Хүүхдийн хүнсний зохицтой хэрэглээний тухай хууль (The Special Act on Children's Dietary Life Safety Management), Малын гаралтай бүтээгдэхүүний ариун цэврийн тухай хууль (The Livestock Product Sanitary Management Act) болон Хүнсний код (Food	Хортой хүнснээс урьдчилан систем (Hazard Analysis Critical Control Point) System нь Хүнс, эмийн аюулгүй байдлын яамны удирдлага дор хэрэглэгчдэд сурталчилгаа явуулах, техникийн дэмжлэг	Хүнс, эмийн аюулгүй байдлын яам (MFDS), Хүнс, хөдөө аж ахуйн, орон нутгийн яам (the Ministry of Agriculture, Food and Rural Affairs), Амьтан, ургамлын хорио цээрийн газар (the Animal and Plant Quarantine Agency), Солонгосын гаалийн алба (the Korea Customs Service)

⁷⁵ Exporter Guide, Sangyong OhOctober 14, 2021
⁷⁶ https://www.mfds.go.kr/eng/brd/m_15/list.do

		Code), Хүнсний нэмэлт орцны код (The Food Additive Code), Хүнсний баяжуулсан бүтээгдэхүүний код, Бараа тэмдэгийн тухай стандарт (Labelling standards)	үзүүлэх, мөн сайн дурын үндсэн дээр байгууллагууд уг системээс магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авдаг байна.	<ul style="list-style-type: none"> - АНУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хүнсний аюулгүй байдлын зөвлөл (President's Council on Food Safety), Хүнсний аюулгүй байдлын хороо (Food Safety Commission) болон Хөдөө аж ахуйн яамны Хүнсний аюулгүй байдал, хяналтын газар (Food Safety and Inspection Service), Эрүүл мэндийн яамны харьяа Хүнс болон эмийн газар (Food and Drug Administration), Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төв (Center for Disease Control and Prevention) болон холбогдох бусад агентлагууд
(АНУ)	Дотооддоо хүнсний хэрэгцээгээ хангах түвшин нь 2022 оны байдлаар дэлхийн улс орнуудаас 5-р байранд буюу 147%-тай байна. Хүнсний аюулгүй байдлын нэгдсэн дүнгээр (Үүнд дараах үзүүлэлтүүд орно: худалдан авах боломж-88.7%, хүртээмж-71.0%, чанар болон аюулгүй байдал-94.3%) дэлхийн улс орнуудаас 9-р байранд буюу 79.1%-тай байна.	Нэгдсэн Улсын Код, Хэсэг 21 “Хүнс болон эм” (US Code Title-21 Food and Drug) Холбооны хүнс, эм, гоо сайхны бүтээгдэхүүний тухай хууль (Federal Food, Drug and Cosmetic Act), Хүнсний аюулгүй байдлын шинэчлэлийн тухай хууль (Food Safety Modernization Act), Хүнсний чанарыг хамгаалах тухай хууль (Food Quality Protection Act), Хүнсийг ариун цэврийн шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэх тухай хууль (Sanitary Food Transportation Act), Холбооны махны хяналтын тухай хууль (Federal Meat Inspection Act), Шувууны махан бүтээгдэхүүний хяналтын тухай хууль (Poultry Products Inspection Act), Шувууны өндөгний хяналтын тухай хууль (Egg Products Inspection Act), Мал зааглах хүмүүнлэг аргын тухай хууль (Humane Methods of Livestock Slaughter Act), Холбооны хуурамчаар үйлдэхийн эсрэг хууль (Federal Anti-Tampering Act)	<ul style="list-style-type: none"> - Хүнс, Хөдөө аж ахуйн Үндсэн бодлого - Хүнсний аюулгүй байдлыг хангах Үндэсний бодлого - Хүнсний тогтвортой тогтолцооны стратеги 	<ul style="list-style-type: none"> - Хүнсний аюулгүй байдлын Комисс (Food Safety Commission of Japan)
(Их Британи)	Хүнсний хэрэгцээг дотооддоо хангах түвшин 37%	Хүнсний эрүүл ахуйн тухай хууль (Food Sanitation Act) - Хүнсний аюулгүй байдлын тухай хууль (Food Safety Basic Act) - Хүнс, хөдөө аж ахуйн тухай хууль (Basic Act on Food, Agriculture and Rural Area)	<ul style="list-style-type: none"> - Хүнс, Хөдөө аж ахуйн Үндэсний хүнсний бодлого (The National Food Strategy) 	<ul style="list-style-type: none"> - Хүнсний аюулгүй байдлын Комисс (Food Safety Commission of Japan)
		Хүнсний Ерөнхий хууль (General Food Law Regulation), Хүнсний аюулгүй байдлын тухай хууль (Food Standards Act), Умард Ирландын Хүнсний аюулгүй байдлын тухай журам (Food Safety (Northern Ireland))	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн яам (Department for Environment Food & Rural Affairs), Эрүүл мэнд нийгмийн хамгааллын яам (Department	

		Order, Умард Ирландын хүнсний эрүүл ахуйн тухай хууль (Food Hygiene Regulations (Northern Ireland)) Европын Холбооны хүнсний эрүүл ахуйн тухай хууль (EU Food Hygiene Regulations), Европын хамтын нийгэмлэгийн тухай хууль (European Communities Act), Мал, амьтны тэжээлийн эрүүл ахуйн хууль (Feed Hygiene Regulations), Хэрэглэгчдэд хүнсний тухай мэдээлэл олгох журам (Food Information for Consumers)	эрүүл мэнд, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор Хөдөө аж ахуй, Байгаль орчин, Загас агнуур, Аж үйлдвэрлэлийн бодлого, Хүүхдийн таргалалт тулгуурлан хүнсний бодлого (National Food Strategy ⁷⁷ -ыг тодорхойлсон байна.	of Health and Social Care), Хөдөө аж ахуй, байгаль орчны яам (Department of Agriculture, Environment and Rural Affairs), Хүнсний стандартын агентлаг (Food Standards Agency)
(Австрали)	Дотооддоо хүнсний хэрэгцээгээ хангах түвшин нь 2022 оны байдлаар дэлхийн улс орнуудаас 3-р байранд буюу 218%-тай байна.	<ul style="list-style-type: none"> - Австрали Шинэ Зеландын Хүнсний стандартын дүрэм - Хүнсний тухай хууль (Food act 2003-NSW) болон 2015 оны Хүнсний журам - Импортын хүнсний хяналтын тухай хууль (Imported Food Control Act 1992) - Австралийн хөдөө аж ахуйн экспортын шинэ хууль (Australia's new legal framework for agricultural exports) - Хүнсний стандарт Австрали Шинэ Зеландын хууль 1991 он (Food Standards Australia New Zealand Act 1991) 	<p>2018 онд Австрали, Шинэ Зеландын Хүнсний зохихуулалтын Сайд нарын форум нь технологийн томоохон өөрчлөлтүүд гарч буйтай холбогдуулан хүнсний зохихуулалтыг шинэчлэх хувилбаруудыг авч үзэхийг FSANZ-аас хүссэн. Уг хүсэлтийн дагуу FSANZ нь Сайд нарт шинэчлэлийн хүрээг танилцуулах зорилгоор ажиллаж байна.</p>	Австрали, Шинэ Зеландын Хүнсний зохихуулалтын сайд нарын зөвлөл (ANZFRMC) нь Австралийн бүх муж улсын Эрүүл мэндийн сайд нар (Шинэ Өмнөд Уэльсийн NSW Аж үйлдвэрийн сайд зөвхөн), Шинэ Зеландын Засгийн газрын тэргүүн болон бусад холбогдох сайд нараас бүрддэг. Хүнсний стандарт Австрали Шинэ Зеланд (FSANZ) нь Австралийн засгийн газрын эрүүл мэндийн хууль ёсны эрх бүхий байгууллага юм. FSANZ нь Австрали, Шинэ Зеландын хүнсний стандартыг боловсруулдаг. Австралийн хорио цээрийн хяналтын алба ⁷⁸ (AQIS) нь бодит хяналт шалгалтыг хариуцдаг.

⁷⁷ National Food Strategy <https://www.gov.uk/government/publications/developing-a-national-food-strategy-independent-review-2019-terms-of-reference>

⁷⁸ Australian Quarantine https://www.awe.gov.au/sites/default/files/sitecollectiondocuments/aqis/about/corporate-docs/naim/naim_report.pdf

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ САЛБАРЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ЛАВЛАГАА

1.1 Хүнсний хангамж

Монгол Улсын ДНБ нь 2022 оны эхний улиралд 9.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 359.8 (4.0%) тэрбум төгрөгөөр өссөн. Монгол Улсын өрхийн хэрэглээний 45.1 хувийг хүнсний хэрэглээ, 19.7 хувийг хүнсний бус хэрэглээ, 35.2 хувийг үйлчилгээ эзэлж байна. Өрхийн хүнсний барааны хэрэглээ өмнөх оны мөн үеэс 525.0 (22.6%) тэрбум төгрөгөөр өсөж, энэхүү өсөлтөд мах, махан бүтээгдэхүүний хэрэглээ 190.6 (21.4%) тэрбум төгрөгөөр, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ 57.0 (15.1%) тэрбум төгрөгөөр, тамхины хэрэглээ 59.3 (45.4%) тэрбум төгрөгөөр, согтууруулах ундааны хэрэглээ 59.5 (37.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.⁷⁹

1.2 Хүнсний тухай хууль, эрх зүйн орчинд холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичиг

Монгол Улс нь хүнстэй холбогдох дараах олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцод нэгдэн орж холбогдох харилцаанд оролцогчид өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж байна.

Монгол Улсын нэгдэж орсон олон улсын конвенцууд

- Биологийн төрөл зүйлийн тухай конвенц
- “Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай” Женевийн конвенц
- Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын конвенц
- Тир карнейг хэрэглэн барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенц

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын олон талт гэрээ, хэлэлцээр

- Олон улсын хөдөө аж ахуйн санг байгуулах тухай хэлэлцээр
- Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр
- Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (8 дугаар зүйл⁸⁰)
- Ачилтын өмнө хяналт шалгалтын тухай хэлэлцээр⁸¹
- Барааны худалдааны тухай олон талт хэлэлцээрүүд⁸²
- Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр⁸³
- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дүрэм

1.3 Хууль эрх зүйн зохицуулалт

Хүнсний тухай хууль⁸⁴ нь 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан 6 бүлэг 20 зүйлтэй. Энэ хуулийн зорилт нь хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

- Энэ хуулиар хүнсний аюулгүй байдлыг хангах
- Хүнсний хангамжийг тодорхойлох
- Хүнсний нөөц
- Хувиргасан амьд организмаас гаралтай хүнс

⁷⁹ <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=GDP%202022%20I-III%20mn.pdf&ln=Mn>

⁸⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1205>

⁸¹ https://ub.customs.gov.mn/?page_id=321

⁸² <https://legalinfo.mn/mn/detail/10680>

⁸³ <https://legalinfo.mn/mn/detail/10681>

⁸⁴ <https://legalinfo.mn/mn/detail/8912>

- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал
- Хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах
- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлага
- Хүнс экспортлох, импортлоход тавих шаардлага
- Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт
- Хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын оролцоо
- Хүнсний аюулгүй байдлыг хангахад үзүүлэх хэрэглэгчийн дэмжлэг
- Бүртгэл
- Баталгаажуулалт
- Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг зохицуулж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль нь 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан 5 бүлэг 20 зүйлтэй. Энэ хуулийн зорилт нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим
- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн талаарх мэдээлэл
- Хүнсний сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга хэлбэр
- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах
- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үл мөрийг мөрдөн тогтоох бүртгэл
- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг
- Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн
- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго
- Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн
- Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн
- Үндэсний лавлагаа лаборатори
- Эрсдэлийн үнэлгээ хийх
- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллагын үүрэг
- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих төрийн хяналт
- Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг зохицуулж байна.

Органик хүнсний тухай хууль нь 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр батлагдсан 4 бүлэг 14 зүйлтэй. Энэ хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх, органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх, тэдгээрийг баталгаажуулах, худалдах, импортлох, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- Органик үйлдвэрлэлийн зарчим
- Органик үйлдвэрлэлийн шилжилтийн үе
- Органик үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг
- Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавих шаардлага
- Органик хүнсийг импортлох, экспортлох, худалдах
- Органик хүнсний баталгаажуулалт, шошгололт, бүртгэл
- Органик үйлдвэрлэл, органик хүнсэнд тавих хяналт
- Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг зохицуулж байна.

Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль нь 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан 5 бүлэг 20 зүйлтэй. Энэ хуулийн зорилт нь хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг

дэмжих бодлогыг тодорхойлох, эрүүл, аюулгүй хүнсээр хангах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих бодлого
- Зориулалтын бүтээгдэхүүний найрлагад тавих ерөнхий шаардлага
- Зориулалтын бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгод тавих ерөнхий шаардлага
- Сүүн тэжээлийн сав, баглаа боодол, шошгод тавих тусгай шаардлага
- Нэмэгдэл хоол, ундааны сав, баглаа боодол, шошгод тавих тусгай шаардлага, хориглох зүйл
- Хооллох хэрэгслийн сав, баглаа боодол, шошгод тавих тусгай шаардлага, хориглох зүйл
- Нялх, балчир хүүхдийн хүнс, хооллох хэрэгслийн зар сурталчилгаа
- Нялх, балчир хүүхдийн хоол тэжээлийн мэдээлэл, сургалт
- Хүүхдийг сүүн тэжээлээр хооллох
- Зориулалтын бүтээгдэхүүний талаар эрүүл мэндийн ажилтанд өгөх мэдээлэл
- Төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн салбар зөвлөлийн чиг үүрэг
- Эрүүл мэндийн байгууллага болон ажилтны чиг үүрэг
- Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүлээх үүрэг
- Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг зохицуулна.

Баяжуулсан хүнсний тухай⁸⁵ хууль нь 2018 оны 05 дугаар сарын 03-ны батлагдсан 4 бүлэг 12 зүйлтэй. Энэ хуулийн зорилт нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, аминдэм, эрдэс бодисын дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зарим төрлийн хүнсийг албан журмаар баяжуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- Хүнс баяжуулах үйл ажиллагаа;
- Хүнс баяжуулалтын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг;
- Баяжуулсан хүнс үйлдвэрлэгчийн эрх, үүрэг;
- Баяжуулсан бэлдмэл импортлогчийн эрх, үүрэг;
- Баяжуулсан хүнс импортлох;
- Баяжуулсан хүнсэнд тавих хяналт;
- Баяжуулсан хүнсний тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг зохицуулна.

Хувиргасан амьд организмын тухай хууль нь 2007 оны 06 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан 4 бүлэг 20 зүйлтэй.

- Үндэсний хорооны бүрэн эрх;
- Хувиргасан амьд организмын улсын хилээр нэвтрүүлэх, гарган авах, эрсдэлийн үнэлгээ хийх;
- Технологийн нууцлал хадгалах;
- Био аюулгүй байдлыг хангах;
- Хуульд зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг зохицуулна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль нь 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан, 8 бүлэг 32 зүйлтэй. Энэ хуулийн зорилт нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

⁸⁵ <https://legalinfo.mn/mn/detail/13353>

Зөрчлийн тухай хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

- Архидан согтууруулахтай тэмцэх тухай хууль зөрчих
- Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль зөрчих
- Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль зөрчих
- Хүнсний тухай хууль зөрчих⁸⁶
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих⁸⁷ гэх мэтчилэн зөрчлийн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан 8 бүлэг 32 зүйлтэй. Энэ хуулийн зорилт нь амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Эрүүл ахуйн тухай хууль нь хүнстэй холбогдох эрүүл ахуйн тухай харилцааг холбогдох зүйл заалтаар зохицуулна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- Махны үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай /ЗГ-ын 2001 оны 277-р тогтоол/
- Үндэсний чанарын хөтөлбөр /ЗГ-ын 2016 оны 344-р тогтоол/
- Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт /ЗГ-ын 2018 оны 291-р тогтоол/
- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам /ЗГ-ын 2013 оны 172-р тогтоол/
- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам /ЗГ-ын 2014 оны 157-р тогтоол/
- Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам /ЗГ-ын 2017 оны 195-р тогтоол⁸⁸/

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дахь хүнстэй холбогдох хэсгүүд. Үүнд:

- Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, **хүнсний аюулгүй байдлыг хангах**, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн.⁸⁹

⁸⁶ Зөрчлийн тухай хууль зөрчих 6.14. Хүнсний тухай хууль зөрчих

⁸⁷ Зөрчлийн тухай хууль зөрчих 6.15. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих

⁸⁸ <https://legalinfo.mn/mn/detail/12863>

⁸⁹ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Хүний аюулгүй байдал. 3.4

- Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна.
- Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана.
- Хүнсний түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно.
- Мал эмнэлгийн тогтолцоог шинэчилж, малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхыг дээшлүүлж, халдвар, хамгаалал, биоаюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгоно. Монгол малын удмын сан, үр тарианы нутагшмал сортыг хамгаална. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.
- Хүнсний чанар, аюулгүй байдлын техникийн шаардлагыг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчилж, хяналтын тогтолцоог бэхжүүлэн, олон улсын итгэмжлэлд хамруулах арга хэмжээ авна.
- Хүнсний бүтээгдэхүүнийг зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан импортлох тогтолцоог бүрдүүлж, импортын хүнсний бүтээгдэхүүнд чанарын урьдчилсан хяналт, бүртгэлжүүлэлт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоо бий болгох, импортлох үеийн чанарын баталгаат байдалд эрсдэлийн үнэлгээ хийх замаар чанар, аюулгүй байдлын баталгааг хангана.⁹⁰

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хүнстэй холбогдох хэсгүүд.

- Үндэсний соёл, спорт, хоол хүнс судлал хөгжиж, дэлхий нийтэд танигдсан байна.⁹¹
- Үндэсний соёл, спорт, хүнс хоолны үйлчилгээг түгээн дэлгэрүүлсэн байна.
- Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.
- Инновац нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж аюулгүй, тэжээллэг хэрэгцээт хүнсээр хангадаг болно.
- Хүнсний хангамж, нийлүүлэлтийн үйл ажиллагаанд тавих эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт, шаардлагыг боловсронгуй болгож, баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгон органик, баяжуулсан, зохицуулах үйлчилгээтэй болон эрүүл хүнсний хэрэглээтэй болно.
- Монгол брэндийн эко хүнс экспортлох нөхцөлийг сайжруулж, хүнсний боловсруулах салбарын хөгжлөөр тэргүүлнэ.
- Боловсруулах салбар давамгайлсан эдийн засгийн бүтцийг бүрдүүлж, хүнсний аюулгүй байдал хангагдсан байна.

⁹⁰ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Хүнсний аюулгүй байдал. 3.4.2.8.

⁹¹ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Дэлхийн Монгол Зорилт 1.5. 1-р үе шатын 4.

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулж, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангана.
- Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээ бий болгоно.
- Дагуул, хаяа хот, тосгон тус бүрд нь худалдаа, үйлчилгээ, соёл боловсрол, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулсан байна.

1.4 Хүнсний стандарт

Монгол Улсад Стандарт хэмжил зүйн газраас гаргасан хүнстэй холбогдох 700 гаруй стандартын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Монгол Улсын хэмжээнд хүнстэй холбогдох дараах стандартуудыг дагаж мөрддөг. Үүнд:

MNS CAC RCP:2003 Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (олон улсын зөвлөмж)

Хамрах хүрээ- Хүнсийг хүний хэрэглээнд аюулгүй, тохиромжтой байлгах зохилгод хүрэхийн тулд **MNS 6648:2016** Хүнсний бүх хэлхээнд хамаарах, хүнсний эрүүл ахуйн гол чухал зарчмуудыг тогтооно.

MNS CAC RCT 20:2007 Хүнсний олон улсын худалдаанд баримтлах ёс зүй

Хамрах хүрээ: Энэхүү стандарт нь олон улсын худалдаанд нийлүүлж буй бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүнд хамаарна.

MNS CAC GL 32:2017 Органик хүнсийг боловсруулах, үйлдвэрлэх, шошголох, худалдаалахад баримтлах арга зүйн удирдамж

Хамрах хүрээ: Органик хүнсийг үйлдвэрлэх болон бүтээгдэхүүний шошгод органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, мэдэгдлийг хэрэглэхэд харилцан хүлээн зөвшөөрсөн нийтлэг шаардлагыг тавих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор энэхүү арга зүйн удирдамжийг (цаашид “удирдамж” гэх) боловсруулсан болно.

MNS 4579:1998 Хүнсний бүтээгдэхүүний тухай хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл. Ерөнхий техникийн шаардлага

Хамрах хүрээ: Энэ стандарт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бөөний болон жижиглэн худалдаалах аж ахуйн нэгжийн борлуулж байгаа буюу хэрэглэгчдийн үйлчилгээтэй шууд холбоо бүхий хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сувиллын газар, бусад байгууллагуудад нийлүүлж байгаа хүнсний бүтээгдэхүүнд хамаарах бөгөөд энэ талаар хэрэглэгчдэд зориулсан мэдээллийн ерөнхий шаардлагыг тогтооно.⁹²

MNS 6880:2020 Хүнсний бүтээгдэхүүний баяжуулагч бэлдмэл төмөр, цайрын агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга.

Хамрах хүрээ: Энэ стандарт нь баяжуулагч бэлдмэлд агуулагдах төмөр, цайрын агуулгыг атом шингээлтийн спектрийн дөлөн аргаар тодорхойлоход хамаарна⁹³ гэх мэт олон стандартууд байна.⁹⁴

Хүнсний сүлжээнд заавал мөрдөгдөх зохистой дадлууд:

- GAP-Хөдөө аж ахуйн зохистой дадал
- GMP-Үйлдвэрийн зохистой дадал
- GHP-Эрүүл ахуйн зохистой дадал

⁹² <https://estandard.gov.mn/standard/v/3363>

⁹³ <https://estandard.gov.mn/standard/v/6698>

⁹⁴ <https://estandard.gov.mn/>

- GTP-Худалдааны зохистой дадал
- GSP-Хадгалалтын зохистой дадал
- GRP-Жижиглэн худалдааны зохистой дадал
- GCP-Эрүүл мэндийн зохистой дадал
- GHK-Үйлчилгээний зохистой дадал
- GLP-Лабораторийн зохистой дадал
- GNP-Шим тэжээлийн зохистой дадал

1.5 Хүнсний хяналтын байгууллагууд

Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, худалдаа зэрэг хүнсний харилцааг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн хорио цээрийн газар, Гаалийн ерөнхий газрын хүнсний аюулгүй байдал хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс зэрэг төрийн байгууллагууд тус тусын чиглэлээр хариуцан зохицуулж байна.

ХХААХҮЯ-ны хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтсийн чиг үүрэг

Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс нь мал эмнэлэг, мал, амьтны үржлийн болон ургамал хамгаалал, хорио цээр, таримал ургамлын үр сортын чанарын хяналт, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны чиглэлээр таатай орчныг бий болгох, аливаа сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хяналт шалгалтыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх, бодлогын удирдамжаар хангах, салбарын хяналтын бодлого, стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл боловсруулах ажлыг мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоо, стратеги, төлөвлөлт, зарчимд нийцүүлэн мөрдөхөд чиглэсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.⁹⁵

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг

Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч	1.	Хоол үйлдвэрлэл үйлчилгээний технологийн үйл ажиллагаа, шат дамжлагад хоол, хүнсний аюулгүй байдал алдагдуулах болзошгүй эрсдэлийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх хяналт тавих
	2.	Хоол, үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглаж буй түүхий эд, бэлэн болон чанар аюулгүй байдал, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, үйлчилгээний явцад /явуулын үйлчилгээ, зөөврийн хоол, түргэн хоолны газар зэрэг/ хоолны чанар аюулгүй байдал алдагдах эрсдэл гарч буй эсэхэд хяналт тавих
	3.	Нийтийн хоолны газруудад дотоод хяналт, эргүүлэн татах, мөрдөн мөшгих журмын хэрэгжилтийг ханган тогтмолжуулсан эсэх, үйл ажиллагааны онцлогт тохирч хоол хүнсний аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдсэн эсэхэд хяналт тавих

Худалдааны стандартын хяналтын чиглэлээр доорх асуудлыг хамаарна.

Хүнсний чанар, стандартын хяналтын улсын /ахлах/ байцаагч	1.	Хүнсийг худалдаалах, хадгалах, тээвэрлэх үе шат болон үйл ажиллагааны явцад эрсдэлд суурилсан хяналтыг төлөвлөж хэрэгжүүлэх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үл мөрийг мөрдөн тогтоох бүртгэл, татан авах үйл ажиллагаанд хяналт тавих
	2.	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдаалалт, хадгалалт, тээвэрлэлт, шошгололт, дотоод хяналттай холбогдон гарсан хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт тавих
	3.	Согтууруулах ундаа, тамхийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр холбогдох хууль, журмын дагуу худалдаалж буй эсэхэд хяналт тавих
	4.	Улсын нөөцийн хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт тавих

⁹⁵ http://inspection.gov.mn/new/ulaanbaatar/?page_id=46864

Хүнсний үйлдвэрийн технологийн хяналтын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг

Хүнсний чанар, стандартын хяналтын улсын /ахлах/ байцаагч	1.	Хүнсний үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөж хэрэгжүүлэх.
	2.	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалт, шошгололт, дотоод хяналттай холбогдолтой хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, салбарын хяналтын бодлогыг тодорхойлох.
	3.	Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагууд үйлдвэрлэлийн зохистой дадал, /GMP/ нэвтрүүлэх болон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үл мөрийг мөрдөн тогтоох бүртгэл, татан авах үйл ажиллагаанд хяналт тавих.
	4.	Өндөр эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан хяналт хийж дүгнэлт гаргах.
	5.	Хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж буй томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих

Мал эмнэлгийн хяналтын чиг үүрэг

Мал эмнэлгийн хяналтын улсын /ахлах/ байцаагч	1.	Мал амьтан, хорио цээр, чанарын хяналтын улсын байцаагч нь Нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрт мал эмнэлгийн чиглэлээр холбогдох хууль, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийн байдалд хяналт тавих, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учруулж болзошгүй эрсдэл, малаас хүнд дамжих халдварт өвчин нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүнсний аюулгүй байдлыг хангуулах
---	----	--

Ургамал хорио цээр, чанарын хяналтын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг

Ургамал хорио цээр, Чанарын хяналт улсын /ахлах/ байцаагч	1	Ургамал хамгаалах химийн бодис, бордооны чанар аюулгүй байдал, үйлдвэрлэл, импорт, хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөлд хяналт тавих
	2	Бэлчээр, тариалангийн хөнөөлт шавьж, мэрэгч амьтантай хими, биологи, механик аргаар тэмцсэн ажлын үр дүнд хяналт тавих
	3	Ургамал хамгаалах үйл ажиллагааны технологийн горимын мөрдөлт, аюулгүй ажиллагаанд, ургамлын хорио цээрийн лабораторийн үйл ажиллагаанд хяналт тавих
	4	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тамхины ургамлын тариалан, хүлэмж зоорийн хорио цээрийн дэглэмийн мөрдөлт, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөлд хяналт тавих

Эх сурвалж: Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар

БҮЛЭГ 2. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХҮНСНИЙ ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ТУРШЛАГА

1.АНУ

Дэлхийн тэргүүлэгч гүрний нэг АНУ-ын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2022 оны байдлаар 24.79 их наяд ам.доллар байна.⁹⁶ ДНБ нь дангаараа дэлхийн бусад 170 орны ДНБ-ний нийлбэрээс их байна. АНУ нь 330 сая хүн амтай бөгөөд 9.373 сая хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй. Дотооддоо хүнсний хэрэгцээгээ хангах түвшин (food self-sufficiency rate) нь 2022 оны байдлаар дэлхийн улс орнуудаас 5-р байранд буюу 147%-тай байна. Хүнсний аюулгүй байдлын нэгдсэн дүнгээр (Үүнд дараах үзүүлэлтүүд орно: худалдан авах боломж-88.7%, хүртээмж-71.0%, чанар болон аюулгүй байдал-94.3%) дэлхийн улс орнуудаас 9-р байранд буюу 79.1%-тай байна.⁹⁷ АНУ нь хөдөө аж ахуйдаа ихээхэн анхаарал хандуулдаг бөгөөд дэлхийн хамгийн том хүнс экспортлогч орнуудын нэг юм. Дэлхийн нийт

⁹⁶ <https://www.bea.gov/news/2022/gross-domestic-product-fourth-quarter-and-year-2021-advance-estimate>

⁹⁷ <https://impact.economist.com/sustainability/project/food-security-index/Index>

хүнс үйлдвэрлэлийн 16.5%-ийг эзэлдэг байна. Харин нийт хүнсний хэрэглээнийхээ 20%-ийг импортоор оруулж ирдэг байна. АНУ-д хүнстэй холбоотой асуудлыг Нэгдсэн Улсын Код, Хэсэг 21-ээр зохицуулж байгаа бөгөөд хүнсний салбар дахь хурдацтай өөрчлөлттэй уялдуулан шинээр олон тооны хууль батлагдах буюу өмнөх хуульд нэмэлт, өөрчлөлт хийгдсээр байна. Тус улсын Хөдөө аж ахуйн яам (Department of Agriculture) хүнсний асуудлыг хариуцан, Эрүүл мэндийн яам (Department of Health and Human Services) болон холбогдох бусад яамд, тэдгээрийн харьяа агентлагуудтай хамтран хүнсний аюулгүй байдалд хяналт тавьдаг байна. Дэлхийн тэргүүлэгч гүрний хувьд АНУ нь өөрийн улсын төдийгүй дэлхийн бусад улс орнуудын хүнсний аюулгүй байдлыг хангах, ядуу буурай, бага орлоготой иргэдийг дэмжих олон тооны урт болон богино хугацааны стратеги, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

1.1 Хууль, эрх зүйн зохицуулалт

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-д хүнс, хүнсний аюулгүй байдал, түүнд тавих хяналтыг Нэгдсэн Улсын Код, Хэсэг 21 “Хүнс болон эм” (US Code Title-21 Food and Drug), түүнчлэн Нэгдсэн Улсын Кодын холбогдох бусад хэсэг, бүлгээр зохицуулж байна.

Нэгдсэн Улсын Код, Хэсэг 21 нь нийт 29 бүлэгтэй бөгөөд хүнс болон эмийн бүтээгдэхүүн, тэдгээрийн стандарт, боловсруулалт, хадгалалт, аюулгүй байдал, хэрэглээ, хариуцах, хяналт тавих байгууллага зэргийг зохицуулдаг байна.⁹⁸ Хүнсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан хуулиудад Нэгдсэн Улсын Код, Хэсэг 21-ийн Холбооны хүнс, эм, гоо сайхны бүтээгдэхүүний тухай хууль (Federal Food, Drug and Cosmetic Act), Хүнсний аюулгүй байдлын шинэчлэлийн тухай хууль (Food Safety Modernization Act), Хүнсний чанарыг хамгаалах тухай хууль (Food Quality Protection Act), Хүнсийг ариун цэврийн шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэх тухай хууль (Sanitary Food Transportation Act), Холбооны махны хяналтын тухай хууль (Federal Meat Inspection Act), Шувууны махан бүтээгдэхүүний хяналтын тухай хууль (Poultry Products Inspection Act), Шувууны өндөгний хяналтын тухай хууль (Egg Products Inspection Act), Мал заазлах хүмүүнлэг аргын тухай хууль (Humane Methods of Livestock Slaughter Act) болон холбогдох бусад хууль, тухайлбал, Холбооны хуурамчаар үйлдэхийн эсрэг хууль (Federal Anti-Tampering Act) орж байна.

Харин хүнсний бүтээгдэхүүний савлагаа, шошго зэргийг Холбооны худалдааны комиссын тухай хууль (Federal Trade Commission Act), Шударга савлагаа, шошгоны тухай хууль (Fair Packaging and Labeling Act), Барааны тэмдгийн тухай хууль (Trademark Act)-аар тус тус зохицуулж байна. Дээрх хуулиуд болон тэдгээр хуулиудыг хэрэгжүүлэх журмуудаар⁹⁹ хүнс, хүнсний аюулгүй байдал болон хүнсний салбар дахь бусад харилцааг зохицуулж байна.

АНУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хүнсний аюулгүй байдлын зөвлөл (President’s Council on Food Safety)-өөс хүнсний хангамжид учирч болзошгүй биотеррорист аюул заналын эсрэг **Хүнсний аюулгүй байдлын стратеги** (Food Safety and Security Strategy)-ийг боловсруулан хэрэгжүүлдэг байна. Энэхүү стратегид хүнсний аюулгүй байдлын үнэлгээг анхаарах бөгөөд хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх үйлдвэр, байгууламж болон зөөвөрлөх тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хүнсний технологи, стандарт алдагдсан тохиолдолд авах арга хэмжээ, олон нийтэд мэдээлэх зэрэг асуудлыг багтаахаар Холбооны хүнс, эм, гоо сайхны бүтээгдэхүүний тухай хуульд зохицуулжээ.

Түүнчлэн Хүнсний аюулгүй байдлын хороо (Food Safety Commission)-г 15 гишүүнтэйгээр байгуулдаг байна. Хорооны даргыг Ерөнхийлөгч томилно. Гишүүдэд хэрэглэгч, хүнсний эрдэмтэн судлаачид, хүнс үйлдвэрлэгчид, эрүүл мэндийн мэргэжилтнүүд заавал ордог байна. Хорооны бүрэлдэхүүнд мөн доод тал нь 3 төрийн албан хаагч орохоор заажээ. Хороо

⁹⁸ <https://uscode.house.gov/browse/prelim@title21/chapter26&edition=prelim>

⁹⁹ <https://www.ecfr.gov/current/title-21>

нь АНУ-ын хүнсний аюулгүй байдлын тогтолцоог сайжруулах талаар тодорхой зөвлөмжүүдийг гаргах бөгөөд зөвлөмж бүр хүнсний аюулгүй байдлыг хэрхэн сайжруулах талаар тайлбарлана. Хорооноос гаргасан зөвлөмжүүд нь АНУ-д худалдаалагдаж буй бүх хүнсний бүтээгдэхүүнд хамаарна. Хороо нь Ерөнхийлөгч болон Конгресст үйл ажиллагаагаа тайлагнана.

Холбооны хүнс, эм, гоо сайхны бүтээгдэхүүний тухай хууль нь 1938 онд батлагдсан бөгөөд тус хуулиар АНУ-д үйлдвэрлэгдэж, худалдаалагдаж байгаа хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, гоо сайхны бүтээгдэхүүний чанарын стандартыг бий болгосон байна. Эдгээр стандартыг холбооны хэмжээнд мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг АНУ-ын Хүнс болон Эмийн газар (Food and Drug Administration)-т үүрэг болгожээ. Тус хуулиар Хүнс болон Эмийн газарт дараах үүргийг хүлээлгэсэн байна:

- Шинэ эм, тодорхой эмнэлгийн хэрэгслүүд, хүнс, хүнсний нэмэлт будгийг бүртгэн, баталгаажуулах;
- Хүнс, эм, эмнэлгийн хэрэгслүүд, гоо сайхан болон тамхийг боловсруулж, үйлдвэрлэж, савлаж, тээвэрлэж, хадгалж буй үйлдвэр, агуулахын газрууд, тээврийн хэрэгслүүдэд хяналт, шалгалт хийх;
- Жороор олгогдох эм болон тодорхой эмнэлгийн хэрэгслүүдийн зар сурталчилгааг журамлах;
- Бүтээгдэхүүний шошгонд тавигдах шаардлагыг журамлах, тухайлбал:
 - Хүнсний бүтээгдэхүүний савлагаан дээр бүтээгдэхүүний орц, тэжээллэгийн хэмжээг тавих.
 - Хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнүүд дээр шим тэжээлийн агууламжийг тавих.
- Стандартад нийцэхгүй, эрүүл ахуйн шаардлага хангахгүй бүтээгдэхүүнийг худалдаанаас татан авах болон хураах зэрэг болно.

Хуулийн 4-р Дэд хэсэгт хүнсний асуудлыг зохицуулсан байна.¹⁰⁰ АНУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хүнсний аюулгүй байдлын зөвлөл, Хүнсний аюулгүй байдлын хороо, Хүнсний нэмэлт бүтээгдэхүүний шошгыг журамлах комисс (Commission on Dietary Supplement Labels), тэдгээрийн бүтэц бүрэлдэхүүн, чиг үүргийг зохицуулсан байна. Хүнсний аюулгүй байдлын зөвлөл холбогдох бусад холбооны агентлагуудтай хамтран баталдаг Хүнсний аюулгүй байдлын стратеги, түүний хэрэгжилтэд зарцуулагдах төсөв зэргийг хуульчилсан байна.

Түүнчлэн хүнсний нэмэлт бодис бүхий болон хуурамч шошго бүхий хүнс, улс даяар мөрдөх хүнсний шим тэжээлийн мэдээлэл ба шим тэжээлийн үзүүлэлт, хүнсний харшил үүсгэгчийн талаарх мэдээлэл хийгээд хүнсэнд хиймэл амт оруулагч, будагч бодис, хадгалалтын хугацааг уртасгагч бодис, хортон шавьж, мэрэгчээс хамгаалах бодисын тохиромжтой хэмжээ, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн-амин дэм, эрдэс, тэдгээрийн стандартын дагуух зохистой хэрэглээ, хэрэглэгчдэд энэ талын мэдлэг олгох зэрэг асуудлуудыг хуульчилсан байна.

АНУ-д хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч дотоодын болон гадаадын харьяат иргэн, аж ахуйн нэгжүүдийг бүртгэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх олгох, эрхийг цуцлах, эрхийг цуцлах шалтгаан нөхцөл болон тэдгээрт үйл ажиллагаагаа сайжруулах боломжийг олгох, хэрэв цуцалсан тохиолдолд тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчээс АНУ-д хүнсний бүтээгдэхүүн импортлох болон экспортлох, тухайн үйлдвэр, үйлчилгээний газраас хоол хүнсийг муж хоорондын хилээр нэвтрүүлэн худалдаалах болон тухайн мужид худалдаалахыг хориглохоор хуульчилсан байна.

¹⁰⁰ <https://uscode.house.gov/view.xhtml?path=/prelim@title21/chapter9/subchapter4&edition=prelim>

Хүнсний аюулгүй байдлын шинэчлэлийн тухай хууль нь 2011 онд батлагдсан.¹⁰¹ Тус хуулиар хүнсний аюулгүй байдлын тогтолцоог сайжруулснаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилтыг дэвшүүлсэн байна. АНУ төдийгүй дэлхийн хүнсний хангамжийн аюулгүй байдлыг хангах, хүнсийг муудсаны дараа бус муудахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг чухалчилснаараа АНУ-ын хүнсний аюулгүй байдлын хуулиад дотор сүүлийн 70 гаруй жилийн хугацаанд хийгдсэн дорвитой шинэчлэл болсон гэж үздэг байна. Хүнснээс үүдэлтэй өвчний тархалтыг богино хугацаанд илрүүлэн, хариу арга хэмжээ авах нь өвчний тархалтыг таслан зогсооход чухал нөлөөтэй бөгөөд цаашид дахин өвчлөл гарахаас урьдчилан сэргийлэх, улмаар хоол хүнсээр дамжих өвчний ачааллыг бууруулахад чухал нөлөөтэй гэж үзсэн байна. Хуулийн бүтэц:

I дэд бүлэг. Хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх асуудлуудаас урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлэх:

- 2201. Гүйцэтгэлийн стандартууд
- 2202. Үндэсний хөдөө аж ахуй болон хүнс хамгаалах стратеги
- 2203. Хүнс, хөдөө аж ахуйн зохицуулах зөвлөл
- 2204. Дотоодын чадавхыг бэхжүүлэх
- 2205. Хүнсний харшил болон анафилакс (нэг төрлийн харшил)-ийг хянах
- 2206. Архи, согтууруулах ундаатай холбоотой үйлчилгээ

II дэд бүлэг. Хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх асуудлыг илрүүлж, хариу арга хэмжээ авах чадавхыг нэмэгдүүлэх:

- 2221. Хүнсний асуудалтай холбоотой яаралтай тусламжийн сүлжээ
- 2222. Лабораторийн сүлжээний нэгдсэн холбоо
- 2223. Хүнсний хяналт, бүртгэл хөтлөлтийг сайжруулах
- 2224. Тандалт хийх
- 2225. Халдваргүйжүүлэх болон устгал хийх стандарт, төлөвлөгөө

III дэд бүлэг. Импортын хүнсний аюулгүй байдлыг сайжруулах:

- 2241. Худалдааны нарийн бичгийн даргын хийх шалгалт
- 2242. Хүнс, эмийн удирдлагын газрын гадаад дахь төлөөлөгчийн газар
- 2243. Хууль бусаар тээвэрлэсэн хүнс

IV дэд бүлэг. Бусад заалтууд:

- 2252. Хуулийн үйлчлэх хүрээ, хэрэгжүүлэх албан тушаалтнууд
- 2253. Олон улсын гэрээг дагаж мөрдөх

Хүнсний чанарыг хамгаалах тухай хуулиар АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагаас мөрдүүлэх хортон шавьж, мэрэгчээс хамгаалах бодисын хэрэглээний аюулгүй байдлын шинэ стандартыг хуульчилсан байна. Мөн нярайн хоолонд хэрэглэдэг хортон шавьж, мэрэгчээс хамгаалах бодисын эрүүл мэндэд суурилсан стандартыг баталснаар нялх болон бага насны хүүхдийн эрүүл мэндийг давхар хамгаалсан байна.

Хүнсийг ариун цэврийн шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэх тухай хуулийн зорилго нь хүнсний бүтээгдэхүүнийг шаардлагын дагуу зүй зохистой хөргөх, ачаа хооронд тээврийн

¹⁰¹ <https://uscode.house.gov/view.xhtml?path=/prelim@title21/chapter27&edition=prelim>

хэрэгслийг цэвэрлэж ариутгах, хүнсийг хамгаалах зэрэг үйл ажиллагаа алдагдсанаас хүнсний аюулгүй байдалд учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино. Тус хуулиар хүнсийг тээвэрлэх нөхцөлд муудахаас урьдчилан сэргийлэх стандартуудыг батлан, хүнс тээвэрлэх харилцаанд оролцогч талуудад мөрдүүлэхээр хуульчилсан байна.

Холбооны хуурамчаар үйлдэхийн эсрэг хууль нь Холбооны Эрүүгийн хуулийн нэмэлт болон батлагдсан бөгөөд хүнс, эм, гоо сайхны бүтээгдэхүүн болон бусад төрлийн бүтээгдэхүүнийг хуурамчаар үйлдвэрлэх замаар аливаа хүнд санаатайгаар бэртэл, гэмтэл учруулах, амь насыг нь хохироох болон завдах, бизнесийн нэр хүндэд нь хохирол учруулахыг эрүүгийн хэрэгт тооцохоор заажээ. Хэрэв хүний биед гэмтэл учруулсан бол 20 жил хүртэл хорих ял, 20.000 ам.доллар хүртэл торгууль, харин амь насыг нь хохироосон бол бүх насаар нь хорих ял оноохоор заажээ.

Хэрэв бүтээгдэхүүнийг хуурамчаар үйлдвэрлэх талаарх мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан, худал мэдээлэл өгсний улмаас аливаа хүн бэртэж гэмтсэн, амь нас нь хохирсон тохиолдолд тухайн этгээдэд дээрхтэй ижил шийтгэл ногдуулахаар заажээ.

Аливаа хүнийг өөрийн болон бусдын аюулгүй байдлын төлөө хийсэн үйлдлийнх нь хариуд байнгын айдас, түгшүүрт автуулах эсхүл төрийн байгууллага болон бүтээгдэхүүн худалдаалагчийг аливаа хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, гоо сайхны бүтээгдэхүүнийг худалдахад саад хийх, эргүүлэн татахад хүргэсэн этгээдэд 20 хүртэлх жилийн хорих ял оноох болон 20.000 ам.доллар хүртэл торгууль ногдуулах эсхүл дээрх ялыг давхар оноохоор заажээ.

1.2 Хариуцах албан байгууллага

АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны Хүнсний аюулгүй байдал, хяналтын газар (Food Safety and Inspection Service), Эрүүл мэндийн яамны харьяа Хүнс болон эмийн газар (Food and Drug Administration), Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төв (Center for Disease Control and Prevention) нь АНУ-д хүнсний аюулгүй байдлыг хангах асуудалд голлох үүрэг гүйцэтгэдэг байна. Хоол хүнсээр дамжин халдварлах өвчнийг судлах, муудсан болон хортой хоол хүнсийг худалдаанаас эргүүлэн татах зэрэг ажлуудад холбооны засгийн газрын харьяа дээрх болон холбогдох бусад агентлагууд нь муж, орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн газар болон хөдөө аж ахуйн газруудтай хамтарч ажилладаг байна.

Хүнсний аюулгүй байдал, хяналтын газар нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах агентлаг бөгөөд Холбооны махны хяналтын тухай хууль, Шувууны махан бүтээгдэхүүний хяналтын тухай хууль, Шувууны өндөгний хяналтын тухай хууль, Мал заазлах хүмүүнлэг аргын тухай хууль зэрэг хуулиудаар олгогдсон эрхийн хүрээнд үндэсний хэмжээнд мах, шувууны мах, өндгөөр хийсэн бүтээгдэхүүнүүд худалдаанд аюулгүй, эрүүл, зөв шошго, баглаа боодолтой нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавьдаг байна.

Тус газар нь дараах бүтэцтэй байна:¹⁰²

- Хүнсний аюулгүй байдлын алба
- Захиргааны алба
- Үндэсний хэмжээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэх алба
- Хяналт, хэрэгжилт, аудитын алба
- Нийгмийн эрүүл мэндийн шинжлэх ухааны алба
- Бодлого, хөтөлбөр боловсруулах алба
- Олон улсын хамтын ажиллагааны алба
- Олон нийттэй харилцах, хэрэглэгчийн боловсрол олгох алба

¹⁰² <https://www.fsis.usda.gov/contact-us/fsis-offices>

- Дотоод хяналтын алба
- Төлөвлөлт, дүн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын газар

Хүнс болон эмийн газар нь хүнсний бүтээгдэхүүн (Хүнсний аюулгүй байдал, хяналтын газраас хяналт тавьдаг мал болон шувууны мах, өндгөөр хийсэн бүтээгдэхүүнээс бусад)-ий аюулгүй, эрүүл, эрүүл ахуйн шаардлага хангасан, зохих шошго бүхий байх, гоо сайхны бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн нь аюулгүй, эрүүл болон зохих шошго бүхий байх, хүн болон мал амьтны эм, вакцин болон бусад биологийн бүтээгдэхүүнүүд, хүний хэрэгцээнд хэрэглэх эмнэлгийн хэрэгслүүд аюулгүй, үр дүнтэй байх зэрэгт хяналт тавьж иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үүргийг хэрэгжүүлдэг байна.

Тус газар нь дараах бүтэцтэй байна:¹⁰³

- Биологийн үнэлгээ, судалгааны төв
- Төхөөрөмж ба радиологийн эрүүл мэндийн төв
- Эмийн үнэлгээ, судалгааны төв
- Хүнсний аюулгүй байдал болон хэрэглээний шим тэжээлийн төв
- Тамхины бүтээгдэхүүний төв
- Малын эм, эмчилгээний бүтээгдэхүүний төв
- Хортой бодис судлалын үндэсний төв

Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төв нь холбооны засгийн газрын харьяа агентлагууд, хүнс үйлдвэрлэгч хоорондын хүнсний аюулгүй байдлын тогтолцооны уялдаа холбоог хангадаг байна. Төв нь хүнснээс шалтгаалах, хоол хүнсээр дамжих өвчний талаарх мэдээллийг нэгтгэх, бүртгэх, хоол хүнсээр дамжих өвчин, дэгдэлтийг судлах болон хоол хүнсээр дамжих өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах зэрэг чиг үүрэгтэй ажилладаг байна. Төв нь хүнснээс шалтгаалах өвчний тандалт, дэгдэлтийн хариу арга хэмжээ авах боломжийг нэмэгдүүлэх үүднээс мужийн болон орон нутгийн эрүүл мэндийн газруудад тархвар судлал, лаборатори, хүрээлэн буй орчны эрүүл ахуйг сайжруулах чадавхыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Хүнс, тэжээлийн газар нь хүүхэд болон тусламж шаардлагатай гэр бүлүүдэд хүнсний тусламж олгох, хүнсний тусламжийн хөтөлбөрүүдээр дамжуулан хүнс тэжээлийн тухай мэдлэг, мэдээлэл олгодог байна. Тус газраас “Нэмэлт тэжээлийн тусламжийн хөтөлбөр”, “Үндэсний ЕБС-ийн өдрийн хоол хөтөлбөр”-ийг улс орон даяар хэрэгжүүлдэг байна.

Хүрээлэн буй орчныг хамгаалах агентлаг нь ундны усны аюулгүй байдалд хяналт тавьж, ундны усыг хордуулж болзошгүй болон хүнсний бүтээгдэхүүнд үлдэж болох хортон шавьж, мэрэгчээс хамгаалах бодисын зохимжит хэмжээ болон хэрэглээг зохицуулдаг байна.

Үндэсний далай тэнгис ба агаар мандлын захиргааны Далайн хүнсний хяналтын хөтөлбөр нь хүнсний үйлдвэрүүдэд нийлүүлж буй загас, нялцгай биетэн, загасан бүтээгдэхүүнд хяналт тавьдаг байна.

Архи, тамхины татвар, худалдааны газар нь согтууруулах ундаа болон тамхины үйлдвэрлэл, импорт, бөөний худалдаа, шошго, сурталчилгааны асуудалд хяналт тавьдаг байна.

Холбооны худалдааны комисс нь хүнс, бараа бүтээгдэхүүний зар сурталчилгааны үнэн, зөв байдалд хяналт тавьдаг байна.

АНУ-ын гааль, хилийн хамгаалалт нь тус улсын хилээр орж, гарч байгаа бүх зүйлс АНУ-ын хууль, дүрэмд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьдаг байна.

¹⁰³ <https://www.fda.gov/about-fda/fda-organization/fda-organization-charts>

1.3 Төрөөс баримталж буй бодлого стратеги

АНУ-ын Хөдөө аж ахуйн яам 2022-2026 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөндөө “Бүх Америкчуудыг аюулгүй, тэжээллэг хүнсээр хангах” зорилгыг дэвшүүлжээ.

- Хүнс, хоол тэжээлийн аюулгүй байдлыг хангах;
- Хүүхдийг хоол тэжээлийн дутагдалд орохоос сэргийлэх, эрүүл мэндийг нь сахин хамгаалах;
- Эх болон нярай хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах үндсэн зорилгуудын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд,
 - Тэжээллэг, боломжийн өртөгтэй хоол хүнсээр тусламж, дэмжлэг үзүүлэх болон тэдгээрийг авах бусад боломжийг нээж өгөх замаар хүнсний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх;
 - Мэдээлэлд суурилсан, уян хатан, хэрэглэгчид чиглэсэн аргуудыг ашиглан эрүүл, зөв хооллолтыг дэмжих;
 - Хүнсээр дамжин халдварлах өвчлөлөөс урьдчилан сэргийлж, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зэрэг болно.

Холбооны Засгийн газрын агентлагууд хамтран болон дангаар үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хүнс, хүнсний аюулгүй байдал, хүнснээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх болон хоол тэжээлийн тусламж олгохтой холбоотой нэлээдгүй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаагаас, тухайлбал, хөдөө аж ахуйн фермерүүдийн үйл ажиллагаандаа мөрдөх стандартыг зохицуулсан “Үндэсний органик хөтөлбөр” (National Organic Program), “Фермүүдийг дэмжих хөтөлбөр”, ядуу буурай айл өрхүүдийг дэмжсэн “Нэмэлт тэжээлийн тусламжийн хөтөлбөр”, жирэмсэн болон бага орлоготой хөхүүл эхчүүд, тэдгээрийн 5-аас доош насны хүүхдэд зориулсан “Эмэгтэйчүүд, хүүхэд болон нярай хүүхдэд зориулсан тусгай, нэмэлт хоол тэжээлийн хөтөлбөр” (Special Supplemental Nutrition program for Women, Infants and Children), сургуулийн сурагчдад зориулсан “Үндэсний ЕБС-ийн өдрийн хоол хөтөлбөр”, “Тусгай сүү хөтөлбөр”, “Сургуулийн өглөөний цай хөтөлбөр”, сургууль дээрээ хөнгөлөлттэй үнээр/үнэгүй өглөөний цай, үдийн хоолонд хамрагддаг байсан хүүхдүүдэд Ковид-19 цар тахлын хөл хорионы үеэр “Цар тахлын үеэрх тэтгэмж хөтөлбөр”, зарим шаардлагатай өндөр настнуудыг дэмжсэн хоол хүнс гэрт нь хүргэх “Хоол хүргэлт хөтөлбөр” (Meal on Wheel), “Ахмад настнуудад зориулсан Фермийн бүтээгдэхүүн худалдан авах эрхийн тасалбар хөтөлбөр” (Senior Farmers’ Market Nutrition Program) болон “Хоол тэжээлийн хог хаягдлыг бууруулах хөтөлбөр” зэрэг болно.

АНУ нь дэлхийн улс орнуудыг хамарсан хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн тусламж үзүүлэх үйл ажиллагааг мөн хэрэгжүүлдэг бөгөөд тус улсын Засгийн газраас **“Дэлхийн хүнсний аюулгүй байдлын стратеги 2022-2026”**¹⁰⁴-г хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Энэ нь АНУ-ын Засгийн газрын бүхий л салбарыг хамарсан, дэлхийн улс орнуудын өлсгөлөн, ядуурал, хоол тэжээлийн дутагдлыг арилгах “Ирээдүйгээ хүнс тэжээлээр хангая санаачлага” (Feed the Future Initiative)-аар дамжин хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Энэ нь 2016 онд батлагдсан “Дэлхийн хүнсний аюулгүй байдлын тухай хууль”-д заасны дагуу хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үргэлжлэл бөгөөд дэлхийн улс орнуудыг өлсгөлөн ядуурлаас аврах боломж буйг тодорхойлсон байна. Хэрэгжүүлж эхэлснээс хойш “Ирээдүйгээ хүнс тэжээлээр хангая санаачилга”-ын хүрээнд 23.4 сая хүн туйлын ядуу байдлаас ангижирч, өлсгөлөнгөөс болж өсөлт нь зогссон 3.4 сая хүүхэд хүнд байдлаас гарч, 5.2 сая гаруй гэр бүл өлсгөлөнгөөс ангид амьдарч байна.


¹⁰⁴ https://cg-281711fb-71ea-422c-b02c-ef79f539e9d2.s3.us-gov-west-1.amazonaws.com/uploads/2021/10/Global-Food-Security-Strategy-FY22-26_508C.pdf

2.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

БНСУ-нь 2020 оны байдлаар дэлхийд 10-т орох том эдийн засагтай улс бөгөөд ДНБ нь 1.6 их наяд ам.доллар-т (GDP) хүрч, нэг хүнд ногдох Үндэсний нийт орлого GNI (Gross national income) 31.755 ам.доллартай тэнцэж байна. Солонгосын иргэдийн 90 гаруй хувь нь томоохон хотуудад амьдардаг ба хүнсний хэрэгцээний 45 хувийг дотоодын үйлдвэрлэл нь хангадаг.¹⁰⁵

БНСУ-ын хэрэглэгчдэд чиглэсэн импортын бүтээгдэхүүн: Солонгос 2020 онд 14.8 тэрбум ам.долларын хэрэглэгчдэд чиглэсэн бүтээгдэхүүн импортолсон нь хөдөө аж ахуйн импортын 41 хувийг эзэлж байна. Хэрэглэгчдэд чиглэсэн хөдөө аж ахуйн хүнсний гол бүтээгдэхүүнд үхрийн мах, гахайн мах, жимс жимсгэнэ, модны самар, сүүн бүтээгдэхүүн, чихэр, ундаа, цаашлаад бэлтгэсэн хүнсний бүтээгдэхүүнүүд багтдаг байна.

БНСУ-д хэрэглэгчдэд чиглэсэн хөдөө аж ахуйн хүнсний бүтээгдэхүүн импортолж буй голлох улсууд



Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй үйлдвэрүүд: Солонгос Улс 2020 оны байдлаар 35.000 гаруй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэртэй болж, 56 тэрбум ам.долларын борлуулалт хийсэн байна. Солонгосын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниуд нь импортын бүтээгдэхүүн, орц найрлага түүхий эдээс ихээхэн хамаардаг байна. Хөдөө аж ахуйн үндсэн болон завсрын бүтээгдэхүүний импорт 2020 онд 13.4 тэрбум ам.долларт хүрсэн байна.


Хүнсний жижиглэнгийн худалдаа: Солонгосын хүнсний жижиглэнгийн борлуулалт 2020 онд нийт 103 тэрбум ам.долларт хүрсэн нь нийт жижиглэнгийн худалдааны 29 хувийг эзэлж байна. Хүнсний супермаркетууд нь хүнсний жижиглэнгийн худалдааны тэргүүлэгч борлуулагчид бөгөөд дараа нь онлайн жижиглэн худалдаачид, том хэмжээний хайпармаркетууд, энгийн дэлгүүрүүд, их дэлгүүрүүд ордог байна. Ирэх 5-10 жилийн хугацаанд онлайн жижиглэнгийн худалдаачид болон дэлгүүрүүд бусад сувгуудаас илүү хурдан өсөх төлөвтэй байна. Онлайн худалдаачдын хурдацтай өргөжиж байгаа нь ердийн жижиглэнгийн худалдааны сувгуудын орон зайн бүтцийг өөрчлөх, хэрэглэгчдийн урсгалыг татах шинэ стратеги боловсруулахад хүргэж байна.

БНСУ-ын Экспортын хүнсний бүтээгдэхүүн: БНСУ-ын Гаалийн албаны статистик мэдээгээр, Солонгосын хүнсний бүтээгдэхүүний экспорт 2020 онд 4.3 тэрбум ам.долларын тээвэрлэлт хийсэн байна. Солонгосын нийт экспортын барааны хэмжээ буурсан хэдий ч хүнсний экспортын хэмжээ (14.6%) түүхэндээ байгаагүй хамгийн өндөр өсөлтөд хүрсэн байна. Тодруулбал, цагаан будааны бүтээгдэхүүн 53.3%-аар өсөж 37 сая ам.доллар, рамен 29.9%-аар өсөж 604 сая ам.долларт хүрчээ. БНСУ 1960-аад оноос далайн гаралтай бүтээгдэхүүн, будаа зэрэг хүнсний бүтээгдэхүүн экспортолж эхэлсэн байна. 1988 оны

¹⁰⁵ Exporter Guide, Sangyong OhOctober 14, 2021

Сөүлийн олимп, 2002 оны Хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний дараа Солонгосын хүнсний бүтээгдэхүүнүүд бусад улс руу экспортлох хэмжээ, чанарыг нэмэгдүүлсэн ба дэлхий даяар кимчи, рамен, архины эрэлтийг бий болгосон. 2019 онд хүнсний бүтээгдэхүүний экспорт Солонгосын нийт экспортын ердөө 1.2%-ийг л эзэлж байгаа нь дунджаар 7.7%-ийн хүнсний бүтээгдэхүүн экспортолдог бусад орнуудтай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт юм. Гэсэн хэдий ч Солонгосын хүнсний бүтээгдэхүүний экспорт тогтмол нэмэгдсээр байна.¹⁰⁶

2012-2020 оны хооронд Өмнөд Солонгосоос экспортолсон хүнсний үнэ (тэрбум доллараар)¹⁰⁷



2020 онд Өмнөд Солонгосын хүнсний экспортын үнэ 7.98 тэрбум ам.доллар болж, өмнөх оны үзүүлэлтээс ойролцоогоор 0.31 тэрбум ам.доллараар өссөн байна. БНСУ-ын экспортын хэмжээ 2012 оноос жил бүр тогтвортой өссөөр байна.

Ковид-19 Цар тахлын үед Солонгос Улсын хүнсний экспорт тасралтгүй өссөн ба тэр дундаа Кимчи, рамен (Бэлэн хоол)-ын экспортын хэмжээ онцгой өссөн байна. Солонгос Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас 2020 онд 01 дүгээр сараас 08 дугаар сарын хооронд хөдөө аж ахуйн хүнсний бүтээгдэхүүний экспортын хэмжээ 4.9 хувиар өссөн (4.9 сая ам.доллар) хэмээн зарласан ба тэр дундаа кимчиний экспортын хэмжээ хамгийн их буюу 40.3 хувь (97.9 сая ам.доллар) ба түүний дараа рамен 36.7 (89.1 сая ам.доллар) хувь тус тус өссөн байна.

2.1.БНСУ-ын хүнсний тухай хууль тогтоомж, дүрэм журам

Хүнсний аюулгүй байдал болон хүнсний бусад эрүүл ахуйн шаардлага

БНСУ-ын хүнсний салбарыг зохицуулах хамгийн голлох үүрэгтэй гол яам нь Хүнс, эмийн аюулгүй байдлын яам (MFDS) юм. Тус яамны үндсэн үүрэг нь хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, улмаар хүнсний аюулгүй байдалтай холбоотой бүхий л шаардлага тэр дундаа хөдөө аж ахуй малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн, импортын хүнсний бараа зэрэгт хяналт тавьж зохицуулах үүрэгтэй байна. Тодруулбал, Хүнс, эмийн аюулгүй байдлын яам дараах голлох хууль болон стандартуудаар хүнсний харилцааг зохицуулдаг байна.

¹⁰⁶ Korean food export highlights <https://keia.org/the-peninsula/koreas-food-exports-reach-new-highs/>

¹⁰⁷ <https://www.statista.com/statistics/780427/south-korea-food-export-value/#:~:text=In%202020%2C%20the%20export%20value,value%20increased%20throughout%20the%20years.>

- **Хүнсний ариун цэврийн тухай хууль**¹⁰⁸ (The Food Sanitation Act): Тус хуулийн зохицуулалтууд нь хүнсний аюулгүй байдлыг хангах гол үндэс болдог байна. Мөн үүн дээр Баяжуулсан хүнсний тухай хууль нэмэгддэг ба энэ нь баяжуулсан хоол хүнс, тэр дундаа эрүүл хоол хүнс, нэмэлт тэжээлд хяналт тавих эрх зүйн үндсийг бүрдүүлдэг.
- **Импортын хүнсний аюулгүй байдлын удирдлагын тухай тусгай хууль** (Special Act on Imported Food Safety Management): Импортын хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой бодлого, эрх зүйн орчинг уг хуулиар зохицуулдаг байна. Тус хуулийг 2016 онд шинэчлэн найруулсан ба бусад хууль тогтоомжид тархсан импортын хүнсний бүх зохицуулалтыг нэгтгэсэн. Өмнө нь бусад хууль тогтоомжид байгаагүй онцлох шинэ заалт болох хүнсний гадаад байгууллагуудыг урьдчилан бүртгүүлэх зүйл заалт нэмэгдсэн байна.
- **Хүнсний код** (Food Code): Уг кодоор хүнсний үйлдвэрлэл, боловсруулалт, хэрэглэх, хадгалах стандартуудыг тусгасан байдаг байна. Түүнчлэн хөдөө аж ахуйн химийн бодис, мал эмнэлгийн эмийн үлдэгдлийн дээд хэмжээ, цацраг идэвхт туяаны стандарт, бохирдуулагч бодис зэргийг зааж өгсөн байна.

Мөн дээрх голлох хуулиудаас гадна хүнсний эрүүл ахуйн шаардлага, бусад харилцааг дараах хууль, стандартаар зохицуулдаг.

- **Хүнсний нэмэлт орцны код** (The Food Additive Code¹⁰⁹): Тус кодоор хүнсний бүтээгдэхүүнд орж буй нэмэлт орц, стандарт үзүүлэлтүүдийг тодорхойлсон байдаг.
- **Импортын хүнсний бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх заавар** (Inspection Guidelines for Imported Food): Импортын хүнсний бүтээгдэхүүний хяналт шалгалт хийх хуудас байдаг ба дээж авах, шалгах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байна.
- **Хүнсний баяжуулсан бүтээгдэхүүний код** (The Functional Food Code) стандарт хэмжээг хангасан эсэхийг шалгана.
- **Хүүхдийн хүнсний зохистой хэрэглээний тухай хууль** (The Special Act on Children's Dietary Life Safety Management): Хүүхдийн хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүнд голлон хяналт тавьдаг ба зарим илчлэг ихтэй, кофейн өндөртэй хүнсний бүтээгдэхүүний борлуулалт болон олон нийтийн сурталчилгаа зэргийг хязгаарладаг байна.
- **Малын гаралтай бүтээгдэхүүний ариун цэврийн тухай хууль** (The Livestock Product Sanitary Management Act): Мал аж ахуйн бүтээгдэхүүний ариун цэврийн зохицуулалт эрх зүйн үндэс болдог байна.
- **Бараа тэмдэгтийн тухай стандарт** (Labelling standards): Ерөнхий шошгын стандартаас гадна хүнс, малын гаралтай бүтээгдэхүүний нэмэлт стандартууд багтдаг байна.

Согтууруулах ундааны татварын тухай хууль (The Liquor Tax Act) нь мөн хүнсний импортын зохицуулалттай холбогддог ба Үндэсний татварын алба согтууруулах ундаанд тавигдах татварын хэмжээг тогтоодог байна. Согтууруулах ундаа импортлох, экспортлохыг хүссэн худалдаа эрхлэгч, аж ахуйн нэгж Үндэсний татварын албанаас согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл авах ёстой байна. Энэхүү зөвшөөрөлгүй тохиолдолд согтууруулах ундаа импортлох, экспортлохыг хориглоно.

¹⁰⁸ https://www.mfds.go.kr/eng/brd/m_15/list.do

¹⁰⁹ <https://www.foodsafetykorea.go.kr>

Хүнсний аюулгүй байдал, хүнсний бусад харилцааг зохицуулах голлох хуулиуд¹¹⁰

Хуулийн нэр	Агуулга	Хариуцах буй байгууллага
Малын гаралтай бүтээгдэхүүн ариун цэврийн хяналтын тухай хууль (Livestock Products Sanitary Control Act)	- Мал аж ахуйн амьтдын нядалгаа, мах бэлтгэлийн ариун цэвэр, эрүүл ахуйн хяналт - Мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, тайлан - Хүнсний аюулгүй байдлын системийн ажиллагаа - Стандартын шошго, малын гаралтай бүтээгдэхүүний тодорхойлолт гэх мэт	Хөдөө аж ахуй, загасны бүтээгдэхүүний бодлогын хэлтэс (Agro-livestock and Fishery Products Policy Division)
Хөдөө аж ахуй, загасны бүтээгдэхүүний чанарын хяналтын тухай хууль (Agricultural and Fishery Products Quality Control Act)	Хөдөө аж ахуй, загасны бүтээгдэхүүний аюулгүй байдлын шинжилгээ	Хөдөө аж ахуй, загасны аж ахуйн бүтээгдэхүүний аюулгүй байдлын хэлтэс (Agricultural and Fishery Products Safety Division)
Хүнсний ариун цэврийн тухай хууль (Food Sanitation Act)	Хөдөө аж ахуй, загас агнуурын бүтээгдэхүүний хяналт, импортын загасны бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх холбогдох журам	Хяналтын хэлтэс, Хөдөө аж ахуй, загасны бүтээгдэхүүний аюулгүй байдлын хэлтэс (Foreign Inspection Division, Agricultural and Fishery Products Safety Division)
Импортын хүнсний аюулгүй байдлын удирдлагын тухай тусгай хууль (Special Act on Imported Food Safety Management)	Хүнсний гадны байгууллагуудын хяналт шинжилгээ, зөвшөөрөл	Гадаад байгууллагуудын хяналтын хэлтэс (Foreign Inspection Division)
Хүнс, эмийн шинжилгээ, хяналтын тухай хууль (Law regarding test and inspection on food and drug)	Малын гаралтай бүтээгдэхүүнийг шинжлэх, шалгах журам	Малын ариун цэврийн аюулгүй байдлын хэлтэс (Livestock Sanitation Safety Division)

2.2. БНСУ-ын Хүнсний аюулгүй байдал, хяналтын байгууллага

БНСУ-ын Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортыг хянах, зохицуулах үйл явцыг хэд хэдэн байгууллага хариуцан ажилладаг. Үүнд:

- **Солонгосын гаалийн алба** (the Korea Customs Service)
- **Хүнс, эмийн аюулгүй байдлын яам** (the Ministry of Food and Drug Safety)
- **Хүнс, хөдөө аж ахуй, орон нутгийн яам** (the Ministry of Agriculture, Food and Rural Affairs)
- **Амьтан, ургамлын хорио цээрийн газар** (the Animal and Plant Quarantine Agency)

Хүнсний импортын бараа бүтээгдэхүүний шаардлага, хязгаарлалт

Импортын хүнсний бүтээгдэхүүн оруулж ирэхээс өмнө дараах хоёр төрлийн бүртгэлийг хийдэг.

- **Хилийн чанад дахь үйлдвэрийн бүртгэл**- Хэрэв хүнсний бүтээгдэхүүн импортлох бол гадаадад үйлдвэрлэж буй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрийн нэр, хаяг, үйлдвэрлэсэн барааны импортын зөвшөөрөл олгохоос өмнө Хүнс, эмийн аюулгүй байдлын яаманд бүртгүүлсэн байх ёстой. Малын гаралтай бүтээгдэхүүн импортлох гэж байгаа тохиолдолд Хүнс, эмийн аюулгүй байдлын яам, Хүнс, хөдөө аж ахуй, орон нутгийн яаманд (MFDS/MAFRA) тус тус бүртгүүлэх өргөдөл гаргах ёстой.

¹¹⁰ https://www.mfds.go.kr/eng/wdae/m_9/denofile.do

- **Бизнесийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэл**- Солонгост хүнсний бүтээгдэхүүн оруулж ирж байгаа аж ахуйн нэгжид шаардлагатай.

Бүртгэл амжилттай дууссаны дараа Импортод тавигдах шаардлагыг агуулсан мэдүүлэг гаргадаг байна.

- (1) ерөнхий шаардлага (бүх импортын бүтээгдэхүүнд хамаарна);
- (2) хөдөө аж ахуйн хүнсний импортын тусгай шаардлага.

Уг шаардлагад боомтоор нэвтрэх мэдэгдэл, гаалийн импортын мэдүүлэг, үнэ тоо хэмжээн мэдээлэл, тухайн бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, амьтны гаралтай бүтээгдэхүүний зөвшөөрлийн бичиг, бусад бүтээгдэхүүнд хамааралтай эрүүл ахуйн шаардлага хангасан сертификатууд ордог байна.

Эдгээр шаардлагуудаас гадна тодорхой бүтээгдэхүүнд тавигдах зарим тусгай шаардлагууд байдаг. Үүнд мах, жимс, хүнсний ногоо ордог ба үхрийн маханд таних тусгай дугаар тавигдах шаардлагатай байдаг байна.

Солонгост анх удаа оруулж ирж буй аливаа хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн шинжилгээ заавал авдаг бөгөөд энэ нь бүтээгдэхүүнээс хамаарч өөр өөр байдаг. Эдгээр эрүүл ахуйн шинжилгээг таван жил тутам давтан хийнэ.

Бараа тэмдэгтийн (шошго) шаардлага

БНСУ-ын бараа тэмдэгтийн шаардлагатай холбоотой 5 түлхүүр шаардлага байдаг байна. Үүнд:

- Хүнсний бүтээгдэхүүний бараа тэмдэгтийн стандарт
- Малын гаралтай бүтээгдэхүүний бараа тэмдэгтийн стандарт
- Боловсруулаагүй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бараа тэмдэгтийн стандарт
- Согтууруулах ундааны бараа тэмдэгтийн стандарт
- Улсын гаралтай бүтээгдэхүүний стандарт

1. Хүнсний бүтээгдэхүүний бараа тэмдэгтийн стандарт нь импортын хүнсний бүтээгдэхүүнд дагаж мөрдөх ёстой хууль тогтоомжийн гол хэсэг юм. Уг стандартын дагуу импортын бүх хүнсний бүтээгдэхүүнд Солонгос хэл дээр бичигдсэн гаргацтай шошго байх ёстой бөгөөд эдгээр шошго нь уг бүтээгдэхүүний анхны шошгыг халхлах ёсгүй, мөн амархан салж хуулахгүй байх ёстой. Шошго нь дараах зүйлийг агуулсан байна.

- Бүтээгдэхүүний нэр
- Бүтээгдэхүүний төрөл
- Импортлогчийн нэр, хаяг
- Үйлдвэрлэсэн огноо (зарим төрлийн бүтээгдэхүүний хувьд)
- Найрлагын нэр ба агуулга
- Бүтээгдэхүүний орцод аливаа бодис 5%-аас дээш хувийг эзэлдэг бол нийлмэл орц бэлтгэхэд ашигласан орцын нэрс оруулах
- Нэмэлтүүд (Хүнсний нэмэлтийн дүрэмд заасан бүтэн буюу товчилсон нэр)
- Харшил үүсгэгч бодис (хамгийн бага түвшинд байсан ч оруулна)
- Шим тэжээл

2. Малын гаралтай бүтээгдэхүүний бараа тэмдэгтийн стандарт нь (мах, болон дайвар бүтээгдэхүүн) Солонгост импортолж буй бусад хүнсний бүтээгдэхүүнд тавигдах ерөнхий шаардлага:

- Нэр, хаяг: зөвхөн импортлогчийн нэр, хаяг төдийгүй экспортлогч улсын боловсруулах үйлдвэрийн хаяг шаардлагатай байна.
- Үйлдвэрлэсэн огноо хадгалах хугацаа шаардлагатай.
- Ихэнх сүүн бүтээгдэхүүн болон ихэнх боловсруулсан махан бүтээгдэхүүнд шим тэжээлийн шошготой байна.

3. Боловсруулаагүй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бараа тэмдэгтийн стандарт: Генийн өөрчлөлттэй холбоотой заалтуудыг агуулсан шошготой байх бөгөөд тодорхой нөхцөлд хувиргасан амьд организмын мэдээлэл байх.

4. Согтууруулах ундааны бараа тэмдэгтийн стандарт: Согтууруулах ундаанд агуулагдах хүний биед хортой, хавдар үүсгэх эрсдэлтэй гэдгийг анхааруулсан санамж бичигтэй байх.

5. Улсын гаралтай бүтээгдэхүүний стандарт: ХАА-н бүтээгдэхүүн гарал үүслийг нь тодорхойлсон байх шаардлагатай байдаг (зарим бүтээгдэхүүнд) ба үүнд: Зах зээлд нэвтрэхийн тулд улс орнуудтай тохиролцсон стандартуудыг хангасан байх (жишээлбэл, хүнсний шинжилгээнд хамрагдсан мах, шинэ жимс, хүнсний ногоог батлах хуудас агуулсан байх) гарал үүслийн улсын шошготой байна.

2.3 БНСУ-ын хүнсний аюулгүй байдлын систем

Хүнс, эмийн аюулгүй байдлын яам нь аюулгүй хүнсээр ард иргэдийг хангахын тулд хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгосон байна. Дотоодын хүнсний бүтээгдэхүүнийг:

- үйлдвэрлэх;
- түгээх;
- хэрэглэх гэсэн гурван үе шаттайгаар зохицуулдаг байна.

	Үйлдвэрлэл (Manufacturing)	Түгээлт (Distribution)	Хэрэглээ (Consumption)
Хүнсний аюулгүй байдал (төрөл)	Боловсруулсан хоол хүнс, хүнсний нэмэлт орц, баяжуулсан хүнс (Нийт 35.000 орчим хүнсний үйлдвэртэй)	Газар тариалан, Мал аж ахуй, загасны бүтээгдэхүүн. Боловсруулсан хоол хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн (Нийт 31.000 импортлогч байгууллага)	Хоол, зоогийн газруудад бэлтгэсэн хоолон бүтээгдэхүүн (Нийт 817.000 Зоогийн газар)
Хүнсний аюулгүй байдлын арга зүй	<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэж буй хүнсний бүтээгдэхүүнийг мэдээлэх, • Чанарын шаардлага Тухайн байгууллагын өөрийн хяналтын систем, • Хортой хүнснээс урьдчилан сэргийлэх систем (НАССР system) 	<ul style="list-style-type: none"> • Түгээсэн хүнсний бүтээгдэхүүнийг цуглуулах, шалгах • Хүнсний түгээлтийг хянах систем, хортой хүнсний борлуулалтыг хориглох систем 	<ul style="list-style-type: none"> • Худал агуулгатай зар сурталчилгааны хяналт • Хэрэглэгчийн хүнсний ариун цэврийн байцаагч хяналт тавих
Хүнсний аюулгүй байдлыг хариуцаж буй байгууллага	<ul style="list-style-type: none"> • Хүнс, эмийн аюулгүй байдлын яам • Орон нутгийн засаг захиргаа 	<ul style="list-style-type: none"> • Хүнс, эмийн аюулгүй байдлын яам • Орон нутгийн засаг захиргаа 	<ul style="list-style-type: none"> • Хүнс, эмийн аюулгүй байдлын яам • Орон нутгийн засаг захиргаа

ХОРТОЙ ХҮНСНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СИСТЕМ (НАССР СИСТЕМ)

(Hazard Analysis Critical Control Point) System

Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилготой шинжлэх ухаанд суурилсан, урьдчилан сэргийлэх удирдлагын систем болох ХХУСС нь түүхий эдээс эхлээд хүнсний үйлдвэрлэл, боловсруулалт, хоол хийх, түгээх үйл явц хүртэл үүсэж болзошгүй хортой элементүүдийг шалгаж, үнэлж, удирдан чиглүүлдэг систем юм.

Үүнд, аюулд хүргэж болзошгүй бүх биологи, химийн болон физик хүчин зүйлсийн дүн шинжилгээ, хортой элементүүдээс урьдчилан сэргийлэх, устгах эсвэл хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах арга хэмжээ авдаг байна. Хүнсний үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн аюулгүй байдлын түвшинг бэхжүүлэхийн тулд Хүнс, эмийн аюулгүй байдлын яам нь 2002 онд батлагдсан "Хүнсний ариун цэврийн тухай хууль"-д ХХУСС ((Hazard Analysis Critical Control Point) System) -ийг заавал хэрэглэхийг тусгасан байдаг байна. Энэхүү системд дараах 6 төрлийн хүнсний бүтээгдэхүүн заавал шалгуулсан байх ёстой байна.

- боловсруулсан загасны бүтээгдэхүүн
- хөлдөөсөн далайн бүтээгдэхүүн
- хөлдөөсөн хоол (пицца, банш, гоймон)
- зайрмаг
- ундаа
- боловсруулсан бүтээгдэхүүн

((Hazard Analysis Critical Control Point) System) нь Хүнс, эмийн аюулгүй байдлын яамны удирдлага дор хэрэглэгчдэд сургалт сурталчилгаа явуулах, техникийн дэмжлэг үзүүлэх, мөн сайн дурын үндсэн дээр байгууллагууд уг системээс магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авдаг байна.

3. ЯПОН УЛС

Япон Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 5.1 их наяд ам.доллар бөгөөд дэлхийд гуравдугаарт жагсдаг орон юм. Хүнсний аюулгүй байдал гэдэг нь Япон Улсын хувьд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар дотоодын хүнсний хэрэгцээгээ хангах чадвараа дээшлүүлэх явдал юм. 2020 онд хүнсний хэрэгцээг дотооддоо хангах түвшин 37% байгаа нь өмнөх оны мөн үеэс нэг хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь хүнсний голлох бүтээгдэхүүн болох цагаан будааны ургац буурснаас шалтгаалж байна гэж үзжээ.

3.1. Хууль эрх зүйн зохицуулалт

Япон Улс хүнсний талаарх нийтлэг асуудлыг дараах хуулиуд болон холбогдох дүрэм журмаар зохицуулж байна.

- **Хүнсний эрүүл ахуйн тухай хууль (Food Sanitation Act)**¹¹¹ нь 1947 онд батлагдсан нийтдээ 11 бүлэг 89 зүйл заалттай байна.

Хуулийн зорилго: Ард нийтийн эрүүл мэндийг сахин хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангах, түүнээс шалтгаалж иргэдийн эрүүл мэндэд хор хөнөөл, хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх болон зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилготой байна.

Уг хуулиар:

- Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, импортлох, борлуулах, хадгалах;
- Хүнсний бүтээгдэхүүний орц найрлага (нэмэлт бодис, хадгалагч бодис, нэмэлт химийн элемент гэх мэт);

¹¹¹ Food Sanitation Act <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3687>

- Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын стандарт;
- Хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулах шошго, шошгоны стандарт;
- Хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаа
- Холбогдох хяналтын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа;
- Хяналт үнэлгээ хийх байгууллагын бүтэц, чиг үүрэг;
- Хүнсний эрүүл ахуйд онцгой анхаарах зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, хадгалах, худалдаах стандарт;
- Хүлээлгэх үүрэг хариуцлага, ял шийтгэл зэргийг зохицуулж байна.

- **Хүнсний аюулгүй байдлын тухай хууль (Food Safety Basic Act)**¹¹² нь 2003 онд батлагдсан нийтдээ 3 бүлэг 38 зүйл заалттай байна.

Хуулийн зорилго: Төрөөс хүнсний аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх бодлого зорилт болон шинжлэх ухаан, технологийн ахиц дэвшил, хүрээлэн буй орчны өөрчлөлт зэрэгт хариу арга хэмжээ авах нэгдсэн нэг бодлогоор хангахад зорилго оршино.

Уг хуулиар:

- Хүнсний аюулгүй байдлыг хангах, авч хэрэгжүүлэх арга хэмжээ;
- Хүнсний аюулгүй байдлыг хангах Үндэсний бодлого, хэрэгжилт;
- Хүнсний аюулгүй байдлын хороо, чиг үүргийг зохицуулж байна.

2018 онд тус хуульд:

- Хүнсний бүтээгдэхүүнээс хордлого авсан үед авах арга хэмжээ;
- Хүнсний бизнес эрхлэгчдэд зориулсан хүнсний эрүүл ахуйн хяналтыг сайжруулах;
- Зөвшөөрөгдсөн хэмжээ найрлага орцтой бүтээгдэхүүн хэрэглэсэн ч эрүүл мэндэд хохирол учирсан үеийн арга хэмжээ;
- Хүнсний сав баглаа, боодлын стандартыг шинэчлэх;
- Хүнсний бизнес эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн тогтолцоог хянах үйл ажиллагааг сайжруулах;
- Хүнсний бүтээгдэхүүн эргүүлэн татах үйл ажиллагаа;
- Импорт, экспортын хүнсний аюулгүй байдлын гэрчилгээг сайжруулах гэсэн 7 чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

- **Хүнс, хөдөө аж ахуйн тухай хууль (Basic Act on Food, Agriculture and Rural Area)**¹¹³ нь 1999 онд батлагдсан 4 бүлэг 43 зүйл заалттай байна.

Хуулийн зорилго: Хүнс, хөдөө аж ахуйн, орон нутагт чиглэсэн Үндэсний эдийн засгийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж ард иргэдийн хүнсний тогтвортой хангамжийг бэхжүүлэхэд зорилго оршино. Уг хуулиар:

- Хүнс, хөдөө аж ахуйн Үндсэн төлөвлөгөө;
- Хүнсний тогтвортой хангамжийг хангах арга хэмжээ;
- Хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх арга хэмжээ;
- Хөдөө орон нутгийг тогтвортой хөгжүүлэх арга хэмжээ
- Төр, орон нутгийн захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг тодорхой болгох зэргийг зохицуулж байна.

Холбогдох хуулиуд: Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуйн тодорхой бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний нэрийг хамгаалах тухай хууль (Act on Protection of Names of Specific Agricultural, Forestry and Fishery Products and Foodstuffs), Хүнсний шошгоны тухай хууль (Food Labeling Act), Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй, хүнсний бүтээгдэхүүний

¹¹² Food Safety Basic Act <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3757>

¹¹³ Basic Act on Food, Agriculture and Rural Area <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3994>

экспортыг дэмжих тухай хууль (Act on Facilitating the Export of Agricultural, Forestry, and Fishery Products and Food),

Хоол тэжээлийн тухай хууль (Basic Act on Shokuiku (Food and Nutrition Education), Эрүүл мэндийг дэмжих тухай хууль (The Health Promotion Law) гэсэн хуулиуд байна.


3.2. Хүнсний аюулгүй байдлын Комисс (Food Safety Commission of Japan)¹¹⁴

Комиссын бүтэц

2003 онд Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэдэх Хүнсний аюулгүй байдлын комиссыг байгуулж, тус хороо нь 7 гишүүнтэй бөгөөд 3 жилийн хугацаатайгаар хоёр танхимын зөвшөөрлөөр Ерөнхий сайд томилдог байна. Хүнсний аюулгүй байдлын комисс нь 16 салбар хэсэг (төлөвлөлт, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн химийн бодис, мал эмнэлгийн эм, шошго сав баглаа боодол, бохирдуулагч бодис, бичил биетэн, прион, микотоксин, генийн өөрчлөлттэй хоол хүнс, шинэ бүтээгдэхүүн, бордоо тэжээл, үнэртэнд тэсвэртэй нянгийн эсрэг, эмэнд тэсвэртэй нянгийн эсрэг, хоол тэжээлийн найрлагатай нэмэлт бүтээгдэхүүн болон үнэлгээний технологийн төлөвлөлтийн ажлын хэсэг) бүхий 200 гаруй ажилтнаас бүрдэж хүний эрүүл мэндэд үзүүлэх хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн шинжилгээг шинжлэх ухааны баримт нотолгоотой хийдэг эрсдэлийн үнэлгээний байгууллага юм.

Үйл ажиллагааны чиг үүрэг:

- Хүнсний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх;
- Нөлөөллийн үнэлгээний үр дүнг Ерөнхий сайдад танилцуулж, авах арга хэмжээний зөвлөмжийг холбогдох сайдад хүргүүлэх;
- Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх санал зөвлөмжийг холбогдох захиргааны байгууллагуудад хүргүүлэх;
- Хүргүүлсэн санал зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин тайланг холбогдох сайдад хүргүүлэх;
- Шинжлэх ухааны нотолгоо баримттай судалгаа шинжилгээ хийдэг байна.



Эх сурвалж: https://www.fsc.go.jp/english/what_we_do.html

¹¹⁴ Food Safety Commission of Japan <https://www.fsc.go.jp/english/aboutus/>

3.3 Төрөөс баримталж буй бодлого стратеги

Хүнс, хөдөө аж ахуйн үндсэн бодлого

Хүнс нь хүний оршин тогтнох, эрүүл, сэтгэл хангалуун амьдрахын үндэс суурь болдог учраас чанартай хүнсний бүтээгдэхүүнийг тогтвортой үнээр хангахын тулд “Хүнс, хөдөө аж ахуйн Үндсэн бодлого”-ыг Засгийн газраас 5 жил тутам шинэчлэн боловсруулдаг байна. Уг бодлогод:

- Дэлхийн хүнсний эрэлт, нийлүүлэлт, худалдаа тогтворгүй байх зэргээс шалтгаалан хүнсний тогтвортой хангамжийн үндэс болсон дотоодын хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, нийлүүлэлт, импорттой хослуулан иргэдийн хүнсний хангамжийг тогтвортой байлгаж, хүнсний нөөц бүрдүүлэх;
- ХАА-н бүтээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрүүдийг цогцоор нь хөгжүүлэх;
- Цаг үеийн асуудлаас шалтгаалан дотоодын хүнсний хомсдол нь эдийн засагт нөлөөлөхгүй байх тал дээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэргийг тусгасан байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний бодлого

Хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг боловсруулахдаа биологи, хими, физикийн хор хөнөөл учруулж болзошгүй хүчин зүйлийн талаар “Хүнсний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ”-г Хүнсний аюулгүй байдлын Комисс хийж, түүний үр дүнг Ерөнхий сайд болон холбогдох сайд нарт танилцуулсан санал зөвлөмжийн дагуу хүнсний аюулгүй байдлыг хангах Үндэсний бодлогыг боловсруулдаг байна.

Хүнсний тогтвортой тогтолцооны стратеги (Strategy for Sustainable Food Systems)¹¹⁵

2021 онд Инновац боломжуудыг ашиглан хүнсний тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд “Хүнсний тогтвортой тогтолцооны стратеги”-ийг боловсруулж Хүнсний хангамжийг бүрдүүлэгч талуудын оролцоог нэмэгдүүлэх, Байгаль орчны ачааллыг бууруулах инновацыг дэмжих гэсэн 2 гол зорилт дэвшүүлэн дараах ажлуудыг төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

- Хортон шавьжтай тэмцэх нэгдсэн менежментийг бий болгож, хортон шавьж устгах химийн бодисын хэрэглээг 50% бууруулах;
- Химийн бордооны хэрэглээг 30% бууруулах;
- Органик газар тариаланг нэмэгдүүлэх;
- Хүнс үйлдвэрлэгчдийн бүтээмжийг дээшлүүлэх;
- Импортын материалын тогтвортой нөөцийг бүрдүүлэх;
- Шилэгдмэл үрээр ой модыг 90% нэмэгдүүлэх;
- Могой загас, туна загасны хиймэл үржүүлгийн хэмжээг 100% нэмэгдүүлэх зэрэг зорилт тавин ажиллаж байна.

4. ИБУИНХУ

Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын тоонд зүй ёсоор орох Их Британи, Умард Ирланды Нэгдсэн Хаант Улс нь ДНБ-ний хэмжээгээр 5 дугаарт ордог. ИБУИНХУ-ын дотоодын ний бүтээгдэхүүн 2022 оны сүүл үед 3.40%-д хүрэх төлөвтэй байгаа бөгөөд 2023 онд 2.50%, 2024 онд 2.30%-д хүрэх магадлалтай байна. Түүнчлэн тус улсын ДНБ-ний 79%-ийг үйлдвэрлэлий салбар бүрдүүлдэг. ИБУИНХУ нь автомашин, нисэх онгоц, нэхмэл, эмийн үйлдвэрлэл түлхү хөгжсөн үйлдвэрлэгч улс юм. ИБУИНХУ-ын хүнсний инфляц нь 2023 онд 2.00%, 2024 онд

¹¹⁵ Strategy for Sustainable Food Systems https://www.maff.go.jp/e/policies/env/env_policy/meadri.html

1.90% болох төлөвтэй байна гэж Худалдааны эдийн засаг (Trading Economics)¹¹⁶ болон олон улсын шинжээчид үзэж байна. ИБУИНХУ нь дотоодын үйлдвэрлэлээрээ хүнсний зах зээлийн 75%-ийг дангаар эзэлдэг бөгөөд хүнсний зах зээлийн үлдсэн хувийг импортын бүтээгдэхүүн эзэлж байна. Импортын бүтээгдэхүүн худалдаалах нь тухайн улсын хүнсний зах зээлийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх бодлогын нэг хэсэг юм.

4.1. ИБУИНХУ-ын хүнсний тухай хууль тогтоомж, дүрэм журам

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын **Хүнсний Ерөнхий хууль** (General Food Law)-ийн¹¹⁷ зорилго нь хүний эрүүл мэнд, хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах юм. Энэ нь бүтээгдэхүүний бүх шатанд буюу үйлдвэрлэлээс, хэрэглэгчдийн гарт хүрэх хүртэлх бүх шатанд хамаарах эрх зүйн зохицуулалтыг хийх юм. Хүнсний Ерөнхий хуулийг хураангуйлан авч үзвэл:

Хүнсний Ерөнхий хуулийн 5-10 дугаар зүйлд ерөнхий зарчим, 14-21 дүгээр зүйлд хүнсэнд тавигдах шаардлагуудыг тодорхойлсон байдаг.

Хүнсний аюулгүй байдлын талаар 14 дүгээр зүйлд хэрвээ хүнсийг аюулгүй гэж үзвэл худалдаанд гаргахгүй байхаар заасан байдаг. Хүнсийг дараах тохиолдолд аюултай гэж үзнэ:

- Эрүүл мэндэд хортой;
- Хүний хэрэгцээнд нийцэхгүй.

Хүнсний аюулгүй байдлын тухай зүйлчилсэн уг зүйлд хүнсийг хүний эрүүл мэндэд хортой эсхүл хүний хэрэгцээнд тохиромжгүй эсэхийг тодорхойлох ямар хүчин зүйлийг авч үзэх талаар дурдсан.

ХЕХ-ийн 16 дугаар зүйлд хүнсний бүтээгдэхүүний шошго, сурталчилгаа, танилцуулга, тэр дундаа тухайн хүнсний бүтээгдэхүүнийг байрлуулах орчин нь хэрэглэгчдийг төөрөгдүүлэхгүй байх тухай зүйлчилсэн.

ХЕХ-ийн 18 дугаар зүйлд хүнсний бизнес эрхлэгчид дараах зүйлсийг бүртгэх шаардлагатай байдаг. Үүнд:

- Хүнс;
- Хүнсний бодис;
- Хүнс үйлдвэрлэхэд ашигласан амьтны гаралтай нэмэлт бодис;
- Бүтээгдэхүүн нийлүүлж буй байгууллага.

Үүнээс гадна хүнсний бизнес эрхлэгчид ямар ч тохиолдолд холбогдох байгууллагуудын шаардсан мэдээллийг гаргаж өгөх шаардлагатай.

Их Британи Улсад импортолж буй бүтээгдэхүүнүүд нь Хүнсний Ерөнхий хуулийн шаардлагыг хангасан байх тухай ХЕХ-ийн 11 дүгээр зүйлд заасан. Түүнчлэн Их Британи болон экспортлогч улс хооронд тусгайлсан хэлэлцээр байгаа тохиолдолд импортын хүнсэнд хэлэлцээрт заасан шаардлагыг дагаж мөрдөнө.

Их Британи улсаас экспортолж байгаа эсхүл буцаан экспортолж байгаа хүнс нь импортлогч улсын хууль, дүрмийн шаардлагад нийцэхгүй байх эсхүл тухайн импортлогч орон хүсэлт гаргаагүй тохиолдолд Хүнсний Ерөнхий хуулийг дагаж мөрдөх тухай 12 дугаар зүйлд заасан.

Хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох, буцаан экспортлохдоо (re-export) эрүүл мэндэд хор хөнөөлгүй, аюултай биш бол тухайн улсын эрх бүхий байгууллага тухайн хүнсийг экспортлох, буцаан экспортлохыг зөвшөөрсөн байх ёстой. Эрх бүхий байгууллагууд яагаад хүнсний

¹¹⁶ Trade Economics <https://tradingeconomics.com/united-kingdom/full-year-gdp-growth>

¹¹⁷ General Food Law <https://www.food.gov.uk/print/pdf/node/355>

бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах боломжгүй болсон талаар бүрэн мэдээлэл өгсний дараа батлах ёстой.

ИБУИНХУ-ын Хүнс, хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж ажилладаг хэд хэдэн байгууллагууд байдаг. Үүнд, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн яам, Хүнсний стандартын агентлаг, Хөдөө аж ахуй, байгаль орчны яам, Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яам гэх мэт.

Хүнсний эрүүл ахуйн тухай хууль (Food hygiene legislation) тогтоомж нь Хүнсний Ерөнхий хуулийн үндсэн шаардлага, ХЕХ-ийн үндсэн зарчимтай уялдсан байдаг боловч хүнсний микробиологийн аюулгүй байдалд түлхүү анхаарсан байдаг. Хүнсний эрүүл ахуйн тухай уг хууль нь хувийн хэвшлийн өөрөөр хэлбэл хүнсний салбарын бизнес эрхлэгчдэд хүнсний эрүүл ахуйн дүрэм, анхан шатны үйлдвэрлэлээс хэрэглэгчийн гарт хүрэх хүртэлх бүхий л шат дамжлагад хяналт тавьж, зохицуулалт хийх зорилготой.

4.2. ИБУИНХУ-ын Хүнсний стандарт, аюулгүй байдал, хяналтын байгууллага

ИБУИНХУ-ын хүнс, хүнсний стандарт, хүнсний аюулгүй байдалд хяналт, зохицуулалтын чиг үүрэгтэй дараах байгууллагууд ажилладаг: Үүнд:

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ		
Хүнсний стандартын агентлаг	Умард ирланд дахь хүнсний стандартын агентлаг	Уэльс дэх хүнсний стандартын агентлаг
Хүнсний аюулгүй байдал Малын тэжээлийн аюулгүй байдал, эрүүл ахуй, шошго Хүнсний шошго (аюулгүй байдал, харшлын мэдээлэл)	Хүнсний аюулгүй байдал Малын тэжээлийн аюулгүй байдал, эрүүл ахуй, шошго Хүнсний шошго (аюулгүй байдал, харшлын мэдээлэл) Шим тэжээлийн стандарт, шим тэжээлт хүнсний шошго Бусад хүнсний шошго (хүнсний найрлагын стандарт, аль улсаас гаралтай)	Хүнсний аюулгүй байдал Малын тэжээлийн аюулгүй байдал, эрүүл ахуй, шошго Хүнсний шошго (аюулгүй байдал, харшлын мэдээлэл) Бусад хүнсний шошго (хүнсний найрлагын стандарт)
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ	ЭРҮҮЛ МЭНД, НИЙГЭМ ХАМГААЛЛЫН ЯАМ	УЭЛЬСНИЙН ЗАСГИЙН ГАЗАР
Бусад хүнсний шошго (Англи) (хүнсний найрлагын стандарт, аль улсаас гаралтай)	Шим тэжээлийн стандарт, шим тэжээлт хүнсний шошго (Англи)	Шим тэжээлийн стандарт, шим тэжээлт хүнсний шошго (Уэльс)
ХҮНСНИЙ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА		
ХҮНСНИЙ СТАНДАРТЫН АГЕНТЛАГ	УМАРД ИРЛАНД ДАХЬ ХҮНСНИЙ СТАНДАРТЫН АГЕНТЛАГ	УЭЛЬС ДЭХ ХҮНСНИЙ СТАНДАРТЫН АГЕНТЛАГ
Махны эрүүл ахуйн байцаагч, албан ёсны малын эмч нар эрүүл ахуй, бичиг баримтад шалгалт хийж, зөвшөөрөгдсөн мах үйлдвэрлэгчдээс биет үзлэг хийж дээж авах (нядалгааны газар, зүсэх үйлдвэрийг оролцуулан) Мэргэшсэн малын эмч нар малын гаралтай бүтээгдэхүүнд үзлэг хийж, малын эрүүл мэндийн үзлэг* явуулдаг. *Хөдөө аж ахуй, байгаль орчин, хөдөө орон нутгийн асуудал эрхэлсэн яам нь Умард Ирландын Хүнсний стандартын агентлагийн өмнөөс мах боловсруулах явцад хяналт тавин, хариуцлага хүлээн ажилладаг.	Хүнсний аюулгүй байдлын байцаагчид хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн байдалд хяналт тавьдаг. Хүнсний стандартын байцаагчид хүнсний аюулгүй байдал, найрлага, шим тэжээлийн шошгын стандарт (жишээ нь: харшил үүсгэх орцын шошго, шим тэжээл, найрлагын мэдээлэл, дуусах хугацаа гэх мэт)	Импортын хүнс Боомтын эрүүл ахуйн байцаагчид эрсдэлд суурилсан баримт бичгийн шалгалт хийх, биет үзлэг хийх, импортын хүнснээс дээжийн шинжилгээ авах Албан ёсны малын эмч, загасны эрүүл ахуйн байцаагч мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавьж ажилладаг.

4.3. ИБУИНХУ-ын Хүнсний Стандартын Агентлаг¹¹⁸

Хүнсний стандартын агентлаг нь 2000 онд байгуулагдсан бие даасан байгууллага бөгөөд нийтийн эрүүл мэндийг хамгаалах, Англи, Уэльс, Умард Ирланд дахь хоол хүнстэй холбогдох хэрэглэгчдийн сонирхлыг судлан ажилладаг. Уг байгууллагын үндсэн зорилго нь хүнсний найдвартай, эрүүл, чанартай байдлыг хангах юм.

Байгууллагын чиг үүрэг

- Хүнсний найдвартай, эрүүл, чанартай байдлыг хангах чиг үүрэгтэй ажилладаг;
- Хүнсний аюулгүй байдал;
- Хүнсний чанарт анхаарах;
- Хэрэглэгчдийг хүнсний тухай мэдээллээр хангах, хүнсний сонголт хийх мэдлэгтэй болоход дэмжлэг үзүүлэх;
- Хэрэглэгчдэд одоо болон ирээдүйд тохирсон хэмжээний хоолны зохистой хэрэглээний талаарх мэдлэг, мэдээлэл олгох;

**Хүнсний стандартын агентлаг* нь зөвхөн Умард Ирландын шим тэжээлийн бодлогыг тодорхойлно.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл

Хүнсний стандартын байгууллага нь шинжлэх ухаан, нотолгоонд суурилсан аргаар хүнсний аюулгүй байдлыг хангах, бизнес эрхлэгчид болон хэрэглэгчдэд хүнсний аюулгүй байдлыг хангахад шаардагдах зөв зүйтэй ажиллах боломжоор хангадаг.

Хүнсний тухай үр дүнтэй, шинэлэг хууль, дүрэм, журам: Хүнсний тухай хууль тогтоомжийн биелэлтийг ханган ажилладаг. Олон улсын хүнсний экосистем, хурдацтай шилжилт, нарийн төвөгтэй нөхцөл байдалд хувийн хэвшлийн байгууллагуудад зөв зүйтэй үйл ажиллагаа эрхлэх, хууль эрх зүйн боломжоор хангах.

Хоол хүнсээр дамжих өвчлөлөөс нийт иргэдийг хамгаалах: Жилд 9.1 тэрбум фунтын өртөг бүхий хоол, тэжээлээр дамжих өвчний эрсдэлийг бууруулахын тулд тариаланч, хүнс үйлдвэрлэгч, боловсруулагч, хэрэглэгчидтэй хамтран ажилладаг.

Мал нядалгааны газар, анхан шатны үйлдвэрүүдэд хяналт тавих: Мал нядалгааны үйлдвэрүүдэд тус байгууллага нь шалгалт хийх, мах зүсэлтийн үйлдвэр, фермийн сүү, сүүн бүтээгдэхүүн, дарсны үйлдвэрүүдэд аудитын болон хяналт, шалгалтын ажлыг гүйцэтгэдэг. Түүнчлэн далайн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн талбайд хяналт тавьдаг байна.

Эрсдэлийн үнэлгээ: Хэрэглэгчдийн сонирхол, хүнсний аюулгүй байдлын тухай шинжлэх ухаан, нотолгоонд суурилсан мэдээлэл, зөвлөгөөг Англи, Уэльс, Умард Ирланд дахь яамдуудад хүргүүлэх бөгөөд зах зээлд гарах шинэ бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгох явцад яаманд зөвлөгөө өгч ажилладаг.

Хүнсний хэт мэдрэг байдал: Хоол, хүнснээс харшилтай иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, тэдний аюулгүй байдлыг ханган ажилладаг.

Хүнсний гэмт хэрэг: Хүнсний стандартын агентлагийн Үндэсний хүнсний гэмт хэргийн хэлтэс хүнсний гэмт хэргийн хуулийг сахиулах ажлыг удирдан зохицуулдаг.

Хоол хүнс, тэжээлийн зөрчлийг зохицуулах, хариу арга хэмжээ авах: Хүнсний чанар эсхүл аюулгүй байдалд эрсдэл үүссэн бол хэрэглэгчдийг хамгаалах хариу арга хэмжээ авч ажилладаг.

¹¹⁸ Food we can trust <https://www.food.gov.uk/sites/default/files/media/document/food-we-can-trust.pdf>

5. АВСТРАЛИ, ШИНЭ ЗЕЛАНД

Хүнсний аюулгүй байдлын тогтолцоог боловсруулах, хэрэгжүүлэхэд Холбооны Засгийн газрын үүрэг

Австрали, Шинэ Зеландын Хүнсний зохицуулалтын сайд нарын зөвлөл¹¹⁹ (ANZFRMC) нь Австралийн бүх муж улсын Эрүүл мэндийн сайд нар (Шинэ Өмнөд Уэльсийн NSW Аж үйлдвэрийн сайд зөвхөн), Шинэ Зеландын Засгийн газрын тэргүүн болон бусад холбогдох сайд нараас бүрддэг бөгөөд Австралийн Эрүүл мэндийн сайдаар ахлуулдаг. Уг зөвлөл нь:

- Хүнсний дүрэм журмын үндсэн удирдамж бэлтгэх;
- Хүнсний стандартыг боловсруулах, хянах;
- Австралийн муж эсвэл Шинэ Зеланд, Австрали-Шинэ Зеландын хооронд болон бусад улсуудын стандартыг уялдуулах;
- Хэлэлцсэн удирдамж, стандартуудыг гишүүн улсуудын хууль тогтоомж, дүрэм журамд тусгасан эсэхийг баталгаажуулах гол үүрэгтэй.

5.1. Хүнсний стандарт Австрали - Шинэ Зеланд (FSANZ)¹²⁰

Австрали-Шинэ Зеландын хүнсний стандарт (FSANZ) нь Хүнсний зохицуулалтын сайд нарын зөвлөлийн шийдвэрлэсэн, хүнсний зохицуулалтын үндсэн бодлогын дагуу хүнсний аюулгүй байдлын тусгай стандартыг боловсруулдаг бие даасан байгууллага юм. 2000 онд Австрали-Шинэ Зеландын хүнсний аюулгүй байдлын стандартыг баталсан бөгөөд 2002 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс зарчмын хувьд бүх хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагчдад заавал байх ёстой хүнсний нэмэлт, шошгоны стандартаас гадна үйлдвэрлэлийн эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний боловсруулалтанд тавигдах хууль эрх зүйн шаардлагыг тогтоосон. Энэхүү дүрэм нь Австрали, Австралийн муж, Шинэ Зеландын засгийн газар хамтран боловсруулсан дөрвөн бүлэг чиг үүрэгтэй. Тус хүнсний стандартууд нь:

1. Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсэнд хэрэглэхэд тохиромжтой байх;
2. Хоол хүнс борлуулахтай холбоотой зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэх;
3. Хэрэглэгчдэд нээлттэй сонголт хийх боломжийг олгох, хангалттай мэдээллээр хангах;
4. Хүнсний үйлдвэрлэлийг үр ашигтай ажиллуулах зохицуулалтын тогтолцоог бий болгох.

Дүрэм нь Австралид борлуулах хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах, эсвэл хүнсний бүтээгдэхүүн борлуулахтай холбоотой аливаа бизнес, үйл ажиллагаанд хамаарна. Виктория мужид хүнсний бизнесийн үйл ажиллагаа эрхлэгчдийг хотын захиргаанд бүртгэн, нутгийн зөвлөлүүд хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлдэг.

Дүрэмд заасан шаардлагыг хангаагүй хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах, борлуулах нь Хүнсний тухай хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэг болно. Хүнсний тухай хуульд аюултай, тохиромжгүй хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах, худалдах, хүнсний талаар худал тайлбарлах зэрэг гэмт хэрэг багтсан байдаг.

¹¹⁹ ANZFRMC <https://www.madge.org.au/australia-and-new-zealand-food-regulation-ministerial-council-anzfrmc>

¹²⁰ FSANZ <https://www.foodstandards.gov.au/Pages/default.aspx>

АВСТРАЛИ - ШИНЭ ЗЕЛАНДЫН ХҮНСНИЙ СТАНДАРТЫН ДҮРЭМ¹²¹

1-р бүлэг - Хүнсний ерөнхий стандарт

Эдгээр стандартууд нь бүх хүнсний бүтээгдэхүүнд хамаарах бөгөөд шошго, хүнсний бүтээгдэхүүнд юу нэмж болох, юу байж болохгүй, микробиологийн хязгаарлалт, генийн өөрчлөлттэй, цацраг идэвхт хүнсний бүтээгдэхүүний зохицуулалт зэрэг орно.

2-р бүлэг - Хүнсний бүтээгдэхүүний стандарт

Энэ бүлэгт тодорхой хоол хүнс эсвэл хүнсний ангилалд хамаарах тодорхойлолт, найрлага, шошгоны шаардлагыг багтаасан болно.

3-р бүлэг - Хүнсний аюулгүй байдлын стандарт

3-р бүлгийн стандартыг дагаж мөрдөх нь хүний хэрэглээнд тохирсон, аюулгүй хоол хүнсээр хангахад чухал үүрэгтэй. Эдгээр стандартууд нь хүнсний бүх бизнест хамаарах бөгөөд хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах бүх тал болон хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд тавигдах шаардлагыг тогтоодог. Стандартууд нь Виктория дахь орон нутгийн засаг захиргааны хүрээлэн буй орчны эрүүл мэндийн эмч нарын хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан байдаг.

4-р бүлэг - Анхдагч үйлдвэрлэл, боловсруулалтын стандарт

Энэ бүлэгт далайн хоол, мах, шувууны мах, сүүн бүтээгдэхүүн, тусгай бяслаг, өндөг, үрийн нахиа, дарсны анхан шатны үйлдвэрлэл, боловсруулалтын стандартыг багтаасан болно.

Тайлбар:

- 1 ба 2-р бүлэг Австрали улс болон Шинэ Зеланд улсад аль алинд нь үйлчилнэ;
- 3 ба 4-р бүлэг нь зөвхөн Австрали улсад үйлчилнэ.

Шошго

Австрали, Шинэ Зеландын Шударга өрсөлдөөний хууль болон хүнсний хуулиуд нь шошгоор дамжуулан худал эсвэл хууран мэхлэх замаар хэрэглэгчдэд буруу мэдээлэл өгөхгүй байхыг шаарддаг бөгөөд хүнсний бүтээгдэхүүний шошгонд тавигдах шаардлагыг Хүнсний стандартын дүрмээр тогтооно. Томоохон түргэн хоол, хөнгөн зуушны цэгүүдийн цэсэн дэх хоол тэжээлийн шошготой холбоотой заалтуудыг Хүнсний тухай хууль¹²² (Food act 2003-NSW) болон 2015 оны Хүнсний журамд тус тус тусгасан болно.¹²³

Хүнсний бүтээгдэхүүний шошго нь тухайн хүнсний жинхэнэ мөн чанарыг илтгэх үнэн зөв нэр эсвэл тайлбартай байх ёстой.

Нийлүүлэгч нь хүнсний бүтээгдэхүүний шошгон дээр жин, хэмжүүрийн үнэн зөв мэдээлэл (багцанд агуулагдах хүнсний хэмжээ)-ийг багтаасан байх ёстой. Жин ба хэмжүүрийн мэдэгдлийг Австралийн Үндэсний Хэмжилтийн Хүрээлэн¹²⁴ болон Шинэ Зеландын худалдааны стандартуудаар¹²⁵ зохицуулдаг.

Хүнсний стандартын дүрэмд шошго нь гаргацтай, тод байх ёстойгоос гадна арын дэвсгэр болон англи хэлээр ялгаатай байхыг шаарддаг. Сэрэмжлүүлэгт заасан төрлийн хэмжээ нь 1.5 мм-ээс багагүй өндөртэй жижиг савлагааны хэмжээнээс бусад тохиолдолд 3 мм-ээс багагүй өндөртэй байх ёстой гэж заажээ.

¹²¹ Food standards code <https://www.foodstandards.gov.au/code/pages/default.aspx>

¹²² Food act 2003 <https://legislation.nsw.gov.au/view/html/inforce/current/act-2003-043>

¹²³ Food act 2003-NSW <https://www.foodstandards.gov.au/consumer/labelling/truth/Pages/default.aspx>

¹²⁴ National Measurement institute <https://www.industry.gov.au/policies-and-initiatives/national-measurement-institute>

¹²⁵ Trading Standards <https://www.tradingstandards.govt.nz/>

Шошгон дээрх мэдээлэл нь:

- Хоолны нэр ба тайлбар
- "Бага" дугаарыг тодорхойлох
- Хүнсний нийлүүлэгчийн нэр болон Австрали дахь хаяг
- Найрлагын жагсаалт
- Огнооны тэмдэг
- Хоол тэжээлийн мэдээллийн самбар (NIP)
- Хүнс нь аль улсаас гарал үүсэлтэй
- Анхааруулга, зөвлөмжийн мэдэгдлийг заавал агуулсан байх бөгөөд гаргацтай, тод, англи хэл дээр байх ёстой.

Хоол хүнсийг эргүүлэн татах

Хүнсний стандартын дүрмийн дагуу хүнсний компаниуд (импортлогчдыг оруулаад) шаардлагатай бол түргэн эргүүлэн татах боломжийг олгох үүднээс баримтжуулах төлөвлөгөөтэй байх ёстой. Хүнсний компани нь эргүүлэн татахтай холбоотой зардлыг гаргахаас гадна шаардлагатай тохиолдолд Хүнсний стандарт Австрали - Шинэ Зеланд (FSANZ)-ын Хүнс эргүүлэн татах зохицуулагчтай холбоо барих ёстой. Үүний хариуд зохицуулагч нь тухайн улсын эргүүлэн татах зохицуулагчидтай холбоо барьж, улмаар эргүүлэн татах ажиллагааг хянаж, уг мэдээллийг FSANZ-д өгнө.

Хүнсний импорт

Импортын хүнсний хяналтын тухай хууль¹²⁶ (Imported Food Control Act 1992) нь голлох зохицуулалт байна. Хүнсний стандартын дүрэмд заасан бүх шаардлага нь импортын хүнсний бүтээгдэхүүнээс гадна дотооддоо үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнд хамаарна. Импортлоор орж ирж буй хүнсний бүтээгдэхүүн дүрэмд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулж, чиг үүргийн хуваарилалтын хувьд Хүнсний стандарт Австрали - Шинэ Зеланд (FSANZ) нь эрсдэлийн үнэлгээний шинжилгээ хийж, Австралийн хорио цээрийн хяналтын алба¹²⁷ (AQIS) нь бодит хяналт шалгалтыг хариуцдаг.

Импортлолж буй хүнсний бүтээгдэхүүн нь хяналтын гурван ангиллын аль нэгэнд багтдаг. Үүнд:

1. Эрсдэлтэй хоол хүнс

Нийгмийн эрүүл мэндэд өндөр эсвэл дунд зэргийн эрсдэл учруулж болзошгүй хүнсний бүтээгдэхүүнүүд.

2. Идэвхтэй хяналттай хоол хүнс

Уг ангиллын хүнсний бүтээгдэхүүний хувьд Хорио цээрийн хяналтын алба нь 10%-д нь шалгалт хийнэ. Эдгээр хүнсний бүтээгдэхүүнээс дээж авч дууссаны дараа импортлох зөвшөөрөл олгоно. Идэвхтэй хяналтанд байгаа хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний үр дүнг FSANZ тогтмол шинжлэн зохих ангиллыг хянаж байдаг.

3. Санамсаргүй хяналтын хоол хүнс

Эдгээр хүнсний ачааны 5%-д нь шалгалт хийгдэнэ. Идэвхтэй хяналтанд байгаа эсвэл санамсаргүй байдлаар хянагдсан хүнсний бүтээгдэхүүн нь Хүнсний стандартын дүрэмд нийцэхгүй бол саатуулах тушаал гаргаж болно.

¹²⁶ Imported Food Control Act 1992 <https://www.legislation.gov.au/Details/C2021C00497>

¹²⁷ Australian Quarantine https://www.awe.gov.au/sites/default/files/sitecollectiondocuments/aqis/about/corporate-docs/naim/naim_report.pdf

FSANZ нь эрсдэлийн үнэлгээнд үндэслэн AQIS-д ямар хоол хүнс ямар ангилалд хамаарахыг зааж өгнө. Эдгээр хүнсний хяналтын ангиллыг FSANZ тогтмол хянаж байдаг.

Хүнсний экспорт

Дэлхий дээр Австрали Улс нь Хөдөө аж ахуй болон хүнсний бүтээгдэхүүний тодорхой хувийг экспортолдог. Экспортлогч Хорио цээрийн хяналтын газарт экспортын зорилгын мэдэгдэл болон ачааны эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг илгээж зөвшөөрлийг авах ба Хорио цээрийн алба мал амьтан дээр заавал үзлэг хийдэг байна.

Австралийн хөдөө аж ахуйн экспортын шинэ хууль 2021 оны 03-р сарын 28-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэн.¹²⁸

Австралийн засгийн газар Австралийн хөдөө аж ахуйн экспорт, зах зээлд нэвтрэх боломжийг бэхжүүлэх өргөн хүрээний санаачилгын нэг хэсэг болгон экспортын шинэ хууль тогтоомжийг баталсан. Энэхүү хуулийн гол зорилго нь:

- Хууль тогтоомж, актуудыг хамааралтай болгох;
- Мэдрэмжтэй, үр дүнтэй байх;
- Зохицуулалтын хяналтыг ижил түвшинд хангах;
- Давхардлыг арилгах;
- Бараа бүтээгдэхүүний тогтвортой байдлыг хангах. Энэ нь төрөл бүрийн түүхий эдийг зохицуулах арга замыг оновчтой болгож, экспортлогчдод илүү хүртээмжтэй байх боломжийг олгоно.

Экспортын шинэ хууль тогтоомж нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй:

1. Экспортын хяналтын тухай хууль 2020 нь Австралийн нутаг дэвсгэрээс экспортолж буй бараа бүтээгдэхүүн, тэр дундаа хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг зохицуулах эрх зүйн ерөнхий зохицуулалтыг тодорхойлсон. Энэ нь Хөдөө аж ахуй, ус, байгаль орчны газрын нарийн бичгийн даргад тодорхой бараа бүтээгдэхүүнийг экспортлохтой холбоотой шаардлагыг нарийвчлан тодорхойлсон дүрэм журам гаргах боломжийг олгодог.
2. Экспортын хяналтын дүрэм 2021 нь Австралийн нутаг дэвсгэрээс эсвэл Австралийн нутаг дэвсгэрийн зарим хэсгээс (жишээ нь мах) тодорхой бараа бүтээгдэхүүн экспортлоход дагаж мөрдөх үйл ажиллагааны шаардлагуудыг тодорхойлдог.

5.2. Хүнсний аюулгүй байдлын хяналтын байгууллагууд

Австралид бүх хүнсний бүтээгдэхүүний хууль дүрмийн хэрэгжилтийг муж, нутаг дэвсгэрийн эрх баригчид хянадаг. Шинэ Зеландад Аж үйлдвэрийн яам, Нийгмийн эрүүл мэндийн нэгжүүд хянадаг.

Австралийн Засгийн газрын Хөдөө аж ахуй, ус, байгаль орчны яам импортын хүнсний бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх, дээж авах ажлыг хариуцдаг.

Хүнсний бүтээгдэхүүний талаарх гомдлыг муж, нутаг дэвсгэр эсвэл Шинэ Зеландын холбогдох агентлагт илгээнэ.

Австрали, Шинэ Зеландын хүнсний зохицуулалтын байгууллагууд хүнсний зохицуулалтыг тууштай хэрэгжүүлэхийн тулд хамтран ажилладаг. Энэхүү ажлыг Хүнсний зохицуулалтын хэрэгжилтийн дэд хороо¹²⁹ (ISFR) уулзалт хийх, хуралдаанаас гадуурх бизнес, хамтын ажиллагаа зэргээр дамжуулан гүйцэтгэдэг.

¹²⁸ Australia's new legal framework for agricultural exports <https://www.awe.gov.au/biosecurity-trade/policy/legislation#export-legislation>

¹²⁹ ISFR <https://foodregulation.gov.au/internet/fr/publishing.nsf/Content/ISFR>

Хүнсний зохицуулалтын гэрээ

2000 оны 11-р сарын 03-нд Австралийн Засгийн газрын Зөвлөл (COAG) хүнсний зохицуулалтын шинэ тогтолцоог хүлээн зөвшөөрсөн Засгийн газар хоорондын Хүнсний зохицуулалтын хэлэлцээрт (FRA) гарын үсэг зурсан. Австралийн хамтын нөхөрлөл болон Австралийн бүх муж, нутаг дэвсгэрүүд гэрээнд гарын үсэг зурсан. FRA нь 2000 оноос хойш хэд хэдэн удаа шинэчлэгдсэн.

Эдгээр шинэчлэлийг 1998 оны 08-р сард Засгийн газарт танилцуулсан Хүнсний зохицуулалтын тоймыг (Блэйрийн тайлан) авч үзсэний дараа 2000 оны 11-р сард Австралийн Засгийн газрын Зөвлөлийн (COAG) шийдвэрийн үр дүнд хийсэн.

5.3 Хүнсний тухай хууль тогтоомж

Австралийн хүнсний тухай хууль тогтоомж

- Хүнсний стандарт Австрали - Шинэ Зеландын хууль 1991 он¹³⁰ (Food Standarts Australia New Zealand Act 1991)
- Хүнсний стандарт Австрали - Шинэ Зеландын дүрэм 1994 он¹³¹ (Food Standards Australia New Zealand Regulations 1994)
- Импортын хүнсний хяналтын тухай хууль 1992 он¹³² (Imported Food Control Act 1992)

Хүнсний тухай хууль нь аюулгүй байдал, шошгололт, найрлага, хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах шаардлагууд зэрэг хүнсний тодорхой хүрээг хамардаг.

Австралийн муж, нутаг дэвсгэр, Шинэ Зеландын засгийн газрын агентлагууд Хүнсний тухай хууль болон хүнсний бусад хууль тогтоомжоор дамжуулан хүнсний зохицуулалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэгтэй. Төрийн байгууллагууд аль болох хамтран ажиллаж, хүнсний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, тууштай хэрэгжүүлдэг. Энэ ажлыг ISFR-ээр¹³³ дамжуулан, нүүр тулсан уулзалтууд, хуралдаанаас гадуурх бизнес, тусдаа хамтын ажиллагаа зэргээр гүйцэтгэдэг. ISFR-ийн үүрэг нь импортын, экспортын болон дотооддоо үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнд адил хамаарна. ISFR-ийн гол үүргүүдийн нэг бол хүнсний хангамжийн аюулгүй байдал, хүнсний хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих явдал юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹³⁰ Food Standarts Australia New Zealand Act 1991 <https://www.legislation.gov.au/Details/C2018C00243>

¹³¹ Food Standards Australia New Zealand Regulations 1994 <https://www.legislation.gov.au/Series/F1996B01999>

¹³² Imported Food Control Act 1992 <https://www.legislation.gov.au/Details/C2021C00497>

¹³³ Implementation Subcommittee for Food Regulation (ISFR)

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**МОНГОЛ УЛС**

- Хүнсний тухай хууль
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
- Органик хүнсний тухай хууль, баяжуулсан хүнсний тухай хууль
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль
- Хувиргасан амьд организмын тухай хууль
- Зөрчлийн тухай хууль, төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хууль
- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль
- Эрүүл ахуйн тухай хууль
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Мэргэжлийн хяналтын газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газар
- Стандарт хэмжил зүйн газар
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичиг
- Статистикийн үндэсний хороо

БНСУ

- Хүнс, эмийн аюулгүй байдлын яам https://www.mfds.go.kr/eng/brd/m_15/list.do
- Exporter Guide, Sangyong Oh October 14, 2021
- Korean food export highlights <https://keia.org/the-peninsula/koreas-food-exports-reach-new-highs/>
- <https://www.statista.com/statistics/780427/south-korea-food-export-value/#:~:text=In%202020%2C%20the%20export%20value,value%20increased%20throughout%20the%20years.>
- https://www.mfds.go.kr/eng/brd/m_15/list.do
- <https://www.foodsafetykorea.go.kr>
- https://www.mfds.go.kr/eng/wpge/m_9/denofile.do

ЯПОН УЛС

- Food Sanitation Act <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3687>
- Food Safety Basic Act <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3757>
- Basic Act on Food, Agriculture and Rulas Area <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3994>
- Food Safety Commission of Japan <https://www.fsc.go.jp/english/aboutus/>
- Strategy for Sustainable Food Systems https://www.maff.go.jp/e/policies/env/env_policy/meadri.html

АНУ

- Code of Federal Regulations <https://www.ecfr.gov/current/title-21>
- Food sufficiency rate <https://min.news/en/world/fe3d6927bec31d558381ffe3adb27ee1.html>
- Food and Drug Administration <https://www.fda.gov/about-fda>
- FSIS Programs and Offices <https://www.fsis.usda.gov/contact-us/fsis-offices>
- Centers for Disease Control and Prevention <https://www.cdc.gov/foodsafety/outbreaks/investigating-outbreaks/index.html>

- Center for Health law and policy innovation <https://chlp.org/project/national-food-strategy/#:~:text=In%202020%2C%20The%20Urgent%20Call,food%20strategies%20developed%20since%202017>
- Federal anti-tampering act <https://www.congress.gov/bill/97th-congress/senate-bill/3048>
- US Government global food security strategy https://cg-281711fb-71ea-422c-b02c-ef79f539e9d2.s3.us-gov-west-1.amazonaws.com/uploads/2021/10/Global-Food-Security-Strategy-FY22-26_508C.pdf
- FNS Nutrition programs <https://www.fns.usda.gov/programs>
- https://foodstrategyblueprint.org/wp-content/uploads/2020/12/FSR_Congress_Summary_120420.pdf

ИБУИНХУ

- General Food Law Uk. (n.d.). From food.gov.uk: <https://www.food.gov.uk/print/pdf/node/355>
- lebensmittelrecht: Ein kurzer Überblick. (n.d.). From <https://www.ihk.de/blueprint/servlet/wiikh24/recht/rechtsberatung/produkte/lebensmittelrecht-1255656?print=true&printsrc=button>
- From The General Food Regulations 2004: <https://www.legislation.gov.uk/uksi/2004/3279/made>
- From The General Food Law (Amendment etc.): <https://www.legislation.gov.uk/uksi/2019/641/made>
- From Regulation (EC) No 178/2002: <https://www.legislation.gov.uk/eur/2002/178/contents>
- From Understanding food safety: <https://www.bmel.de/SharedDocs/Downloads/DE/Broschueren/Lebensmittelsicherheit-verstehen.html>
- From Lebensmittel- und Futtermittelgesetzbuch: http://www.gesetze-im-internet.de/lfgb/inhalts_bersicht.html
- From Lebensmittel- Futtermittelgesetzbuch: <http://www.gesetze-im-internet.de/lfgb/LFGB.pdf>
- From Federal Ministry of Food and Agriculture: [https://en.wikipedia.org/wiki/Federal_Ministry_of_Food_and_Agriculture_\(Germany\)](https://en.wikipedia.org/wiki/Federal_Ministry_of_Food_and_Agriculture_(Germany))
- From Developing National Food Strategy: <https://www.gov.uk/government/statistics/food-statistics-pocketbook/food-statistics-in-your-pocket>
- From Food Security Report: <https://www.gov.uk/government/publications/developing-a-national-food-strategy-independent-review-2019/developing-a-national-food-strategy-independent-review-2019-terms-of-reference>
- From Food law and enforcement: <https://www.nibusinessinfo.co.uk/content/overview-food-regulation-and-legislation>
- From Food statistics: <https://www.gov.uk/government/statistics/food-statistics-pocketbook/food-statistics-in-your-pocket>

АВСТРАЛИ, ШИНЭ ЗЕЛАНД

- ANZFRMC <https://www.madg.org.au/australia-and-new-zealand-food-regulation-ministerial-council-anzfrmc>
- FSANZ <https://www.foodstandards.gov.au/Pages/default.aspx>
- Food standarts code <https://www.foodstandards.gov.au/code/pages/default.aspx>
- Food act 2003 <https://legislation.nsw.gov.au/view/html/inforce/current/act-2003-043>
- Food act 2003-NSW <https://www.foodstandards.gov.au/consumer/labelling/truth/Pages/default.aspx>
- National Measurement institute <https://www.industry.gov.au/policies-and-initiatives/national-measurement-institute>

**ХӨГЖИНГҮЙ ОРНУУДЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙГ
ЗОХИЦУУЛАХ БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Р.Нургүл,
И.Жаргалзаяабямба, О.Билгүүтэй, Б.Туул*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

НЭГ. УЛС ОРНУУДЫН ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

ХОЁР. ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

1.КАНАД УЛС

2.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

3.ЯПОН УЛС

4.НИДЕРЛАНДЫН ХААНТ УЛС

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Хөгжингүй орнуудын хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийг зохицуулах бодлого, хууль эрх зүйн орчин” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Өндөр хөгжилтэй орнуудын хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ зохицуулах чиглэлээр хэрэгжүүлдэг бодлого, арга хэмжээ болон хууль эрх зүйн орчны талаар судлах.

Судалгааны хамрах хүрээ: Энэ судалгаанд Канад, БНСУ, Япон, Нидерланд зэрэг хөгжингүй орнуудын туршлагыг авч үзлээ.

Судалгаа 2 бүлэгтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (OECD) гаргасан “Agricultural Policy Monitoring and Evaluation 2021” судалгааны хүрээнд дэлхийн улс орнуудын хөдөө аж ахуйн салбарыг дэмжих бодлого, арга хэмжээний талаар товч тоймлон оруулав. Хоёрдугаар бүлэгт, судалгаанд авагдсан орнуудын хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ зохицуулах чиглэлээр хэрэгжүүлдэг бодлого, арга хэмжээ болон хууль эрх зүйн орчны талаарх туршлагыг авч үзлээ.

Судалгааны арга зүй: Энэхүү судалгааг гүйцэтгэхдээ холбогдох мэдээллийг гадаад хэлнээс хөрвүүлэх, судалгааны захиалгад өгсөн асуултуудын хүрээнд мэдээллийг судлах, нэгтгэн дүгнэх, харьцуулах зэрэг арга зүйг ашиглав.

Түлхүүр үг: зах зээлийн үнийг зохицуулах, хөдөө аж ахуйн салбарын бодлого

Keyword: market price support policy, agricultural policy

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Улс орнуудын хүнс, хөдөө аж ахуйн (ХАА) бүтээгдэхүүний үнийн зохицуулалтын бодлого нь харилцан адилгүй байдаг бөгөөд хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьд ялгаатай байна.

Хөгжингүй орнуудын хувьд дотоодын үнийг дэлхийн зах зээлийн үнээс дээгүүр барих бодлого баримтлан дотоодын ХАА-н үйлдвэрлэлийг дэмжиж байдаг бол хөгжиж буй орнуудын хувьд дотоодын хүнсний бүтээгдэхүүний хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор дотоодын үнийг экспортын үнээс бага байлгах бодлого баримтлах нь түгээмэл байдаг.

Гэхдээ үнийн зохицуулалтын бодлого нь дотоодын хүнсний хүртээмжийг нэмэгдүүлэх боловч дэлхийн хэмжээний хүнсний хомстолд хүргэх сөрөг нөлөөтэй ба үнийг өндөр түвшинд барьснаар дотоодын үйлвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг бууруулж, хэрэглэгчдэд нэмэлт дарамт болно гэж үздэг. Тиймээс энэхүү бодлогод шүүмжлэлтэй хандах болсон.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (OECD) гаргасан “Agricultural Policy Monitoring and Evaluation 2021” судалгааны тайланд тэмдэглэснээр тус байгууллагын гишүүн орнууд үнийн зохицуулалтын арга хэмжээгээ багасгах болсон. 2015 онд батлагдсан Дэлхийн Худалдааны Байгууллагын дүрмээр экспортыг дэмжсэн татаасыг хориглосноор ихэнх улс орнууд үнийн зохицуулалтын бодлогоосоо татгалзах болсон ба түүний оронд орлого дэмжих төсвийн татаасын бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Судалгаанд авагдсан орнуудын хүнс, ХАА-н бүтээгдэхүүний үнийг зохицуулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ болон хууль эрх зүйн орчны талаар тоймлон авч үзвэл:

Судалгаанд авагдсан БНСУ, Канад, Япон, Нидерланд зэрэг орнуудын туршлагаас харахад орон болгоны хувьд төрөөс дэмжлэг үзүүлдэг хүнсний бүтээгдэхүүний төрөл болон тэдгээрт үзүүлэх дэмжлэгийн хэлбэр өөр өөр байна. Эдгээр орнуудад (бүгд хөгжингүй орнууд) татаас олгох, бага хүүтэй зээл олгох болон бусад хэлбэрээр дэмжих бодлого хэрэгжүүлж байна.

- БНСУ-ын хувьд дэмжлэг олгодог хүнсний гол бүтээгдэхүүн цагаан будаа бөгөөд Засгийн газар нь нийт үйлдвэрлэсэн будааны тодорхой хувийг (23-30%) худалдаж авдаг. Түүнээс гадна цагаан будааны тариалан эрхлэгчдэд талбайн төлбөр болон ургацын хомстлын төлбөрийг олгох, бага хүүтэй тусгай зээл олгох зэрэг дэмжлэгийг үзүүлж байна.
- Канадад Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд 5 төрлийн бүтээгдэхүүнд (сүү, сүүн бүтээгдэхүүн; тахианы мах, махан бүтээгдэхүүн; цацагт хяруулын мах, махан бүтээгдэхүүн; өндөг; үржүүлгийн өндөг) төрөөс дэмжлэг үзүүлж байна. Эдгээр бүтээгдэхүүний борлуулалтын орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний татаасыг фермерүүдэд олгодог. Энэхүү дэмжлэгийн хүрээнд сүү, сүүн бүтээгдэхүүнд олгох дэмжлэг хамгийн өндөр (борлуулалтын орлогын 34%) байна, түүний дараа шувууны мах, махан бүтээгдэхүүн (борлуулалтын орлогын ойролцоогоор 16%), өндөг (борлуулалтын орлогын ойролцоогоор 10%) ордог. Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлогыг тухайн бүтээгдэхүүний Маркетингийн зөвлөлөөр дамжуулан хэрэгжүүлдэг.
- Японд цагаан будаанд дэмжлэг үзүүлдэг бөгөөд орлогын даатгалын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Нидерландын Засгийн газрын хүнсний бодлого байгаль орчин болон амьтанд хор хөнөөлгүй, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэгдэнэ. Засгийн газар нь хөдөө аж ахуйг олон талаас хөгжүүлэх, тогтвортой газар тариалан, байгалийн бүс нутгийг нөхөн сэргээх, арчлах чиглэлээр бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллаж, санхүүжүүлдэг байна.

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын тусгай дэмжлэг үзүүлдэг хүнс, ХАА-н бүтээгдэхүүний төрлүүд, дэмжлэгийн хэлбэр болон хууль эрх зүйн орчны талаарх тойм

	Дэмжлэгт хамрагдах бүтээгдэхүүн	Дэмжлэгийн хэлбэр	Хууль эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй стратеги, хөтөлбөрүүд
БНСУ	Цагаан будаа	Засгийн газар нөөц бүрдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор нийт үйлдвэрлэсэн будааны 23-30%-ийг худалдаж авдаг. Цагаан будааны тариалан эрхлэгчдэд талбайн төлбөр болон ургацын хомстлын төлбөрийг олгодог. Тусгай хөтөлбөрийн хүрээнд бага хүүтэй зээл олгож байна.	<u>Хууль</u> Цагаан будааны орлогын нөхөн олговрын тухай хууль (Rice Income Compensation Act) Хөдөө аж ахуй, загасны гаралтай бүтээгдэхүүнийг тогтворжуулах тухай хуулийг хэрэгжүүлэх журам (Enforcement Rules of the Act on the Distribution and Price Stabilization of Agricultural and Fishery Products) <u>Хөтөлбөр</u> Нийтийн хүнсний үр тарианы нөөцийг хангах хөтөлбөрийн хүрээн дэх Засгийн газрын будаа худалдан авах хөтөлбөр (Government Rice Purchase Program under the Public Food Grain Stockholding Program) Засгийн газар болон Үндэсний хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны (NACF) цагаан будааны бизнес эрхлэгчдэд олгох зээлийн хөтөлбөрүүд (Government and National Agricultural Cooperative Federation's (NACF's) Loan Programs to Rice Millers)
Канад	1.сүү, сүүн бүтээгдэхүүн; 2.тахианы мах, махан бүтээгдэхүүн; 3.цацагт хяруулын мах, махан бүтээгдэхүүн; 4.өндөг; 5.үржүүлгийн өндөг.	Төрөөс фермерүүдэд сүү, сүүн бүтээгдэхүүнд борлуулалтын орлогын 34%, шувууны мах, махан бүтээгдэхүүнд ойролцоогоор 16%, өндөгний хувьд ойролцоогоор 10%-тай тэнцэх татаас олгож байна.	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний агентлагийн тухай хууль (Farm Products Agencies Act) Канадын Сүүн бүтээгдэхүүний Комиссын тухай хууль (Canadian Dairy Commission Act)
Нидерланд	Тогтвортой үйлдвэрлэл 1.ХАА бүтээгдэхүүн (сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, амьтны гаралтай бүтээгдэхүүн) 2.Газар тариалан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн 3.уураг 4.загасны аж ахуй, загас агнуур	Засгийн газар сүү, сүүн бүтээгдэхүүн, мах зэрэг амьтны гаралтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ХАА эко системийг бүрэлдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 60 сая евро 65,4 сая ам.доллар 2022 онд төсөвлөсөн байна. Энэ санхүүжилт нь инновацийн салбарыг дэмжих, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилготой байна. Үндэсний өсөлтийн сан	<u>Хууль</u> ЕХ-ны Хүнсний Ерөнхий хууль (EU General Food Law) Барааны тухай хууль (Commodities Act) Барааны тухай хуульд хүнсний аюулгүй байдлын тухай зохицуулалт (Food safety regulations in the Commodities Act) ЕХ-ны олон улсын хүнсний стандарт, дүрэм журам (Codex Alimentarius) Амьтан үржүүлгийн журам

		(National Growth Fund) -г байгуулж, 2021-2025 онуудад эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах хамгийн өндөр чадамжтай хоёр салбарт 20 тэрбум еврогийн хөрөнгө оруулалтыг зарцуулна.	(Animal Breeding Regulation) <u>Бодлого, хөтөлбөрүүд</u> ЕХ-ны ХАА-н нэгдсэн бодлого (EU Common Agricultural Policy (CAP)) Баруун хойд Европ дахь амьтны гаралтай бүтээгдэхүүнийг тогтвортой хөгжүүлэх хөтөлбөр (Advancing sustainable animal products in Northwest Europa. 2020) Загасны аж ахуйн нийтлэг бодлого (Common Fisheries Policy) ХАА, байгаль, хүнсний чанарын яамны 2030 он хүртэлх үйл ажиллагааны төлөвлөгөө (Ministry of Agriculture, Nature and Food Quality of The Netherlands, Plan of action 2030)
Япон	Цагаан будаа	Цагаан будааны тариалангийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой орлогын даатгалын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Даатгалын хугацаанд орлого нь жишиг үзүүлэлтийнхээ 90 хувиас доогуур байвал тариаланчдад орлогын алдагдлын 90 хүртэлх хувийг нөхөн олгох боломжтой.	<u>Хууль</u> Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлт, үнийг тогтворжуулах тухай хууль (Law for Stabilization of Supply Demand and Price of Staple Food) Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загас, загасан бүтээгдэхүүний экспортыг дэмжих тухай хууль (Act on Facilitating the Export of Agricultural, Forestry, and Fishery Products and Food). Японы хөдөө аж ахуйн экспортыг хөнгөвчлөх тухай хууль (Japan Revises Agricultural Export Facilitation Act) <u>Стратеги төлөвлөгөө</u> Япон Улсын хөдөө аж ахуйн экспортыг өргөжүүлэх стратеги төлөвлөгөө.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. УЛС ОРНУУДЫН ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

Аливаа улсын эдийн засаг нь анхдагч буюу хөдөө аж ахуйн салбар, хоёрдогч буюу аж үйлдвэрийн салбар, гуравдагч буюу үйлчилгээний салбар гэсэн уламжлалт 3 хэсгээс бүрддэг. Хөдөө аж ахуйн (ХАА) салбар нь нөгөө 2 салбараа бодвол бүтээмж бага байдаг тул энэ салбарын ажил эрхлэлт, орлогыг дэмжих зорилгоор улс орнууд ХАА-г дэмжих бодлого авч хэрэгжүүлдэг. Улс орнуудын ХАА-г дэмжих бодлого нь үндсэн 3 зорилтыг хангахад чиглэж байна.

- Дотоодын хүнсний хүртээмж, аюулгүй байдлыг хангах;
- Фермерүүд, аж ахуйн нэгжүүдийн орлогыг дэмжих;

- Байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх.


Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD-ЭЗХАХБ) 2022 оны 6-р сард гаргасан судалгааны тайланд тэмдэглэснээр¹³⁴ улс орнууд ХАА-н салбарыг дэмжихэд чиглэсэн ямар бодлого, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг талаар тоймлон авч үзье. ЭЗХАХБ нь улс орнуудын ХАА-г дэмжих бодлогыг хэмжихдээ TSE (Total Support Estimate) буюу Нийт дэмжлэгийн хэмжээ гэсэн үзүүлэлтийг тооцон гаргадаг. Энэ нь ХАА-г дэмжих бодлогын хүрээнд шууд болон шууд бусаар хуваарилагдаж буй хөрөнгийн тооцоолсон үзүүлэлт юм. TSE буюу Нийт дэмжлэгийн хэмжээ нь дор дурдсан 3 хэсгээс бүрдэнэ.

1. Үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэг буюу Producer Support Estimate (PSE)
2. Салбарын ерөнхий дэмжлэг буюу General Services Support Estimate (GSSE)
3. Хэрэглэгчид үзүүлэх дэмжлэг буюу Consumer Support Estimate (CSE)

ХАА-н салбарыг дэмжихэд зарцуулж буй хөрөнгө нь дараах 2 аргаар хуваарилагдаж байна.

- Зах зээлийн зохицуулалт;
- Төсвийн хуваарилалт.

Зураг 1. ХАА-н салбарт үзүүлдэг дэмжлэгүүд



ХАА-н салбарыг дэмжих бодлогын хүрээнд хуваарилагдаж буй хөрөнгийн дийлэнх нь үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэг байдаг. Үйлдвэрлэгчид үзүүлж буй дэмжлэг нь үнийн зохицуулалтын бодлогоор дамжуулан дотоодын үнийг өндөр түвшинд тогтоох, эсхүл төсвөөр дамжуулан үйлдвэрлэгч, фермерүүдэд олгож буй татаасаас бүрдэнэ.

ХАА-н салбарын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, судалгаа шинжилгээнд зарцуулж буй хөрөнгө, улсын нөөц бүрдүүлэх, маркетингийн гэх мэт үйл ажиллагаанд зарцуулагдаж буй хөрөнгө нь Салбарын ерөнхий дэмжлэг болно. Энэ нь төсвийн санхүүжилтээс бүрдэнэ.

Хэрэглэгчид үзүүлж буй дэмжлэг нь хүнсний талон олгох, үнийн хяналт тогтоох гэх мэт хэрэглэгчийн ХАА, хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний зардалд хөнгөлөлт үзүүлж буй арга хэмжээ юм.

¹³⁴ “Agricultural Policy Monitoring and Evaluation 2021” судалгаа нь ЭЗХАХБ-аас гаргадаг судалгаа бөгөөд өндөр хөгжилтэй 42 улс болон хөгжиж буй 12 улсыг хамарч хийгдсэн судалгаа юм. Эдгээр 54 улсын хөдөө аж ахуйн салбар нь дэлхийн хөдөө аж ахуйн салбарын нэмэгдсэн өртгийн 3/4-ийг бүрдүүлдэг.
<https://www.oecd.org/publications/agricultural-policy-monitoring-and-evaluation-22217371.htm>

ЭЗХАХБ-ын судалгаагаар 2018-2020 оны хооронд улс орнууд жилд дунджаар 720 тэрбум ам.долларын дэмжлэгийг ХАА-н салбарт хуваарилжээ. Үүнээс үйлдвэрлэгчид олгох дэмжлэг нь жилд дунджаар 540 тэрбум ам.доллар буюу нийт ХАА-н салбарын дэмжлэгийн 75%-ийг бүрдүүлж байгаа бол Салбарын ерөнхий дэмжлэг нь 102 тэрбум ам.доллар буюу 14%-ийг, Хэрэглэгчид үзүүлж буй дэмжлэг нь 78 тэрбум ам.доллар буюу 11%-ийг бүрдүүлж байна.

Үнийн зохицуулалтын бодлого буюу Market Price Support Policy

Үйлдвэрлэгчид дэмжлэг үзүүлэх бодлогыг голчлон үнийн зохицуулалт хийх замаар хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ нь үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэгийн талаас илүү хувийг бүрдүүлдэг.

Үнэ зохицуулах буюу Market Price Support бодлого нь хилийн үнэ болон дотоодын үнийн зөрүүг бий болгох замаар үйлдвэрлэгчид дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг бодлого юм. Ихэвчлэн өргөн хэрэглээний голлох хүнсний бүтээгдэхүүнд энэхүү бодлогыг хэрэгжүүлдэг.

Үнэ зохицуулах буюу Market Price Support бодлогын зорилго нь:

- Дотоодод хүнсний хүртээмжийг сайжруулах;
- Хүнс, ХАА-н компаниуд, фермерүүдийн орлогыг дэмжих;
- Хүнс, ХАА-н компаниуд, фермерүүдийг дампуурлаас сэргийлэх;
- Хүнс, ХАА-н салбарын ажил эрхлэлтийг дэмжихэд оршино.

Энэ бодлогын хүрээнд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлдэг:

- Тарифын зохицуулалтын хүрээнд гаалийн татвар ногдуулах;
- Импорт, экспортын хэмжээ (квот) тогтоох;
- Үнийн доод (дээд) хэмжээг тогтоох;
- Татаас хэлбэрээр үнийн зөрүүг олгох замаар ХАА-н компани, фермерүүдийн алдагдлыг бууруулах, орлогыг дэмжих;
- Төр дэлхийн зах зээлийнхээс өндөр үнээр худалдан авалт хийх.

ЭЗХАХБ-ын судалгаагаар 2018-2020 онуудад улс орнуудын үнийн зохицуулалтын бодлогын хүрээнд үйлдвэрлэгчид үзүүлж буй дэмжлэг нь жилд дунджаар 272 тэрбум ам.доллар буюу ХАА-н салбарын дэмжлэгийн 38%-ийг, үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэгийн 60%-ийг бүрдүүлж байна.

Үнэ зохицуулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлдэг хамгийн түгээмэл арга хэмжээ нь тарифын буюу импортын татвар ногдуулах, квот тогтоох арга байдаг. Жишээ нь, дэлхийн дунджаар ХАА-н бүтээгдэхүүний импортын татварын дундаж хэмжээ нь 7.8% (аж үйлдвэрийн бүтээгдэхүүний татвар 4.6%) байна. Дэлхийн худалдааны байгууллагын журмаар улс орнууд ХАА-н бүтээгдэхүүнд ногдох импортын татварын дундаж хэмжээг дунджаар 48.9% хүртэл нэмэгдүүлж (харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүний татварыг 27.1% хүртэл нэмэгдүүлж болно) болдог.

ЭЗХАХБ-ын судалгааны тайланд тэмдэглэснээр үнийн зохицуулалтын нөлөө хамгийн өндөр байгаа улс нь Өмнөд Солонгос, Япон, Исланд, Норвег, Швейцар улсууд бөгөөд эдгээр улсын үнийн зохицуулалтын бодлогын нөлөө нь дунджаар ХАА-н нийт орлогын 20%-ийг бүрдүүлж байна.

Хөгжингүй болон хөгжиж буй улсуудын үнийн зохицуулалтын бодлого

Улс орнуудын үнэ зохицуулах бодлого нь харилцан адилгүй байдаг бөгөөд хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьд ялгаатай байдал ажиглагддаг.

Хөгжингүй орнуудын хувьд дотоодын үнийг дэлхийн зах зээлийн үнээс дээгүүр барих бодлого баримтлан дотоодын ХАА-н үйлдвэрлэлийг дэмжиж байдаг. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчид

нэмэлт зардал ноогдуулах замаар үйлдвэрлэгчдийг дэмждэг. ЭЗХАХБ-ын гишүүн улс орнуудын хэрэглэгчид ногдох нэмэлт зардал нь үнийн дүнгийн 10%-аас илүү байгаа бол Исланд, Өмнөд Солонгос, Япон, Норвег улсуудад хэрэглэгчид ногдох нэмэлт зардал үнийн дүнгийн 35%-аас их байна. ЭЗХАХБ-ын судалгааны тайланд тэмдэглэснээр дэлхийн зах зээлийн үнэ болон үйлдвэрлэгчийн борлуулалтын бодит үнийн зөрүү нь Исландад 94%, Норвегт 75%, Өмнөд Солонгост 68%, Японд 61% байна.

Харин хөгжиж буй орнуудын хувьд дотоодын хүнсний бүтээгдэхүүний хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор дотоодын үнийг экспортын үнээс бага байлгах бодлого баримтлах нь түгээмэл байдаг. ЭЗХАХБ-ын судалгааны тайланд тэмдэглэснээр 2018-2020 оны хооронд жилд дунджаар 104 тэрбум ам.долларын сөрөг Market Price Support буюу дотоодын үнийг бууруулах нөлөө бий болгосон байна. Бразил, Аргентин, Казахстан, Вьетнам, Энэтхэгт хэрэглэгчид ХАА-н бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн үнээс бага үнээр хэрэглэж байна. Дэлхийн зах зээлийн үнэ болон үйлдвэрлэгчийн борлуулалтын бодит үнийн зөрүү нь Энэтхэгт 14%, Аргентинд 20%, Вьетнамд 10%, Казахстанд 3% орчим байна.

ХАА-г дэмжих бодлогын чиг хандлага

Зах зээлийн зохицуулалт, үнийн зохицуулалтын арга хэмжээ авах бодлого нь дотоодын хүнсний хүртээмжийг нэмэгдүүлэх боловч дэлхийн хэмжээний хүнсний хомстолд хүргэх сөрөг нөлөөтэй. Үнийг өндөр түвшинд барьснаар дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг бууруулж, хэрэглэгчдэд нэмэлт дарамт болдог гэж үздэг. Тиймээс зах зээлийн зохицуулалт, үнийн зохицуулалтын арга хэмжээнд шүүмжлэлтэй хандаж байна.

ЭЗХАХБ-ын гишүүн орнууд зах зээлд нөлөөлөх, үнийн зохицуулалтын дэмжлэгийн бодлогын арга хэмжээгээ багасгах болсон. 2015 онд батлагдсан Дэлхийн Худалдааны Байгууллагын дүрмээр экспортыг дэмжсэн татаасыг хориглосноор ихэнх улсууд үнийн зохицуулалтын бодлогоосоо татгалзах болсон байна. Оронд нь орлого дэмжих төсвийн татаасын бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Жишээ нь: Швейцар үнийн зохицуулалтын дэмжлэгээ бууруулж фермерүүдэд олгодог шууд татаасын хэмжээг нэмэгдүүлсэн. Гэхдээ энэхүү татаас нь байгальд ээлтэй үйл ажиллагааг дэмжих нөхцөлд олгогддог. Швейцарын төсвийн татаас нь 1980 онд үйлдвэрлэгчид олгодог дэмжлэгийн 20% байсан бол 2020 оны байдлаар 50%-д хүрээд байна. Хөгжингүй орнуудын ХАА-г дэмжих бодлогын чиг хандлага нь дараах хэлбэртэй байна.

- Үнийн зохицуулалт гэх мэт зах зээлд нөлөөлөх бодлогоос татгалзах;
- Чөлөөт худалдааг дэмжих;
- Дэд бүтэц, судалгаа шинжилгээнд хөрөнгө оруулах;
- Шинэ технологи нэвтрүүлэн ХАА-н салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
- Байгаль орчинд ээлтэй ХАА-г дэмжих, ногоон технологи нэвтрүүлэх.

ХОЁР. ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

1.КАНАД УЛС

Канад Улсад 1951 онд Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний Зөвлөлийн тухай хууль (Agriculture Product Board Act) батлагдсанаар ХАА-н бүтээгдэхүүний үнийг зохицуулж эхэлсэн түүхтэй. (Энэ хууль 1997 онд Agricultural Marketing Programs Act батлагдсанаар хүчингүй болсон) Анхандаа Canada Wheat Board буюу Канадын Улаан буудайн зөвлөлөөр дамжуулан үр тарианы зах зээлд зохицуулалт хийж эхэлсэн байна. 1958 онд Хөдөө аж ахуйн тогтвортой байдлыг хангах тухай хуулийг (Agriculture Stabilization Act) баталснаар 9 төрлийн бүтээгдэхүүнд зах зээлийн зохицуулалт (үнийн зохицуулалт) хийж байсан.

Түүнчлэн Канадын Сүүн бүтээгдэхүүний Комиссын тухай хууль (Canadian Dairy Commission Act) батлагдснаар сүү, сүүн бүтээгдэхүүнд үнийн зохицуулалт, нийлүүлэлтийн хязгаарлалтын арга хэмжээг авах талаарх зах зээлийн зохицуулалтыг хуульчилсан байна. Канадын ХАА-г дэмжих бодлогыг 3 үед хувааж үздэг. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Канадын ХАА-г дэмжих бодлогын чиг хандлага

Үе	Бодлогын чиг хандлага	Бодлогын арга хэмжээнүүд
1985 оноос өмнөх	Импортын протекционизм, экспортын дэмжлэг, дотоод зах зээлийн зохицуулалт	<ul style="list-style-type: none"> Импортын ижил төрлийн бүтээгдэхүүнд өндөр татвар ногдуулах Импортын квот тогтоох, импортын тарифын квотыг тогтоох Экспортын бүтээгдэхүүнд татаас олгох ХАА-н бүтээгдэхүүний тээврийн зардалд татаас олгох Үр тариа, сүү, сүүн бүтээгдэхүүн, шувууны мах, махан бүтээгдэхүүнд нийлүүлэлтийн зохицуулалт (үнийн зохицуулалт) хийх Marketing Board буюу Маркетингийн зөвлөлөөр дамжуулан үнийн хяналт тогтоох (Канадын Улаан Буудайн зөвлөл гэх мэт)
1985-2000 он	Бодлогын шинэчлэлийг аажмаар тууштай хэрэгжүүлэн чөлөөт худалдааг дэмжиж эхэлсэн. Орлого болон борлуулалтыг дэмжихэд илүү чиглэгдэх болсон.	<ul style="list-style-type: none"> ХАА-н бүтээгдэхүүний импортын татварыг бууруулж квотын арга хэмжээг багасгах Нийлүүлэлтийн зохицуулалт болон үнийн хяналтыг багасгах (Маркетингийн зөвлөлийн үр нөлөө буурсан) Хойд Америкийн Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан Баруун бүсийн үр тарианы тогтворжуулалтын хөтөлбөрийг зогсоох Фермерүүдэд татаас (орлогын тогтвортой байдлыг хангах) олгох Даатгалын татаасыг нэвтрүүлэх
2000 оноос хойш	Орлогын тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн Холбооны Засгийн газар болон муж улсуудын хамтын ажиллагааг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх болсон.	<ul style="list-style-type: none"> Сүү, сүүн бүтээгдэхүүн, шувууны мах, махан бүтээгдэхүүн болон өндөг зэрэг бүтээгдэхүүнд үнэ тогтоох, импортын тариф, үйлдвэрлэлийн хэмжээний хяналт тогтоох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн нийлүүлэлтийн зохицуулалтыг үргэлжлүүлж байна. ХАА-н бодлогыг Холбооны Засгийн газар болон муж улсууд хамтран боловсруулах болсон. Фермерүүдийн орлогын тогтвортой байдлыг хангахад зориулсан татаасын бодлого хэрэгжүүлдэг. Фермерүүдийг хуримтлал үүсгэхийг дэмжсэн татаасын бодлогыг хэрэгжүүлдэг. Даатгалын татаасын бодлого хэрэгжүүлдэг.

Канадын ХАА-н бодлогын түүхээс харахад үйлдвэрлэгчдэд давуу байдал олгосон зах зээлийн зохицуулалтын арга хэмжээгээ багасгаж оронд нь ХАА-н өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, фермерүүдийн орлогын тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн бодлого хэрэгжүүлэх болсон байна. ХАА-н салбарт үзүүлэх дэмжлэгийн хэмжээ нь 1980-аад оны дунд үед ДНБ-ний 1.6%-ийг эзэлж байсан бол 2020 оны байдлаар 0.3% болж буурсан байна. Үйлдвэрлэгчдэд үзүүлэх дэмжлэг нь мөн буурсаар ирсэн бөгөөд 1985 онд фермерүүдийн орлогын 35%-ийг үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэг бүрдүүлж байсан бол одоогийн байдлаар 9% болж буурсан байна. Энэ нь ЭЗХАХБ-ын дунджаас 2 дахин бага үзүүлэлт юм.

Үнэ зохицуулах бодлого

Канадын үнэ зохицуулах бодлогыг Supply management буюу Нийлүүлэлтийн зохицуулалт гэж нэрлэдэг. 1960-аад онд технологийн дэвшлийн үр дүнд Канадад ХАА-н үйлдвэрлэлийн илүүдэл бий болж эхэлсэн. Энэ үед фермерүүд, Холбооны засгийн газар, муж улсын засгийн газарт шаардлага тавин Маркетингийн зөвлөл (Marketing board) байгуулан зах зээл дэх

нийлүүлэлт, үнэд нөлөөлөх зорилгоор Нийлүүлэлтийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх болсон.

Одоогийн байдлаар нийлүүлэлтийн зохицуулалтад 5 төрлийн бүтээгдэхүүнийг хамруулж байна.

- Сүү, сүүн бүтээгдэхүүн;
- Тахианы мах, махан бүтээгдэхүүн;
- Цацагт хяруулын мах, махан бүтээгдэхүүн;
- Өндөг;
- Үржүүлгийн өндөг.

Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлогоор 3 арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

1. Үйлдвэрлэлийн хэмжээний хяналт;
2. Үнэ тогтоох механизм;
3. Импортын хяналт.

Үйлдвэрлэлийн хэмжээний хяналт. Энэ нь тухайн ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн илүүдлээс шалтгаалан үнийн бууралт бий болохоос сэргийлж улсын хэмжээнд үйлдвэрлэлийн хэмжээг тогтоон, муж бүрт хуваарилах арга хэмжээ юм.

Үнэ тогтоох механизм. Энэ нь тухайн ХАА-н бүтээгдэхүүний хамгийн бага баталгаат үнийг фермерүүдэд зориулж тогтоох арга хэмжээ юм. Өөрөөр хэлбэл, фермерүүд Мужийн Маркетингийн зөвлөлөөр дамжуулан худалдан авагчтай зөвшилцөн тухайн ХАА-н бүтээгдэхүүний өртөгт суурилсан худалдах үнийг тогтоодог.

Импортын хяналт. Дотоодын үйлдвэрлэлд хэмжээ, үнийн зохицуулалт хийхээс гадна дотоодын зах зээлийг хамгаалах зорилгоор тухайн ХАА-н бүтээгдэхүүний импортод татварын болон квотын хязгаарлалт тогтоох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

1966 онд Канадын Сүү, сүүн бүтээгдэхүүний Комисс, 1972 онд өндөгний Маркетингийн Зөвлөл, 1974 цацагт хяруулын мах, махан бүтээгдэхүүний Маркетингийн Зөвлөл, 1978 онд тахианы мах, махан бүтээгдэхүүний Маркетингийн Зөвлөл тус тус байгуулагдаж Нийлүүлэлтийн зохицуулалтыг хийх болсон.

2020 оны байдлаар дотоодын үйлдвэрлэгчдэд 4.8 тэрбум долларын дэмжлэг үзүүлсний 2.7 тэрбум буюу 60% нь үнийн зохицуулалтын дэмжлэг (нийлүүлэлтийн зохицуулалтын арга хэмжээ) байна. Дэмжлэгийн нөлөө хамгийн өндөр бүтээгдэхүүн сүү, сүүн бүтээгдэхүүн бөгөөд фермерүүдийн тухайн бүтээгдэхүүнээс олох нийт борлуулалтын орлогын 34%-ийг бүрдүүлж байна. Шувууны мах, махан бүтээгдэхүүний дэмжлэг нь фермерүүдийн тухайн бүтээгдэхүүнээс олох нийт борлуулалтын орлогын ойролцоогоор 16%-ийг, өндөг ойролцоогоор 10%-ийг тус тус бүрдүүлж байна.

Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлогын (Supply management) эрх зүйн орчин

Канадын Үндсэн хуулиар ХАА-н салбарт бодлого хэрэгжүүлэх эрх мэдлийг Холбооны Засгийн газар болон мужийн Засгийн газрын аль аль нь эдлэх эрхтэй байхаар заажээ. Иймээс ХАА-н салбарын бодлогыг боловсруулахдаа Холбооны Засгийн газар болон Мужийн Засгийн газрын хооронд байгуулсан хэлэлцээрийг баримталдаг. Холбооны улсын түвшний үйл ажиллагаа нь нийт улс даяар хэрэгжих бодлогыг боловсруулахад чиглэгддэг бол мужийн түвшинд тухайн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Канадын ХАА-н салбарт хэрэгжүүлж буй Нийлүүлэлтийн зохицуулалтын арга хэмжээг дараах эрх зүйн актуудаар зохицуулж байна.

- Холбооны улсын хууль, эрх зүйн акт;

- Мужийн хууль, эрх зүйн акт;
- Холбооны улсын Засгийн газрын шийдвэр;
- Мужийн Засгийн газрын шийдвэр;
- Үндэсний ХАА-н бүтээгдэхүүний зөвлөлийн шийдвэр;
- Холбооны улсын түвшний Маркетингийн зөвлөлийн шийдвэр;
- Мужийн Маркетингийн Зөвлөлийн шийдвэр.

1967 онд батлагдсан Канадын Сүүн бүтээгдэхүүний Комиссын тухай хууль (Canadian Dairy Commission Act)¹³⁵ нь тухайн бүтээгдэхүүнтэй холбогдох харилцааг зохицуулдаг бол 1972 онд батлагдсан Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний агентлагийн тухай хууль (Farm Products Agencies Act) болон түүнд нийцүүлэн гаргасан мужийн хуулиуд Нийлүүлэлтийн зохицуулалтын арга хэмжээг зохицуулдаг гол эрх зүйн акт болно.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний агентлагийн тухай хуульд (Farm Products Agencies Act)¹³⁶ нийлүүлэлтийн зохицуулалтын арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих эрх, үүрэг бүхий Холбооны улсын түвшний агентлаг (ерөнхийд нь Маркетингийн зөвлөл гэж нэрлэдэг) байгуулах, түүний бүтэц, эрх мэдэл, үүргийн талаар зохицуулсан байна.

Мужууд Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний агентлагийн тухай хуульд (Farm Products Agencies Act) нийцүүлэн өөрсдийн мужийн хүрээнд мөрдөгдөх хуулийг батлан Мужийн Маркетингийн Зөвлөл (Provincial Marketing Board) байгуулж, эрх үүргийг нь зохицуулдаг байна.

Канадад Нийлүүлэлтийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлдэг эрх бүхий 3 бүтэц байдаг.

1. National Farm Products Council буюу Үндэсний хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зөвлөл;
2. Farm Product Marketing Agency буюу Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний Маркетингийн хороо;
3. Provincial Marketing Board буюу Мужийн Маркетингийн зөвлөл.

National Farm Products Council буюу Үндэсний хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зөвлөл

Зөвлөл нь Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлого, арга хэмжээнд хяналт тавих хяналтын функц бүхий бүтэц бөгөөд дараах үндсэн чиг үүрэгтэй байна.

- ХАА-н бүтээгдэхүүний Маркетингийн хороог байгуулах үйл явцад хяналт тавих;
- ХАА-н бүтээгдэхүүний Маркетингийн хорооны үйл ажиллагаанд хяналт тавих.

Энэхүү Зөвлөлийг байгуулах, гишүүдийг томилох эрхийг Канадын Амбан захирагч эдэлнэ.

Зөвлөл нь 3-7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дор хаяж 50% нь үйлдвэрлэгчдийн төлөөлөл байна. Бүрэлдэхүүнийг сонгохдоо Канадын Баруун бүс, Төвийн бүс, Атлантын бүсийн төлөөллийг тэнцүү хэмжээтэй байлгах зарчмыг баримтална.

Farm Product Marketing Agency буюу Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний Маркетингийн хороо

Хороо нь тухайн ХАА-н бүтээгдэхүүний Нийлүүлэлтийн зохицуулалтын бодлогыг боловсруулж, арга хэмжээг тодорхойлдог үндсэн бүтэц юм.

Тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч-фермерүүдийн гаргасан хүсэлт болон тэдгээрийн дунд явуулсан санал асуулгыг үндэслэн Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний Маркетингийн хороог байгуулах тухай шийдвэрийг Канадын Амбан захирагч гаргана.

¹³⁵ Canadian Dairy Commission Act, https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-15/page-1.html?fbclid=IwAR0ZFGX6Vo5u_3ilbnioCM4H4s-2OVmwyEuaP54L-YH_Wx9zeSr4Lm19dfw

¹³⁶ Farm Products Agencies Act, <https://lois-laws.justice.gc.ca/eng/acts/F-4/page-1.html?fbclid=IwAR2WSFIS71MGlU3PULkaJ5qzmSK691vwOjvz8WAnQgXEIRtD2aVMm8FUql#docCont>

Энэхүү Хороог шаардлагатай гэж үзсэн ХАА-н аль ч бүтээгдэхүүний хувьд байгуулж болдог. Гэхдээ одоогоор тамхи, өндөг, шувууны махнаас бусад бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэлийн хэмжээний хязгаарлалт тогтоодоггүй байна.

Хорооны үндсэн чиг үүрэг:

- Нийлүүлэлтийн зохицуулалт бүхий ХАА-н бүтээгдэхүүний салбарын бодлогыг тодорхойлох;
- Муж хоорондын ХАА-н бүтээгдэхүүний худалдааг зохицуулах;
- Тухайн бүтээгдэхүүний экспортын бодлогыг тодорхойлох;
- Тухайн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг муж бүрээр тогтоох;
- Тухайн ХАА-н бүтээгдэхүүнийг худалдан авах, худалдах, хадгалах, тээвэрлэх, даатгах, экспортлох;
- Үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалсан бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

Provincial Marketing Board буюу Мужийн Маркетингийн зөвлөл

Мужийн Маркетингийн зөвлөл нь Нийлүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлдэг гол бүтэц бөгөөд түүний үйл ажиллагаа тухайн муж улсын хуулиар зохицуулагдана. Энэхүү Зөвлөлийн бүрэлдэхүүнийг гишүүн фермерүүдийн сонгуулиар бүрдүүлдэг.

Мужийн Маркетингийн зөвлөлийн үндсэн чиг үүрэг:


- Мужийн түвшинд тухайн ХАА-н бүтээгдэхүүний талаарх бодлогыг Холбооны улсын түвшний бодлоготой уялдуулан тодорхойлох;
- Тухайн мужид ноогдсон үйлдвэрлэлийн квотыг гишүүн фермерүүдэд хуваарилах;
- Тухайн ХАА-н бүтээгдэхүүний худалдах үнийг тогтоох;
- Мужийн түвшинд тухайн ХАА-н бүтээгдэхүүнийг худалдан авах, худалдах, хадгалах, тээвэрлэх, даатгах, экспортлох;
- Үйлдвэрлэгч, фермерүүдийн эрх ашгийг хамгаалсан бодлого хэрэгжүүлэх.

2.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

БНСУ нь 2020 оны байдлаар дэлхийд 10-т орох том эдийн засагтай улс бөгөөд ДНБ нь 1.6 их наяд ам.доллар-т хүрч, нэг хүнд ногдох Үндэсний нийт орлого 31,755 ам.доллартай тэнцэж байна. БНСУ-ын иргэдийн 90 гаруй хувь нь томоохон хотуудад амьдардаг ба хүнсний хэрэгцээний 45 хувийг дотоодын үйлдвэрлэл нь хангадаг. АНУ 2020 оны байдлаар тус улсад 8.8 тэрбум ам.долларын ХАА-н бүтээгдэхүүн экспортолсон нь АНУ-ын экспортын тав дахь том зах зээл юм.¹³⁷

БНСУ-ын хэрэглэгчдэд чиглэсэн импортын бүтээгдэхүүн: БНСУ 2020 онд 14.8 тэрбум ам.долларын хэрэглэгчдэд чиглэсэн бүтээгдэхүүн импортолсон нь ХАА-н импортын 41 хувийг эзэлж байна. Хэрэглэгчдэд чиглэсэн ХАА-н хүнсний гол бүтээгдэхүүнд үхрийн мах, гахайн мах, жимс жимсгэнэ, модны самар, сүүн бүтээгдэхүүн, чихэр, ундаа, цаашлаад бэлтгэсэн хүнсний бүтээгдэхүүнүүд багтдаг байна.

Зураг 2. БНСУ-д хэрэглэгчдэд чиглэсэн ХАА-н хүнсний бүтээгдэхүүн импортолж буй голлох улсууд




¹³⁷ Exporter Guide, Sanqvoq OhOctober 14, 2021

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй үйлдвэрүүд: Тус улс 2020 оны байдлаар 30,000 гаруй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компанитай болж, 56 тэрбум ам.долларын борлуулалт хийсэн байна. БНСУ-ын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниуд нь импортын бүтээгдэхүүн, орц найрлага түүхий эдээс ихээхэн хамаардаг байна. ХАА-н үндсэн болон завсрын бүтээгдэхүүний импорт 2020 онд 13.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Эдгээр импортын бүтээгдэхүүний 23% буюу 3.1 тэрбум ам.долларыг АНУ-аас импортолсон байна.

Хүнсний жижиглэнгийн худалдаа: БНСУ-ын хүнсний жижиглэнгийн борлуулалт 2020 онд нийт 103 тэрбум ам.долларт хүрсэн нь нийт жижиглэнгийн худалдааны 29%-ийг эзэлж байна. Хүнсний супермаркетууд нь хүнсний жижиглэнгийн худалдааны тэргүүлэгч борлуулагчид бөгөөд дараа нь онлайн жижиглэн худалдаачид, том хэмжээний хайпармаркетууд, энгийн дэлгүүрүүд, их дэлгүүрүүд ордог байна. Ирэх 5-10 жилийн хугацаанд онлайн жижиглэнгийн худалдаачид болон дэлгүүрүүд бусад сувгуудаас илүү хурдан өсөх төлөвтэй байна. Онлайн худалдаачдын хурдацтай өргөжиж байгаа нь ердийн жижиглэнгийн худалдааны сувгуудын орон зайн бүтцийг өөрчлөх, хэрэглэгчдийн урсгалыг татах шинэ стратеги боловсруулахад хүргэж байна.

Экспортын хүнсний бүтээгдэхүүн: БНСУ-ын Гаалийн албаны статистик мэдээгээр, тус улсын хүнсний бүтээгдэхүүний экспорт 2020 онд 4.3 тэрбум ам.долларын тээвэрлэлт хийсэн байна. БНСУ-ын нийт экспортын барааны хэмжээ буурсан хэдий ч хүнсний экспортын хэмжээ (14.6%) түүхэндээ байгаагүй хамгийн өндөр өсөлтөд хүрсэн байна. Тодруулбал, цагаан будааны бүтээгдэхүүн 53.3%-аар өсч 37 сая ам.доллар, рамен (бэлэн хоол) 29.9%-аар өсч 604 сая ам.долларт хүрчээ. БНСУ 1960-аад оноос далайн гаралтай бүтээгдэхүүн, будаа зэрэг хүнсний бүтээгдэхүүн экспортолж эхэлсэн байна. 1988 оны Сөүлийн олимп, 2002 оны хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний дараа БНСУ-ын хүнсний бүтээгдэхүүнүүд бусад улс руу экспортлох хэмжээ, чанарыг нэмэгдүүлсэн ба дэлхий даяар кимчи, рамен, архины эрэлтийг бий болгосон. 2019 онд хүнсний бүтээгдэхүүний экспорт БНСУ-ын нийт экспортын ердөө 1.2%-ийг л эзэлж байгаа нь дунджаар 7.7%-ийн хүнсний бүтээгдэхүүн экспортолдог бусад орнуудтай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт юм. Гэсэн хэдий ч БНСУ-ын хүнсний бүтээгдэхүүний экспорт тогтмол нэмэгдсээр байна.¹³⁸

Зураг 3. 2012-2020 оны хооронд БНСУ-аас экспортолсон хүнсний үнэ (тэрбум доллараар)¹³⁹



¹³⁸ Korean food export highlights <https://keia.org/the-peninsula/koreas-food-exports-reach-new-highs/>

¹³⁹ <https://www.statista.com/statistics/780427/south-korea-food-export-value/#:~:text=In%202020%2C%20the%20export%20value,value%20increased%20throughout%20the%20years.>

2020 онд хүнсний экспортын үнэ 7,98 тэрбум ам.доллар болж, өмнөх оны үзүүлэлтээс ойролцоогоор 0.31 тэрбум ам.доллараар өссөн байна. Экспортын хэмжээ 2012 оноос жил бүр тогтвортой өссөөр байна.

Ковид-19 Цар тахлын үед БНСУ-ын хүнсний экспорт тасралтгүй өссөн ба тэр дундаа кимчи, рамен (бэлэн хоол)-ы экспортын хэмжээ онцгой өссөн байна. Солонгос Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас 2020 онд 01 дүгээр сараас 8 дугаар сарын хооронд ХАА хүнсний бүтээгдэхүүний экспортын хэмжээ 4.9%-аар өссөн (4.9 сая ам доллар) хэмээн зарласан ба тэр дундаа кимчиний экспортын хэмжээ хамгийн их буюу 40.3% (97.9 сая ам доллар) ба түүний дараа рамен 36.7% (89.1 сая ам доллар) тус тус өссөн байна.

Олон улсын худалдааны нэгдсэн сан бүхий ОЕС-д тавигдсан мэдээллээр 2020 оны байдлаар БНСУ-ын ургамлын гаралтай, амьтны гаралтай хүнсний 189 нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн байна. Үүнээс 10 топ бүтээгдэхүүний төрөл нь дараах байдлаар бүртгэгдсэн байна.¹⁴⁰

Хүснэгт 3.БНСУ-ын ургамлын болон амьтны гаралтай хүнсний топ 10 бүтээгдэхүүн

Төрөл	Бүтээгдэхүүн	Худалдааны үнэ
Хүнс	Ороосон тамхи /Rolled Tobacco/	893.820.950\$
Хүнс	Боловсруулсан жимс болон самар /Other Processed Fruits and Nuts/	814.955.669\$
Хүнс	Паста /Pasta/	784.298.722\$
Амьтны гаралтай бүтээгдэхүүн	Хөлдөөсөн загас /Non-fillet Frozen Fish/	607.331.873\$
Хүнс	Бусад хүнсний бэлдмэл /Other Edible Preparations/	604.196.706\$
Хүнс	Амттай ус /Flavored Water/	498.684.457\$
Хүнс	Соус ба амтлагч /Sauces and Seasonings/	309.068.965\$
Хүнс	Гурилан бүтээгдэхүүн /Baked Goods/	281.399.472\$
Амьтны гаралтай бүтээгдэхүүн	Загасны мах /Fish Fillets/	26.307.8471\$
Хүнс	Боловсруулсан хавч /Processed Crustaceans/	25.789.7192\$

Төрөөс баримталж буй бодлого, хууль эрх зүйн орчин

Цагаан будааны тариалан эрхлэгчид цагаан будааны орлогын нөхөн олговрын тухай хуулийн (Rice Income Compensation Act¹⁴¹) дагуу төрөөс дэмжлэг авдаг байна. Үүнд,

Талбайн төлбөр: Энэхүү төлбөрийг “га тутамд” тооцож, 1998-2000 оны суурь үеийн цагаан будааны үйлдвэрлэлийн дундаж талбайг ашиглан тооцдог. 2018 оны талбайн дундаж төлбөр нэг га талбайд дунджаар 909 ам. доллар байна.

Энэхүү дэмжлэгийн хөтөлбөрт хамрагдсан талбай 2018 онд 818,000 га талбайд хүрсэн бөгөөд газар ашигласны төлбөр 817.1 тэрбум солонгос вон (743 сая доллар) болсон байна.

Ургацын хомстлын төлбөр (Deficiency Payment): 2018 оны ургац хураалтын үеийн улсын дундаж зах зээлийн үнэ болон Засгийн газраас тогтоосон 2018 оны зорилтот үнийн зөрүүнээс талбайн төлбөрийг хасч тооцсон үнийн дүнгийн 85 хувиар хомстлын төлбөр төлнө.

Дээрх хоёр төрлийн төлбөрөөс цагаан будааны тариалан эрхлэгчдийг төрөөс дэмжин хөнгөлөлт үзүүлдэг байна.

¹⁴⁰ https://oec.world/en/visualize/tree_map/hs92/export/kor/all/show/2020/

¹⁴¹ <https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=Rice+Income+Compensation+Act+&x=0&y=0#lBgcolor0>

Нийтийн хүнсний үр тарианы нөөцийг хангах Засгийн газрын будаа худалдан авах хөтөлбөр (Government Rice Purchase Program under the Public Food Grain Stockholding Program): Засгийн газар хүнсний аюулгүй байдал, үнийн тогтвортой байдлыг хангах үүднээс нийгэмд шаардлагатай будааны нөөцийг бүрдүүлэх зорилгоор будааг худалдаж авдаг. Уг хөтөлбөрийн дагуу БНСУ-ын засгийн газар ургац хураалтын үеэр дотоодын цагаан будааг зах зээлийн дундаж үнээр худалдаж аван дараа нь ургац хураалтын бус үед дотоодын зах зээлийн үнээр борлуулдаг. 2018 оны 10-р сараас 12-р сарын хооронд БНСУ-ын засгийн газар 340,000 тонн энгийн будаа 350,000 МТ (тээрэмдсэн) цагаан будаа, нөөцөд зориулан нэмэлтээр 10,000 тонн будаа худалдаж авсан байна.

Засгийн газар болон Үндэсний Хөдөө Аж Ахуйн Хоршоодын Холбооны (NACF) цагаан будааны бизнес эрхлэгчдэд олгох зээлийн хөтөлбөрүүд (Government and National Agricultural Cooperative Federation's (NACF's) Loan Programs to Rice Millers): Засгийн газар 2018 онд дээрх холбооны дэмжлэгтэйгээр дотоодын будаа үйлдвэрлэгчдэд 1.28 их наяд солонгос вон (1.16 тэрбум ам.доллар) жилийн 0-2 хувийн хүүтэй тусгай зээл олгосон байна. Мөн цаашлаад үндэсний тариаланчдын холбоо мөн цагаан будааны тариаланч тээрэмчдэд тэг хүүтэй 1.9 их наяд солонгос воны (1.7 тэрбум ам.доллар) зээлийг үргэлжлүүлэн олгосон. Уг зээлийн хөтөлбөрүүдийн гол зорилго нь дотоодын будаа үйлдвэрлэлтийг дэмжиж зах зээл дээрх үнийн дарамтыг бууруулах ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байдаг байна.

Хөдөө аж ахуй, загасны гаралтай бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах тухай хууль¹⁴² (Enforcement Rules of the Act on the Distribution and Price Stabilization of Agricultural and Fishery Products): Уг хууль нь 5 бүлэг 57 зүйлтэй ба үүнд Ерөнхий заалтууд, Хөдөө аж ахуй, загасны гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлтийн хяналт, Хөдөө аж ахуй, загасны гаралтай бүтээгдэхүүний зах зээл, Хөдөө аж ахуй, загасны гаралтай бүтээгдэхүүн нийлүүлэх байгууллагуудын зохицуулалт, нэмэлт зохицуулалтууд зэрэг агуулгууд багтсан байна. Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2021 оны 511 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон байна.

ХАА-н бүтээгдэхүүн, түүний дотор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, ойн гаралтай бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг сайжруулах зорилгоор Засгийн газраас Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах санг (Price Stabilization Fund) байгуулсан байна. Тус сан нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ.

- Засгийн газрын хөрөнгө оруулалт;
- Сангийн үйл ажиллагаанаас олсон орлого;
- Бусад сангаас оруулсан хөрөнгө оруулалт.

Уг сан ХАА-н бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах зорилгоор дараах төслүүдийг санхүүжүүлж, зээл олгодог байна.

- ХАА-н бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, үйлдвэрлэх, зах зээлд гаргахыг дэмжих төслүүд;
- ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих төслүүд;
- ХАА-н бүтээгдэхүүнийг хадгалах, боловсруулах төслүүд;
- ХАА-н бүтээгдэхүүний борлуулалтыг сайжруулах төслүүд.

Уг хуулийн хүрээнд ХАА-н үйлдвэрлэл, дотоодын хэрэгцээг урт хугацаандаа тогтвортой хангах, хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалах зэрэг холбогдох төслүүдэд зээл олгож санхүүжүүлэх хэлбэрээр дэмжлэг үзүүлдэг байна.

¹⁴² Enforcement Rules of the Act on the Distribution and Price Stabilization of Agricultural and Fishery Products <https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%86%8D%EC%88%98%EC%82%B0%EB%AC%BC%EC%9C%A0%ED%86%B5%EB%B0%8F%EA%B0%80%EA%B2%A9%EC%95%88%EC%A0%95%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0%EC%8B%9C%ED%96%89%EA%B7%9C%EC%B9%99>

БНСУ-ын үнэ зохицуулах бодлого

Зах зээлийн үнийг дэмжих тал дээр БНСУ дотоодын үнэ тогтворжуулах арга хэмжээнүүд, тухайлбал, Засгийн газрын хамтарсан худалдан авалт, квот, импортын хяналт зэрэг арга хэмжээнүүд багтдаг. 1994 оноос эхлэн цагаан будааны импортыг тусгай зөвшөөрлийн системээр хянадаг байсан нь үр дүнтэй арга хэмжээ болж байсан байна.

1993 он хүртэл Засгийн газар цагаан будааны нөөцийг бүрдүүлж худалдан авалт хийн жижиглэнгийн тогтмол үнээр зарж байсан ба одоо хувийн хэвшлийн сувгууд зах зээлд цагаан будаа нийлүүлж байна. Одоогоор импортын бүтээгдэхүүнд зөвхөн тариф ногдуулдаг болсон.

Цагаан будаа: ХАА-н үйлдвэрлэлийн нийт үнийн дүнгийн 30 гаруй хувийг цагаан будаа дангаараа эзэлдэг ба ХАА-н голлох чухал бүтээгдэхүүн юм. Цагаан будааны салбарын бодлого нь дотоодын үнийг дэмжих зорилготой хэд хэдэн оролцогч талуудаас бүрддэг бөгөөд үүнд Засгийн газар дотоодын үйлдвэрлэлийг зохицуулалттай үнээр худалдан авах, импортыг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүд орно. 1970-аад оноос хойш Засгийн газар цагаан будааны үйлдвэрлэлийн тодорхой хувийг худалдан авч, зах зээл дээр борлуулагдах үнэ болон худалдан авах хэмжээг урьдчилан тогтоодог байсан байна. 1980-аад оны үед Засгийн газрын худалдан авсан цагаан будааны зах зээлд эзлэх хувь 14-23%-д хэлбэлзэж байв. Энэ нь 1990 онд 29%-д хүрч, 1990-ээд оны эхээр бага зэрэг буурч, 1994-1996 онд 30% орчим болсон байна.

3.ЯПОН УЛС

Япон Улс 2020 оны байдлаар нийт экспортын хэмжээгээр дэлхийд 4-т, импортын хэмжээгээр 5-д, нэг хүнд ногдох ДНБ-ээр (одоогийн ам.доллар) 25-т жагссан үзүүлэлттэй байна.¹⁴³

ОЕС-ийн тайланд¹⁴⁴ дурдсанаар, 2022 оны 3 дугаар сарын байдлаар тус улс нь 8.46 иений экспорт, 8.87 иений импорт хийж, худалдааны тэнцэл 414 тэрбум иен болжээ. 2021 оны 3 дугаар сараас 2022 оны 3 дугаар сарын хооронд экспорт 7.38 иенээс 8.46 иен хүрч 1.08 иенээр (14.7%), импорт 6.72 иенээс 8.87 иен хүрч 2.15 иенээр (32%) тус тус өссөн байна.

2020 онд Япон 64.7 сая долларын цагаан будаа экспортолж, дэлхийд 29-р байрт бичигдсэн байна. Японы цагаан будааны гол экспортлогч орнууд:

- Хонконг 28% (16.8 сая ам.доллар)
- Сингапур 12.4% (7.35 сая ам.доллар)
- Бусад Азийн орнууд 9.89% (5.83 сая ам.доллар)
- АНУ 8.98% (5.29 сая доллар)
- Мавритани 6.71% (3.95 сая доллар)
- Австрали 5.31% (3.13 сая доллар)
- Хятад 5.1% (3 сая ам.доллар)
- Тайланд 2.3% (1.36 сая ам.доллар)
- Их Британи 2.08% (1.23 сая ам.доллар)
- Сенегал 2.03% (1.2 сая ам.доллар)


Экспортод гаргадаг хүнсний бүтээгдэхүүн. Японы хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүний экспорт сүүлийн 6 жилийн хугацаанд тогтмол өссөн байна.¹⁴⁵ (Зураг 3)

¹⁴³ <https://oec.world/en/profile/country/jpn>

¹⁴⁴ <https://oec.world/en/profile/country/jpn>


¹⁴⁵ https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf

Зураг 4. Японы хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон далайн гаралтай бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээ (тэрбум доллар), 2016-2021¹⁴⁶



Source: Trade Data Monitor

Зураг 5. Японы хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт, орноор (тэрбум доллар), 2016-2021¹⁴⁷



Source: Trade Data Monitor

https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf
https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf

Хүснэгт 4. Японы экспортод гаргадаг топ 20-н хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн
(сая иен), 2016-2021¹⁴⁸

Rank	Product	2016	2017	2018	2019	2020	2021	2021/16
1	Alcohol beverages	42,996	54,503	61,827	66,083	71,030	114,668	167%
2	Scallops	54,834	46,254	47,675	44,672	31,446	63,943	17%
3	Beef	13,552	19,156	24,731	29,675	28,874	53,679	296%
4	Sauces	27,372	29,590	32,539	33,657	36,542	43,533	59%
5	Soft drinks	19,431	24,505	28,167	30,391	34,164	40,570	109%
6	Yellow tail	13,473	15,380	15,765	22,920	17,262	24,620	83%
7	Confectionary/snacks	18,162	18,222	20,364	20,156	18,809	24,422	34%
8	Mackerel	17,986	21,885	26,690	20,612	20,444	22,025	22%
9	Logs	8,466	13,683	14,800	14,714	16,339	21,070	149%
10	Green tea	11,551	14,357	15,333	14,642	16,188	20,418	77%
11	Tuna and bonito	9,794	14,262	17,943	15,261	20,388	20,413	108%
12	Apples	13,299	10,948	13,970	14,492	10,702	16,212	22%
13	Sea cucumber	18,175	20,740	21,070	20,775	18,117	15,515	-15%
14	Tobacco	21,873	13,820	18,513	16,375	14,203	14,553	-33%
15	Infant formula	7,728	8,398	8,827	11,263	13,714	13,918	80%
16	Seeds for sowing	14,623	15,166	12,751	13,108	12,516	12,422	-15%
17	Soup broth	8,334	9,498	11,510	10,982	10,673	11,827	42%
18	Fish paste	9,272	9,520	10,667	11,168	10,382	11,258	21%
19	Instant coffee	2,419	2,363	2,792	3,493	9,231	8,822	265%
20	Bonsai trees	8,033	12,632	11,962	9,288	10,552	6,931	-14%

Source: MAFF

ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Японы хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн экспортлохтой холбогдох харилцааг бие даасан хууль болон бусад эрх зүйн баримт бичгээр зохицуулдаг. Үүнд:

- Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлт, үнийг тогтворжуулах тухай хууль;
- Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүний экспортыг дэмжих тухай хууль;
- Хөдөө аж ахуйн экспортыг хөнгөвчлөх тухай хууль.

Хүнсний бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн үнийг тогтворжуулах тухай хууль (Law for Stabilization of Supply Demand and Price of Staple Food)¹⁴⁹ –ийг баталж, 2004 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Японы хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох цагаан будаа, улаан буудай, арвай нь ХАА-н салбарт чухал байр суурь эзэлдэг тул үйлдвэрлэгчдээс хэрэглэгчдэд цагаан будааг түгээх цогц арга хэмжээг авахаар тус хуульд тусгасан байна. Мөн Засгийн газраас хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийг худалдан авах, импортлох, борлуулах зэрэг арга хэмжээг энэхүү хуулиар зохицуулж байна.

¹⁴⁸ https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf

¹⁴⁹ Law For Stabilization Of Supply Demand And Price Of Staple Food, https://www8.cao.go.jp/kisei-kaikaku/oto/otodb/english/houseido/hou/lh_9999-11.html

Хуулийн зорилго нь хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт, үнийг тогтворжуулах, улмаар иргэдийн амьдрал, үндэсний эдийн засгийг тогтвортой байлгахад хувь нэмэр оруулахад оршино.

Цагаан будааны эрэлт нийлүүлэлт, үнийг тогтворжуулах үндсэн чиглэлийг батлан эрэлт нийлүүлэлт, үнийг тогтворжуулахын тулд Засгийн газар цагаан будааны эрэлт, нийлүүлэлтийн урьдчилсан тооцоог гаргадаг. Үүнд үндэслэн Засгийн газар цагаан будааны үйлдвэрлэлийн зохицуулалтыг жигдрүүлэх, нөөцийн урт, дунд хугацаанд үр ашигтай бодлого, дэмжлэг үзүүлэн ажилладаг.

Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүний экспортыг дэмжих тухай хууль (Act on Facilitating the Export of Agricultural, Forestry, and Fishery Products and Food) –ийг 2019 онд баталсан.¹⁵⁰

Хуулийн зорилго нь хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүн экспортлох төвийг байгуулах, дүрэм журмыг ханган ажиллах, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад оршино.

Энэхүү хуулиар “Японы хүнсний бүтээгдэхүүнийг гадаадад сурталчилах төв”-ийн чиг үүргийг заасан байна. Японд үйлдвэрлэсэн хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүнийг экспортлоход дэмжлэг үзүүлэх зорилгоор үндсэн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, экспортын гэрчилгээ олгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх юм. Японы Засгийн газар хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж япон үндэсний хоол хүнсийг гадаадад сурталчлах болон бусад арга хэмжээг авч ажилласаар байна.

2017 онд Засгийн газрын харьяа Японы гадаад худалдааны байгууллагын дэргэд **Японы хүнсний бүтээгдэхүүнийг гадаадад сурталчлах төв**¹⁵¹ (The Japan Food Product Overseas Promotion Center - JFOODO) байгуулагдаж Японы хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүний брэндийг сурталчлан ажиллаж байна. Иймд бүтээгдэхүүний экспортыг цаашид нэмэгдүүлэхийн тулд энэхүү хууль нь импортлогч орнуудтай Засгийн газрын хэлэлцээр хийх, экспортын гэрчилгээ олгох зэрэг экспорттой холбоотой тогтолцоог оновчтой болгох замаар экспортыг хөнгөвчлөх зорилготой юм.

Японы хөдөө аж ахуйн экспортыг хөнгөвчлөх тухай хууль¹⁵² (Agricultural Export Facilitation Act)-ийг 2022 онд шинэчлэн баталжээ.

Хуулийн зорилго нь хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түгээлтэд инновац хийхээр төлөвлөж буй хүнсний экспортын бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгч, борлуулагчдад зээл авах эрх зүйн орчинг бүрдүүлжээ. Ингэснээр тухайн бүтээгдэхүүнд хамаарах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бага хүүтэй, урт хугацаатай зээлийн сан байгуулжээ. Тус хуулиар MFF-аас зөвшөөрөгдсөн хувийн хэвшлийн байгууллагуудад экспортын гэрчилгээ олгох тогтолцоог бий болгосон.

Мөн тус хуулиар дараах асуудлыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Онцлогтой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох;
- Зөвшөөрөгдсөн экспортлогчдод үзүүлэх дэмжлэгийг өргөжүүлэх;
- Хяналтын байгууллагаас экспортын гэрчилгээ олгох.

¹⁵⁰ Act on Facilitating the Export of Agricultural, Forestry and Fishery Products and Food, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3583/en>

¹⁵¹ <https://www.jetro.go.jp/en/jfoodo/>

¹⁵² https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf

Дээрх хууль эрх зүйн орчноос гадна дараах стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж байна.

Япон Улсын хөдөө аж ахуйн экспортыг өргөжүүлэх стратеги төлөвлөгөө¹⁵³ Японы Засгийн газар Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загасны гаралтай хүнс, бүтээгдэхүүн тэдгээрийн экспортыг тэлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг 2020 онд баталсан.

Зорилго нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загас, загасан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бөгөөд эдгээр салбарын бизнес эрхлэгчдийн ашгийг нэмэгдүүлэх юм. Мөн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийг төвлөрүүлэх, бүс нутгуудыг тодорхойлж экспортод чиглэсэн бизнесийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж Засгийн газрын үйл ажиллагааг оновчтой болгох алхмуудыг хийх юм.

Экспортыг өргөжүүлэх стратеги төлөвлөгөө нь гурван үндсэн зарчим дээр суурилдаг.

- Японы давуу талыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүнүүдийг тодорхойлох;
- Бүтээгдэхүүн экспортлох сорилтыг даван туулж буй бизнесүүдийг дэмжих;
- Экспортын саад бэрхшээлийг шийдвэрлэх засгийн газрын хандлагыг нэгтгэх.

Энэхүү стратеги төлөвлөгөөнд бүтээгдэхүүний экспортын зорилтыг 2025 онд хоёр их наяд иен (19 тэрбум ам.доллар), 2030 онд таван их наяд иен (48 тэрбум ам. доллар) болгох зорилттой экспортын өсөлтийг хангах боломжтой 27 бүтээгдэхүүнийг тодорхойлж, экспортыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

1. Үхрийн мах
2. Гахайн мах
3. Тахианы мах
4. Өндөг
5. Хүүхдийн хуурай сүү
6. Алим
7. Усан үзэм
8. Тоор
9. Цитрус
10. Гүзээлзгэнэ
11. Амтат төмс
12. Цэцэг
13. Ногоон цай
14. Будаа (бэлэн бүтээгдэхүүн, нэг удаагийн хэрэглээний цагаан будааны гурил, цагаан будааны гурилан бүтээгдэхүүн)
15. Мод
16. Фанер
17. Бүри (шар сүүлт загас)
18. Тай (далайн боргоцой)
19. Хулуу
20. Судв
21. Ундаа
22. Чихэр
23. Соус, амтлагч
24. Мисо (шар буурцагны соус, нухаш)
25. Nihonshu (будааны дарс)
26. Виски
27. Шочу, Авамори (нэрмэл архи)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁵³ https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Establishes%20Agricultural%20Export%20Expansion%20Strategy_Tokyo_Japan_12-10-2020

Хүснэгт 5. Хөдөө аж ахуйн бодлогын чиг хандлага¹⁵⁴

Хугацаа	Хэрэгжүүлсэн бодлого	Хөдөө аж ахуйн бодлогод гарсан өөрчлөлт
1960 оноос өмнө	Хөдөө орон нутгийн ядуурлыг арилгах, хүнсний хангамжийг нэмэгдүүлж	<ul style="list-style-type: none"> Тариаланчдад тариалангийн талбай эзэмшихэд нь туслах зорилгоор газрын шинэчлэлийг хэрэгжүүлсэн; Хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлого (Хөдөө аж ахуйн хоршооллын тухай хууль 1947, Хөдөө аж ахуйн гамшгийн нөхөн төлбөрийн тухай хууль 1947, Хөдөө аж ахуйн газрын тухай хууль 1952; Хүнсний хомстлыг шийдвэрлэхийн тулд будааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого (Хүнсний менежментийн тухай хууль 1942, Хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх 5 жилийн төлөвлөгөө 1952;
1960-1980	Хөдөө аж ахуйн болон бусад салбаруудын орлогын ялгааг бууруулах	<ul style="list-style-type: none"> Хөдөө аж ахуйн хуулийн зорилго нь фермийн хэмжээг нэмэгдүүлэх, тариалангийн талбайг сайжруулах, хөдөө аж ахуйн техник технологийг нэвтрүүлэх, будаа улаан буудайн үйлдвэрлэлээс мал аж ахуй, хүнсний ногоо, жимс жимсгэнэ рүү шилжих замаар тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх 1961 он; Цагаан будааны бодлогыг хэрэгжүүлсэн 1967 он; Цагаан будааны үйлдвэрлэлийн тохируулгын хяналтыг нэвтрүүлсэн 1971 он;
1980-2010	Олон улсын түвшинд нийцүүлэх, хөдөө аж ахуйн салбарт зах зээлийн зарчмуудыг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн бодлогод “хөдөө орон нутаг”, “хүнс” гэсэн ойлголтуудыг нэгтгэх	<ul style="list-style-type: none"> Хөдөө аж ахуйн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх тухай хуулиар мэргэшсэн тариаланчдад үзүүлэх дэмжлэгийг системчилсэн 1993 он; Үндсэн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт, эрэлт, үнийг тогтворжуулах тухай хууль цагаан будааны улсын худалдаанд Засгийн газрын үүргийг өөрчилсөн 1994 он; Засгийн газар зөвхөн нөөцлөх зорилгоор худалдан авах; Цагаан будааны тоон квотыг тарифын квотоор сольсон 1999 он; Хүнс, хөдөө аж ахуй, хөдөөгийн байдлын тухай хуулиар эдийн засаг, нийгмийн шинэ нөхцөлд хөдөө аж ахуйн тогтвортой бүтцийг бий болгох 1999 он; Алслагдсан газар тариалан эрхлэгчид хоол хүнсээр өөрийгөө хангах зорилт, шууд төлбөрийг нэвтрүүлсэн 1999 он;
2010-одоог хүртэл	Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд хөдөө аж ахуйн шинэ шинэчлэл	<ul style="list-style-type: none"> Тариалангийн газрын шинэчлэл (Хөдөө аж ахуйн газрыг нэгтгэх ажлыг хөнгөвчлөх зорилгоор 2009 оны Хөдөө аж ахуйн газрын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2013 оны Хөдөө аж ахуйн газрын зуучлалын менежментийг дэмжих тухай хууль); Хөдөө аж ахуйн хоршоодын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2015 он; Цагаан будааны үйлдвэрлэлийн квотын тогтолцоог халах 2018 он; Орлогын даатгалын хөтөлбөрийн танилцуулга 2019 он; Томоохон худалдааны хэлэлцээрүүд (Номхон далай дамнасан түншлэлийн иж бүрэн ба дэвшилтэт хэлэлцээр 2018 он, Япон-ЕХ-ны эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр 2019, Япон-АНУ-ын худалдааны хэлэлцээр 2019, Хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүний экспортыг дэмжих хөтөлбөр.)

4.НИДЕРЛАНДЫН ХААНТ УЛС

Нидерланд нь 2020 оны байдлаар ДНБ-ээр дэлхийн хэмжээнд 17-р, эдийн засаг, нийт бүтээгдэхүүн экспортоор (511 тэрбум ам.доллар) 6-р, импортоор (524 тэрбум ам.доллар) 8-р, нэг хүнд ногдох ДНБ (экспорт 29.3 мянган ам.доллар, импорт 30.1 мянган ам.доллар)-

¹⁵⁴ <https://www.oecd-ilibrary.org/sites/e4c38702-en/index.html?itemId=/content/component/e4c38702-en>

ээр 12-р байранд тус тус жагссан. Эдийн засгийн хүндрэлийн индексээр дэлхийн 127 улсаас 22-р байрыг эзэлсэн байна.¹⁵⁵

Хүснэгт 6. Нидерланд Улсын 2020 оны байдлаар экспорт, импортын үзүүлэлт (ам.доллараар)

2020 оны нийт бүтээгдэхүүн		2020 оны нэг хүнд ногдох ДНБ		2018 оны худалдаа үйлчилгээ	
экспорт	импорт	экспорт	импорт	экспорт	импорт
511 тэрбум	524 тэрбум	29.3 мянга	30.1 мянга	253 тэрбум	239 тэрбум

Эх сурвалж: <https://oec.world/en/profile/country/nld>

Хүснэгт 7. Нидерландын 2020 оны байдлаар экспорт, импортын бараа, бүтээгдэхүүн, (тэрбум ам.доллараар)

Экспорт		Импорт	
Бусад амьд ургамал	4.4	Үйлдвэрлэлийн тосны хүчил, тос, спиртний төрөл	5.73
Тайрсан цэцэг	4.01	Какао, шошны төрөл	1.78
Соёолжны ханд	3.4	Тээврийн хэрэгсэл	1.55
Завь	2.81	Спиртний төрөл	1.25
Нүүрсний давирхайн тос	2.52	Хүнсний биш тос	1.14

Эх сурвалж: <https://oec.world/en/profile/country/nld>

2021 оны байдлаар:

2021 оны 10 дугаар сарын байдлаар Нидерланд Улс нь 45.1 тэрбум еврогийн бараа, бүтээгдэхүүнийг экспортолж, 43.1 тэрбум еврогийн бараа, бүтээгдэхүүнийг импортолсны үр дүнд 2.01 тэрбум еврогийн худалдааны тэнцэл эерэг гарсан байна.¹⁵⁶

2020-2021 оны 10 дугаар сарын байдлаар:

- экспорт 41.5 тэрбум еврогоос 3.64 тэрбум еврогоор нэмэгдэж, 45.1 тэрбум евро буюу 8.76% -аар өссөн;
- импорт 35.3 тэрбум еврогоос 43.1 тэрбум европ хүрч, 7.8 тэрбум евро буюу 22%-аар тус тус өссөн үзүүлэлтэй байна.¹⁵⁷

Экспортод гаргадаг хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний жагсаалт, товч мэдээлэл

АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны Хөдөө аж ахуйн гадаад харилцааны алба (United States Department of Agriculture, Foreign Agricultural service (USDA)) болон Дэлхийн хөдөө аж ахуйн мэдээллийн сүлжээний газар (Global Agricultural Information Network (GAIN))-ын хамтарсан “Хүнсний технологийн бүрэлдэхүүн” тайланг¹⁵⁸ 2022 оны 4 дүгээр сарын 04-ний байдлаар гаргажээ.

¹⁵⁵ <https://oec.world/en/profile/country/nld>

¹⁵⁶ <https://oec.world/en/profile/country/nld>

¹⁵⁷ <https://oec.world/en/profile/country/nld>

¹⁵⁸ Food Processing Ingredients, NL2022-001, 9April 04, 2022, https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients_The%20Hague_Netherlands_NL2022-0019.pdf



Source: Trade Data Monitor

2021 онд дараах 10 улс Нидерландад 1.5 тэрбум ам.долларын бараа, бүтээгдэхүүн нийлүүлэгч болсон байна. Үүнд, Герман, Испани, Итали, АНУ, Бельги, Англи, Бразил, Франц, Польш, Өмнөд Африк орно.

Уг тайланд дурдсанаар, Нидерландад 7340 гаруй хүнсний бүтээгдэхүүнийг компаниуд үйлдвэрлэсэн бөгөөд борлуулалтын цэвэр орлого нь 2021 онд 88 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь хүнсний жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 300,000 гаруй хүнийг

ажлын байраар тогтвортой хангасан, 4,300 гаруй хүнсний дэлгүүр үйл ажиллагаа эрхэлсэнтэй холбоотой аж. Мөн хүнсний бүтээгдэхүүний эргэлтийг хурдасгаж, онлайнаар бараа, бүтээгдэхүүнийг худалдаж авснаар 2020 онд 6.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Дээрх тайланд дурдсанаар, 2021 оны байдлаар хүнсний үйлдвэрлэл нь:

- хэрэглэгчдэд чиглэсэн бүтээгдэхүүний импорт 50.6 тэрбум ам.доллар;
- хэрэглэгчдэд чиглэсэн бүтээгдэхүүний экспорт 94.6 тэрбум ам.доллар;
- хөдөө аж ахуйн болон холбогдох бүтээгдэхүүний импорт 103.3 тэрбум ам.доллар;
- хөдөө аж ахуйн болон холбогдох бүтээгдэхүүний экспорт 140.9 тэрбум ам.доллар;
- хүнсний үйлдвэрлэл 88.0 тэрбум ам.доллар;
- хүнсний жижиглэнгийн үйлдвэрлэл 53.1 тэрбум ам.доллар;
- хүнсний үйлчилгээ 13.9 тэрбум ам.долларт хүрчээ.

Европын Холбоо (ЕХ)-ны хамгийн том импортлогч орон Нидерланд байдаг бөгөөд ХАА-н бүтээгдэхүүнээр АНУ болон Германы дараа ордог, экспортлогчоор дэлхийд хоёрдугаар байр эзэлдэг байна.¹⁵⁹

Ковид-19 цар тахлын үед

Сүүлийн хоёр жилийн хугацаанд Нидерландын хүнсний үйлдвэрлэгчдийн хувьд хүнд хэцүү үе байсан. Жил бүр гаргадаг “Хүнсний үйлдвэрлэлийн хяналт (Food Industry Monitor), Голландын Хүнс болон хүнсний аж үйлдвэрийн холбоо (Federation of Dutch Food and -FNLI)-той хамтарсан тайланд хүнсний үйлдвэрлэгчид ковидын үе ихээр нөлөөлсөн гэж мэдээлсэн. Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үед Засгийн газар “Нийгмээс тусгаарлах арга хэмжээ” авсан нь хүнсний үйлдвэрлэлийн борлуулалт ойролцоогоор гуравны нэгээр буурсан гэж үзжээ. Энэ салбар хаагдсанаас болоод ундааны төрлийн үйлдвэрлэл, биеийн тамирын заал, усан бассейн болон бусад спорт, чөлөөт цагийг өнгөрөөх газар, хүнсний компаниудын бизнес зэрэг ихээхэн хохирол амссан байна. Хүнсний жижиглэнгийн худалдаачдын борлуулдаг хүнсний үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн хувьд борлуулалт нэмэгдэж, супермаркетуудад илүү мөнгө зарцуулсан гэх мэдээлэл байна.

Үнийн өсөлт

2021 оны сүүлийн хагас жилд хүнсний салбарынхан шинэ сорилт тулгарсан. ХАА-н түүхий эд, сав баглаа боодлын материал, ачаа тээвэр, эрчим хүч гээд янз бүрийн зардлуудад мэдэгдэхүйц өсөлт ажиглагдсан. Зарим түүхий эдийн үнэ 40 хүртэлх хувиар нэмэгдсэн, харин эрчим хүчний салбарын зардал 85%-аар өссөн үзүүлэлттэй байна. Сав, баглаа боодлын материал, тухайлбал цаас болон хуванцар зүйл нь ковидын өмнөх үеэс 6 болон 12 %-аар илүү үнэтэй болсон бөгөөд хүнсний түүхий эд худалдан авагч, далайн тээврийн үнийн өсөлттэй тулгарч байсан.

¹⁵⁹https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients_The%20Hague_Netherlands_NL2022-0019.pdf

Украины дайнтай холбоотойгоор сүлжээг тасалдах, зарим түүхий эдийн үнийн өсөлтөд нөлөөлсөн гэж үздэг. Шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүнийг солих, дахин боловсруулах, туршилт хийх, бүтээгдэхүүний шошгыг өөрчлөх шаардлагатай болсон байна.

Хууль, эрх зүйн орчин

Европын Парламент болон Зөвлөл 2019 оны 1381 тоот дүрэм (*Regulation 2019/1381 of the European Parliament and of the Council*) Хүнсний тухай хууль (Food law)-ийн ерөнхий зарчим, шаардлагыг тодорхойлсон.¹⁶⁰

Европын Хүнсний аюулгүй байдлын агентлаг (European Food Safety Authority)-ыг байгуулж, хүнсний аюулгүй байдлын талаарх журмыг тогтоосон.

- Төрийн санхүүгийн тогтвортой байдлын тухай хууль (Sustainable Public Finances Act)
- Хууль тогтоомжид гарсан өөрчлөлтүүд Changes in law and regulations 1st Quarter 2022
- Хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүний импортын дүрэм болон стандарт (Food and Agricultural Import Regulations and Standards)
- Нидерландын Хүнсний Ерөнхий хуулийн зохицуулалт Regulation (EC) 178/2002 (General Food Law) ЕХ-ны Хүнсний хуулийн ерөнхий зарчим, шаардлагад нийцүүлсэн, уялдаа холбоотой зохицуулалт юм.

Төрийн байгууллага

- Хүнсний аюулгүй байдал, эрүүл хүнсийг Эрүүл мэнд, халамж спортын яам (The Ministry of Health Welfare and Sport) хариуцдаг.
- Эрүүл мэнд, халамж, спортын яамны Хоол тэжээл, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх баг- Хүнсний аюулгүй байдал (Ministry of Health, Welfare and Sport Department for Nutrition, Health Protection and Prevention Team Food Safety)
- Хөдөө аж ахуй, байгаль, хүнсний чанарын яам (Ministry of Agriculture, Nature and Food Quality)
- Сангийн яам (Ministry of Finance)
- Нидерландын Хүнс, хэрэглээ, бүтээгдэхүүний аюулгүй байдлын газар (The Netherlands Food and Consumer Product Safety Authority - NVWA)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁶⁰ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A32019R1381>

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

КАНАД

- Canada's Supply Management System, Economics, Resources and International Affairs Division,
https://lop.parl.ca/sites/PublicWebsite/default/en_CA/ResearchPublications/201842E?fbclid=IwAR1TybruF30jD4l7PsbC_dfbqqMxxnSLhwZKrW0pr3X-T-DOG1HYIxxTERY#a3
- Agricultural Marketing Board,
https://www.thecanadianencyclopedia.ca/en/article/agricultural-marketing-board?fbclid=IwAR1VDbeic__cOQ0uonRKbZENmaPIbJJSAT1TnhXW8X0cuDI-gKnyfpeWI
- Agricultural Policy Monitoring and Evaluation 2021, OECD, 23 Jun 2022, <https://www.oecd-ilibrary.org/sites/1174c7b1-en/index.html?itemId=/content/component/1174c7b1-en>
- Canadian Dairy Commission Act, https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-15/page-1.html?fbclid=IwAR0ZFGX6Vo5u_3ilbnioCM4H4s-2OVMwyEuaP54L-YH_Wx9zeSr4Lm19dfw
- Farm Products Agencies Act, <https://lois-laws.justice.gc.ca/eng/acts/F-4/page-1.html?fbclid=IwAR2WSFISS71MGlu3PULkaj5qzmSK691vwOjvz8WAnQgXEIRtD2aVMm8FUql#docCont>

БНСУ

- The food and beverage Market entry handbook: South Korea
- Review of Agriculture policies in Korea
- Review of Rice: Production, Trade, Consumption, and Future Demand in Korea and Worldwide
- Rice Production Stays Steady Despite Government's Rice Reduction Program
- Exporter Guide, Sangyong Oh October 14, 2021
- Korean food export highlights <https://keia.org/the-peninsula/koreas-food-exports-reach-new-highs/>
- <https://www.statista.com/statistics/780427/south-korea-food-export-value/#:~:text=In%202020%2C%20the%20export%20value,value%20increased%20throughout%20the%20years.>
- https://oec.world/en/visualize/tree_map/hs92/export/kor/all/show/2020/
- <https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=Rice+Income+Compensation+Act+&x=0&y=0#liBgcolor0>

ЯПОН

- <https://oec.world/en/profile/country/jpn>
- https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf
- Law For Stabilization Of Supply Demand And Price Of Staple Food-
https://www8.cao.go.jp/kisei-kaikaku/oto/otodb/english/houseido/hou/lh_9999-11.html
- Act on Facilitating the Export of Agricultural, Forestry and Fishery Products and Food-
<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3583/en>
- <https://www.jetro.go.jp/en/jfoodo/>
- https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Revises%20Agricultural%20Export%20Facilitation%20Act_Tokyo_Japan_JA2022-0030.pdf

- https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Japan%20Establishes%20Agricultural%20Export%20Expansion%20Strategy_Tokyo_Japan_12-10-2020
- <https://www.oecd-ilibrary.org/sites/e4c38702-en/index.html?itemId=/content/component/e4c38702-en>

НИДЕРЛАНД

- <https://oec.world/en/profile/country/nld>
- https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients_The%20Hague_Netherlands_NL2022-0019.pdf
- <https://www.government.nl/topics/food/food-safety-requirements>
- https://ec.europa.eu/info/sites/default/files/stabiliteitsprogramma_2022_en.pdf
- <https://assets.kpmg/content/dam/kpmg/xx/pdf/2022/04/global-economic-outlook.pdf>
- https://www.un.org/development/desa/dpad/wp-content/uploads/sites/45/WESP2022_CH2.pdf
- https://ec.europa.eu/info/sites/default/files/food-farming-fisheries/farming/documents/short-term-outlook-spring-2022_en.pdf
- https://ec.europa.eu/info/sites/default/files/food-farming-fisheries/farming/documents/commodity-price-dashboard_2022-04_en.pdf
- https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients_The%20Hague_Netherlands_NL2022-0019.pdf
- <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A02002R0178-20210526#M9-12>
- https://ec.europa.eu/info/sites/default/files/2021-netherlands-stability-programme_en.pdf
- https://ec.europa.eu/info/sites/default/files/stabiliteitsprogramma_2022_en.pdf
- https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20Processing%20Ingredients_The%20Hague_Netherlands_NL2022-0019.pdf
- https://apps.fas.usda.gov/newgainapi/api/Report/DownloadReportByFileName?fileName=Food%20and%20Agricultural%20Import%20Regulations%20and%20Standards%20Country%20Report_The%20Hague_Netherlands_12-31-2021
- https://atradiuscollections.com/documents/industry_trends_food_beverages_january_2022.pdf
- https://ec.europa.eu/info/sites/default/files/stabiliteitsprogramma_2022_en.pdf
- <https://atradiuscollections.com/global/reports/food-industry-trends-netherlands-2022.html>
- https://atradiuscollections.com/documents/industry_trends_food_beverages_january_2022.pdf
- [government-supported funding for agricultural products in the netherlands,2022 - Search \(bing.com\)](#)
- [English | Nationaal Groeifonds https://wetten.overheid.nl/BWBR0001969/2018-11-17](#)
- [Food safety requirements | Food | Government.nl https://www.government.nl/binaries/government/documenten/policy-notes/2019/11/30/plan-of-action---supporting-transition-to-circular-agriculture/Plan+of+action+-+supporting+transition+to+circular+agriculture.pdf](#)

БУСАД

- [Agricultural Policy Monitoring and Evaluation 2021, https://www.oecd.org/publications/agricultural-policy-monitoring-and-evaluation-22217371.htm](#)

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛ**

(Тойм мэдээлэл)

О.Билгүүтэй, Б.Буянзаяа

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ТОЙМ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТАЛААР
2. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ
3. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 3.3 ДАХЬ ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН ЖУРАМ
4. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛТАЙ ХОЛБООТОЙ БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЛАВЛАГАА
5. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

ХАВСРАЛТ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн зарим асуудал” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас баталсан журам болон холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой судалгааны мэдээлэлд үндэслэн 1) түгээмэл тархацтай ашигт малтмалыг орон нутагт ашиглахад хүндрэл бэрхшээл үүсч буй эсэх, 2) хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас баталсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам” нь орон нутагт бусад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж, хязгаарлалт үүсгэж буй эсэхийг тодорхойлох.

СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ТОЙМ

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их хурлаас 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” хуулийг баталж тус хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулж байна. Эрх зүйн орчны хүрээгээр авч үзвэл уг асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна.

Үзэл баримтлалын хувьд уг хуулиар түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг даргад олгосон бөгөөд ингэснээр тусгай зөвшөөрөл олгох эрх мэдлийн төвлөрлийг сааруулах бодлого баримталсан. Ингэхдээ “Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно” хэмээн хуулийн 3.3-т заасан.

Сэдвийн хүрээнд уг хууль болон хуулийн 3.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор баталсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам” нь орон нутагт бусад хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хязгаарлалт үүсгэж, хүндрэл учруулж байгаа эсэхийг судлах зорилго тавьсан тул нөхцөл байдлыг олдсон мэдээллүүдийн хүрээнд дараах байдлаар тоймлон танилцуулж байна.

Нэг. Уг хуулиар орон нутагт эрх мэдлийг бодитоор шилжүүлж, түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтын дагуу ашиглуулах, зөрчил гаргасан тохиолдол уг зөрчлийг таслан зогсоох, байгаль орчин нөхөн сэргээлтэд хяналт тавих боломжийг бүрдүүлснээрээ давуу талтай байна. Мөн орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, зам барилга, бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдүүд дур мэдэн дуртай газраа ухаж сэндийлэн элс, хайрга олборлох явдлыг таслан зогсоох, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах асуудлыг шийдвэрлэхийг зорьсон. Судалгаанаас үзэхэд, улсын дүнгээр 2016 оноос хойш орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого жил бүр өссөн

дүнтэй байх ба 2016 онд 1,7 тэрбум төгрөг төвлөрүүлж байсан бол 2021 онд 5,4 тэрбум төгрөг төвлөрүүлж, жил тутам өссөн дүнтэй байна. (Хавсралт: Сангийн яамны мэдээлэл)

Хоёр. Засгийн газраас баталсан тусгай журам нь зөвхөн улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой ач холбогдолтой дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг саадгүй, шуурхай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд журмын Дөрөвдүгээр бүлэгт “зарим төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа эрх эзэмшигч нь ажил гүйцэтгэх гэрээний дагуу төслийн ерөнхий гүйцэтгэгчид ашиглалтын талбайг ашиглуулах (журмын 4.1)-аас бусад тохиолдолд ордыг зөвхөн журмын 1.3-т заасан авто зам, төмөр замын бүтээн байгуулалт буюу 1) төмөр замын суурь бүтэц барих, засварлах, 2) олон улс болон улсын чанартай, түүнчлэн Засгийн газрын зээл, бондын хөрөнгөөр, эсхүл ЗГ-аас баталгаа гарган хэрэгжүүлэх том бүтээн байгуулалт, тухайлбал авто зам, замын байгууламж барих, засварлахад ашиглана (журмын 4.2) хэмээн заасан.

Өнөөгийн байдлаар улсын чанартай зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах орон нутгийн мэдлийн түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах ажиллагааг Засгийн газраас **эрх олгох** журмаар (журмын 1.3-д заасан) шийдвэрлэж байгаа бөгөөд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдэд зам тээвэр болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын шийдвэрээр эрх олгож байна. Уг шийдвэрт тухайн төсөл хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээлт хийж орон нутгийн эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөхийг төсөл хөтөлбөрийн ажлыг гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд тогтоолоор үүрэг болгодог бөгөөд ийнхүү ашигласан талбайг орон нутагт буцаан шилжүүлснээр тухайн төсөл, хөтөлбөртэй холбоотой Засгийн газраас олгосон түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх дуусгавар болсонд тооцох журамтай. Гэвч төсөл хэрэгжүүлэгчээс хайгуулын болон ашиглалтын талбайд нөхөн сэргээлт явуулж орон нутагт хүлээлгэн өгөх ажиллагаа хэрхэн явагдаж байгаа, цаашид ордын ашиглалтыг орон нутагт хэрхэн зохион байгуулж байгаа талаарх мэдээлэл хомс байна. (Холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудаас тодруулах шаардлагатай).

Эрх зүйн орчны хүрээнд авч үзвэл, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11.2.5-д зааснаар аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрт нь хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эрхтэй. Гэвч Засгийн газраас баталсан журмын 1.4-т заасны дагуу улсын чанартай томоохон төсөл хэрэгжүүлэгч орон нутагт байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг Засгийн газрын эрх олгох шийдвэрээр олгож байна. Төсөл хэрэгжиж дууссанаар орд ашиглах тусгай эрх дуусгавар болох бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь дуусгавар болсон ашиглалтын талбайд нөхөн сэргээлт хийж орон нутгийн мэдэлд буцаан өгснөөр ордыг орон нутаг хяналтандаа авах боломжтой боловч практикт олон зөрчилтэй асуудал, хүндрэл бэрхшээл тулгарч байна гэж орон нутгийн удирдлага, ААН, иргэдээс гомдол санал гардаг тул Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль болон журам хоорондын уялдаа холбоо, зөрчил хийдлийг арилгах асуудлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор судлан шийдвэрлэх нь зүйтэй болов уу.

Өөрөөр хэлбэл, Хууль тогтоомжоор орон нутгийн чанартай хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад тухайн нутаг дэвсгэрт байгаа түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, хайх, олборлох эрхийг хязгаарласан заалт байхгүй боловч хууль хэрэгжүүлэх шатанд Засгийн газраас “эрх” олгох замаар энэхүү асуудлыг шийдвэрлэж байгаа нь “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” хуулийн 11.2.5-д заасан нутгийн удирдах байгууллагын эрхийг шууд бусаар хязгаарлаж, улмаар эдгээр ордыг орон нутгийн түвшинд ашиглах дараа дараагийн ажиллагаанд хүндрэл учруулж байж болзошгүй хэмээн дүгнэж байна. Тухайлбал, захиалагчаас иоввлсэн албан бичигт энэ талаар длодсанаас гадна зарим аймгийн ИТХ-аас

ийнхүү ашиглаад орхисон элс, хайрга, хүрмэн чулууны орд эзэнгүйдэж сум орон нутгийн байгаль орчин ихээр сүйдэж байгаа талаар мэдээлсэн байна. Орон нутгийн төрийн захиргааны төв байгууллага, барилга үйлдвэр эрхлэгчид болон иргэдээс ч мөн тодорхой санал гомдол гарч байгаа учраас “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч буй гажуудал, үр нөлөөг мэргэжлийн байгууллагуудын хүрээнд судлан шинжилж, шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой хэмээн үзэж байна.

Судалгааны явцад уг асуудлаар хийгдсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан болон холбогдох бусад мэдээллийн хайлт хийж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад хандсан боловч судалгаанд шаардагдах иж бүрэн мэдээлэл, дүгнэлтийг олж авч чадаагүй болно. Иймд холбогдох байгууллага, нэгжүүдээс авсан мэдээлэл, эрх зүйн орчны харьцуулалтад үндэслэн дараах асуудлуудыг онцгойлон танилцуулж байна.

- Холбогдох хууль, журмаар орон нутгийн чанартай хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, цуцлахтай холбоотой асуудлыг тус журмын¹⁶¹ 1 дүгээр зүйлийн 1.3, 1.4 дэх хэсэгт зааснаас бусад зорилгоор ашиглахтай холбоотой харилцааг эрх зүйн орчны хүрээнд хориглоогүй боловч тодорхой зохицуулаагүй байна.
- Орон нутгийн чанартай хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын бусад ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой аймаг, нийслэлийн Засаг даргын хуулиар олгосон эрх хүчин төгөлдөр хэвээр байна.
- Засгийн газраас баталсан журамд түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашигласны төлбөр тооцох, төлөхтэй холбоотой харилцааг тодорхой зохицуулсан.¹⁶² Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрх авсан хуулийн этгээд нь холбогдох хууль, журмын дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөхгүй.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль болон Засгийн газрын тусгай журмын нийцэл, уялдаа холбоог хянах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөрчлийг шийдвэрлэх арга хэмжээ авах.

Жич: Одоогоор Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газраас зөвхөн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3.3 “Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно” хэмээх заалтыг 100% хэрэгжсэн хэмээн үзэж хяналтаас хассан байдалтай байна. Засгийн газрын түвшинд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай тайлан, мэдээлэл олдоогүй болно.

Түлхүүр үг: Түгээмэл тархацтай ашигт малтмал, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн журам

Key Words: Common minerals, Legislation of common minerals, Amendment of common minerals law, Government rules of common minerals law

¹⁶¹ Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам

¹⁶² Ibid Тав.Төлбөр тооцох. төлөх

СУДАЛГААНЫ ХЭСЭГ**1. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛЫН ТАЛААР**

Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага: УИХ 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Ашигт малтмал тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийг баталж 2010 оноос хойш 3 жилийн хугацаанд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдоогүй байна.

Хуулиар тусгай зөвшөөрөл олгохыг хориглосноор хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо буурч, ашиглалтын тусгал зөвшөөрлийн тоо өссөн нь зарим талдаа сайн боловч зам, барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж буй үед тэдгээрийн бүтээн байгуулалтад шаардлагатай элс, хайрга зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын ажил зогсонги байдалд орсон нь сөрөг үр дагавартай байсан байна. Барилга бүтээн байгуулалтад шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт Улаанбаатар хотын ойролцоо Туул голын дагуу төвлөрч байсан нь хотын хүн амын унд, ахуйн хэрэгцээний усан хангамж болон Туул голын экологийн орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлж байсан хэмээн үзэж байжээ. Иймд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлэн нөөцийг тогтоон ашиглалтад оруулж Засгийн газрын үйл ажиллагааны 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан дэд бүтцийн болон бүтээн байгуулалтын арга хэмжээнүүдэд шаардлагатай түүхий эдээр хангах шаардлага үүссэн байна.

Нийгэм, эдийн засгийн ач холбогдол

Нийгмийн үр дагавар:

- Улаанбаатар хотын ойр орчим, Туул голын хөндий дагасан элс, хайрганы тусгай зөвшөөрөлд зохицуулалт хийх;
- Зам барилга бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдүүд дур мэдэн дуртай газраа ухаж сэндийчэн элс, хайрга олборлох үйл ажиллагаа зогсоох;
- Орон нутагт ажлын байр нэмэгдэх;
- Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад газар нутгийнхаа хаана нь түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох боломжийг бүрдүүлэх;
- Орон нутгийн зүгээс ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад дэмждэг болох.

Эдийн засгийн үр дагавар:

- Засгийн газрын үйл ажиллагааны 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зам, барилгын бүтээн байгуулалтын зорилгууд хэрэгжих;
- Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх;
- Ажлын байр нэмэгдэж, ард иргэдийн амьдралын чанар дээшилнэ.

2. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Их хурлаас 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” хуулийг баталжээ. Энэ хууль нь 10 бүлэг 44 зүйлтэй байна.

Тус хуулиар түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна. Хуульд тодорхойлсноор “түгээмэл тархацтай ашигт малтмал” гэдэгт зам, барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий элс, хайрга,

тоосгоны шавар, хүрмэн, боржин, дайрганы зориулалттай барилгын чулууны хуримтлалыг хамааруулсан байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно. Ингэхдээ нэг тусгай зөвшөөрлийг зөвхөн нэг хуулийн этгээдийн нэр дээр олгохоор тус хуульд заасан. Өөрөөр хэлбэл, тусгай зөвшөөрөл авахыг хүссэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлд хязгаарлалт тогтоогоогүй бөгөөд харин нэг тусгай зөвшөөрлийг хоёр болон түүнээс дээш хуулийн этгээд хамтран эзэмшихийг хязгаарласан байна.

Орон нутагт эрх мэдлийг бодитоор тусгаж өгсөн нь хуулийн гол онцлог болсон байна. Тухайлбал, хуульд аймаг нийслэлийн Засаг дарга түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргасан тохиолдолд уг зөрчлийг таслан зогсоох, байгаль орчин нөхөн сэргээлтэд хяналт тавих зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Аймаг нийслэл нь түгээмэл тархацтай хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авагч ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон тусгай хэрэгцээ нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон, түрүүлж ирсэн өргөдөлд дурдсан хайгуулын талбайтай давхцаж байгаа эсэхийг тогтоолгох өргөдлийг холбогдох материалын хамт төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ. Төрийн захиргааны байгууллага аймаг нийслэлийн засаг даргын хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой эсхүл боломжгүй талаар мэдэгдэнэ. Ингэхдээ хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож 2 жилийн хугацаатайгаар нэг удаа сунгах ба нийтдээ 5 жил байна. Харин ашиглалтын тусгай зөвшөөрлийг 15 жилийн хугацаатайгаар олгож нөөцийн хэмжээнээс хамаарч арав, арван жилээр нийтдээ 35 жилээр сунгана гэж заасан байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авахад тавих шаардлагын талаар

Хуульд зааснаар нэг тусгай зөвшөөрлөөр олгох түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайн хэмжээ 25 гектараас багагүй, 400 гектараас ихгүй байна.

Өргөдөлд дурдсан хайгуулын талбай нь дараах шаардлагыг хангасан байна:

- Дөрвөн өнцөгт хэлбэртэй байх бөгөөд түүний хил нь уртраг, өргөргийн дагуух чиглэлтэй давхацсан шулуун шугамаар хүрээлэгдсэн;
- Тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газар, нөөцөд авсан талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй;
- Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон болон түрүүлж өгсөн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд дурдсан талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг аймаг, нийслэлийн Засаг даргын баталсан маягтын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргад гаргах бөгөөд өргөдөлд хуульд заасан баримт бичгийг хавсаргана.

Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуульд заасны дагуу Төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч ажлын 10 өдрийн дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох, эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад тавих шаардлага:

Хуульд зааснаар түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах эрхтэй байна.

Уурхайн талбай нь дараах шаардлагыг хангасан байна:

- Тал бүр тийш 500 метрээс багагүй урттай, уртраг, өргөргийн дагуух чиглэлтэй давхацсан шулуун шугамаар хүрээлэгдсэн тэгш олон өнцөгт хэлбэртэй;
- Тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай давхцаагүй;
- Давс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын тухайд талбайн хэмжээ нь тал бүр тийш 100 метрээс багагүй урттай.¹⁶³

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож, худалдсан эсвэл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө. Энэ нь борлуулалтын үнэлгээний 2.4 хувьтай тэнцүү байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргад гаргах бөгөөд түүнд хуульд заасан баримт бичгийг хавсаргана.

Өргөдөл гаргасан этгээд нь хуульд заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлснөөс хойш ажлын 5 өдөрт багтаан аймаг, нийслэлийн Засаг дарга ашиглалтын тусгай зөвшөөрлийг 15 жилийн хугацаагаар олгохоор заажээ. Тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх талаар хуульд тусгайлан зохицуулаагүй байна.

**3. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 3.3 ДАХЬ
ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН ЖУРАМ**

Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн журмыг 2014 оны 222 дугаар тогтоолоор засгийн газар баталсан байна.

Уг журмын зорилго нь улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой ач холбогдолтой дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг саадгүй, шуурхай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3.3-т заасан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Зарим төсөл, хөтөлбөр гэдэгт дараах төсөл, хөтөлбөрүүдийг хамааруулна:

- Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтэц барих, засварлах;
- Олон улс болон улсын чанартай, түүнчлэн Засгийн газрын зээл, бондын хөрөнгөөр, эсхүл Засгийн газраас баталгаа гарган хэрэгжүүлэх том бүтээн байгуулалтын

¹⁶³ <https://legalinfo.mn/mn/detail/9750>
<https://advocate.mn/news/73/single/122>

төслийн авто зам, замын байгууламж барих, засварлах зэрэг төсөл хөтөлбөрүүд багтдаг.

Дээрх түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн журамд ЗГ-ын 2015 оны 11-р сарын 09-ний өдрийн 440-р тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам"-ын 1.3.2 дахь заалтын "авто зам, замын байгууламж" гэсний өмнө, түүнчлэн "Засгийн газрын зээл, бондын хөрөнгөөр, эсхүл Засгийн газраас баталгаа гарган хэрэгжүүлэх том бүтээн байгуулалтын төслийн" гэж нэмэх тухай өөрчлөлт оруулсан байна.

Мөн зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрхийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээдэд зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас олгоно хэмээн заасан байдаг.

Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайд тавигдах шаардлага:

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл нь хүчинтэй байгаа болон эсхүл уг зориулалтаар тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг эхэлж гаргасан этгээдийн талбайтай давхцаагүй байх;
- Газрын тухай хуулийн 16.1.1, 16.1.3, 16.1.4-т зааснаас бусад улсын тусгай хэрэгцээний газар, ердийн ба стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олгосон газар, нөөцөд авсан талбайтай давхцсан байж болно. Энэ тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зөвшилцсөн байх;
- Талбайн хэмжээ 1 гектараас багагүй, 5 гектараас ихгүй байх;
- Тухайн бүсэд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын төрөл, хэмжээ төслийн техник эдийн засгийн үндэслэлд нийцсэн, ашиглалтын талбайн тоо, талбай хоорондын зай байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх.

Эрх эзэмшигчийн эрх, үүрэг

Уг журмын 4.2-т ашиглалтын талбайгаас олборлосон түгээмэл тархацтай ашигт малтмалыг зөвхөн авто зам, төмөр замын бүтээн байгуулалтад ашиглана хэмээн заасан байдаг. Мөн ашиглалтын болон нөхөн сэргээлтийн ажлын тайланг нутгийн захиргааны байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ гэсэн заалтуудыг оруулсан нь түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах эрх эзэмшигчийг хариуцлагажуулсан голлох заалтууд болсон байна.

Төлбөр тооцох, төлөх

Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашигласан хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн тогтооно. Нутгийн захиргааны байгууллага болон эрх эзэмшигч хамтран сар бүр гүйцэтгэлийг баталгаажуулна. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр тооцох борлуулалтын үнэлгээ нь түгээмэл тархацтай ашигт малтмалын төрлөөс хамаарч нэг шоо метр нь 5000 төгрөгөөс хэтрэхгүй байна. Талбай ашиглагч нь түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг дараа сарын 25-ны дотор орон нутгийн төсөвт төлнө.

4. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛТАЙ ХОЛБООТОЙ БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЛАВЛАГАА

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Д/д	Түгээмэл тархацтай ашигт малтмалтай холбоотой хууль	Хуулийн зүйл, заалт
1	Монгол Улсын Үндсэн хууль	Зургадугаар зүйл. 6.2 Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.
2	Ашигт малтмалын тухай хууль	3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 3.3.Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна. 6 дугаар зүйл. Ашигт малтмалын ордын ангилал 6.3.Барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий хурдас, чулуулгийн хуримтлалыг түгээмэл тархацтай ашигт малтмалын ордод хамааруулна. 11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 11.1.13. тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргах; 24 дүгээр зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлага 24.4.3.давс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын тухайд талбайн хэмжээ нь тал бүр тийш 100 метрээс багагүй урттай.
3	Газрын тухай хууль	ЗУРГАДУГААР БҮЛЭГ 50 дугаар зүйл. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах нийтлэг шаардлага 50.1.3.газар, түүний баялаг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахдаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;
4	Газрын хэвлийн тухай хууль	16 дугаар зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын жагсаалт <i>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</i> 17 дугаар зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг ашиглахад зориулан уурхайн эдэлбэр олгох нөхцөл <i>/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</i>
5	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	ЗУРГАДУГААР БҮЛЭГ 30.11.Ой, амьтан, ус, ашигт малтмал зэрэг байгалийн баялаг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг хуулиар болон төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрхийн дагуу эрхлэн зохицуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн байгууллага гэнэ.

Эх сурвалж: УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРАЛ, УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНЬ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ (2016 оны жилийн эцсийн тайлан)

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль 2014 оноос хэрэгжиж эхэлсэн ба Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газраас гаргасан 2014 онь үнэлгээгээр Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3.3-т заасан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулах заалтыг 100% хэмээн үзэн хяналтаас хасах санал гаргасан байна.

Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалт	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, хяналтаас хасах санал
Нэг. Монгол Улсын хууль		
Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай 2014-01-09 № 01 3.2 эмчилгээний зориулалтаар шавар, элсийг ашиглахтай холбогдсон харилцааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.	Энэхүү харилцааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулах тул хяналтаас хасуулах саналтай байна.	Үнэлгээгүй ажил
3.3 Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно.	Гацууртын ордын төрийн эзэмшлийн 34 хувийг АМНАТ тусгай төлбөрийн хувийн 3 хувиар орлуулахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.	10%

Эх сурвалж: УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ (2017 оны жилийн эцэс)

Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалт	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ
ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ 2014-01-09 №: 2014_01 3.3 Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 09-ний өдөр 222 дугаар тогтоолоор Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журмыг хавсралт ёсоор баталсан.	100% Хяналтаас хасах саналтай

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ (2017 оны хагас жилийн байдлаар)

Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалт	Хэрэгжилтийн явц	Хувь
ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ 2014-01-09 3.3 Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно.	Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 222 дугаар тогтоолоор Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журмыг баталсан.	100%

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР ДУУСГАВАР БОЛОХ

Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт заасан зарим төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ төсөл хөтөлбөрийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг баталдаг.¹⁶⁴

Батлагдсан солбицол бүхий тайлбайд төсөл хөтөлбөрийн ажлыг гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад, төсөл хөтөлбөрийн ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад тус тус даалгадаг байна.

Харин эрх олгох тухай Монгол Улсын Засгийн газраас баталсан тогтоолд тухайн төсөл хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөх үүргийг төсөл хөтөлбөрийн ажлыг гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэгжүүлэн өгдөг байна. Үүгээр тухайн төсөл хөтөлбөртэй холбоотой Монгол Улсын Засгийн газраас олгосон түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх дуусгавар болж байна гэж үзэж болно.¹⁶⁵

5. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө гэж заасан байдаг.

Түүнчлэн төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасны дагуу Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хамаардаггүй болно.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмыг Ашигт малтмалын тухай хуулийн¹⁶⁶ хүрээнд Монгол Улсын Сангийн сайдын 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 17 дугаартай Аргачлал батлах тухай тушаалын дагуу Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь АМНАТ-ийн орлогыг аймаг, нийслэлийн ОНХС-д шилжүүлэхдээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Тогтворжуулалтын санд холбогдох орлогыг шилжүүлсний дараа үлдсэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос Мега төслүүдээс төвлөрсөн орлогыг хассан зөрүүний 30 хувийг холбогдох аймаг, нийслэлийн Орон нутгийг хөгжүүлэх санд хуваарилнагэж заасан.¹⁶⁷

Орон нутгийг хөгжүүлэх сан нь нутгийн иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэрэгсэл бөгөөд 2013 оноос хэрэгжиж эхэлсэн Төсвийн тухай хуульд тусгалаа олсон. Тухайн орон нутгийн иргэд нь өөрсдөө тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийн

¹⁶⁴ “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай” тогтоолын хавсралт: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231083764351>

¹⁶⁵ Жишээ болгон: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай” 281 дугаартай Тогтоолыг үзэж болно.

¹⁶⁶ Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/63>

¹⁶⁷ Монгол Улсын Сангийн сайдын 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн Аргачлал батлах тухай 17 тоот тушаал <https://legalinfo.mn/mn/detail/11911>

санаачлан шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг олгосон шийдэл бөгөөд зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.¹⁶⁸

Хүснэгт. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нийт дүн /сая төг/

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021
Архангай	24.5	34.0	31.2	57.7	58.2	112.9
Баян-Өлгий	19.2	31.3	21.5	26.2	14.7	38.6
Баянхонгор	9.5	8.5	12.0	25.4	40.3	36.5
Булган	69.4	74.4	70.7	91.8	41.8	121.3
Говь-Алтай	120.1	14.9	15.3	24.0	19.3	89.6
Дорноговь	149.5	124.7	689.6	276.9	1,549.2	1,109.7
Дорнод	139.1	153.7	100.2	53.2	10.6	12.9
Дундговь	30.6	22.8	55.2	32.1	20.5	6.9
Завхан	10.2	9.5	43.4	29.1	27.7	12.9
Өвөрхангай	19.5	34.2	63.5	62.6	63.9	43.8
Өмнөговь	452.0	1,271.6	1,947.9	2,001.2	1,239.5	2,572.2
Сүхбаатар	43.7	49.7	7.2	55.3	30.0	10.4
Сэлэнгэ	181.5	81.9	114.6	74.6	319.6	286.7
Төв	185.6	108.4	91.1	168.1	173.5	221.6
Увс	42.1	38.0	36.1	67.8	82.7	70.5
Ховд	56.0	74.3	41.0	57.2	44.8	50.4
Хөвсгөл	29.7	27.1	26.5	36.6	52.4	49.0
Хэнтий	35.8	37.8	37.8	86.0	89.3	67.9
Дархан-Уул	14.0	38.8	34.2	109.1	74.5	104.3
Улаанбаатар	105.7	141.4	107.1	260.7	210.6	313.0
Орхон	19.0	31.6	19.8	32.6	44.1	40.8
Говьсүмбэр	1.5	1.5	64.4	20.7	15.1	27.9
Нийт	1,758.4	2,410.3	3,360.4	3,648.7	4,222.3	5,401.1

Эх сурвалж Монгол Улсын сангийн яам

Түгээмэл тархацтай ашигт малтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө гэж заасан байдаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁶⁸ Орон нутгийн хөгжлийн сан <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/?p=117>



Хэнтий аймгийн хэмжээнд Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 2016 онд 35.8 сая төгрөг, 2017 онд 37.8 сая төгрөг, 2018 онд 37.8 сая төгрөг, 2019 онд 86.0 сая төгрөг, 2020 онд 89.3 сая төгрөг, 2021 онд 67.9 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Хэнтий аймаг нь 2021 онд түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн үзүүлэлтээрээ нийслэл Улаанбаатар хот, 21 аймгийн хэмжээнд 10 дугаарт эрэмбэлэгдэж байна. Зарим аймгуудын хувьд жишээлбэл, Өмнөговь аймаг 2021 онд 2,572.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй харьцуулахад бага хэдий ч зарим аймаг тухайлбал, Дундговь аймаг 2021 онд 6.9 сая төгрөгийг орон нутгийн санд төвлөрүүлснээс их байна.

ХАВСРАЛТ

"ПАРЛАМЕНТ" СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

БОТЬ-41

Хүснэгт 1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нийт дүн

Сангийн яамны 2022 оны 07 дугаар сарын 10 өдрийн 4-2/622 албан тоот бичгийн хавсралт

Хүснэгт 1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нийт дүн

ҮЗҮҮЛЭЛТ	2016	2017	2018	2019	2020	2021
Архангай	24.5	34.0	31.2	57.7	58.2	112.9
Баян-Өлгий	19.2	31.3	21.5	26.2	14.7	38.6
Баянхонгор	9.5	8.5	12.0	25.4	40.3	36.5
Булган	69.4	74.4	70.7	91.8	41.8	121.3
Говь-Алтай	120.1	14.9	15.3	24.0	19.3	89.6
Дорноговь	149.5	124.7	689.6	276.9	1,549.2	1,109.7
Дорнод	139.1	153.7	100.2	53.2	10.6	12.9
Дундговь	30.6	22.8	55.2	32.1	20.5	6.9
Завхан	10.2	9.5	43.4	29.1	27.7	12.9
Өвөрхангай	19.5	34.2	63.5	62.6	63.9	43.8
Өмнөговь	452.0	1,271.6	1,947.9	2,001.2	1,239.5	2,572.2
Сүхбаатар	43.7	49.7	7.2	55.3	30.0	10.4
Сэлэнгэ	181.5	81.9	114.6	74.6	319.6	286.7
Төв	185.6	108.4	91.1	168.1	173.5	221.6
Увс	42.1	38.0	36.1	67.8	82.7	70.5
Ховд	56.0	74.3	41.0	57.2	44.8	50.4
Хөвсгөл	29.7	27.1	26.5	36.6	52.4	49.0
Хэнтий	35.8	37.8	37.8	86.0	89.3	87.9
Дархан-Уул	14.0	38.8	34.2	109.1	74.5	104.3
Улаанбаатар	105.7	141.4	107.1	260.7	210.6	313.0
Орхон	19.0	31.6	19.8	32.6	44.1	40.8
Говьсүмбэр	1.5	1.5	64.4	20.7	15.1	27.9
НИЙТ	1,758.4	2,410.3	3,630.4	3,648.7	4,222.3	5,401.1

Хүснэгт 2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын төрөлд хамаарах ээрэнүүдийн жагсаалт

Гэрээ	Он	Эрдэсийн Төрөл	Гэрээний Төрөл
Хөвсгөл аймаг болон Далай гоулд ХХК-ийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ	2017	Түгээмэл тархацтай ашигт малтмал	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ
Төв аймгийн Лүн сум болон Авдархайрхан ТӨҮГ-ийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ	2017	Түгээмэл тархацтай ашигт малтмал	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ
Орхон аймаг болон Чингэл бөөнцагаан ХХК-ийн хооронд байгуулсан газар ашиглах гэрээ	2015	Барилгын Материал Түгээмэл тархацтай ашигт малтмал	Газар ашиглах тухай гэрээ
БОАЖЯ, АМГТГ, МХЕГ, Сэлэнгэ аймаг болон Даланбулаг трейд ХХК-ийн хооронд байгуулсан нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ	2017	Барилгын Материал Түгээмэл тархацтай ашигт малтмал	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн дагуу хийгдэх гэрээ
Орхон аймаг болон Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн хооронд байгуулсан газар ашиглах гэрээ	2010	Барилгын Материал Шавар Зэс Молибден Түгээмэл тархацтай ашигт малтмал	Газар ашиглах тухай гэрээ

127

Төв аймгийн Баянцагаан сум болон Э-транс ХХК-ийн хооронд байгуулсан газар ашиглах гэрээ	2016	Барилгын Материал Түгээмэл тархацтай ашигт малтмал	Газар ашиглах тухай гэрээ
Дорноговь аймгийн Улаанбадрах сум болон Эрэл ХХК-ийн хооронд байгуулсан газар ашиглах гэрээ	2016	Барилгын Материал Алт Гөлтгөнө Түгээмэл тархацтай ашигт малтмал Битум	Газар ашиглах тухай гэрээ
Хөвсгөл аймаг болон Хөвсгөл геологи ХК-ийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ	2017	Түгээмэл тархацтай ашигт малтмал	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ
Өвөрхангай аймаг Ундарга капитал ХХК	2019	Түгээмэл тархацтай ашигт малтмал	Аймгийн засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/340 дугаар захирамж
Өвөрхангай аймаг Эрдэнэтүшиг ХХК	2019	Түгээмэл тархацтай ашигт малтмал	Аймгийн Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/340 дугаар захирамж

Эх сурвалж: Эрдэс баялагийн гэрээний мэдээллийн сан-<https://www.iltodqeree.mn/resource/111>

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хувийн хэрэг (Архив 2014)
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/9750>
- Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам
- Эрдэс баялагийн гэрээний мэдээллийн сан
- “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай” тогтоолын хавсралт: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231083764351>
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай” 281 дугаартай Тогтоол
- Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/63>
- Монгол Улсын Сангийн сайдын 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн Аргачлал батлах тухай 17 тоот тушаал <https://legalinfo.mn/mn/detail/11911>
- Орон нутгийн хөгжлийн сан <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/?p=117>

МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗАРИМ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА

(Хонин сүрэг, үхэр сүрэг, малын тэжээл бэлтгэл)

Г.Алтан-Оч (Ph.D), О.Билгүүтэй,
С.Дөлгөөнномун, С.Золжаргал

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

БҮЛЭГ 1. ХОНИН СҮРГИЙН ТАЛААРХ ТОЙМ

- 1.1 Хонин сүргийн тоо, толгой (бүсээр, аймаг)
- 1.2 Эрчимжсэн хонины аж ахуй
- 1.3 Хонин сүргийн омог, үүлдэр
- 1.4 Хонины омог
- 1.5 Хонины үүлдэр
- 1.6 Хонины цөм сүргийн байршил, ашиг шим
- 1.7 Хээлтэгч, хээлтүүлэгч хонь
- 1.8 Хонины махны экспортын тойм

БҮЛЭГ 2. ҮХЭР СҮРГИЙН ТАЛААРХ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

- 2.1 Үхэр сүргийн тоо толгой (бүсээр, аймгаар)
- 2.2 Эрчимжсэн үхрийн аж ахуй
- 2.3 Үхэр сүргийн омог, үүлдэр
- 2.4 Мах, сүүний чиглэлийн үхэр, сарлагийн цөм сүргийн байршил, үхэр сүргийн ашиг шимийн чиглэл
- 2.5 Үхрийн махны экспортын тойм

БҮЛЭГ 3. МОНГОЛ ОРНЫ МАЛЫН ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

- 3.1 Монгол орны хөрсний бүрхэвч
- 3.2 Монгол орны ургамлын бүрхэвч
- 3.3 Бэлчээрийн хүрэлцээ, тэжээлийн хангамж
- 3.4 Малын тэжээл үйлдвэрлэл, хангамж
- 3.5 Гурил, тэжээлийн үйлдвэрүүдийн хүчин чадал
- 3.6 Тэжээлээр дагнасан үйлдвэр
- 3.7 Бэлтгэсэн өвс хадлан (бүсээр)
- 3.8 Тэжээл импорт

ХАВСРАЛТ МЭДЭЭЛЭЛ

1. Малын тэжээл
2. Бэлчээрийн хүрэлцээ- 2019 он

ХОЛБОГДОХ СУДАЛГАА, ЭХ СУРВАЛЖИЙН ТОЙМ

1. Хонины махны чиглэлээр үржүүлэн өсгөх, маллах, тэжээх, бордох чиглэлээр хийгдсэн судалгааны тойм
2. Үхрийн махны чиглэлээр үржүүлэн өсгөх, маллах, тэжээх, бордох чиглэлээр хийгдсэн судалгааны тойм.
3. Монгол орны бэлчээр, тэжээлийн ургамлын химийн найрлага, шингэц, шимт чанарыг судалсан тойм
4. Монгол орны бэлчээрийн ургамлан нөмрөгийн судлагдсан байдал
5. Багсармал тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр хийгдсэн судалгааны тойм
6. Даршны судлагдсан байдал

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МАА	Мал аж ахуй
МИД	Малын индексжүүлсэн даатгал
ТЕГ	Татварын ерөнхий газар
УЦУОСМХ	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу Монгол Улсын үхэр сүрэг, хонин сүрэг, малын тэжээлийн өнөөгийн байдлын талаарх лавлагаа, мэдээллийг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Үхэр болон хонин сүргийн бүтэц, тоо толгой, тархалт, омог, үүлдэр, эрчимжсэн аж ахуй, махны экспорт, ашиг шим болон Монгол Улсын бэлчээр ургамлын байдал, малын тэжээл үйлдвэрлэл, хадлан тэжээл бэлтгэлтэй холбоотой статистик мэдээлэл, холбогдох судалгааны тайлангуудад тулгуурлан лавлагаа, мэдээлэл бэлтгэх.

Судалгааны тайлангийн бүтэц: Судалгааны мэдээллийг дараах 3 бүлэг асуудлын хүрээнд боловсруулсан:

- 1-р бүлэг. Үхэр сүргийн талаарх тойм мэдээлэл
- 2-р бүлэг. Хонин сүргийн талаарх тойм мэдээлэл
- 3-р бүлэг. Малын тэжээл бэлтгэлийн өнөөгийн байдал

Судалгаанд ашигласан мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам болон Үндэсний статистикийн хорооны мэдээллийн нэгдсэн сангаас цуглуулсан. Мөн судалгаанд сэдвийн хүрээнд хийгдсэн судалгааны тайлан болон холбогдох мэдээллийг ашигласан болно.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монголын мал сүрэг нь эрт цагаас өдгөө хүртэлх хугацаанд эх газрын эрс тэс, экологийн нөхцөлд байгалийн урт хугацааны шалгарал, мал маллагааны олон зууныг дамжиж ирсэн ардын сонгон үржүүлгийн үр дүнд байгаль-цаг уурын хатуу ширүүн нөхцөлд дасан зохицож, биологийн онцгой шинжийг хадгалсан Монгол нутгийн мал бий болсон юм.¹⁶⁹

Мал сүргийн тоон хувьслын хөдлөл зүйд суурилан тэдгээрийн газар зүйн тархалт, нягтшил, төлөрхөг байдал, үр өгөөж зэргийг тодорхойлох, өөрчлөлтийг үнэлэхэд малын тооллого чухал үүрэг гүйцэтгэж байна. 2021 оны жилийн эцэст малын тоо толгой 67.3 саяд хүрч, өмнөх оныхоос 0.2 сая (0.3%) үүнээс тэмээ 18.9 мянган толгойгоор (4.0%), ямаа 1.3 сая (4.5%)-аар тус тус буурч, үхэр 290.2 мянга (6.1%), адуу 230.5 мянга (5.6%), хонь 1.0 сая (3.5%) толгойгоор өссөн байна. 2021 оны дүнгээр нийт 305.4 мянган малчид, малтай 246.2 мянган өрх байгаагийн 188.6 мянга нь малчин өрх байна.

Хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйн үйлдвэрлэл нь хүн амыг гол нэрийн хүнсээр, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах, улмаар экспортын болон гадаад валютын орлогыг нэмэгдүүлэх, худалдаа, үйлчилгээний салбарын ажиллагсдын ажлын байранд шууд болон шууд бус хэлбэрээр онцгой үүрэг гүйцэтгэж, эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлдэг үйлдвэрлэлийн анхдагч салбар билээ. Өнөөдөр дэлхийн аль ч улс орны төр засгийн тэргүүлэх чиг үүргийн нэг нь хүн амаа тэжээллэг, аюулгүй хүнсээр хүртээмжтэй хангах асуудал байдаг.

Хөдөө аж ахуйн салбар нь 2020 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 12.9 хувийг, үүний дотор мал аж ахуйн салбар нь 80 гаруй хувийг үйлдвэрлэж, нийт ажиллах хүчний гуравны нэг нь уг салбарт ажиллаж байна.

¹⁶⁹ <https://mofa.gov.mn/exp/blog/7/1>

Мал аж ахуйн салбар нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх гол салбар бөгөөд бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь жилээс жилд тогтвортой нэмэгдэж, сүүлийн 10 жилд 4.0 дахин, 2020 онд өмнөх оноос 18.1 хувиар өсөж, дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд мал аж ахуйгаас жилд 6.3 их наяд төгрөгийн нэмэгдэл өртгийг бүрдүүлж байна.

МАН-н салбарын 2020-2025 оны хөгжлийн хандлага, стратегийн зорилт:

Бодлого нь мэдлэгт суурилсан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, шинэ технологи, инновацыг нэвтрүүлэх, мэргэжлийн үйлчилгээг төгөлдөржүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжээс хүртэх үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ;

Хөгжлийн загвар нь уламжлалт өв соёлыг хадгалсан бэлчээрийн аж ахуйг зонхилон, дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн мал аж ахуйг хот суурингийн орчимд бүсчлэн хөгжүүлэх, нөөцийг тогтвортой, зохистой ашиглах, ногоон эдийн засгийн чиг баримжааг дэмжихэд суурилна.

Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ:

- Малын төрөл бүрийн тэжээлийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлж, түүний шимт чанарыг сайжруулах үйл ажиллагааг тогтворжуулах;
- Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, эрүүл тайван байдлыг баталгаажуулах арга хэмжээг бүс нутгийн онцлогтой уялдуулан ялгавартайгаар хэрэгжүүлж, баруун болон төвийн бүс нутаг дахь вакцинжуулалтыг эрс багасгаж, эрүүлжүүлэх шинжилгээ хийх стратегид шилжих ба малын эмийн үлдэгдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Бүс нутгийн онцлог, ашиг шимийн чиглэлээс хамаарч малын төрөл хоорондын харьцаа, сүргийн зохист бүтцийг бүрдүүлэх эдийн засгийн хөшүүргийг бий болгох;
- Малын үржил селекцийн ажлыг мэргэжлийн байгууллагын удирдлага, хяналтын дор малын ашиг шимийн чиглэлд нийцүүлэн үржлийн ажлын стратеги төлөвлөгөөний дагуу явуулах;
- Шинээр болон дахин сэргэж байгаа малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин, оношлуурыг дотооддоо үйлдвэрлэн хэрэгцээг бүрэн хангах;
- Гоц халдварт зарим өвчнөөр тайван бүсийн статусыг хангах, мал эмнэлгийн ажил, үйлчилгээ, тогтолцоог олон улсын жишигт хүргэх;
- Малын эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлд үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлж, малын эм, био бэлдмэлийн бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэх;
- Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд бүртгэлээр дамжуулан хяналт тавьж гарал үүсэл, эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах;
- Бэлчээр, тэжээл, усан хангамжийг зохистой ашиглах, хамгаалах менежментийн нэгдсэн системийг бий болгож, мал аж ахуйг уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхтай болгох;
- Малаас гаралтай органик түүхий эд бэлтгэлийн хэмжээ, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж экспортын чиг баримжаатай дотоодын үйлдвэрлэлийг дэмжих.

Мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй эрх зүйн баримт бичиг:

Монгол Улсын хууль

1. Хоршооны тухай /шинэчилсэн найруулга/ хууль
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/ хууль
3. Малын тоо толгойн албан татварын тухай хууль
4. Малын генетик нөөцийн тухай хууль

5. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
6. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль
7. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль
8. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль
9. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
10. Гамшгаас хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/
11. Захиргааны ерөнхий хууль
12. Зөрчлийн тухай хууль
13. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
14. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
15. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль

Улсын Их Хурлын тогтоол

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
4. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
5. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого
6. Ногоон хөгжлийн бодлого батлах тухай
7. Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай
8. Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай
9. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлах тухай
10. “Ус” үндэсний хөтөлбөр батлах тухай
11. “Монгол мал” үндэсний хөтөлбөр
12. Мах, ноолуурын үнийн талаар авах зарим арга хэмжээний тухай
13. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /Малын генетик нөөцийн тухай хууль/
14. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль/
15. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /2018 оны 41 дүгээр тогтоол/

Засгийн газрын тогтоол

1. “Монгол малчин” үндэсний хөтөлбөр батлах тухай /2020 оны 34 дүгээр тогтоол/
2. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөр батлах тухай /2018 оны 400 дугаар тогтоол/
3. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2018 оны 267 дугаар тогтоол/
4. Жагсаалт, журам батлах тухай /Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт/ /2018 оны 266 дугаар тогтоол/
5. Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай /2018 оны 225 дугаар тогтоол/
6. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2018 оны 188 дугаар тогтоол/
7. Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2018 оны 187 дугаар тогтоол/
8. Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай /2018 оны 186 дугаар тогтоол/
9. Улсын аварга малчин, улсын хошой аварга малчин, улсын аварга саальчин, улсын аварга фермер, улсын аварга тариаланч хамт олон, улсын аварга тариаланч шалгаруулах тухай /2019 оны 15 дугаар тогтоол/

10. Малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2018 оны 29/
11. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр батлах тухай /2018 оны 12/
12. Мал, махны экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /2017 оны 318/
13. Малын гоц халдварт өвчингүй, хорио цээрийн тусгаарлагдсан бүс байгуулахтай холбогдуулан зарим арга хэмжээний тухай /2017 оны 284/
14. Малын гоц халдварт өвчний нөхцөл байдалтай холбогдуулан зарим арга хэмжээний тухай /2017 оны 257/
15. Хөдөө аж ахуйн салбарын 2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай /2017 оны 186/
16. Жагсаалт шинэчлэн батлах тухай /Гаалийн албан татвараас чөлөөлөх ЖДҮ тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл/ /2017 оны 168/
17. Мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай /2017 оны 14/
18. Журам батлах, мал эмнэлгийн хяналтын цэгийн байршил тогтоох тухай /2016 оны 240/
19. “Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” дэд хөтөлбөр батлах тухай /2016 оны 114/
20. Малчдыг дэмжих зарим арга хэмжээний тухай /2016 оны 90/
21. “Мах хөтөлбөр” батлах тухай /2015 оны 492/
22. Журам шинэчлэн батлах тухай /“Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”/ /2015 оны 122/
23. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай /2014 оны 299/
24. Жагсаалтад нэмэлт оруулах тухай /Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын/ /2014 оны 190/
25. Цөм сүргийн үржлийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай /2013 оны 420/
26. Журам шинэчлэн батлах тухай /“Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”/ /2013 оны 394/
27. Малчдын хоршоог хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /2013 оны 08/
28. Аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай /2012 оны 158/
29. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай /2010 оны 64/
30. Хөтөлбөр батлах тухай /Хоршоог хөгжүүлэх/ /2009 оны 173/
31. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай /2009 оны 100/
32. Журам батлах тухай /Малын гоц халдварт өвчний онош/ /2008 оны 305/
33. Журам батлах тухай /Малчдаас ноолуур худалдан авах.../ /2008 оны 260/
34. Отрын бэлчээрийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай /2007 оны 187/
35. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үлгэрчилсэн дүрмийг батлах тухай /2005 оны 02/
36. Жагсаалт, журам батлах тухай /Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт/ /2003 оны 173/
37. Мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /2002 оны 181/

Бусад

1. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөр
2. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн тайлан
3. Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан
4. Малын эмийн үлдэгдлийн хяналтын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан
5. Монгол мал үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатны буюу 2016-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
6. Монгол мал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан
7. Малын эмийн улсын бүртгэлийн жагсаалт
8. Малын эм үйлдвэрлэх үйл ажиллагаатай 11, малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох үйл ажиллагаатай 111 аж ахуйн нэгжүүдийн жагсаалт
9. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын танилцуулга

2021 онд МАА-н салбарт шинээр боловсруулах эрх зүйн баримт бичгүүд:

- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан тодорхой зорилт, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн онцлогт нийцсэн, нөөцөд суурилсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тусгасан дунд хугацааны бодлогын баримт бичиг
- Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/
- Малын эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- “Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай” хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, холбогдох судалгаа
- Малын эмийн үлдэгдлийг хянах үндэсний хөтөлбөрийн төсөл

БҮЛЭГ 1. ХОНИН СҮРГИЙН ТАЛААРХ ТОЙМ

Өнгөрсөн 75 жилийн хугацаанд Монгол Улсын хонин сүрэг 2.4 дахин өссөн ба тэдгээрийн тоон хөдлөл зүйг нарийвчлахад 1944-1945 оны зуданд 625.5 мянга, 2009-2010 оны зуданд 4.4 сая хонь хорогдсон ч түүнээс хойших сүүлийн 10 жилийн хугацаанд нийт дүнгээр 2.2 дахин өсөж, өсөлт эдийн засгийн бүх бүс нутагт бий болжээ.¹⁷⁰

1.1 ХОНИН СҮРГИЙН ТОО ТОЛГОЙ (бүсээр, аймгаар)

Мал тооллогын 2021 оны жилийн эцсийн дүнгээр хонины тоо толгой 31086.9 мян.тол болж, өмнөх оноос 1037.5 мян.тол буюу 3.5 хувиар өссөн байна.

Монгол Улсын хонин сүргийн газар зүйн байршлын өөрчлөлт, бүс нутгаар

Баг, хороо	2016	2017	2018	2019	2020	2021
Улсын дүн	27856.6	30109.9	30554.8	32267.265	30049.43	31086.9
Баруун бүс	6417.5	6903.2	6606.9	6729.714	6431.828	6885.68
Хангайн бүс	10694.3	11329	11459.3	12243.5	10553.5	10749.5
Төвийн бүс	6256.3	6678.1	6898.9	7428.866	7247.47	7087.03
Зүүн бүс	4311.7	5029.3	5423.3	5688.452	5641.71	6195.72
Улаанбаатар	176.813	170.2	166.4	176.709	174.9	169.01

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (хэмжих нэгж мян.тол)

¹⁷⁰ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн мэдээ.

2021 оны байдлаар хонин сүргийн зонхилох хэсэг буюу 34,6 хувь Хангайн, 22,1 хувь Баруун, 22,8 хувь Зүүн, 22,8 хувь Төвийн, 0,5 хувь Улаанбаатарын бүсэд тус тус байршиж байна. Нийт хонин сүргийн хувийн жин төвийн бүсэд 2 хувь, Улаанбаатарын бүсэд 3 хувиар тус тус буурч, баруун бүсэд 7,1 хувь, хангайн бүсэд 1,9 хувиар, зүүн бүсэд 9,8 хувиар нэмэгдсэн хөдлөл зүйтэй байна. Цаашид газар зүйн байршлаар баруун болон зүүн бүсэд хонин сүрэг түлхүү байрших, өсөх хандлагатай байна.

Монгол Улсын хонин сүргийн газар зүйн байршлын өөрчлөлт, аймгаар

Баг, хороо	2016	2017	2018	2019	2020	2021
Улсын дүн	27856.6	30109.9	30554.804	32267.26	30049.4	31086.9
Завхан	1730.2	1837.731	1827.5	1950.9	1799.8	1919.5
Говь-Алтай	1107.1	1194.602	1057.8	1066.7	945.7	885.9
Баян-Өлгий	937.71	995.222	979.6	995.9	937.4	1013.9
Ховд	1266.04	1323.579	1174.2	1111.3	1126.29	1267.8
Увс	1376.4	1552.09	1567.9	1604.8	1622.6	1798.4
Орхон	52.6	47.656	47.5	50.562	51.2	59.6
Өвөрхангай	2378.4	2663.296	2588.13	2606.9	2114.9	2000.9
Булган	1861.2	1794.4	1778.2	1923.9	1765.7	1918.9
Баянхонгор	1244.6	1381.1	1297.5	1405.9	1156.2	951.8
Архангай	2668.04	2845.05	2981.8	3321.2	2842.6	2935.05
Хөвсгөл	2489.3	2597.457	2766.18	2935.06	2622.8	2883.2
Төв	2442.4	2461.124	2449.2	2619.8	2540.33	2535.5
Говьсүмбэр	185.9	205.229	208.08	219.5	218.4	219.4
Сэлэнгэ	749.3	699.295	705.9	744.8	783.4	849.7
Дорноговь	758.4	861.478	926.18	1021.6	1069.7	1158.5
Дархан-Уул	162.2	150.838	147.063	162.3	161.8	163.8
Өмнөговь	520.9	613.98	631.4	718.2	682.6	626.7
Дундговь	1437.14	1686.203	1831.05	1942.7	1791.2	1533.4
Дорнод	831.36	1001.567	1147.9	1262.4	1303.06	1470.2
Сүхбаатар	1542.2	1815.324	1922.12	1971.2	1993.9	2179.012
Хэнтий	1938.13	2212.453	2353.5	2454.9	2344.7	2546.5
Улаанбаатар	176.8	170.173	166.33	176.7	174.9	169.006

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (хэмжих нэгж мян.тол)

Оросын судлаачдын 1950-аад онд хийсэн судалгаанд “Монголын говийн ба баруун аймгуудад хонь, ямаа их хувь эзэлж, хойд ба дорнод хэсгийн аймгуудад бог мал бага тархсан. Ямаа зүүн тийшлэх тутам бүр цөөрч байна.” гэж тэмдэглэж байжээ. Судлаач Б.Өүлэн-Эрдэнэ “Өвөг монголчууд хонийг бие дааж гэршүүлсэн соёлын үүслийн газар зүйн төв буюу Монгол нутаг дахь хонины унаган тархалтын хамгийн өндөр нягтралын газар зүйн голомт нь одоогийн Говь-Алтай аймгийн Жаргалан, Шарга, Баян-Уул, Хөхморьт, Дарви, Тонхил сум, Ховд аймгийн Дарви, Чандмань, Зэрэг, Мөст, Цэцэг, Алтай, Үенч, Булган, Мөнххайрхан, Манхан, Дуут, Жаргалант, Ховд сум, Баян-Өлгий аймгийн Булган, Дэлүүн, Алтай сум зэрэг нийт 3 аймгийн 22 сумдын газар нутгийг хамарч, тэндээс тал тал тийш шингэрсэн байх таамаглалыг дэвшүүлж, энэхүү голомт төвийн тодорхой хэсэг нь БНХАУ-ын Шинжаан Уйгурын Өөртөө Засах орны буюу эрт үеийн монголчуудын уугуул нутагт байршиж байсныг холбогдох зургуудын тархалтын зүй тогтлоос харж болно.” гэжээ.¹⁷¹

¹⁷¹ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн мэдээлэл

1.2 ЭРЧИМЖСЭН ХОНИНЫ АЖ АХУЙ

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар 3035 өрх, аж ахуйд сүүний үхрийн 98025 үнээ, 341 аж ахуйд 34963 махны үхэр, 28 аж ахуйн нэгж, 1190 өрхөд 1 сая 60 мянган шувуу, 15 аж ахуйн нэгж, 446 өрхөд 21652 гахай, 36 аж ахуйн нэгж, 680 өрхөд 13708 бүл зөгий үржүүлж байна. Үүнээс мах, ноосны хонины 90 аж ахуй, 34523 хонь бүртгэлтэй байна.¹⁷²

Хонин сүргийн эрчимжсэн аж ахуйн тоо, хонины тоо толгой (аймгаар¹⁷³)

	Аймаг	Хонь					
		Нарийн нарийвтар		Бүдүүн бүдүүвтэр		Бордож байгаа хонь	
		Аж ахуйн тоо	Толгойн тоо	Аж ахуйн тоо	Толгойн тоо	Аж ахуйн тоо	Толгойн тоо
1	Архангай	3	108	0	0	2	963
2	Баян-Өлгий	0	0	0	0	0	0
3	Баянхонгор	0	0	0	0	0	0
4	Булган	1	515	1	200	0	0
5	Говь-Алтай	0	0	0	0	0	0
6	Говьсүмбэр	0	0	0	0	0	0
7	Дархан-Уул	3	988	2	3620	0	0
8	Дорноговь	0	0	0	0	0	0
9	Дорнод	0	0	0	0	0	0
10	Дундговь	0	0	0	0	0	0
11	Завхан	0	0	2	2500	0	0
12	Орхон	1	85	0	0	0	0
13	Өвөрхангай	2	163	0	0	0	0
14	Өмнөговь	0	0	0	0	0	0
15	Сүхбаатар	0	0	0	0	2	280
16	Сэлэнгэ	58	17874	0	0	0	0
17	Төв	2	951	0	0	0	0
18	Увс	0	0	2	3437	0	0
19	Ховд	1	1960	0	0	0	0
20	Хөвсгөл	1	250	0	0	0	0
21	Хэнтий	0	0	0	0	0	0
22	Улаанбаатар	6	629	0	0	0	0
Бүгд		79	23523	7	9757	4	1243

2021 эрчимжсэн мал аж ахуйн судалгаа (2022.01.13-ны байдлаар)

1.3 ХОНИН СҮРГИЙН ОМОГ, ҮҮЛДЭР

2021 оны байдлаар эрх бүхий байгууллагаас хянан баталгаажуулсан үндэсний 24 үүлдэр (15 үүлдэр, 3 үүлдрийн хэсэг, 3 үржлийн хэсэг 3 омог), гадаад улсаас авчирсан нийт 26 үүлдрээс 2021 оны түвшинд үржүүлж буй нутагшуулсан болон нутагшуулж байгаа 15 үүлдрийн хонь байна.

¹⁷² <https://mofa.gov.mn/exp/blog/7/4>

¹⁷³ <http://203.26.189.154/files/pdf-files/pdf/6255232d5b58af779a8603ef.pdf>

**Хонин сүргийн үүлдэрлэг байдлын бүрэлдэхүүн, газар зүйн байршлын
нягтшил, цөм сүргийн байршил¹⁷⁴**

д/д	Үүлдрийн гарал	№	Үүлдэр, омгийн нэр	Сүрэгт эзэлж буй хувь	Тухайн үүлдэр, омгийн хонины газар зүйн байршлын нягтшил	Цөм сүргийн байршил
1	Монголын уугуул үүлдрүүд	1	Монгол хонь	99,94	21 аймаг, нийслэлийн 179 сум, дүүрэгт тархсан	Төв аймгийн Баянцагаан, Дундговь аймгийн Эрдэнэдалай
		2	Байдраг		Баянхонгор, Өвөрхангай аймагт	Баянхонгор аймгийн Жаргалант сум
		3	Барга		Зүүн бүсийн бүх аймаг, Төв, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Архангай, Өвөрхангай, Орхон аймагт	Дорнод аймгийн Хөлөнбуйр сум
		4	Баяд		Увс, Ховд, Баян-Өлгий, Архангай, Өвөрхангай, Орхон, Булган, Төв, Сэлэнгэ Дархан-Уул, Дундговь аймагт	Увс аймгийн Малчин, Зүүнговь, Хяргас сум
		5	Говь-Алтай		Говь-Алтай, Орхон аймаг	Говь-Алтай аймгийн Бугат, Цээл, Тонхил
		6	Дархад		Хөвсгөл, Булган, Архангай Дархан-Уул	Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Баянзүрх Ринчинлхүмбэ
		7	Керей		Баян-Өлгий, Ховд, Увс Дархан-Уул, Сэлэнгэ, Төв	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум
		8	Орхон		Сэлэнгэ, Дархан-Уул Булган, Өвөрхангай	Сэлэнгэ аймгийн Орхон сум
		9	Сартуул		Завхан, Орхон	Завхан аймгийн Эрдэнэхайрхан, Алдархаан сумд
		10	Сутай		Ховд	Ховдын Дарви
		11	Сүмбэр		Говьсүмбэр	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум
		12	Тал нутгийн цагаан		Хэнтий	Хэнтий аймаг
		13	Үзэмчин		Зүүн бүсийн бүх аймаг, Төв, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Архангай, Өвөрхангай	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Сэргэлэн сум
		14	Хангай		Булган, Сэлэнгэ	Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум
		15	Цагаан-Уул		Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн Цагаан -Уул
		16	Ерөө үүлдрийн хэсэг		Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн Ерөө сум
		17	Тамир үүлдрийн хэсэг		Архангай аймаг	Архангай аймгийн Ихтамир сум
		18	Торгууд үүлдрийн хэсэг		Ховд, Баян-Өлгий, Улаанбаатарын бүс	Ховд аймгийн Булган сум
		19	Баянгол омог		Өвөрхангай, Дундговь аймагт	Өвөрхангай аймгийн Баянгол сум
		20	Буриад омог		Дорнод, Хэнтий, Дундговь	Дорнод аймгийн Дашбалбар сум
		21	Сайнцагаан омог		Дундговь амйаг	Дундговь аймгийн Сайнцагаан сум
		22	Алтанбулаг үржлийн хэсэг		Төв, Дундговь	Төв аймгийн Алтанбулаг сум
		23	Жаргалант үржлийн хэсэг		Төв, Жаргалант сум	
		24	Хотонт үржлийн хэсэг		Архангай	Архангай аймгийн Хотонт сум

¹⁷⁴ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн мэдээ.

2	Гадаад улсаас нутагшуулсан, нутагшуулж буй хонины үүлдрүүд	1	Меринос	Импортын хонины 67,3 хувь Улаанбаатар орчимд, 32,4 хувь төвийн бүсэд, 0,31 хувь Хангайн бүсэд байна.
		2	Дорсет	
		3	Эдильбаев	
		4	Каракуль	
		5	Сараджин	
		6	Романов	
		7	Тушин	
		8	Грузин	
		9	Суффольк	
		10	Дорпер	
		11	Ромни-Марш	
		12	Дегерес	
		13	Берришон дюшер	
		14	Грознен	
		15	Гиссар	
Бүгд			100.0	

1.4 ХОНИНЫ ОМОГ

Монгол Улсад нийт 3 хонины омог байдаг. Хонины омгийн тархалт, бий болсон үржил селекцийн арга, ашиг шимийн үндсэн чиглэл, онцлог, тохиромжтой хэвшлийн хонины үндсэн ашиг шимийн доод үзүүлэлт, омгийн баталгаажсан огноо, шийдвэрийн дугаар, цаашид баримтлах үржил селекцийн ажлын чиглэлийг Монгол Улсын генетик нөөцийн төлөвийн газраас гаргаж байна.

БАЯНГОЛ ОМОГ¹⁷⁵



Тархалт:

Өвөрхангай, Булган, Хөвсгөл аймгуудын зарим сумдад хонин сүргийнхээ махан ашиг шимийг дээшлүүлэх зорилгоор Баянгол омгийн хонийг сайжруулагчаар ашиглаж байна. Баянгол омгийн хонины цөм сүргийг Өвөрхангай аймгийн Баянгол суманд үржүүлдэг.

Бий болгосон үржил селекцийн арга:

Өвөрхангай аймгийн Баянгол суманд ардын селекцийн үр дүнд бий болсон цөлөрхөг хээрийн бүс нутагт зохицсон махны хэвшлийн хонин сүрэгт түшиглэн Үзэмчин, Барга, Баяд үүлдрийн хуц ашиглан цус шингээх аргаар үржил селекцийн ажлыг явуулж, тохиромжтой хэвшлийн хонийг өөр дотор нь сонгон үржүүлж, мах – өөх – бүдүүн ноосны чиглэлийн өөхөн сүүлт “Баянгол омог”-ийн хонийг бий болгожээ.

Ашиг шимийн үндсэн чиглэл:

Мах-өөх-бүдүүн ноосны

¹⁷⁵ <https://www.muz.gov.mn/strains/view/4>

Баянгол омгийн хонины онцлог:

Цөлөрхөг хээрийн бүс нутгийн экологийн эрс тэс нөхцөлд эрсдэл даах чадвар сайтай, бэлчээрээр таргалах чадвар өндөртэй, өвөл, хавар тарга хүчээ сайтар хадгалж онд ордог, махны хэв шинж илүүтэй хөгжсөн зэрэг биологийн онцлог давуу шинжүүдтэй юм. Сүргийн дотор хар, бор, шар нүдэн, халзан, шар бор, бараан толгойтой цагаан зүсмийн хонь 80 шахам хувийг эзэлнэ.

Тохиромжтой хэвшлийн хонины үндсэн ашиг шимийн доод үзүүлэлт:

Хонины нас, хүйс	Амьдын жин /кг/		Ноосны гарц /гр/
	Хавар /V сард/	Намар /X сард/	
Бүдүүн хуц	54.0	65.0	1600
Төлгөн хуц	37.0	45.0	1400
Эм хонь	38.0	52.0	1300
Охин төлөг	31.0	42.0	1100

Омгоор баталгаажсан огноо, шийдвэрийн дугаар:

ХХАА-н сайдын 2015 оны А/60 дугаар тушаал.

Цаашид баримтлах үржил селекцийн ажлын чиглэл:

Цөлөрхөг хуурай хээрийн бүсэд цэврээр нь үржүүлж, аж ахуй-биологийн ашигтай шинж чанаруудыг улам бататган сайжруулж, тохиромжтой хэвшлийн хонины тоог олшруулж, тархалтын хүрээг өргөтгөж, тухайн бүс нутагтаа мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хонин сүргийн онд оролт, тэсвэрт чанарыг дээшлүүлэхэд Баянгол омгийн хонийг сайжруулагчаар ашиглахад чиглүүлэх.

БУРИАД ОМОГ¹⁷⁶



Тархалт:

Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Цагаан – Овоо, Дашбалбар сумдад зонхилон үржүүлж байна. Буриад омгийн хонины цөм сүргийг Дорнод аймгийн Дашбалбар суманд үржүүлдэг.

Бий болгосон үржил селекцийн арга:

Ардын уламжлалт селекцийн арга

Ашиг шимийн үндсэн чиглэл:

Мах-өөх-бүдүүн ноосны

Буриад омгийн хонины онцлог:

Улз голын сав дагуух дорнод тал хээрийн бүс нутгийн байгаль цаг уурын нөхцөл дахь бэлчээрийн маллагаанд сайтар дасан зохицсон, ууц ялимгүй өргөдсөн, цээж өргөн, гүн,

¹⁷⁶ <https://www.muz.gov.mn/strains/view/5>

харьцангуй богино зузаан өөхөн сүүлтэй, өвөл – хаврын улиралд тарга хүчээ сайн хадгалдаг онцлогтой, ихэвчлэн улаан, шар, бор толгойтой, халзан, их бие нь хундан цагаан зүстэй байдаг.

Тохиромжтой хэвшлийн хонины үндсэн ашиг шимийн доод үзүүлэлт:

Хонины нас, хүйс	Амьдын жин /кг/		Ноосны гарц /гр/
	Хавар /V сард/	Намар /X сард/	
Бүдүүн хуц	60.0	70.0	1800
Төлгөн хуц	35.0	52.0	1200
Эм хонь	40.0	55.0	1300
Охин төлөг	32.0	48.0	1100

Омгоор баталгаажсан огноо, шийдвэрийн дугаар:


ХХАА-н сайдын 2015 оны А/94 дүгээр тушаал.

Цаашид баримтлах үржил селекцийн ажлын чиглэл:

Улз голын сав дагуух дорнод тал хээрийн бүсэд цэврээр нь үржүүлж, аж ахуй-биологийн ашигтай шинж чанаруудыг улам бататган сайжруулж, тохиромжтой хэвшлийн хонины тоог олшруулах, тархалтын хүрээг өргөтгөх замаар үүлдрийн хэмжээнд хүргэж, улмаар тухайн бүс нутагтаа хонины мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд Буриад хонийг сайжруулагчаар ашиглах хэмжээнд хүргэх.

1.5 ХОНИНЫ ҮҮЛДЭР

МОНГОЛ ҮҮЛДЭР¹⁷⁷



Тархалт:

Монгол Улсын нийт хонин сүргийн 90 гаруй хувийг “Монгол” үүлдрийн хонь эзлэх бөгөөд бүх бүс нутагт жигд тархсан. Төв аймгийн Баянцагаан, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Архангай аймгийн Хотонт сумдын Монгол үүлдрийн хонины улсын үржлийн фермүүдээс өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулан улсын хэмжээнд нийт 70 гаруй сумдын хонин сүрэгт сайжруулагчаар ашиглаж, цэврээр нь үржүүлж ирсэн уламжлалтай.

Бий болгосон үржил селекцийн арга:

Ардын уламжлалт селекцийн арга

Ашиг шимийн үндсэн чиглэл:

Мах-өөх-бүдүүн ноосны

¹⁷⁷ <https://www.muz.gov.mn/breeds/view/5>

Монгол үүлдрийн хонины онцлог:

Монгол үүлдрийн хонины гол онцлог нь байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлд байгалийн бэлчээрийг жилийн турш ашиглан хямд өртөгтэй, чанар сайтай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, амьдрах чадвар онцгой сайтайд оршино. Зун-намрын улиралд хаврын жингээ 13.1-19.6 кг буюу 23.2- 62.4 хувиар нэмэгдүүлж, өвөл-хаврын улиралд намрын жингээс 25-30 хувийг алдаж, онд мэнд ороод үр төл, ашиг шимээ өгч чадах гайхамшигт чадавхтай. Мах, өөхөн ашиг шим нь давуу хөгжсөн, махны амт, чанараар тэргүүн зэрэгт үнэлэгдэж, сувилгаа хүндэтгэлийн идээ зууш болгон эрхэмлэдэг уламжлалтай. Сүргийн дотор халзан, хар бор шар нүдэн, хар бор улаан толгойтой, цагаан зүсмийн хонь 65.7 хувийг эзэлнэ.

Тохиромжтой хэвшлийн хонины үндсэн ашиг шимийн доод үзүүлэлт:

Хонины нас, хүйс	Амьдын жин /кг/		Ноосны гарц /гр/
	Хавар /V сард/	Намар /X сард/	
Бүдүүн хуц	45.0	60.0	1400
Төлгөн хуц	32.0	45.0	1100
Эм хонь	35.0	48.0	1200
Охин төлөг	28.0	36.0	1000

Үүлдэрээр баталгаажсан огноо, шийдвэрийн дугаар:

Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн сайдын 1990 оны А/69 дүгээр тушаал

Цаашид баримтлах үржил селекцийн ажлын чиглэл:

“Шилж өсгөн-ширвэж хэрэгцээлэх” ардын селекцийн уламжлалт арга ажиллагааг, шинжлэх ухааны үндэслэлтэй үржил- селекцийн ажилтай зохистой хослон зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн өөхгүй, уургаар баялаг, хүнсний аюулгүй байдлыг хангасан мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд махны чиглэлийн өсвөр хонины мах үйлдвэрлэхэд чиглэсэн үржлийн ажлын стратегийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

ҮЗЭМЧИН ҮҮЛДЭР¹⁷⁸



Тархалт:

Үзэмчин омгийн хонь үржүүлэх улсын үржлийн фермийг 1972 онд байгуулж, улмаар Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Төв, Булган, Сэлэнгэ, Өвөрхангай аймгийн ихэнх сумдад үржлийн хуц бойжуулан худалдаж, сайжруулагчаар ашиглаж ирсэн байна. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Сэргэлэн сумдад Үзэмчин үүлдрийн хонины цөм сүргийг үржүүлдэг.

Бий болгосон үржил селекцийн арга:

¹⁷⁸ <https://www.muz.gov.mn/breeds/view/22>

Бий болгосон үржил селекцийн арга:

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Сэргэлэн сумдад ардын уламжлалт селекцийн аргаар бий болсон махны хэвшлийн хонийг түшиглэн 1972 оноос доцент З.Гончигжавын удирдлагаар шинжлэх ухааны үндэслэлтэй эрдэм-шинжилгээ үйлдвэрлэлийн ажил явуулж, шилмэл хонийг “өөр дотор” нь сонгон үржүүлэх аргаар 20 гаруй жил явуулсан үржил-селекцийн ажлын үр дүнд тал хээрийн бүсэд зохицсон мах-өөх-бүдүүн ноосны чиглэлийн өөхөн сүүлт “Үзэмчин үүлдэр”-ийн хонь бий болжээ.

Ашиг шимийн үндсэн чиглэл:

Мах-өөх-бүдүүн ноосны

Үзэмчин үүлдрийн хонины онцлог:

Үзэмчин үүлдрийн хонины биологийн гол онцлог нь дорнод тал нутгийн экологийн нөхцөлд гойд зохицсон, бэлчээрээр таргалах чадварын хувьд бусад үүлдрийн хониноос илт давуутай, нядлагын жингээр халх болон ашиг шимийн ижил чиглэлийн бусад хонины үзүүлэлтээс 4-8 хувиар илүү байдаг оршино. Сүргийн дотор халзан, шар бор нүдэн, шар бор улаан толгойтой цагаан зүсмийн хонь 87.8 хувийг эзэлнэ.

Тохиромжтой хэвшлийн хонины үндсэн ашиг шимийн доод үзүүлэлт:

Хонины нас, хүйс	Амьдын жин /кг/		Ноосны гарц /гр/
	Хавар /V сард/	Намар /X сард /	
Бүдүүн хуц	52.0	65.0	1200
Төлгөн хуц	33.0	50.0	1000
Эм хонь	40.0	55.0	1100
Охин төлөг	30.0	45.0	800

Үүлдэрээр баталгаажсан огноо, шийдвэрийн дугаар:

ХАА-н сайдын 1991 оны А/65 дугаар тушаал

Цаашид баримтлах үржил селекцийн ажлын чиглэл:

Цэврээр нь үржүүлж, аж ахуй-биологийн ашигтай шинж чанаруудыг бататган сайжруулахын зэрэгцээ тал хээрийн бүс нутгийн хонины мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэгцээний эрлийзжүүлгийг эрчимтэй хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

БАРГА ҮҮЛДЭР¹⁷⁹



Тархалт:

Хэнтий, Дорноговь, Дундговь, Төв, Булган, Өвөрхангай, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудын зарим сумдад хонин сүргийнхээ махан ашиг шимийг дээшлүүлэх зорилгоор сайжруулагчаар ашиглаж иржээ. Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд Барга үүлдрийн хонины цөм сүргийг үржүүлдэг.

¹⁷⁹ <https://www.muz.gov.mn/breeds/view/23>

Бий болгосон үржил селекцийн арга:

Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд ардын уламжлалт селекцийн аргаар бий болсон махны хэвшлийн хонийг түшиглэн 1972 оноос улсын үржлийн ферм байгуулагдсанаар шинжлэх ухааны үндэслэлтэй эрдэм-шинжилгээ үйлдвэрлэлийн ажил явуулж, шилмэл хонийг “өөр дотор” нь сонгон үржүүлэх аргаар мах - өөх - бүдүүн ноосны чиглэлийн өөхөн сүүлт “Барга үүлдэр”-ийн хонийг бий болгожээ.

Ашиг шимийн үндсэн чиглэл:

Мах-өөх-бүдүүн ноосны

Барга үүлдрийн хонины онцлог:

Барга үүлдрийн хонины биологийн гол онцлог нь дорнод монголын тал, хуурай хээрийн экологийн өвөрмөц нөхцөлд сайтар зохицсон, сүүл, ууц нуруундаа харьцангуй их хэмжээний өөх хуримтлуулдаг, бага зэрэг өргөгдсөн богино зузаан отоггүй мухар сүүлтэйгээрээ бусад хониноос ялгагдана. Хуримтлагдсан өөх нь шим тэжээлийн нөөц болдог тул онд мэнд орох, харьцангуй бага турах, тэжээл, усны дутагдлыг илүүтэй даван туулах, өвчин эмгэгт тэсвэртэй зэрэг аж ахуй - биологийн үнэт гойд чадвартайгаараа онцлог хонь юм. Сүргийн дотор улаан толгойтой, шар халзан зүсмийн хонь 83.7 хувийг эзэлнэ.

Тохиромжтой хэвшлийн хонины үндсэн ашиг шимийн доод үзүүлэлт:

Хонины нас, хүйс	Амьдын жин /кг/		Ноосны гарц /гр/
	Хавар /V сард/	Намар /X сард/	
Бүдүүн хуц	50.0	63.0	1200
Төлгөн хуц	32.0	46.0	1000
Эм хонь	39.0	52.0	1100
Охин төлөг	30.0	42.0	900

Үүлдэрээр баталгаажсан огноо, шийдвэрийн дугаар:

ХХААХҮ-ийн сайдын 2012 оны А/126 дугаар тушаал.

Цаашид баримтлах үржил селекцийн ажлын чиглэл:

Дорнод Монголын тал, хээрийн бүсэд цэврээр нь үржүүлж, аж ахуй-биологийн ашигтай шинж чанаруудыг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн бататган сайжруулж, хонины мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хонин сүргийн онд оролт, тэсвэрт чанарыг дээшлүүлэхэд Барга үүлдрийн хонийг сайжруулагчаар ашиглахад чиглүүлэх.

БАЯД ҮҮЛДЭР¹⁸⁰



¹⁸⁰ <https://www.muz.gov.mn/breeds/view/24>

Тархалт:

Увс, Завхан, Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Төв, Сэлэнгэ, Орхон, Булган аймгуудын зарим сумдад хонин сүргийнхээ бэлчээр ашиглах, тэсвэрт чадавх болон махан ашиг шимийг дээшлүүлэх зорилгоор сайжруулагчаар ашиглаж иржээ. Увс аймгийн Малчин, Зүүнговь, Хяргас сумдад Баяд үүлдрийн хонины цөм сүргийг үржүүлж байна.

Бий болгосон үржил селекцийн арга:

Увс аймгийн Малчин, Зүүнговь, Хяргас, Тэс сумдад ардын селекцийн үр дүнд бий болсон хонин сүрэгт түшиглэн шинжлэх ухааны үндэслэлтэй үржил селекцийн ажлыг явуулж, тохиромжтой хэвшлийн хонийг өөр дотор нь сонгон үржүүлэх аргаар мах – өөх - бүдүүн ноосны чиглэлийн өөхөн сүүлт “Баяд үүлдэр”-ийн хонийг бий болгожээ.

Ашиг шимийн үндсэн чиглэл:

Мах-өөх-бүдүүн ноосны

Баяд үүлдрийн хонины онцлог:

Баяд үүлдрийн хонины биологийн гол онцлог нь Их нууруудын хотгор, Ханхөхийн нурууны байгаль экологийн эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалын нөхцөлд цас тээж бэлчээр ашиглах, хүйтнийг даах өлчир зэрэг амьдрах чадвар сайтай, бэлчээрээр тарга хүчээ хурдан авч, түүнийгээ сайн хадгалдаг, борвио хүрэхгүй ууцандаа өргөгдсөн богино дугараг хэлбэрийн отоггүй, мухар огтор өөхөн сүүлтэй, богинохон дөрвөлжин биетэй, махан ашиг шим харьцангуй өндөртэйгээрээ бусад үүлдэр, омгийн хониноос ялгагдана. Сүргийн дотор хар бараан толгойтой цагаан зүсмийн хонь 30 гаруй хувийг эзэлнэ.

Тохиромжтой хэвшлийн хонины үндсэн ашиг шимийн доод үзүүлэлт:


Хонины нас, хүйс	Амьдын жин /кг/		Ноосны гарц /гр/
	Хавар /V сард/	Намар /X сард/	
Бүдүүн хуц	43.0	65.0	2000
Төлгөн хуц	33.0	47.0	1700
Эм хонь	38.0	54.0	1600
Охин төлөг	31.0	40.0	1400

Үүлдэрээр баталгаажсан огноо, шийдвэрийн дугаар:

ХАА-н сайдын 1991 оны А/65 дугаар тушаал.

Цаашид баримтлах үржил селекцийн ажлын чиглэл:

Баяд үүлдрийн хонийг өөр дотор нь цэврээр үржүүлж, үнэт шинж чанаруудыг батжуулан бэхжүүлж, байгаль цаг уурын эрс тэс уур амьсгал бүхий бүс нутгийн хонин сүргийн тэсвэрт чанар, онд орох чадамжийг дээшлүүлэх, мах-ноосон ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр ашиглах.



БАЙДРАГ ҮҮЛДЭР¹⁸¹



Тархалт:

Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Дундговь, Архангай, Төв, Хэнтий зэрэг аймгийн 50 шахам сумын 1.7 сая хонинд үндсэн сайжруулагчаар ашиглаж байжээ. Баянхонгор аймгийн Жаргалант суманд Байдраг үүлдрийн хонины цөм сүргийг үржүүлж байна.

Бий болгосон үржил селекции арга:

Говь-Алтай, Баянхонгор аймгийн баруун урьд талын сумдын хониноос “Чамар хонь” гэж нэрлэгдэх урт ноостой хуц 15, эм хонь 444, хурга 125, нийт 584 хонийг 1953 онд худалдан авч, урт бүдүүвтэр ноост хонь бий болгох эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн ажлыг дэд доктор Ц.Арвийн удирдлагаар 1983 оныг хүртэл “өөр дотор нь” сонгон үржүүлэх аргаар мах-өөх-бүдүүвтэр ноосны чиглэлийн “Байдраг үүлдрийн хонь”-ийг бий болгожээ.

Ашиг шимийн үндсэн чиглэл:

Мах-өөх-бүдүүвтэр ноосны

Байдраг үүлдрийн хонины онцлог:

Энэ хонийг “Чамар” гэж нэрлэдэг байсан бөгөөд гол онцлог нь торгомсог, урт бүдүүвтэр ноостой, борвио хүрсэн уртавтар өөхөн сүүлтэй, цөлөрхөг хээрийн байгаль цаг уурын нөхцөлд илүүтэй зохицсон бэлчээр ашиглалт, онд оролтоор бусад үүлдрийн хониноос ялгарах зүйлгүй ижил, төсөөтэй хонь юм. Харин шинжлэх ухааны үндэслэлтэй зориудын шилэн сонголтын үр дүнд бий болсон тул халзан, хар бор нүдэн, хар бараан толгойтой их бие нь хундан цагаан зүстэй хонь зонхилно.

Тохиромжтой хэвшлийн хонины үндсэн ашиг шимийн доод үзүүлэлт:

Хонины нас, хүйс	Амьдын жин /кг/		Ноосны гарц /гр/
	Хавар /V сард/	Намар /X сард /	
Бүдүүн хуц	48.0	60.0	2000
Төлгөн хуц	30.0	42.0	1800
Эм хонь	37.0	50.0	1700
Охин төлөг	28.0	40.0	1500

Үүлдрээр баталгаажсан огноо, шийдвэрийн дугаар:

ХАА-н сайдын 1983 оны А/81 дүгээр тушаал.

Цаашид баримтлах үржил селекции ажлын чиглэл:

Байдраг үүлдрийн хонийг цэврээр нь үржүүлж, аж ахуй-биологийн ашигтай үндсэн шинж чанаруудыг алдагдуулахгүй бататган сайжруулахын зэрэгцээ ноос, махан ашиг шимийн

¹⁸¹ <https://www.muz.gov.mn/breeds/view/25>

зохистой хослолыг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн амьдын жинг нэмэгдүүлэх, тэсвэрт чадварыг сайжруулахад чиглүүлж, үнэт генофондыг хамгаалан арвижуулах.


Монгол Улсын хонин сүргийн 99.94 хувийг уугуул үүлдрийн хонь, 0.06 хувийг гадаад улсаас нутагшуулсан болон нутагшуулж байгаа хонь, тэдгээрийн эрлийз тус тус бүрдүүлж байна. Монгол Улсад байгаа бусад хонины үүлдэр, хэсэг, омгийн дэлгэрэнгүй мэдээллийг Монгол Улсын малын генетик нөөцийн төлөвийн цахим хуудаснаас үзэх боломжтой. (<https://www.muz.gov.mn>)

1.6 МАХНЫ ҮҮЛДРИЙН ХОНИНЫ ЦӨМ СҮРГИЙН БАЙРШИЛ, АШИГ ШИМ


Уугуул болон нутагшуулсан, нутагшуулж буй үүлдрийн хонийг ашиг шимийн чиглэлээр нь ангилж, тархалт, нягтаршилт, цөм сүргийн байршилыг тодорхойлоход 2021 оны байдлаар дараах төлөв байдалтай байна.

Махны чиглэлийн үүлдрийн хонины цөм сүргийн байршил


Бүдүүн ноос-махны чиглэлийн хонин сүргийн тархалт, цөм сүргийн байршил




Бүдүүвтэр ноос-махны чиглэлийн хонин сүргийн тархалт, цөм сүргийн байршил



Нарийн, нарийвтар ноосны болон бусад ашиг шимийн чиглэлийн хонин сүргийн
тархалт, цөм сүргийн байршил



Гадаад орноос авчран нутагшуулсан, нутагшуулж буй
хонины тархалт, байршил



Гадаад улс орноос авчирч нутагшуулж байгаа хонины зонхилох хэсэг Улаанбаатарын орчимд болон Төвийн бүсэд, эрлийз хонины 81.3 хувь Төвийн бүсэд тус тус байршиж байна. Сүүлийн жилүүдэд гадаад улсаас авчирсан хонь, тэдгээрийн эрлийзийг Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Дорнод аймгийн зарим сумд, Улаанбаатар хотын мал бүхий дүүргүүдэд голчлон үржүүлж байна.

Хонин сүргийн ашиг шимийн чиглэл

Монгол Улсад хонин сүргийг ашиг шимийн дараах 5 үндсэн чиглэлээр үржүүлж, ашиглаж байна. Үүнд:


- Бүдүүн ноос-махны чиглэлийн өөхөн сүүлт хонин сүрэг;
- Бүдүүвтэр ноос-махны чиглэлийн өөхөн сүүлт хонин сүрэг;
- Махны чиглэлийн ууцан сүүлт хонин сүрэг;
- Нарийн, нарийвтар ноосны чиглэлийн хонин сүрэг;
- Хурганы арьсны чиглэлийн хонин сүрэг.

Хонин сүргийн бүс нутаг дахь тархалт: ашиг шим ашиглалтын чиглэлээр

Эдийн засгийн бүс	Ашиг шимийн чиглэл				
	Бүдүүн ноост, махны чиглэлийн өөхөн сүүлт	Бүдүүвтэр ноост, махны чиглэлийн өөхөн сүүлт	Ноос, махны чиглэлийн ууцан сүүлт	Нарийн, нарийвтар ноосны чиглэлийн	Хурганы арьсны
Баруун	16.7	59.5	94.1	-	-
Хангай	38.6	40.5	-	2.7	-
Төвийн	24.6	-	5.91	93.3	100
Зүүн	19.6	-	-	4.0	-
Улаанбаатар	0.6	-	0.03	-	-
Нийт дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0

Бүдүүн ноост, махны чиглэлийн өөхөн сүүлт хонийг Хангайн бүсэд, бүдүүвтэр ноост, махны чиглэлийн өөхөн сүүлт хонийг Баруун болон Хангайн бүсэд, ноос, махны чиглэлийн ууцан сүүлт хонийг Баруун бүсэд, нарийн, нарийвтар ноост хонийг Төвийн бүсэд, хурганы арьсны чиглэлийн хонийг Төвийн бүсэд тус тус зонхилон үржүүлж байна.

Хонин сүргийн ашиг шимийн чиглэлийн бүтэц, хувиар



Нийт хонин сүргийн зонхилох буюу 90,6 хувийг бүдүүн ноос-махны чиглэлийн хонь эзэлж байна.

1.7 ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧ ХОНЬ

Мал үржүүлгийн ажлыг зохион байгуулахдаа хээлтүүлгийн аргуудыг сонгон хэрэглэдэг. Мал хээлтүүлгийн ажлыг зохион байгуулахад нэг талаас хээлтэгч, хээлтүүлэгч малын ороо эрчимтэй явагдах үе, нөгөө талаас гарах төл нь өсч бойжиход хамгийн тохиромжтой улирлыг сонгоход анхаарна. Бэлчээрийн маллагаатай монгол малаас ингэ өвлийн, гүү, үнээ хавар,

зуны, хонь, ямаа намрын улиралд нийлүүлэгт орж 3 болон 4 сард төллөхөөр тааруулах нь зүйтэй. Харин эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа нөхцөлд малыг жилийн турш жигд, ээлжээр төллүүлж байхаар хээлтүүлгийн ажлыг зохион байгуулна. Хээлтүүлгийн аргыг дараах байдлаар ангилна.

1. **Ердийн хээлтүүлэг:** Малчид олон зуун жилийн турш мал маллагаандаа ердийн болон гардан хээлтүүлгийн аргыг өргөн ашиглаж ирсэн юм. Ердийн хээлтүүлгийн үед сүргийн дотор хээлтүүлэгч малыг байнга хамт байлгана.
2. **Гардан хээлтүүлэг:** Гардан хээлтүүлгийн үед ороо нь орсон хээлтэгчийг зогсоолд оруулж бэхлээд юм уу ороотой эх малыг тусгай хашаанд хээлтүүлэгчтэй хамт оруулан тус тус хээлтүүлэгчийг харайлгах аргаар нийлүүлэг явуулна. Энэ аргын давуу тал нь хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог оновчтой хийх, хээлтүүлэгчийг үр бүтээлтэй ашиглах, үржлийн бүртгэл тооцоо хөтлөх, гарсан төлийг гарал, үүслээр нь үнэлэх, мал эмнэлгийн үзлэг шинжилгээ хийх боломжтой болно. Гардан хээлтүүлгийн үед хээлтүүлэгчийг тусад нь малладаг учир туршигч хээлтүүлэгч ашиглан хээлтэгчийн ороог илрүүлэх нь илүү үр дүнтэй байдаг. Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироог дараах хүснэгтийн дагуу баримжаалан тогтооно.
3. **Зохиомол хээлтүүлэг:** Малыг зохиомлоор хээлтүүлэх нь хээлтүүлгийн бусад аргуудаас хамгийн дэвшилттэй арга юм. Зохиомол хээлтүүлгийн арга нь арвин ашиг шимтэй хээлтүүлэгчээс олон тооны төл авах, бусад хээлтүүлгийн аргуудаас олон талаар давуутай. Үүнд:
 - Урьдаас төлөвлөн шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулагддаг.
 - Арвин ашиг шимт үр төлийн чанараар баталгаажсан хээлтүүлэгч малын үрээр олон тооны эх малыг хээлтүүлэх боломжтой.
 - Бруцеллэз, лейкоз, сүрьеэ, вибриоз зэрэг олон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой.
 - Малын чанарыг богино хугацаанд сайжруулах боломж бүрдүүлдэг.

Улсын хэмжээн дэх хээлтэгч эм хонины тоо

Хээлтэгч эм хонины тоо 2021 оны байдлаар өмнөх оноос 793.5 мянган толгой буюу 5.7 хувь өссөн байна.

Статистик үзүүлэлт	Баг, хороо	2016	2017	2018	2019	2020	2021
Эм хонь	Улсын дүн	12578.62	13519.7	14223.4	14748.3	13958.7	14752.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (хэмжих нэгж мян. тол)

Хээлтүүлэгч хонины тоо¹⁸²

Хээлтүүлэгч 195 мянган мал 2021 онд тоологдож өмнөх оноос 43 мянган толгойгоор буюу 28.2 хувиар буурчээ. /Үржлийн нормоор нэг хуцанд 25-30 эм хонь ногдог/.

Статистик үзүүлэлт	Баг, хороо	2016	2017	2018	2019	2020	2021
Хуц	Улсын дүн	139.7	145.0	138.0	154.9	152.0	195.0

Эх сурвалж: Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга (хэмжих нэгж)

¹⁸² Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга. 62 ху

1.8 ХОНИНЫ МАХНЫ ЭКСПОРТЫН ТОЙМ

ХОНИНЫ МАХНЫ ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭ

Монгол Улс 2022 оны эхний 4 сард нийт 134 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5.1 тэрбум америк доллар, үүнээс экспорт 2.8 тэрбум америк доллар, импорт 2.3 тэрбум америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 690.8 (15.5%) сая америк доллароор, экспорт 302.7 (12.1%) сая америк доллароор, импорт 388.1 (19.8%) сая америк доллароор тус тус өсжээ. Мөн экспорт өмнөх сараас 138.1 (18.7%) сая америк доллароор, импорт 5.7 (0.9%) сая америк доллароор тус тус өссөн байна.

Монгол Улсын гадаад худалдааны түнш улсуудын тоо жилээс жилд нэмэгдэж 2019 онд нийт 76 улсад бараа бүтээгдэхүүнээ экспортолж байсан бол Ковид-19 цар тахлаас үүдэн 2020 онд экспортын түнш улсуудын тоо буурч 73 болжээ. Манай улсын экспортын бүтцэд 1992 онд БНХАУ 17.8 хувийг, ОХУ 58.5 хувийг эзэлж байжээ. Харин 2020 онд БНХАУ-ын эзлэх хэмжээ 72.5 хувь, харин ОХУ-ынх 0.8 хувь болжээ.¹⁸³

Экспортын хэмжээ (мянган америк доллароор)¹⁸⁴

2016		2017		2018		2019		2020		2021	
Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн
0.2	361.5	2.6	8,267.0	6.2	15,567.7	7	24,164.6	1.8	4,828.3	1.6	4,334.8

Гаалын ерөнхий газрын мэдээлэл (Хэмжих нэгж мян. тон)

Хонины махны экспортын мэдээ (улсаар)

он	Хүлээн авагч улс	тоо хэмжээ, тонн	үнийн дүн, мян.\$
2016	БНХАУ	126.0	196.7
	Катар	1.8	5.2
2017	Иран (Исламын Бүгд Найрамдах)	2,601.3	8,266.3
	Катар	0.3	0.7
2018	Иран (Исламын Бүгд Найрамдах)	2,289.5	9,022.3
	Вьетнам	1,840.0	2,906.7
	Хонконг	403.5	726.3
	Малайз	86.5	178.0
	Казахстан	34.2	62.5
	Киргиз	20.0	26.0
	Катар	0.4	1.3
	Арабын Нэгдсэн Эмират Улс	0.3	1.4
2019	Иран (Исламын Бүгд Найрамдах)	5,688.7	21,137.9
	БНАСАУ	120.0	252.0
	Вьетнам	44.4	73.8
	ХБНГУ	19.0	70.7
	Азербайжан	16.7	33.9
	Арабын Нэгдсэн Эмират Улс	0.8	2.5
2020	Катар	0.4	1.1
	Иран (Исламын Бүгд Найрамдах)	446.3	1,826.3

¹⁸³ https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=External_trade_2020.pdf&ln=Mn

¹⁸⁴ https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L14&type=sectorbook /Гадаад худалдаа, 2022-03/

2021 эхний 10 сар	БНХАУ	76.0	290.4
	Тайвань	19.0	72.6
	Иран (Исламын Бүгд Найрамдах)	237.1	779.8
	Бахрейн Улс	0.1	0.2
2016-2021.10 дүн		14,072.3	45,934.7

Эх сурвалж: Гаалын ерөнхий газрын мэдээлэл

БҮЛЭГ 2. ҮХЭР СҮРГИЙН ТАЛААРХ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

Манай орны байгаль, газар зүй, экологийн нөхцөлөөс хамааран үхрийн тархалт өндөр уулын бүсэд 27.6, ойт хээрийн бүсэд 25.2, тал хээрийн бүсэд 28.8, их нуурын хотгор, Алтайн бүсэд 12.5, говийн бүсэд 5 хувийг эзлэн үржүүлж байна. Монгол үүлдрийн үхэр нь толгой жижиг, хөнгөн, дух өргөн, хоншоор нарийн, дагз сэртэнгүй байгаа нь хамгийн онцлог шинж юм. Монгол үхэр улаан зүс зонхилж харин хар бидэртэй хүрэн ягаан, ухаа зүсүүд голчлон зонхилно. Манай улсын байгаль цаг, уурын эрс тэс уур амьсгалд дасан зохицсон үхэр болон сарлагийг монголчууд эрт дээр үеэс өсгөн үржүүлж ирсэн бөгөөд уур амьсгалын хувьсал өөрчлөлт, нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлогоос хамаарч үхэр сүргийн тоо, байршил тархалт өөрчлөгдсөөр байна. Үхэр сүргийн тооны хөдлөл зүйг нарийвчлахад 1944-1945 оны зуданд 625.5 мянга, 2009-2010 оны зуданд 423,3 мянган үхэр хорогдож, 2010 онд 2.1 саяд хүрч буурсан ч түүнээс хойших 9 жилийн хугацаанд адуун сүргийн адил 2,2 дахин өсч, 2021 оны жилийн эцэст 5.0 сая үхэртэй болов.

2.1 ҮХЭР СҮРГИЙН ТОО ТОЛГОЙ (бүсээр, аймаг)

Мал тооллогын 2021 оны жилийн эцсийн дүнгээр хонины тоо толгой 5022.2 мян.тол болж, өмнөх оноос 290.2 мян.тол буюу 6.1 хувиар өссөн байна.

Баг, хороо	2016	2017	2018	2019	2020	2021
Улсын дүн	4080.936	4388.455	4380.879	4753.192	4732.01	5022.225
Баруун бүс	742.22	815.963	822.739	854.555	858.963	949.978
Хангайн бүс	1806.824	1934.447	1888.542	2076.047	1967.727	2033.859
Төвийн бүс	761.004	769.252	740.957	809.743	855.074	885.323
Зүүн бүс	681.088	779.948	847.806	927.195	960.733	1068.537
Улаанбаатар	89.8	88.845	80.835	85.652	89.513	84.528

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны байдлаар манай улсын үхэр сүргийн зонхилох буюу 40,5 хувь Хангайн, 21,3 хувь Зүүн, 18,9 хувь Баруун, 17,6 хувь Төвийн, 1,6 хувь Улаанбаатарын бүсэд тус тус байршиж байна.

Монгол Улсын үхэр сүргийн газар зүйн байршлын өөрчлөлт (аймгаар)

Баг, хороо	2016	2017	2018	2019	2020	2021
Улсын дүн	4080.936	4388.455	4380.879	4753.192	4732.01	5022.225
Завхан	172.359	192.16	204.995	228.7	224.995	245.165
Говь-Алтай	71.058	85.4	85.225	84.475	75.856	69.585
Баян-Өлгий	155.615	161.025	155.914	158.582	159.49	181.947
Ховд	182.142	200.512	193.683	187.087	187.124	207.617
Увс	161.046	176.866	182.922	195.711	211.498	245.664
Орхон	21.603	21.9	17.477	19.041	20.335	24.291
Өвөрхангай	259.939	298.244	272.32	292.412	251.816	239.705

Булган	293.602	283.891	255.264	282.391	269.75	293.665
Баянхонгор	213.809	240.342	239.777	257.616	245.752	197.924
Архангай	581.226	628.783	621.246	710.077	678.994	722.169
Хөвсгөл	436.645	461.287	482.458	514.51	501.08	556.105
Төв	326.23	310.761	282.33	313.843	322.09	319.967
Говьсүмбэр	13.646	14.903	14.004	14.543	16.348	17.81
Сэлэнгэ	224.278	218.403	216.805	232.286	255.976	281.565
Дорноговь	63.003	72.62	80.576	91.891	103.747	118.062
Дархан-Уул	49.003	50.291	44.259	47.357	48.598	50.913
Өмнөговь	22.149	26.997	26.864	31.653	33.192	31.28
Дундговь	62.695	75.277	76.119	78.17	75.123	65.726
Дорнод	175.55	207.861	243.14	277.423	305.105	353.221
Сүхбаатар	209.326	236.792	251.639	268.547	280.91	308.227
Хэнтий	296.212	335.295	353.027	381.225	374.718	407.089
Улаанбаатар	89.8	88.845	80.835	85.652	89.513	84.528

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Өнгөрсөн 75 жилийн хугацаанд үхрийн тоо эдийн засгийн бүх бүс нутагт өссөн ч сүрэгт эзлэх хувь нь Хангайн бүсэд 4.6 хувиар нэмэгдэж, бусад бүсэд 1.5 -2.3 хувиар буурсан хөдлөл зүйтэй байна. Цаашид үхрийн тоо болон сүрэгт эзлэх хувь Хангайн бүсэд өсөх хандлагатай байгаа бол Зүүн бүсэд харьцангуй тогтвортой, Төвийн болон Улаанбаатарын бүсэд үхрийн тоо нэмэгдсэн ч сүрэгт эзлэх жин тогтвортой байх хандлагатай байна.

1945-1947 онуудад хийсэн судалгаанд “Монголын дорнод болон хойд талын аймгуудад үхэр олон, баруун ба говийн аймгуудад цөөрдөг” гэж тэмдэглэсэн байдаг. Судлаач Б.Өлэн-Эрдэнэ “Монгол нутаг дахь үхрийн унаган тархалтын хамгийн өндөр нягтралын газар зүйн голомт нь одоогийн Архангай аймгийн Хашаат, Хотонт, Өгийнуур, Өлзийт, Хайрхан, Батцэнгэл, Цэнхэр, Түвшрүүлэх, Булган, Эрдэнэмандал, Их Тамир, Чулуут, Өндөр-Улаан, Жаргалант, Тариат, Хангай сум, Булган аймгийн Рашаант, Гурванбулаг, Дашинчилэн, Баяннуур, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Могод, Сайхан сум, Өвөрхангай аймгийн Хархорин, Бүрд, Хужирт, Бат-Өлзийт сум, Төв аймгийн Заамар, Баянхангай, Угтаалцайдам, Лүн, Өндөрширээт, Алтанбулаг, Эрдэнэсант сум, Хөвсгөл аймгийн Жаргалант, Галт зэрэг нийт 5 аймгийн 37 сумдын газар нутгийг хамарч тэндээс тал тал тийш шингэрсэн төлөвтэй байгаа бөгөөд энэхүү 37 сумдын нийт нутгийн газар зүйн төвлөрөл нь Архангай аймгийн Батцэнгэл, Өгийнуур, Өлзийт гэсэн 3 сумын нутгийн тодорхой хэсгийг хамарсан газар зүйн байршилд оршиж байна” гэж дүгнээд байна. Үхрийн нэгэн төрөл зүйлд багтдаг сарлагийг монголчууд мөн эрт дээр үеэс үржүүлж ирсэн билээ. Судлаачид сарлагийг Төвдөд анх гэрийн мал болгож тэндээс Монголоор дамжин Тува, Алтайд нэвтэрсэн байх магадлалтай гэж үздэг ба түүхэн эх сурвалж, нотолгоогоор Хүннү аймгийн нүүдэлчид ерийн үхэр, сарлаг хоёрын аль алиныг нь өсгөх болсон.¹⁸⁵ гэж тэмдэглэсэн байна. Сарлагийн 50 гаруй хувь нь далайн түвшнээс 2000 метрээс дээш, 40 орчим хувь нь 1600-2000 метрийн өндөрт байрших ба Гималайн салбар уулс, Тэнгэр уул, манай улсын Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутагт илүү зохицсон юм.

Монголчууд сарлагийг бусад төрлийн мал бэлчихэд тохиромжгүй нутгийн бэлчээр ус ашиглаж, арчилгаа маллагааны ердийн нөхцөлд бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг тул эдийн засгийн үр ашиг сайтай мал гэж үздэг.

¹⁸⁵ Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980.10..27

Өдгөө манай улсын уулархаг, ойт хээрийн бүс нутгийн 13 аймаг 132 суманд монгол сарлаг, хайнаг үржиж байна.¹⁸⁶

2.2 ЭРЧИМЖСЭН ҮХРИЙН АЖ АХУЙ

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар 3035 өрх, аж ахуйд сүүний үхрийн 98025 үнээ, 341 аж ахуйд 34963 махны үхэр, 28 аж ахуйн нэгж, 1190 өрхөд 1 сая 60 мянган шувуу, 15 аж ахуйн нэгж, 446 өрхөд 21652 гахай, 36 аж ахуйн нэгж, 680 өрхөд 13708 бүл зөгий үржүүлж байна. Үүнээс сүүний үхрийн аж ахуйн тоо 3035, үхрийн тоо 98025, махны үхрийн аж ахуйн тоо 341, 34963 үхэр бүртгэлтэй байна.¹⁸⁷

Үхэр сүргийн эрчимжсэн аж ахуйн тоо,
үхрийн тоо толгой (аймгаар)¹⁸⁸

	Аймаг	Үхэр							
		Сүүний үхэр		Үүнээс				Махны үхэр	
				Сүүний үхэр		Сүү-мах, мах-сүүний үхэр			
		Бүгд тоо толгой	Нийт аж ахуйн тоо	Аж ахуйн тоо	Толгойн тоо	Аж ахуйн тоо	Толгойн тоо	Аж ахуйн тоо	Толгойн тоо
1	Архангай	1139	59	29	294	30	875	21	363
2	Баян-Өлгий	633	23	5	142	18	491	0	0
3	Баянхонгор	301	18	4	111	14	290	0	0
4	Булган	512	76	1	57	75	455	1	515
5	Говь-Алтай	422	28	4	104	14	318	6	238
6	Говьсүмбэр	61	7	7	61	0	0	12	262
7	Дархан-Уул	2496	35	8	441	27	2055	8	1022
8	Дорноговь	722	26	4	275	22	447	10	195
9	Дорнод	687	30	15	196	15	491	142	13936
10	Дундговь	180	18	15	164	3	16	0	0
11	Завхан	547	35	30	497	5	50	0	0
12	Орхон	294	19	14	157	5	137	7	354
13	Өвөрхангай	1646	82	46	547	36	1099	4	269
14	Өмнөговь	213	22	22	213	0	0	5	65
15	Сүхбаатар	718	30	0	0	30	718	2	494
16	Сэлэнгэ	7886	256	162	3519	94	4367	67	11211
17	Төв	18305	474	203	9070	271	9235	17	2103
18	Увс	913	103	0		103	913	1	30
19	Ховд	1231	24	17	704	7	527	0	0
20	Хөвсгөл	1367	47	0		47	1367	24	2431
21	Хэнтий	5553	2	2	160		5393	0	837
22	Улаанбаатар	52202	1621	301	7452	1320	44750	14	638
Бүгд		98028	3035	889	24164	2136	73994	341	34963

2021 оны эрчимжсэн мал аж ахуйн судалгаа 2022.01.13-ны байдлаар

¹⁸⁶ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас авсан мэдээ.

¹⁸⁷ <https://mofa.gov.mn/exp/blog/7/4>

¹⁸⁸ <http://203.26.189.154/files/pdf-files/pdf/6255232d5b58af779a8603ef.pdf>

2.3 ҮХЭР СҮРГИЙН ОМОГ, ҮҮЛДЭР

Монгол Улсад нийт үхэр сүргийн 97.8 хувийг уугуул үүлдрийн үхэр, үүний дотор 20.0 хувийг сарлаг, гадаад улсаас нутагшуулсан болон нутагшуулж байгаа үхэр 2.2 хувийг тус тус бүрдүүлж байна. Үхэр сүргийн үүлдэрлэг байдлын бүрэлдэхүүн, тэдгээрийн нягтаршил, цөм сүргийн байршлыг 2021 оны байдлаар тодорхойлоход дараах байдалтай байна. Монгол Улсын үхэр сүрэгт 2021 оны байдлаар эрх бүхий байгууллагаас хянан баталгаажуулсан үндэсний 4 үүлдэр, гадаад улсаас авчирч нутагшуулсан болон нутагшуулж байгаа 14 үүлдрийн үхэр байна.


Үхэр сүргийн омог, үүлдрүүд ба газар зүйн байршлын нягтшил, цөм сүргийн байршил¹⁸⁹

№	Үүлдрийн гарал	Үүлдэр, омгийн нэр	Үхэр сүрэгт эзэлж буй хувь
1	Монголын уугуул үүлдрүүд	Монгол үхэр	77.7
		Монгол сарлаг	20.0
		Сэлэнгэ	2.48
		Дорнод монголын улаан	0.59
2	Гадаад улсаас нутагшуулсан, нутагшуулж буй үхрийн үүлдрүүд	Оросын болон Германы хар тарлан***	2.2
		Голштейн**	
		Талын улаан***	
		Симментал***	
		Алатау***	
		Герефорд***	
		Казахын цагаан толгойт***	
		Лимузин***	
		Ангус**	
		Шароле**	
		Монтблярьд**	
		Абонданс	
		Норвегийн улаан	
		Пьемонтес	
Бүгд			100.0

- * нутагшаад 5 хүртэлх жилийн дотор байгаа
- ** нутагшаад 6-15 жил болж байгаа
- *** нутагшаад 16 ба түүнээс дээш жил болсон

ҮХРИЙН ҮҮЛДЭР

МОНГОЛ ҮҮЛДЭР¹⁹⁰



¹⁸⁹ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн мэдээ.

¹⁹⁰ <https://www.muz.gov.mn/breeds/view/4>

Тархалт:

Манай орны байгаль, газар зүй, экологийн нөхцөлөөс хамааран үхрийн тархалт өндөр уулын бүсэд 27.6, ойт хээрийн бүсэд 25.2, тал хээрийн бүсэд 28.8, их нуурын хотгор, Алтайн бүсэд 12.5, говийн бүсэд 5 хувь байна.

Бий болгосон үржил селекцийн арга:

Ардын уламжлалт сонгон үржүүлэг

Ашиг шимийн үндсэн чиглэл:

Мах, сүүний

Монгол үүлдрийн үхрийн онцлог:

Монгол үхэр нь байгаль цаг уурын янз бүрийн бүс нутагт дасан зохицсон тэсвэр хатуужилтай, байгалийн бэлчээрийг чадамгай ашиглан намар нас гүйцсэн үхэр 30-50%, өсвөр үхэр 60-80%-аар хаврын жингээ нэмэгдүүлж, тарга хүч авах чадвартай. Монгол үхэр зун, намрын улиралд өөх ихээр хуримтлуулдаг нь цаг агаарын хүнд нөхцөлийг даван туулах энергийн эх үүсвэр болдог. Хүрэн улаан, бидэртэй хүрэн зүс зонхилох боловч ухаа ягаан, хар, бөөр алаг зүс нэлээд тохиолдоно.

Ашиг шимийн үзүүлэлт:

Нас, хүйс	Амьдын жин /кг/	Сүүлэг чанар	
		Саам /л/	Тослог /%/
Бух	325-396	-	-
Үнээ	273-315	315	4,3

Үйлдрээр баталгаажсан огноо, шийдвэрийн дугаар:

Хөдөө аж ахуй, хөнгөн хүнсний үйлдвэрийн сайдын 1990 оны А/69 дүгээр тушаал

Цаашид баримтлах үржил селекцийн ажлын чиглэл:

Өөр дотор нь шилэн сонгож, махны чиглэлээр үржүүлэх

СЭЛЭНГЭ ҮҮЛДЭР¹⁹¹



Тархалт:

Булган аймгийн Сэлэнгэ сум, Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Алтанбулаг сумдад Сэлэнгэ үүлдрийн үхрийг цэвэрээр нь үржүүлж байна.

¹⁹¹ <https://www.muz.gov.mn/breeds/view/8>

Бий болгосон үржил селекцийн арга:

Казахын цагаан толгойт үүлдэрээр монгол үхрийг 2-3 дахь үе хүртэл эрлийзжүүлж тохиромжтой хэвшлийн үхрийг шилэн сонгож “өөр дотор” нь үржүүлэн махны чиглэлийн “Сэлэнгэ” үүлдрийн үхрийг бий болгожээ.

Ашиг шимийн үндсэн чиглэл:

Махны

Сэлэнгэ үүлдрийн үхрийн онцлог:

Монгол үүлдрийн үхрийн тэсвэрт чанар, бэлчээр ашиглах чадварыг болон Казахын цагаан толгойт үүлдрийн үхрийн биеийн жин, өсөлтийн давуу байдалтай хослуулан удамшуулж чадсан давуу талтай. Сэлэнгэ үүлдрийн үхэр махны хэвшлийг бүрэн хадгалсан, гуя хонгоны махны дүүргэлт сайн, булчин махны хөгжил жигд, цээж бөгс тэнцүү, нядлагын гарц, жингээр махны төрөлжсөн үүлдэртэй ойролцоо, сүүлэг шинжээрээ эхлээр бойжиж байгаа тугалын өсөлтийн эрчмийг бүрэн хангаж чаддаг. Тугал нь 25-30 кг жинтэй төрөх бөгөөд эхлээр бойжуулж, эхээс ялгах үед эр нь 265-330 кг, охин нь 240-280 кг жинтэй байна. Зүсний хувьд их бие нь хүрэн улаан, улаан, ягаан, дух, омруу, хээлүүр, шилбэ, сүүлний үзүүр цагаан, хамрын толио цайвар бор.

Ашиг шимийн үзүүлэлт:

Нас, хүйс	Амьдын жин /кг/	Сүүлэг чанар	
		Саам /л/	Тослог /%/
Бух	625-700	-	-
Үнээ	430-480	1200-1800	3.8-4.2


Үүлдэрээр баталгаажсан огноо, шийдвэрийн дугаар:

Хөдөө аж ахуйн сайдын 1984 оны 287 дугаар тушаал

Цаашид баримтлах үржил селекцийн ажлын чиглэл:

Сэлэнгэ үүлдрийн үхрийн ашиг шимийн үнэт чанарыг бататган сайжруулж, тархалтын хүрээг өргөтгөн цэврээр үржүүлэхийн зэрэгцээ нутгийн Монгол үүлдрийн үхрийн махан ашиг шимийг нэмэгдүүлэхэд сайжруулагчаар ашиглах.

ДОРНОД МОНГОЛЫН УЛААН ҮҮЛДЭР¹⁹²



¹⁹² <https://www.muz.gov.mn/breeds/view/9>

Тархалт:

Дорнод Монголын улаан үхрийг Дорнод аймгийн Халх гол, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд цэврээр үржүүлж байна.

Бий болгосон үржил селекцийн арга:

Дорнод, Сүхбаатар аймгийн үхэр сүргийн дотор ардын уламжлалт селекцийн үр дүнд бий болсон махны хэв шинж хадгалсан үхрийг шинжлэх ухааны үндэслэлтэй өөр дотор нь сонгон үржүүлж “Дорнод Монголын улаан үүлдэр”-ийн үхрийг бий болгожээ.

Ашиг шимийн үндсэн чиглэл:

Махны

Дорнод талын махны хэвшлийн үхрийн онцлог:

Дорнод Монголын улаан үхэр нь жилийн турш бэлчээрийн маллагаанд Монгол үүлдрийн үхэртэй ижил нөхцөлд маллагдаж байгаа боловч 18 сартай охин бяруу 263 кг, нэмрийн гунж 307 кг, дөнгж 355 кг жин татаж байгаа нь нутгийн үхрийн дундаж үзүүлэлтээс 50-60 кг-аар илүү байна. Зүс нь хар улаан ихэвчлэн мухар байдаг онцлогтой.

Ашиг шимийн үзүүлэлт:

Нас, хүйс	Амьдын жин /кг/	Сүүлэг чанар	
		Саам /л/	Тослог /%/
Бүх	500-550	-	-
Үнээ	350-380	300-400	3.8-5.2

Цаашид баримтлах үржил селекцийн ажлын чиглэл:

Дорнод талын махны хэвшлийн үхрийн ашиг шимийн үнэт чанарыг бататган сайжруулж, тархалтын хүрээг өргөтгөн цэврээр үржүүлэхийн зэрэгцээ нутгийн Монгол үүлдрийн үхрийн махан ашиг шимийг нэмэгдүүлэхэд сайжруулагчаар ашиглах

МОНГОЛ САРЛАГ ¹⁹³



Тархалт:

Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгуудын өндөр уулархаг нутагт Монгол үүлдрийн сарлагийг цэврээр үржүүлж байна.

Бий болгосон үржил селекцийн арга:

Ардын уламжлалт сонгон үржүүлэг

¹⁹³ <https://www.muz.gov.mn/breeds/view/10>

Ашиг шимийн үндсэн чиглэл:

Сүү-мах-уналга-эдэлгээ-ноос

Монгол үүлдрийн сарлагийн онцлог:

Сарлагийн биологийн онцлог нь өндөр уулын байгаль, цаг уурын эрс тэс, хатуу ширүүн нөхцөлд гайхалтай идээшин зохицсон, байгалийн бартаа, хад асгатай ямар ч нөхцөлд чөлөөтэй хурдан, шалмаг явж сийрэг, тачир өвс ургамлаар хооллох чадвартай.

Сарлагийн бүх бие сахлаг урт үсэн бүрхэвчтэй, ялангуяа хаа, гуя, гэдэс хэвлий дагуу урт сахлаг савгартай, өтгөн урт сүүлтэй, хөлсний булчирхай цөөн бөгөөд нарийхан учир биеийн гадаргуугаас дулаан алдах нь бага, хүйтэн сэрүүн нөхцөлд зохицсон онцлогтой.

Ашиг шимийн үзүүлэлт:

Нас, хүйс	Амьдын жин /кг/	Сүүлэг чанар	
		Саам /л/	Тослог /%/
Бүх	400-450	-	-
Үнээ	270-280	280-320	7.2-12

Үүлдрээр баталгаажсан огноо, шийдвэрийн дугаар:

Хөдөө аж ахуй, хөнгөн хүнсний үйлдвэрийн сайдын 1990 оны А/69 дүгээр тушаал

Цаашид баримтлах үржил селекцийн ажлын чиглэл:


Монгол үүлдрийн сарлагийг цэврээр үржүүлэхийн зэрэгцээ сүү, хөөвөр, ноосны гарц чанарыг сайжруулах, хязгаарлагдмал хүрээнд хайнагжуулах чиглэл баримтална.

Сарлагийн тоо, эдийн засгийн бүс ба оноор, толгой


	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Улсын дүн	585,161	690,665	745,656	799,558	875,952	877,670	1,005,976	901,716	901,295
Баруун бүс	119,186	145,271	165,033	173,118	194,461	186,044	189,321	175,596	185,179
Хангайн бүс	463,203	541,200	575,550	622,098	676,201	687,481	813,047	720,612	710,901
Төвийн бүс	1,993	2,995	3,126	2,982	2,546	2,525	2,131	3,441	2,427
Зүүн бүс	356	400	793	302	890	571	536	689	929
Улаанбаатар	423	829	1,154	1,058	1,854	1,049	941	1,378	1,859

2.4 МАХ, СҮҮНИЙ ЧИГЛЭЛИЙН ҮХЭР, САРЛАГИЙН ЦӨМ СҮРГИЙН БАЙРШИЛ, ҮХЭР СҮРГИЙН АШИГ ШИМИЙН ЧИГЛЭЛ


Уугуул болон нутагшуулсан, нутагшуулж буй үүлдрийн хонийг ашиг шимийн чиглэлээр нь ангилж, тархалт, нягтаршилт, цөм сүргийн байршлыг тодорхойлоход 2021 оны байдлаар дараах төлөв байдалтай байна.




*Монгол Улсын үхрийн уугуул үүлдрүүд, тэдгээрийн цөм сүргийн газар зүйн байршил, тархалт*¹⁹⁴




Гадаад орноос авчран нутагшуулсан, нутагшуулж буй махны чиглэлийн
үхрийн газар зүйн байршил, тархалт



Гадаад улсаас авчран нутагшуулсан, нутагшуулж байгаа сүүний чиглэлийн үхрийн газар зүйн байршил, тархалт




Гадаад орноос авчран нутагшуулсан, нутагшуулж буй хосолмол ашиг шимт үхрийн газар зүйн байршил, тархалт



2021 оны байдлаар гадаад улсаас авчирсан махны чиглэлийн 5 үүлдэр, сүүний чиглэлийн 3 үүлдэр, хосолмол ашиг шимт 3 үүлдрийн үхэр, тэдгээрийн эрлийзийг Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Дорнод, Дундговь, Сүхбаатар аймгийн зарим сумдууд, Улаанбаатар хотын мал бүхий дүүргүүдэд голчлон үржүүлж байна.

Монгол сарлаг, түүний цөм сүргийн газар зүйн байршил, тархалт



2021 оны байдлаар нийт сарлагийн сүргийн зонхилох буюу 80,0 хувь Хангайн бүсэд, 18.8 хувь Баруун бүсэд, 0.4 хувь бусад бүсэд байршиж байна.

МОНГОЛ УЛСАД ӨСГӨН ҮРЖҮҮЛЖ БАЙГАА ҮХЭР СҮРГИЙН ТАРХАЦ, ЦӨМ СҮРГИЙН БАЙРШИЛ



Үндсний үхдэр - 4

Гадаадаас авч, нутагшуулан үржүүлсэн үхрийн үхдэрүүд - 9


- махны чиглэлийн - 4
- сүүний чиглэлийн - 2
- хосолмол ашиг шимийн - 3



Үхэр сүргийн ашиг шимийн чиглэл

Монгол Улсад үржүүлж буй үхэр сүргийг махны, сүүний, мах-сүүний, сүү-махны хосолсон гэсэн ашиг шимийн үндсэн 4 чиглэлээр ашиглаж байгаа.

Үхэр сүргийн ашиг шим ашиглалтын төлөв



Нийт үхэр сүргийн 77.7 хувийг монгол үхэр, 20 хувийг сарлаг, 1.1 хувийг сүүний чиглэлийн, 0.5 хувийг махны, 0.6 хувийг хосолмол ашиг шимт үхэр эзэлж байна. Үхэр сүргийн ашиглалтын байдлыг сум, дүүрэг, аймаг, нийслэл, бүс нутгийн түвшинд тодорхойлоход дараах байдалтай байна.

Бүс нутагт үхэр сүргийн ашиг шим ашиглалтын байдал (бүс, аймгаар)

Эдийн засгийн бүс	Аймаг, нийслэлийн нэр	Үхэр сүрэт эзэлж байгаа хувь	Ашиг шимийн чиглэл тус бүр дэх үхрийн тоо, мян.толгой				
			Уугуул үүлдэрүүд		Нутагшуулсан, нутагшуулж байгаа үүлдэрүүд		
			монгол үхэр	сарлаг	сүүний	махны	сүү-мах, мах-сүү хосолмол
Баруун	Баян-Өлгий	3.3	89.0	66.3	0.1	-	0.5
	Говь-Алтай	1.8	68.6	15.1	0.1	0.2	1.2
	Завхан	4.8	144.7	59.5	0.7	0.1	-
	Увс	4.1	173.4	8.9	-	-	0.6
	Ховд	3.9	156.2	36.2	0.4	0.1	0.8
	Бүсийн дүн	18.0	631.9	186.0	1.3	0.4	3.1
Хангайн	Архангай	14.9	338.6	280.0	1.1	1.0	0.5
	Баянхонгор	5.4	68.2	170.5	0.02	0.2	0.9
	Булган	5.9	251.5	1.0	0.9	0.4	1.5
	Орхон	0.4	16.4	0.1	0.3	0.4	0.3
	Өвөрхангай	6.2	169.6	99.7	1.7	0.5	0.8
	Хөвсгөл	10.8	344.4	136.2	-	0.1	1.8
	Бүсийн дүн	43.7	1188.6	687.5	4.0	2.6	5.8
Төвийн	Говьсүмбэр	0.3	13.9	0	-	-	0.1
	Дархан-Уул	1.0	41.9	0	0.8	0.1	1.5
	Дорноговь	1.9	79.8	0	0.3	0.4	0.1
	Дундговь	1.7	75.5	0	-	-	0.6
	Өмнөговь	0.7	25.5	0.9	0.3	0.1	0.1
	Сэлэнгэ	5.7	187.7	0.1	3.0	18.1	7.9
	Төв	6.6	256.3	1.5	21.6	0.9	2.0
	Бүсийн дүн	17.0	680.6	2.5	26.0	19.6	12.3
Зүүн	Дорнод	5.8	239.0	0.1	0.1	0.4	3.5
	Сүхбаатар	5.7	251.2	0.1	0.2	0.02	0.1
	Хэнтий	8.0	340.3	0.4	11.0	0.9	0.4
	Бүсийн дүн	19.5	830.8	0.6	11.2	1.32	4.0
Улаанбаатар		1.8	72.2	1.0	5.7	-	1.9
Улсын дүн		100.0	3404.1	877.6	48.3	23.9	27.1
Сүрэгт эзэлсэн хувь			77.7	20,0	1,1	0,6	0,6

2.5 ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧ ҮХЭР

Улсын хэмжээний хээлтэгч үнээний тоо

Хээлтэгч үнээний тоо 2021 оны байдлаар 2035.2 мян.тол болж өмнөх оноос 196.3 мян.тол буюу 10.7 хувь өссөн байна. Үржлийн нормоор нэг бухад 35-45 үнээ ногддог/.

Статистик үзүүлэлт	Баг, хороо	2016	2017	2018	2019	2020	2021
Үнээ	Улсын дүн	1587.811	1707.814	1755.287	1900.605	1838.9	2035.247

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (хэмжих нэгж мян.тол)

Хээлтэгч бухын тоо 2021 оны байдлаар 68.3 мян.тол болж өмнөх оноос 6.5 мян.тол буюу 10.5 хувь өссөн байна.

Статистик үзүүлэлт	Баг, хороо	2016	2017	2018	2019	2020	2021
Бух	Улсын дүн	53.2	55.0	53.4	59.8	61.8	68.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (хэмжих нэгж мян.тол)

2.6 ҮХРИЙН МАХНЫ ЭКСПОРТЫН ТОЙМ

Хөдөө аж ахуйн гаралтай гол нэрийн бүтээгдэхүүн, түүхий эдийн экспорт 2020 онд 421.7 сая ам.доллар болж нийт экспортын орлогын 5.6 хувийг эзэлж байна. ХАА-н гаралтай бүтээгдэхүүний нийт экспорт нь өмнөх оноос 199.7 сая ам.доллар буюу 32.1 хувиар буурсан байна.

Экспортын хэмжээ (мянган америк доллароор)¹⁹⁵

2016		2017		2018		2019		2020		2021	
Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн
0.7	1592.3	0.6	1643.3	1.1	3306.2	0	0	0	0	0	0

Үхрийн махны экспортын хэмжээ (сүүлийн 5 жилээр)

он	Хүлээн авагч улс	тоо хэмжээ, тонн	үнийн дүн, мян.\$
2016	ОХУ	560.0	1,376.2
	БНХАУ	135.1	216.1
2017	ОХУ	600.0	1,643.3
	БНХАУ	0.1	0.7
2018	ОХУ	762.6	2,437.6
	Вьетнам	136.0	332.2
	Узбекистан	136.0	326.6
	Казахстан	60.0	161.0
	БНАСАУ	19.5	48.8
2019	0	0	0
2020	0	0	0
2021 эхний 10 сар	0	0	0
2016-2021.10 дүн		2,409.3	6,542.5

Эх сурвалж: Гаалын ерөнхий газрын мэдээлэл

¹⁹⁵ https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L14&type=sectorbook /Гадаад худалдаа, 2022-03/


БҮЛЭГ 3. МОНГОЛ ОРНЫ МАЛЫН ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3.1 МОНГОЛ ОРНЫ ХӨРСНИЙ БҮРХЭВЧ

Манай орон өргөн уудам нутагтай учраас хөрсний олон хэв шинж үүсэн бий болжээ. Нутгийн хойд хэсэгт хар шороон маягийн хөрс тархсан бол төв хэсэг говийн саарал хөрстэй. Төвийн нутгийн зүүн хэсгийн тал хээрийн 50 гаруй хувийг хүрэн хөрс эзэлдэг. Харин хойд хэсгийн хар шороон маягийн хөрстэй нутагт газар тариалан эрхлэхэд тохиромжтой аж. Тариаланд зохимжтой хөрс нийт 1.6 сая гаруй гектар талбайг хамардаг байна. Мөн Монгол орны хойд хэсгийн уулархаг нутгаар ой, тайга, ойт хээр, төвийн болон зүүн хэсгээр хээрийн, өмнө хэсгийн нутгаар говийн, хамгийн урд захаар цөлийн байгалийн бүс оршдог. Өндөр уулын хувьд ойн дээд хилээс дээш бол тайгын бүс, түүнээс дээш мөнх цастай байдаг.

Монгол орны хөрсний зураг

ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Хөрс судлалын салбарын судлаачдын хамтын бүтээл Монгол орны хөрсний зураг 1:800 000 масштаб, хөрсний зургийн тойм болон хөрсний хэв шинжүүдийг оруулав. Монгол орны хөрсний шинэчилсэн ангиллын дагуу хөрсний 12 бүлэг 33 хэв шинжид хамрагдах 108 төрлийн хөрсийг зураг дээр ялгасан. Тариалангийн хөрс (Antrosols), техногенийн эвдрэлд орсон хот суурингийн (Urbic Technosols) болон уул уурхайн хөрс (Leptic Technosols) үүдийг шинээр нэмж оруулсан.¹⁹⁶




Монгол орны голлох хөрсний хэв шинжүүдийн талбайг тооцож үзэхэд хамгийн их талбайтай хөрс нь дундаж, нам уулсаар тархсан Чулуурхаг хар хүрэн хөрс, 16 008 мян.га буюу 10,24% говийн бор хөрс, 14 892 мян.га буюу 9,53%, хар хүрэн хөрс 13663 мян.га буюу 8,74%-ийг тус тус эзэлж байна.¹⁹⁷

¹⁹⁶ Газарзүй, Геоэкологийн хүрээлэн <https://igg.ac.mn/c/1003754?content=1401049>
http://www.touristinfocenter.mn/news_more.aspx?NewsID=1153


¹⁹⁷ Монгол орны бэлчээр, хөрс, ашиглалт ба хамгаалалт 2017

Монгол орны хээр, говь, цөл, нуга намаг, голын татам, давсархаг хөрсний талбай



Эх сурвалж: Монгол орны бэлчээр, хөрс, ашиглалт ба хамгаалалт 2017

Уулархаг газар ба ойн хөрсний хэв шинжүүдийн талбай



Эх сурвалж: Монгол орны бэлчээр, хөрс, ашиглалт ба хамгаалалт 2017


3.2 МОНГОЛ ОРНЫ УРГАМЛЫН БҮРХЭВЧ

Өдгөө Монгол орны ургамлын аймгийн олон янз байдалд 19 хүрээнд хамаарах 39 ангийн 116 багийн 392 овогт хамаарах 1522 төрөлд багтах 7315 зүйл, дэд зүйл бүртгэгджээ. Үүнд 56 овгийн 156 төрлийн 574 зүйл, дэд зүйл дээд мөөг; 87 овгийн 268 төрлийн 2003 зүйл, дэд зүйл замаг; 63 овгийн 207 төрлийн 1031 зүйл, дэд зүйл хаг; 74 овгийн 208 төрлийн 580 зүйл, дэд зүйл хөвд; 112 овгийн 683 төрлийн 3127 зүйл, дэд зүйл гуурст ургамал тус тус багтана. Монгол орны гуурст ургамлын аймагт унаган ургамал 153 зүйл (4.89%), завсрын унаган 458 зүйл (14.64%), нэн ховор 133 зүйл (4.25%), ховор 356 зүйл (11.38%), харь ургамал 35 зүйл

(1.11%), хөл газрын ургамал 438 зүйл (14.0%), усны ургамал 143 зүйл (4.57%), үлдэц (үлдвэр) ургамал 70 зүйл (0.99%), зэрлэгшиж буй таримал 47 зүйл (1.50%), Улаан номонд (2013) орсон 135 зүйл (4.31%), Улаан дансанд (2011) орсон 148 зүйл (4.73%), CITES-ийн хавсралтад орсон 8 зүйл (0.25%) тус тус ургана.¹⁹⁸

3.3 БЭЛЧЭЭРИЙН ХҮРЭЛЦЭЭ, ТЭЖЭЭЛИЙН ХАНГАМЖ

Манай улс өндөр уул, хангай, хээр, говь бүс хосолсон 110.3 сая га бэлчээр, 1.7 сая га хадлангийн талбай нийт 112.0 сая га бэлчээр, хадлангийн талбайтай. Энэ нь хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 97 хувийг эзэлдэг бөгөөд 52.0 сая га-г өвөл, хаврын улиралд 60.0 сая га-г зун намрын улиралд тус тус ашиглаж байна.¹⁹⁹




Өнгөрсөн оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 169.7 мянган малчин өрх 67.3 сая толгой малаар байгалийн нөөц бэлчээрийг ашиглан мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Бэлчээрийн газрын ангиллаас хот суурин газрын дэд бүтэц, уул уурхайн ашигт малтмал, газар тариалан зэрэг өөр ангилалд шилжих, үерийн усны эвдрэлд орох, элсний нүүдэл зэргээс шалтгаалан бэлчээрийн талбайн хэмжээ багассаар байна.

Өнөөдрийн байгаа бэлчээрийн талбайн хэмжээг 1964 оныхтой харьцуулан үзэхэд бэлчээрийн талбай 10.1 сая га-гаар багасаад байна.

¹⁹⁸ Өнөөгийн монгол орны ургамлын аймгийн зүйлийн бүрдэл, олон янз байдал 2016

199 ХХААХҮЯ <https://mofa.gov.mn/exp/blog/7/6>

**100 га Хадлан, бэлчээрийн талбайд ногдох
хонин толгойд шилжүүлсэн малын тоо (мянган толгой)**




Бэлчээрийн хангамж

	2016	2017	2018	2019	2020
Хадлан, бэлчээрийн талбай, сая.га	112.2	112.1	112.1	112.0	111.4
Хонин толгойд шилжүүлсэн малын тоо, сая.тол	102.8	110.8	111.1	119.0	114.4
100 га бэлчээр хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо, мянг.тол	92	99	99	106	103

Сүүлийн 5 жилд хадлан бэлчээрийн талбай 2016-2020 онд 0.1-0.7 сая га-гаар багасаж, хонин толгойд шилжүүлсэн нийт малын тоо 2016 оноос 11.6 сая толгойгоор өссөн бол өмнөх оноос 4.6 сая толгойгоор буурсан байна.

**100 га бэлчээрийн талбайд ногдох
хонин толгойд шилжүүлсэн малын тоо**



Сүүлийн 17 жилд буюу 2003-2020 онд хадлан, бэлчээрийн талбай 113.1-111.4 сая.га болж 1.7 сая га-гаар багасаж, хонин толгойд шилжүүлсэн нийт малын тоо 46.2-114.0 сая толгой болж 67.8 саяар буюу 2.5 дахин өссөн.


100 га бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо Увс, Өвөрхангай, Говьсүмбэр, Хэнтий, Төв, Хөвсгөл, Сэлэнгэ, Булган, Архангай, Дархан-Уул, Орхон аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 127.4-762.3-аар өндөр байна.

Харин Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай, Дорнод, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар, Ховд, Баян-Өлгийн аймагт улсын дунджаас доогуур байна. Дээрх байдлаас үзэхэд төвлөрсөн хот, суурин газар, мал ихтэй бүс нутаг, аймагт бэлчээрийн даац хэтэрсэн байна.

	2016	2017	2018	2019	2020
Бэлтгэсэн хадлан	1 275.4	1 008.1	1 229.4	1 369.2	1 186.2
Ашигласан сүрэл	9.1	8.5	10.6	9.4	5.2
Гар тэжээл	45.8	52.3	51.7	58.4	42.2
Бэлтгэсэн дарш	3.4	1.5	5.0	23.0	8.0
Бэлтгэсэн эрдэс тэжээл	62.8	77.9	94.5	121.3	90.5
Үйлдвэрлэсэн тэжээл-бүгд, (тэж.нэгж)	710.3	611.5	757.4	849.7	744.4

БЭЛТГЭСЭН ХАДЛАН (мянган тонн)

Бэлтгэсэн хадланг аймгаар авч үзвэл, Улаанбаатар хот болон Говьсүмбэр, Өмнөговь, Төв, Сэлэнгэ, Дундговь, Говь-Алтай, Дорноговь, Булган, Баянхонгор аймгуудад өмнөх оноос 0.2-9.8 мянган тонноор өссөн байна. Бусад аймгуудад 0.5-104.7 мянган тонноор буурчээ.



Малчид, аж ахуйн нэгжүүдийн 2020 онд үйлдвэрийн аргаар боловсруулснаас бусад гар аргаар бэлтгэсэн тэжээлийн хэмжээ, тэжээлийн нэгжид шилжүүлснээр 744.4 мянган тонн болж өмнөх оноос 105.3 мянган тонноор буурсан.

Бэлтгэсэн тэжээл (бүс, нийслэлээр)

Бүс, аймаг, нийслэл	2016	2017	2018	2019	2020
	Мян.тонн				
БҮГД	710.3	611.5	757.4	849.7	744.4
Баруун бүс	121.0	122.4	134.7	153.9	137.7
Хангайн бүс	241.7	178.4	249.4	297.0	225.5
Төвийн бүс	220.2	183.2	229.2	229.7	237.8
Зүүн бүс	115.1	109.8	124.4	148.5	122.8
Улаанбаатар	12.3	17.5	19.8	20.6	20.6

Тэжээл бэлтгэлийн хэмжээг /тэжээлийн нэгжээр/ аймгаар нь авч үзвэл, Улаанбаатар хот болон Говь-Алтай, Баянхонгор, Дорноговь, Булган, Төв аймгуудад өмнөх оноос 0.04-16.5 мянган тонноор өссөн байна. Бусад аймгуудад 0.1-53.4 мянган тонноор буурчээ.


Үйлдвэрлэсэн тэжээлийн хангамж

	2016	2017	2018	2019	2020
Хонин толгойд шилжүүлсэн мал, мян.тол	102 814.8	110 801.8	111 131.5	118 987.5	114 411
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэжээлийн нэгж, кг	6.9	5.5	6.8	7.1	6.5

2019 онд хонин толгойд шилжүүлсэн нэг малд 7.1 кг тэжээл ногдож байсан бол 2020 онд 6.5 кг болж өмнөх оноос 0.6 кг-аар буурсан байна.

3.4 МАЛЫН ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХАНГАМЖ

Монгол Улсад нийт 57 гурил болон тэжээлийн үйлдвэр, цехүүд байгаагаас цагт 2 тн-оос дээш тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тэжээлийн үйлдвэр 14 (гурилын үйлдвэр ороод), үлдсэн нь жижиг оврын тэжээлийн цех байна.²⁰⁰



Нийт тэжээл үйлдвэрлэгчдийн тоо (аймгаар)

	Аймаг	Тэжээлийн үйлдвэр, хоршоод		
		Нийт	Ажиллаж байгаа	Үйл ажиллагаа нь зогссон
1	Архангай	1	1	0
2	Баян-Өлгий	1	1	0
3	Булган	7	7	0
4	Говь-Алтай	1	0	1
5	Дархан	4	4	0
6	Дорнод	2	2	0
7	Дундговь	1	1	0
8	Орхон	7	2	5
9	Өвөрхангай	14	9	5
10	Сэлэнгэ	3	3	0
11	Төв	4	4	0
12	Увс	5	5	0
13	Хөвсгөл	7	6	1
14	Хэнтий	3	1	2
15	Улаанбаатар	11	11	0
Нийт		71	57	14

²⁰⁰ XXAAXYЯ <https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tejeel.pdf>

Малын тэжээлийн төрөл

Бүс нутгаар	Тэжээлийн төрлүүд
Хангайн бүс	Хивэг, няцалсан будаа, багсармал, овьёос буудай
Зүүн бүс (Дорнод)	Хорголжин
Төвийн бүс	Хивэг, багсармал, уураг тэжээл, холимог тэжээл
Баруун бүс (Баян-Өлгий)	Хорголжин, адууны тэжээл
Улаанбаатар	Тахиа, гахайн тэжээл, бүрэн найрлагат тэжээл, 5 төрлийн малын тэжээл, багсармал тэжээл

1996 оноос эхлэн аж ахуйн нэгж, хоршоод малын тэжээлээр дагнасан тэжээлийн үйлдвэрлэлийг эрхэлж эхэлсэн ба 2011 оноос эхлэн тэжээлийн үйлдвэрлэл эрчимтэйгээр нэмэгдэж аж ахуйн нэгжийн тоо 1996 оныхтой харьцуулбал 5 дахин нэмэгдсэн байна.

Ашиглалтад орсон тэжээлийн үйлдвэрүүдийн тоо (оноор)



Үйл ажиллагаа явуулж буй тэжээлийн үйлдвэр, хоршоодоос улирлын чанартай 8, байнгын үйл ажиллагаа явуулдаг 30 байна.

Үйл ажиллагаа явуулж буй нийт тэжээлийн үйлдвэрүүдийг бүс нутгаар нь авч үзвэл Хангайн бүсэд 43.2%, Төвийн бүсэд 35,1% нь голлон байрлаж байна. Харин Зүүн бүсэд одоогоор үйл ажиллагаа явуулж буй тэжээлийн үйлдвэр байхгүй байна.

Ажиллаж буй тэжээлийн үйлдвэрийн тоо (бүсээр)




Монгол Улсын хэмжээнд 14 аймаг, Улаанбаатар хотод малын тэжээлээр дагнасан тэжээлийн үйлдвэрийн суурилагдсан нийлбэр хүчин чадал нь жилд 176.1 мянган тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай байна. Үүнээс ашиглаж буй хүчин чадал нь жилдээ 55762.5 тонн байгаа ба нийт суурилагдсан хүчин чадлынхаа 31.6%-д нь тэжээл үйлдвэрлэж байна.

Үйлдвэр, хоршоодын тэжээл үйлдвэрлэх хүчин чадлын хэмжээ



Үйл ажиллагаа явуулж буй тэжээлийн үйлдвэр, хоршоод жилдээ нийт 55762.5 тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтайгаар ажиллаж байна. Үүнийг аж ахуйн нэгжтэй нь харьцуулан үзвэл 54.05% нь 100-1000 хүртэлх тонн тэжээл, 40.5% нь 1000-аас дээш тонн тэжээлийг жилд үйлдвэрлэх хүчин чадалтай байна.

Жилд үйлдвэрлэх тэжээлийн тоо хэмжээ (аж ахуйн нэгжийн тоогоор)



Үйл ажиллагаа явуулж буй 37 үйлдвэр, хоршоодоос цагт 2 тн-оос дээш тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тэжээлийн үйлдвэр 7 байна. Үүний 4 нь Улаанбаатарт, Сэлэнгэд 2, Завханд 1 байна.

Үйлдвэр хоршоодын хүчин чадал (бүсээр)


Бүсээр	Ашиглаж буй хүчин чадал			Суурилагдсан хүчин чадал			Хувиар
	Цагт	Хоногт	Жилд	Цагт	Хоногт	Жилд	
Баруун бүс	4 тн	20 тн	5000 тн	8 тн	40 тн	10000 тн	50%
Хангайн бүс	5.41 тн	27.05 тн	6762.5 тн	7.1 тн	35.5 тн	8875 тн	75.3%
Төвийн бүс	9 тн	45 тн	11250 тн	22.98 тн	114.9 тн	28725 тн	39.1%
Улаанбаатар	26.2 тн	131 тн	32750 тн	70.55 тн	352.75 тн	88187.5 тн	37.1%
Үйл ажиллагаа нь зогссон				32.25 тн	161.25 тн	40312.5 тн	
Нийт	44.6 тн	223 тн	55762.5 тн	140.88 тн	704.4 тн	176100 тн	31.6%

Үйлдвэр, хоршоодын хүчин чадал (аймгаар)

Аймгаар	Ашиглаж буй хүчин чадал			Суурилагдсан хүчин чадал			Хувиар
	Цагт	Хоногт	Жилд	Цагт	Хоногт	Жилд	
Архангай	0.5 тн	2.5 тн	625 тн	1 тн	5 тн	1250 тн	50%
Баян-Өлгий	1 тн	5 тн	1250 тн	1 тн	5 тн	1250 тн	100%
Булган	0.25 тн	2.25 тн	562.5 тн	0.25 тн	2.25 тн	562.5 тн	100%
Дундговь	0.06 тн	0.3тн	75 тн	0.08 тн	0.4 тн	100 тн	75%
Хөвсгөл	2.06 тн	10.3 тн	2575 тн	3.25 тн	16.25 тн	4062.5 тн	63.3%
Орхон	1.4 тн	7 тн	1750 тн	1.4 тн	7 тн	1750 тн	100%
Сэлэнгэ	6.9 тн	34.5 тн	8625 тн	16.8 тн	84 тн	21000 тн	41.07%
Төв	2.03 тн	10.15 тн	2537.5 тн	6.1 тн	30.5 тн	7625 тн	33.2%
Өвөрхангай	1.2 тн	6 тн	1500 тн	1.2 тн	6 тн	1500 тн	100%
Завхан	3 тн	15 тн	3750 тн	7 тн	35 тн	8750 тн	42.8%
Улаанбаатар	26.2 тн	131 тн	32750 тн	70.55 тн	352.75 тн	88187.5 тн	37.1%
Үйл ажиллагаа нь зогссон				32.25 тн	161.25 тн	40312.5 тн	
Нийт	44.6 тн	223 тн	55762.5 тн	140.88 тн	704.4 тн	176100 тн	31.6%


Бүс нутгаар нь авч үзвэл нийт тэжээл үйлдвэрлэлийн 58.7%-ийг Улаанбаатарт, 15.4% нь Сэлэнгэ аймагт байрлах тэжээлийн үйлдвэрүүд үйлдвэрлэж байна.

Үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, хоршоодын ашиглаж буй хүчин чадлын хувь (бүсээр)




Тэжээлийн үйлдвэрүүд түүхий эдийнхээ 80 орчим хувийг дотоодоос, 20 хувийг импортоор хангаж байна. Үүнээс аж ахуйн нэгжийн 70 орчим хувь нь өөрсдөө түүхий эдээ тариалдаг бол үлдсэн 30% нь дотоодоос, зарим нь импортоор түүхий эдээ худалдаж авдаг байна.

Тэжээлийн үйлдвэрүүдийн түүхий эдийн тариалалт (хувиар)



Газар зүйн бүсийн хувьд авч үзвэл Хангай болон Төвийн бүсийнхэн өөрсдөө түүхий эдээ тариалдаг бол Улаанбаатар хотод байрлах тэжээлийн үйлдвэрүүд түүхий эдийнхээ 95%-ийг дотоодоос болон импортоор худалдаж авдаг байна.

Тэжээлийн үйлдвэр, хоршоодын түүхий эдийн тариалалтын тоо, бүсээр



Нийт аж ахуйн нэгжийн 72,9% нь тэжээлээ хадгалах өөрсдийн агуулахтай ба үлдсэн 27.1% нь одоогоор тэжээлээ хадгалах агуулахгүй байна. Үүнээс зарим нь агуулах түрээслэх, мөн тэжээлээ газар дээр нь шууд борлуулдаг байна.

Үйл ажиллагаа явуулж буй тэжээлийн үйлдвэр, хоршоодын 75.6% нь 10 хүртэлх ажилчинтай жижиг тэжээлийн үйлдвэр, цехүүд байна.


Үйлдвэр, хоршоодын ажилчдын тоо



3.5 ГУРИЛ, ТЭЖЭЭЛИЙН ҮЙЛДВЭРҮҮДИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гаргасан мэдээгээр 2019 оны байдлаар 27 гурилын үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Нийт ажиллаж буй гурилын үйлдвэрийн 32%-ийн хүчин чадлаар ажиллаж байгаа ба нийт тэжээлийн үйлдвэрийн 26.6%-ийн хүчин чадлаар тус тус ажиллаж байна.

Дээрх үзүүлэлтээс харахад тэжээлийн үйлдвэрүүдийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах шаардлага байгаа юм. Үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээс авсан судалгаагаар хүчин чадлаа нэмэгдүүлэхийн тулд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл, түүхий эдийн дутагдалтай байдал, мэргэжлийн технологич бэлтгэх зэрэг асуудлыг цогц байдлаар шийдэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.




Үйлдвэрүүдийн нийлбэр хүчин чадал


Үйлдвэрлэгчийн төрөл	Бүтээгдэхүүн	Үйлдвэрлэлийн нийлбэр хүчин чадал, тонн/жил	Ашиглаж буй хүчин чадал, хувиар
Гурилын үйлдвэр	Хивэг	195,365 тонн	32,0%
Тэжээлийн үйлдвэр, цехүүд	Багсармал, хивэг, хорголжин, холимог тэжээл, уурагт тэжээл	193,600 тонн	26,6%

Нийт гурил болон тэжээлийн үйлдвэр, цехүүдийг бүсчлэн авч үзвэл Хангайн бүсэд 25, Төвийн бүсэд 12, Баруун бүсэд 6, Зүүн бүсэд 3, Улаанбаатар хотод 11 байна.

Төвийн болон Зүүн бүсэд байрлах гурил болон тэжээлийн үйлдвэрүүдийн тоо (аймгаар)




Баруун, Хангайн бүсэд байрлах гурил болон тэжээлийн үйлдвэрүүдийн тоо (аймгаар)




3.6 ТЭЖЭЭЛЭЭР ДАГНАСАН ҮЙЛДВЭР

Монгол Улсын хувьд малын тэжээлээр дагнасан тэжээл үйлдвэрлэдэг нийт 30 аж ахуйн нэгж, цехүүд байна. Үүнээс томоохон 6 аж ахуйн нэгж байгаагаас Улаанбаатар хотод 4, Сэлэнгэ аймагт 1, Дорнод аймагт 1 байна. Нийт тэжээлийн үйлдвэр, цехүүдээс улирлын чанартай 8, байнгын үйл ажиллагаа явуулдаг 22 байна. Нийт тэжээлийн үйлдвэрүүдээ бүс нутгаар нь аваад үзвэл Хангайн бүс буюу Орхон, Булган, Өвөрхангай зэрэг аймгуудад нийт тэжээлийн үйлдвэрийн 53.3% буюу нийт 16 тэжээлийн үйлдвэр, цехүүд байна.




1995 оноос эхлэн аж ахуйн нэгж, цехүүд малын тэжээлээр дагнасан тэжээлийн үйлдвэрлэлийг эрхэлж эхэлсэн ба 2011 оноос эхлэн тэжээлийн үйлдвэрлэл эрчимтэйгээр нэмэгдэж аж ахуйн нэгжийн тоо 1995 оныхтой харьцуулбал 7 дахин нэмэгдсэн байна.

Ашиглалтад орсон тэжээлийн үйлдвэрүүдийн тоо (оноор)




Монгол Улсын хэмжээнд нийт 30 тэжээлийн үйлдвэр байгаа ба нийлбэр хүчин чадал нь жилд 193.6 мянган тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай байна. Нийт хүчин чадлынхаа 26,6%-д тэжээл үйлдвэрлэж байна. Бүс нутгуудаар нь авч үзвэл нийт тэжээл үйлдвэрлэлийн 88,6%-ийг Улаанбаатар хотод байрлах тэжээлийн үйлдвэрүүд үйлдвэрлэдэг байна.

2018 онд үйлдвэрлэсэн нийт тэжээл (хувиар,бүсээр)




Нийт тэжээл үйлдвэрлэлийн төрлүүдийг аваад үзвэл манай оронд хамгийн их буюу 56.4% нь багсармал тэжээл үйлдвэрлэдэг байна. Тэжээлийн үйлдвэрүүд түүхий эдийнхээ 80 орчим хувийг дотоодоос, 20 хувийг импортоор хангаж байна. Үүнээс аж ахуйн нэгжийн 76.6 орчим хувь нь өөрсдөө түүхий эдээ тариалдаг бол үлдсэн 23.4 хувь нь дотоодоос, зарим нь импортоор түүхий эдээ худалдаж авдаг байна. Импортоор авдаг гол түүхий эд нь эрдэнэ шиш, шар буурцаг, рапс ба шар буурцгийн шахдас, премикс, амин хүчлүүд байна.

Тэжээлийн үйлдвэрүүдийн түүхий эдийн тариалалт (хувиар)




Газар зүйн бүсийн хувьд аваад үзвэл Хангай болон Төвийн бүсийнхэн өөрсдөө түүхий эдээ үйлдвэрлэдэг бол Улаанбаатар хотод байрлах тэжээлийн үйлдвэрүүд түүхий эдээ худалдаж авдаг байна.

Тэжээлийн үйлдвэрүүдийн түүхий эдийн тариалалтын тоо (бүсээр)



Нийт аж ахуйн нэгжийн 83.3% нь тэжээлээ хадгалах өөрсдийн агуулахтай ба үлдсэн 16,7% нь одоогоор өөрсдийн тэжээлээ хадгалах агуулахгүй байна. Тэжээлийн үйлдвэр эрхэлж буй аж ахуйн нэгж, цехүүдийн хувьд 73.3% нь 10 хүртэлх ажилчинтай жижиг тэжээлийн, үйлдвэр, цехүүд байна.

Үйлдвэр, цехүүдийн ажилчдын тоо



Манай улсад малын тэжээлээр дагнасан тэжээл үйлдвэрлэдэг нийт 30 аж ахуйн нэгж, цехүүд байгаа ба жилд 193.6 мянган тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай байна. Нийт хүчин чадлынхаа 26,6%-ийг ашиглаж байна.

Бүс нутгуудаар нь авч үзвэл нийт тэжээл үйлдвэрлэлийн 88.6% нь Улаанбаатар хотод байна.



Тэжээл үйлдвэрлэхэд тулгамдаж буй асуудлыг судлан үзэхэд нийт судалгаанд хамрагдсан тэжээлийн үйлдвэр, цехүүдийн 61.9% нь хөрөнгө, санхүүгийн хувьд дутмаг үүнээс үүдээд тоног төхөөрөмжөө шинэчлэх боломжгүй гэсэн байна. Нэн тэргүүнд шаардлагатай зүйлс бол хөрөнгө оруулалт бөгөөд хөнгөлөлттэй зээлд хамрагдаж тоног төхөөрөмжөө шинэчлэх хүсэлтэй байна.

Дарш бэлтгэх тухай

Дарш бэлтгэх үйл ажиллагаа нь тэжээлийн ургамлын гадаргуу, сав төхөөрөмж, бусад орчинд агуулагдах бичил биетнүүдийн өсөлт хөгжилтийг саатуулах зорилгоор нягтруулж, сүүн хүчлийн исэлдэлгээ явагдах нөхцөлийг бүрдүүлэн бусад бактерийн үйл ажиллагааг хязгаарлан, физиологийн хуурай орчныг бий болгон биохимийн процессыг идэвхжүүлж тэжээлийг бүрэн хамгаалан шимт бодисын физик, химийн шинж чанарыг алдагдал багатай удаан хадгалах биологийн арга юм.

Тэжээлийн ургамлын даршлагад чадварыг илтгэх гол үзүүлэлт нь ургамлын чийг болон хялбар шингэх нүүрс усны хэмжээ юм. Нүүрс ус ($C_m(H_2O)_n$) нь амьд организмын гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд амьд бие махбодын хэрэгцээт органик бодисыг биеийн дотоодод синтезлэх, задлах зэрэг урвалуудыг явуулахын зэрэгцээ хурдасгуур болдог. Нүүрс усыг сахар үүсгэх бүтцийн нэгжээр нь ангилах бөгөөд үүнээс олиго буюу дисахаридууд нь даршны исэлдэх үйл ажиллагааг нөхцөлдүүлж сүүн хүчлийн исэлдэлт явагдах орчинг бий болгож өгдөг.

Тэжээлийн түүхий эдийн найрлага дахь хялбар шингэх нүүрс усны эх булаг чихрийн хамгийн бага хэмжээ өвслөг ургамалд 1-1.5 хувь, буурцагт ургамалд 6-8 хувь байхад тухайн исэлдэх процесс зөв явагдах үндэс болно. Судалгаанаас үзэхэд түүхий эдэд агуулагдаж байгаа хялбар уусах нүүрс усны 1 хувь тутам ойролцоогоор 0.3 хувийн сүүний хүчил бий болгодгийг тодорхойлсон байдаг.

Тэжээлийн түүхий эдийг сахарын агууламжаар нь сайн, муу, огт даршлагддаггүй ургамал гэж 3 хуваана. Тиймээс муу даршлагддаг бэлчээрийн ногоо, таримал нэг болон олон наст ургамлууд, огт даршлагддаггүй халгай, лууль, царгас, чихэр өвс, таана, хөмүүл зэрэг ургамлыг даршлах технологийг боловсруулан тэжээлийн нэр төрлийг нэмэгдүүлэх, тэжээлийн баазыг бэхжүүлэх, сайн даршлагддаг болон хялбар шингэх нүүрс усны эх үүсвэрээр баяжуулан хольц байдлаар бэлтгэх явдал чухал юм.

Тэжээлийн ургамалд сахар болон азотлог нэгдлийн хэмжээ харилцан адилгүй учраас даршлагдах чадварыг сахар, протеины харьцаагаар тодорхойлох нь зүйтэй. Энэ харьцаа сайн даршлагддаг ургамалд 0.7-1.0:1, дунд зэргийн даршлагддаг ургамалд 0.5-0.7:1-ээс бага байх нь тохиромжтой юм.

Дарш бэлтгэлийн талбай (аймаг бүсээр (2017-2021))

Даршны ургамал	2017	2018	2019	2020	2021
Аймаг, нийслэл	га				
БҮГД	414.6	1 405.2	1 847.0	1 466.5	1 236.8
Баруун бүс	0.3	3.2	13.0	87.9	3.3
Баян-Өлгий	-	0.2	-	-	-
Говь-Алтай	-	-	-	3.9	3.3
Завхан	-	-	10.0	-	-
Увс	-	-	-	2.0	-
Ховд	0.3	3.0	3.0	82.0	-
Хангайн бүс	6.0	-	15.5	39.0	20.1
Архангай	-	-	-	-	0.1
Баянхонгор	-	-	0.5	-	-
Булган	6.0	-	15.0	32.0	20.0
Орхон	-	-	-	7.0	-
Өвөрхангай	-	-	-	-	-
Хөвсгөл	-	-	-	-	-
Төвийн бүс	293.2	1 332.0	1 818.5	1 289.6	1 163.4
Говьсүмбэр	-	-	-	-	-
Дархан-Уул	-	-	-	-	-
Дорноговь	-	3.0	2.0	0.2	1.0
Дундговь	-	0.0	-	0.0	-
Өмнөговь	8.2	4.7	44.1	18.4	0.5
Сэлэнгэ	255.0	1 229.3	1 732.4	1 211.0	1 159.8
Төв	30.0	95.0	40.0	60.0	2.0
Зүүн бүс	115.0	30.0	0.0	50.0	0.0
Дорнод	5.0	-	-	-	-
Сүхбаатар	40.0	-	-	-	-
Хэнтий	70.0	30.0	0.0	50.0	-
Улаанбаатар	0.1	40.0	0.0	0.0	50.0

Тэжээлийн үйлдвэрүүдэд тулгамдаж буй асуудлууд

№	Тулгамдаж буй асуудлууд	Хувь
1	Тоног төхөөрөмж шинэчлэх, техникийн хүчин чадлаа нэмэгдүүлэх	26.6%
2	Хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт шаардлагатай	35.3%
3	Борлуулалт тааруу	11.1%
4	Түүхий эд дутмаг	13.3%
5	Бусад	13.7%

Бусад асуудлыг авч үзвэл зах зээлийн хувьд тогтворгүй, түүхий эдээ тариалах газаргүй, импортын хямд тэжээлүүд ихээр орж ордог зэрэг асуудлууд тулгардаг байна.

Манай улсад 65-70 мянган тонн үйлдвэрийн тэжээл дутагдалтай байдаг бөгөөд үүнийг хангахын тулд түүхий эдийн бэлтгэл, татан авалт зэрэгтэй уялдуулан 6 тэжээлийн үйлдвэр, цех шинээр барьж байгуулахаар төлөвлөж байна.

Тэжээлийн үйлдвэр байгуулах бүс нутаг




МАЛЫН ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭХ БҮС НУТАГ
(БАРУУН БҮС) /Завхан/



МАЛЫН ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭХ БҮС НУТАГ
(ТӨВИЙН БҮС) /Хөвсгөл/



МАЛЫН ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭХ БҮС НУТАГ
(ЗҮҮН БҮС) /Хэнтий/



ТАРИАЛАНГИЙН БҮС НУТАГ

Дээрх бүс нутгуудад улаанбуудай, хөх тариа, хошуу буудай, арвай, эрдэнэшиш, шар буурцаг зэргийг түлхүү тариалж тэжээлийн үйлдвэр, тэжээлийн ургамал тариалалтыг хослуулан хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ингэснээр:

1. Бүрэн найрлагат тэжээл үйлдвэрлэл 60 гаруй мянган тонноор нэмэгдэнэ.
2. Тогтворжсон жорын тэжээл үйлдвэрлэл, тэжээлийн хангамж тогтвортой болно.
3. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, экспортлох нөхцөл бүрдэж, аж ахуй эрхлэгчдийн чадавх сайжирна.
4. Хот суурин газрын хүн амыг эрүүл, чанартай хүнсээр хүртээмжтэй хангах боломж бүрдэнэ. (Мах, сүүний хангамжийн улирлын хамаарал, үнийн хөөрөгдлөөс урьдчилан сэргийлнэ)

ПАРЛАМЕНТ
СУДАЛГААНЫ САН

Тэжээл бэлтгэл /мян.тн/


Тэжээлийн нэр төрөл	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Байгалийн хадлан	1030.7	912.3	1137.3	1195.2	1175.1	1169.3	1178.7	1028.7	1275.4	1008.1	1229.4	1369.2	1186.2
Сүрэл	11.1	8.5	8.3	7.9	4.6	3.1	7.9	8.5	35.7	15.2	16.0	10.0	9.8
Гар тэжээл	34.4	25.8	32.7	46.7	39.1	36.6	40.3	39.9	45.8	52.3	51.7	58.4	42.2
Дарш	0.9	0.5	4.0	8.5	2.1	3.9	4.0	1.6	7.9	9.3	10.0	16.1	32.8
Эрдэс тэжээл	53.8	44.4	48.0	40.4	36.6	31.8	29.7	61.3	105.6	105.8	154.7	105.8	69.9
Үйлдвэрийн тэжээл											42.4	49.2	22.3
Ногоон тэжээл											113.4	121.1	95.7

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам

Тэжээлийн үйлдвэрүүд түүхий эдийнхээ 80 орчим хувийг дотоодоос, 20 хувийг импортоор хангаж байна. Үүнээс аж ахуйн нэгжийн 76.6 орчим хувь нь өөрсдөө түүхий эдээ тариалдаг бол үлдсэн 23.4-н хувь нь дотоодоос, зарим нь импортоор түүхий эдээ худалдаж авдаг байна. Импортоор авдаг гол түүхий эд нь эрдэнэ шиш, шар буурцгийн, рапс ба шар буурцгийн шахдас, премикс, амин хүчлүүд байна.

Нийт тэжээлийн үйлдвэртэй аж ахуйн нэгжийн 83.3% нь тэжээлээ хадгалах өөрсдийн агуулахтай ба үлдсэн 16,7% нь одоогоор өөрсдийн тэжээлээ хадгалах агуулахгүй байна. Тэжээлийн үйлдвэр эрхэлж буй аж ахуйн нэгж, цехүүдийн хувьд 73.3% нь 10 хүртэлх ажилчинтай жижиг тэжээлийн, үйлдвэр, цехүүд байна.

3.7 БЭЛТГЭСЭН ӨВС ХАДЛАН (БҮСЭЭР)



ХӨНӨГӨӨ АЖ АХУЙН ЯАМ

Бэлтгэсэн өвс хадлан (аймгаар)

Аймаг	Аймгийн код	2017	2018	2019	2020	2021
Баян-Өлгий	183	57.1	66.4	81.5	71.2	78.6
Говь-Алтай	182	7.6	7.5	8.7	11.9	8.5
Завхан	181	18.2	15.7	18.2	14.3	20.9
Увс	185	51.1	50.4	64.0	53.7	64.6
Ховд	184	65.2	75.7	62.1	52.2	122.3
Архангай	265	64.4	74.5	81.0	59.6	86.1
Баянхонгор	264	15.8	14.6	7.5	17.2	8.8
Булган	263	58.3	88.3	90.2	96.5	113.7
Орхон	261	7.2	8.2	9.2	8.7	10.8
Өвөрхангай	262	32.6	38.3	52.8	41.6	39.0
Хөвсгөл	267	190.3	209.9	270.2	165.5	231.8
Говьсүмбэр	342	3.0	4.4	2.1	2.3	2.2
Дархан-Уул	345	47.4	49.1	32.8	27.2	56.2
Дорноговь	344	5.4	5.8	7.8	12.3	16.2
Дундговь	348	1.1	1.8	7.3	9.4	4.8
Өмнөговь	346	5.6	7.6	7.2	6.3	7.7
Сэлэнгэ	343	191.5	159.9	199.3	201.3	270.4
Төв	341	71.7	94.4	85.7	87.0	162.1
Дорнод	421	62.6	74.5	105.8	96.9	127.3
Сүхбаатар	422	27.9	15.0	18.5	15.2	22.0
Хэнтий	423	118.2	138.1	128.2	102.8	220.2
Улаанбаатар	5	28.1	29.5	29.9	31.1	45.6

Хэвлэлийн үйлчилгээний газар

3.8 ТЭЖЭЭЛ ИМПОРТ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 83 аж ахуйн нэгжтэй 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд 133.0 мянган тонн малын тэжээл импортлох “Бодлогын гэрээ” байгуулаад байна. Тухайлбал, хивэг 23.7 мянган тонн, хорголжин 23.5 мянган тонн, овьёос 15.6 мянган тонн, эрдэнэ шиш 5.5 мянган тонн, арвай 2.0 мянган тонн, шар буурцгийн шахдас 5.5 мянган тонн, тэжээлийн улаанбуудай 36.6 мянган тонн, премемикс 0.8 мянган тонн, бусад төрлийн тэжээл 19.9 мянган тонн импортлохоор төлөвлөсөн.

2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 63 аж ахуйн нэгж нийт 43.7 мянган тонн бүх төрлийн тэжээл импортлоод байна. Энэ нь төлөвлөсөн тэжээлийн 32.9 хувийг эзлэж байна.

д/д	Тэжээлийн төрөл	Импортлосон хэмжээ /тн/
1	Хивэг	13366.2
2	Хорголжин	9495.8
3	Овьёос	3560.9
4	Эрдэнэ шиш	5040.0
5	Шар буурцгийн шахдас	1340.9
6	Улаанбуудай, тэжээлийн	5688.5
7	Арвай	2615.8
8	Премикс, бусад	2603.7
	НИЙТ	43711.8

Яамтай “Бодлогын гэрээ” байгуулсан аж ахуйн нэгжүүд дунджаар нэг тонн хивгийг 640 000 төгрөг буюу 25 кг шуудайтайг 16 000 төгрөгөөр, нэг тонн хорголжин тэжээлийг 660 000 төгрөг буюу 40 кг шуудайтайг 26 400 төгрөгөөр, нэг тонн овьёосыг 743 750 төгрөг буюу 40 кг шуудайтайг 29 750 төгрөгөөр худалдаалж байна.²⁰¹

²⁰¹ ХХААХҮЯ <https://mofa.gov.mn/exp/article/entry/2327>

Тэжээлийн дундаж үнэ (төгрөгөөр)

Тэжээлийн төрөл	1 тонн	25 кг шуудайтай	40 кг шуудайтай
Хивэг	640 000	16 000	-
Хорголжин тэжээл	670 000	-	26 400
Овьёос	740 000	-	29 600

Өнгөрсөн оны 12 дугаар сарын 04-ний өдөр хийсэн үнийн судалгаагаар 25 кг савлагаатай хивгийн дундаж үнэ 19 465 төгрөг байсан бол тэжээл импортолсноос хойш буюу 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 17 965 төгрөг болсон нь өмнөхөөс 8 орчим хувиар буурсан үзүүлэлт юм. Харин 03 дугаар сарын 11-ний байдлаар 16 000 төгрөг буюу 01 дүгээр сарын үнээс 10.9 хувиар буурсан байна.

Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Увс аймгийн Боршоо боомтуудаар тэжээлийг халдвар хамгааллын дэглэмийн дагуу импортлох үйл ажиллагаа эхэлж байна. Тус боомтоор 3000 тонн тэжээл импортлохоор 6 аж ахуйн нэгж яамтай “Бодлогын гэрээ” байгуулсан. Ингэснээр баруун аймгуудын тэжээлийн үнэ буурч, хангамж нэмэгдэх боломж бүрдсэн. Өнөөгийн байдлаар Бодлогын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн тэжээл импортлох, борлуулах үйл ажиллагаа хэвийн, үнэ буурч, нийлүүлэлт тогтвортой байна. Тэжээл импортолж буй аж ахуйн нэгжүүдэд тэжээлийн нөөц хуримтлагдсан байдалтай байна.

Малын тэжээлийн экспорт, импорт²⁰² (2021-2022/1)

Хүнсний үйлдвэрлэлээс гарсан үлдэгдэл ба хаягдал; малын тэжээлийн бэлдмэл										
			Экспорт				Импорт			
			2021 оны эхний хагас		2022 оны эхний хагас		2021 оны эхний хагас		2022 оны эхний хагас	
Код	Барааны нэр	нэгж	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
2302	Үр тарианы хаягдал	кг	0	0	0	0	4,111,000.0	744.8	1,041,406.0	180.1
2304	Шар буурцгийн бусад хатуу хаягдал	кг	0	0	0	0	506,000.0	311.3	455,000.0	317.0
2306	Бусад хатуу хаягдал	кг	0	0	0	0	0	0	126,720.0	56.6
2309	Мал, амьтны бэлдмэл тэжээл	кг	6,431.2	25.7	4,994.5	52.9	2,754,394.9	718.7	402,026.2	408.5
Дүн				25.7		52.9		1774.8		962.2

Эх сурвалж: Гаалийн цахим үйлчилгээний систем



²⁰² Гаалийн цахим үйлчилгээний систем <https://gaali.mn/statistic/news/62031aed941b535ef0ad66e3>

ХАВСРАЛТ МЭДЭЭЛЭЛ

1. МАЛЫН ТЭЖЭЭЛ

МАЛЫН ТЭЖЭЭЛ, тэжээлийн нэгжид шилжүүлснээр

Аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	мянган тонн				
БҮГД	611.5	757.4	849.7	744.4	1 109.3
Баруун бүс	122.4	134.7	153.9	137.7	229.3
Баян-Өлгий	33.3	38.4	53.8	47.3	52.2
Говь-Алтай	8.2	9.3	9.4	9.9	7.8
Завхан	11.0	10.4	12.7	11.2	16.2
Увс	32.2	33.5	39.8	35.8	42.3
Ховд	37.6	43.1	38.2	33.5	110.9
Хангайн бүс	178.4	249.4	297.0	225.5	299.6
Архангай	32.3	37.0	41.1	32.0	43.7
Баянхонгор	9.9	9.5	7.4	10.4	8.5
Булган	35.9	50.9	53.1	58.6	69.1
Орхон	3.6	4.3	5.0	4.9	6.3
Өвөрхангай	28.3	40.8	49.0	31.7	48.5
Хөвсгөл	68.4	106.8	141.4	88.0	123.6
Төвийн бүс	183.2	229.2	229.7	237.8	349.6
Говьсүмбэр	2.0	2.7	1.7	1.6	1.8
Дархан-Уул	24.5	27.8	18.2	15.8	30.1
Дорноговь	3.9	3.9	4.2	7.4	9.1
Дундговь	9.6	10.0	9.3	6.2	9.3
Өмнөговь	7.6	8.4	6.8	5.4	5.8
Сэлэнгэ	68.7	87.0	111.4	106.8	144.2
Төв	66.9	89.3	78.1	94.6	149.4
Зүүн бүс	109.8	124.4	148.5	122.8	191.4
Дорнод	30.2	39.5	52.1	48.7	59.8
Сүхбаатар	20.7	14.6	30.7	16.4	17.7
Хэнтий	58.9	70.3	65.6	57.7	114.0
Улаанбаатар	17.5	19.8	20.6	20.6	39.3

Ашигласан сүрэл

Аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	тонн				
Баруун бүс	405.2	1 203.8	1 193.8	1 384.0	605.7
Баян-Өлгий	-	13.6	2.0	-	16.0
Говь-Алтай	5.0	13.0	80.5	-	116.0
Завхан	389.9	860.4	624.1	2.0	32.0
Увс	2.2	315.8	439.3	1 382.0	331.2
Ховд	8.1	1.0	47.9	-	110.5
Хангайн бүс	694.5	2 265.2	2 434.0	575.6	1 231.2
Архангай	13.8	22.1	161.7	132.3	28.0
Баянхонгор	-	4.5	53.5	-	92.4
Булган	369.5	1 323.2	721.1	142.5	313.1
Орхон	161.0	257.2	370.2	287.8	300.4
Өвөрхангай	3.5	652.4	854.7	13.0	441.8
Хөвсгөл	146.7	5.8	272.8	-	55.5
Төвийн бүс	7 098.3	6 887.9	5 535.4	3 152.0	2 253.8

Говьсүмбэр	-	2.3	9.0	-	68.5
Дархан-Уул	20.8	343.7	127.8	-	48.1
Дорноговь	-	22.0	34.1	-	64.8
Дундговь	-	-	12.1	-	31.0
Өмнөговь	-	2.0	2.0	-	16.2
Сэлэнгэ	6 907.9	3 910.7	3 692.3	1 648.0	761.2
Төв	169.6	2 607.3	1 658.1	1 504.0	1 264.1
Зүүн бүс	316.0	73.5	63.5	3.0	385.5
Дорнод	0.0	1.0	13.0	-	68.0
Сүхбаатар	-	37.0	9.5	3.0	12.0
Хэнтий	316.0	35.5	41.0	-	305.5
Улаанбаатар	10.5	183.2	207.6	63.1	156.4

Бэлтгэсэн эрдэс тэжээл

Аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
тонн / tonnes					
БҮГД	77 945.0	94 586.9	121 323.6	90 472.0	142 508.5
Баруун бүс	18 665.6	22 012.5	27 697.2	23 886.9	64 095.8
Баян-Өлгий	1 394.7	2 824.0	7 197.5	6 021.6	6 980.8
Говь-Алтай	3 727.4	4 535.6	3 912.6	3 073.3	2 689.6
Завхан	2 852.0	2 110.7	3 226.4	2 691.2	2 134.7
Увс	5 207.3	6 232.5	5 780.2	5 533.0	7 491.0
Ховд	5 484.3	6 309.8	7 580.5	6 567.8	44 799.9
Хангайн бүс	23 476.1	26 565.3	38 838.8	26 478.3	39 730.4
Архангай	280.1	325.8	1 593.2	853.6	289.2
Баянхонгор	2 368.1	2 386.0	3 118.3	2 158.0	3 644.9
Булган	5 858.3	4 823.0	5 889.1	6 575.6	6 474.1
Орхон	255.9	293.1	446.7	268.2	340.1
Өвөрхангай	5 974.1	7 033.7	9 582.8	5 124.5	12 915.7
Хөвсгөл	8 739.5	11 703.8	18 208.7	11 498.5	16 066.5
Төвийн бүс	21 141.6	27 282.6	23 732.7	19 453.7	22 883.3
Говьсүмбэр	528.1	596.0	507.7	456.9	561.9
Дархан-Уул	841.3	1 764.0	792.9	807.6	1 133.1
Дорноговь	943.5	719.8	416.4	906.8	518.9
Дундговь	2 055.5	2 394.6	2 338.5	1 136.1	2 560.6
Өмнөговь	3 888.8	3 931.6	2 213.0	894.8	1 702.5
Сэлэнгэ	1 362.3	4 603.5	4 069.9	2 656.4	6 094.5
Төв	11 522.1	13 273.0	13 394.4	12 594.9	10 311.9
Зүүн бүс	13 868.2	17 261.9	29 423.6	18 959.9	13 850.1
Дорнод	1 485.7	4 342.1	2 287.9	2 652.3	1 419.9
Сүхбаатар	7 919.7	7 196.9	22 140.1	8 596.8	6 151.5
Хэнтий	4 462.8	5 722.9	4 995.6	7 710.9	6 278.8
Улаанбаатар	793.5	1 464.7	1 631.4	1 693.2	1 948.8

Бэлтгэсэн өвс, хадлан

Аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	мянган тонн				
БҮГД	1 008.1	1 229.4	1 369.2	1 186.2	1 720.6
Баруун бүс	197.1	215.7	234.5	203.2	294.7
Баян-Өлгий	57.1	66.4	81.5	71.2	78.6
Говь-Алтай	7.6	7.5	8.7	11.9	8.5
Завхан	16.2	15.7	18.2	14.3	20.8
Увс	51.1	50.4	64.0	53.7	64.6
Ховд	65.2	75.7	62.1	52.2	122.3
Хангайн бүс	308.6	433.8	511.0	389.1	489.2
Архангай	64.4	74.5	81.0	59.6	85.1
Баянхонгор	15.8	14.6	7.5	17.2	8.8
Булган	58.3	88.3	90.2	96.5	113.7
Орхон	7.2	8.2	9.2	8.7	10.8
Өвөрхангай	32.6	38.3	52.8	41.6	39.0
Хөвсгөл	130.3	209.9	270.2	165.5	231.8
Төвийн бүс	265.8	322.8	342.3	347.9	521.5
Говьсүмбэр	3.0	4.4	2.1	2.3	2.2
Дархан-Уул	47.4	49.1	32.8	27.2	56.2
Дорноговь	5.4	5.8	7.8	12.3	18.2
Дундговь	1.1	1.8	7.3	9.4	4.8
Өмнөговь	5.6	7.6	7.2	8.3	7.7
Сэлэнгэ	131.5	159.9	199.3	201.3	270.4
Төв	71.7	94.4	85.7	87.0	162.1
Зүүн бүс	208.6	227.6	251.5	214.9	369.5
Дорнод	62.6	74.5	106.8	96.9	127.3
Сүхбаатар	27.9	15.0	16.5	15.2	22.0
Хэнтий	118.2	138.1	128.2	102.8	220.2
Улаанбаатар	28.1	29.5	29.9	31.1	45.6

Гар тэжээл

Аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	тонн				
БҮГД	52 288.1	51 690.7	58 440.2	42 194.3	63 640.6
Баруун бүс	10 352.6	10 151.1	14 723.9	14 491.5	22 676.8
Баян-Өлгий	5 980.5	5 399.9	9 496.0	8 754.7	9 351.7
Говь-Алтай	533.3	750.3	846.8	691.8	401.3
Завхан	326.3	268.4	280.8	201.2	231.0
Увс	1 388.8	1 614.0	2 018.4	2 758.1	2 389.7
Ховд	2 123.7	2 118.5	2 081.9	2 085.7	10 303.1
Хангайн бүс	11 799.9	20 662.5	21 746.7	12 387.3	19 161.2
Архангай	952.2	1 155.3	1 946.4	1 566.7	1 341.8
Баянхонгор	251.9	419.4	625.2	217.3	479.8
Булган	2 956.4	3 662.2	3 644.3	3 639.9	3 192.9
Орхон	50.9	115.1	130.8	81.6	184.5
Өвөрхангай	7 059.2	15 076.8	14 464.7	5 760.2	12 707.5
Хөвсгөл	529.3	233.8	935.3	1 121.6	1 254.7
Төвийн бүс	26 309.2	17 198.8	16 540.2	10 838.6	17 031.9
Говьсүмбэр	89.2	92.7	139.3	48.6	108.1
Дархан-Уул	914.7	1 199.5	946.7	851.4	817.8

Дорноговь	537.4	586.3	225.0	953.8	321.5
Дундговь	7 070.2	6 826.6	3 624.6	868.7	4 435.1
Өмнөговь	1 010.0	983.7	1 191.7	619.2	514.6
Сэлэнгэ	788.7	1 479.3	3 848.1	1 121.8	1 849.2
Төв	15 899.0	6 030.7	6 564.8	6 375.2	8 985.6
Зүүн бүс	830.9	1 053.8	2 485.5	1 195.4	1 131.6
Дорнод	481.4	27.4	96.2	64.6	228.5
Сүхбаатар	237.1	341.7	252.8	328.4	174.6
Хэнтий	112.4	684.6	2 136.5	802.5	728.6
Улаанбаатар	2 995.5	2 624.5	2 943.9	3 281.5	3 639.1

Ашигласан үр тарианы хаягдал

Аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	тонн /tonnes				
БҮГД	8 800.6	12 173.4	11 118.9	11 185.3	24 004.8
Баруун бүс	517.9	581.0	635.8	628.5	369.4
Баян-Өлгий	4.0	-	-	0.5	-
Говь-Алтай	14.3	27.5	62.9	39.1	28.1
Завхан	12.8	3.0	-	2.0	4.3
Увс	486.9	550.5	571.9	551.4	332.2
Ховд	-	-	1.0	35.5	4.8
Хангайн бүс	940.6	1 332.8	1 096.9	1 194.5	1 345.8
Архангай	3.5	-	24.0	-	2.0
Баянхонгор	-	0.5	-	25.5	10.0
Булган	492.4	1 241.6	799.1	853.5	1 194.0
Орхон	16.8	35.8	33.4	1.0	8.6
Өвөрхангай	23.0	19.9	163.2	150.6	2.7
Хөвсгөл	405.0	35.1	77.3	164.0	128.6
Төвийн бүс	6 828.0	9 456.8	8 517.0	6 952.4	8 721.2
Говьсүмбэр	58.7	-	93.3	-	185.6
Дархан-Уул	1 391.1	1 384.9	1 542.0	1 618.9	1 588.5
Дорноговь	0.3	0.1	0.5	4.0	10.0
Дундговь	-	-	1.0	-	2.0
Өмнөговь	25.8	3.4	4.0	11.9	3.3
Сэлэнгэ	2 224.4	3 683.0	3 692.1	2 531.5	3 144.6
Төв	3 127.7	4 385.4	3 184.2	2 786.1	3 787.2
Зүүн бүс	11.1	67.2	75.5	1 811.0	218.5
Дорнод	4.1	60.4	37.5	1 557.9	59.5
Сүхбаатар	-	-	5.0	1.0	-
Хэнтий	-	-	33.0	252.1	159.0
Улаанбаатар	503.0	735.7	793.7	598.9	13 349.9

2. БЭЛЧЭЭРИЙН ХҮРЭЛЦЭЭ- 2019 ОН

№	Аймаг	Нийт бэлчээр нутгийн хэмжээ /сая га/	Сум дундын отрын бүс нутгийн хэмжээ /мян га/	Өвөлжөө, хаваржааны эзэмших гэрчилгээтэй малчин өрхийн тоо / мян/	Хадлангийн талбайн хэмжээ /мян.га/
1	Архангай	3.73	121.0	8500	53.9
2	Баянхонгор	3.67	-	8778	11.5
3	Баян-Өлгий	8.73	-	6500	10.4
4	Булган	2.48	133.8	8287	111.9
5	Говь-алтай	7.97	434.3	7251	2.5
6	Говь-сүмбэр	0.47	3.1	441	7.8
7	Дархан-Уул	0.17	-	135	9.0
8	Дорнод	9.24	111.2	3202	0.1
9	Дорноговь	8.96	286.8	2595	811.2
10	Дундговь	7.16	6.4	4134	0
11	Завхан	7.20	2.8	4752	7.7
12	Орхон	0.04	-	120	1.4
13	Өвөрхангай	5.69	90.0	10400	6.6
14	Өмнөговь	10.13	3030.0	6556	0.03
15	Сүхбаатар	7.20	702.0	64	79.1
16	Сэлэнгэ	1.62	-	2953	123.3
17	Төв	5.27	159.4	8504	61.0
18	Увс	4.70	-	3590	16.8
19	Ховд	5.40	4.5	4496	17.7
20	Хөвсгөл	4.50	245.0	9826	48.2
21	Хэнтий	5.50	109.0	3055	326.0
22	Улаанбаатар	0.43	-	-	5.5
	Нийт дүн	110.30	5439.3	104139	1.7 сая.га

100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 2020 онд 103 толгой мал ногдож байгаа нь өмнөх оноос 3-аар буурсан байна.

ХОЛБОГДОХ СУДАЛГАА, ЭХ СУРВАЛЖИЙН ТОЙМ

1. ХОНИНЫ МАХНЫ ЧИГЛЭЛЭЭР ҮРЖҮҮЛЭН ӨСГӨХ, МАЛЛАХ, ТЭЖЭЭХ, БОРДОХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ ТОЙМ

- Д.Чойжил Монгол хонины ноосон ашиг шимийг аймгуудаар судалсан байна.
- Т.Аюурзана /1952/ Дорнод аймгийн халх хонийг Увс аймгийн хоньтой харьцуулан судалсан байна.
- Ц.Арвий 1954-1960 онд Говь-Алтай хонийг судалж, ноос нь 18-25 см урт, үсэн бүрхүүлийн бүрэлдэхүүнд ямааны үсний эзлэх хувийн жин бага болохыг тогтоожээ.
- Б.Аюуш 1957 онд Монгол хонины мах, өөхөн ашиг шимийн гарцыг судалсан байна.

- З.Гончигжав /1962/ Дорнод талын бүс нутагт өсгөн үржүүлж буй Цигай, Монгол, Алтай зэрэг үүлдрийн эрлийз хонины ашиг шимийг судалжээ.
- Б.Пүрэв 1968 онд Нутгийн ууцан сүүлт хонийг Сараджин үүлдэртэй эрлийзжүүлэн, ашиг шимийн гарц, чанарыг судалжээ.
- Б.Минжигдорж /1968, 1970, 1973/ Монгол хонины нутагшилт, төл бойжилт, өсөлт хөгжилт, ашиг шим улирал, нас дагаж өөрчлөгдөх байдал, махны гарц, химийн найрлагыг судалжээ.
- М.Төмөржав /1973/ Монгол хонины арьсны бүтцийг аргаль, бусад ширүүн болон нарийн ноост хоньтой харьцуулан судалсан байна.
- Я.Нямаа /1973, 1994/ Монгол хонины хурганы махан ашиг шимийн гарцыг судалжээ.
- Г.Самбуу /1980/ Монгол омгийн хонинуудын удамших байдлыг судалжээ.
- Т.Содной /1981/ Монгол хонины био-экологийн судалгааг хийж, монгол хонь өсгөн үржүүлж буй бүс нутгаасаа хамааран аж ахуй, биологийн онцлогтой болохыг тодорхойлжээ.
- Б.Цэрэнжав, С.Чойжил, Б.Чутнай, Д.Доржсэмбээ нар дархад хонины аж ахуй, биологийн онцлогийг судалжээ. Тэдний судалгааны онцлог нь Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Баянзүрх сумын нутгийн хонийг монгол үүлдэр, омгийн хоньтой харьцуулан судалж, өндөр уулын эрс тэс уур амьсгалтай, хүйтэн цас ихтэй бүс нутагт бэлчээрээр малладаг өвөрмөц онцлогийг судалсан юм.
- Я.Я.Лус /1936/ “Монгол орны мал аж ахуй” бүтээлээ туурвисан байна. Уг бүтээлд монгол хонины аж ахуйн талаар дэлгэрэнгүй оруулжээ. Тухайлбал, монгол оронд ууцан сүүлт ба өөхөн сүүлт хонь үржүүлдэг, жилийн дөрвөн улирлын арчилгаа, маллагааны технологи, тарга хүч авалт, ашиг шимийн чанар, гарцын талаар дурдсан байна.
- Ф.А.Грехов /1934/ Манай орны зүүн бүсийн хоёр аймгийн хонины ашиг шим, өсөлтийг судалсан байна.
- М.Ф.Шульженко /1934, 1954/ Монгол хонины махан ашиг шимийг судалж, гулуузны жин, нядлагын гарцыг тодорхойлжээ.
- И.П.Трошин /1946/ Монгол хонийг туувраар таргалуулах ажилд ажиглалт судалгаа хийж, монгол хонь нь бэлчээрээр түргэн хугацаанд таргалдаг, сайн чанарын махтай гэжээ.
- Г.Р.Литовченко /1945, 1947, 1953/ Манай орны говь, хангайн бүс нутаг болон Увс аймгийн хонины махан ашиг шим, таргалах чадвар, үржүүлгийн ажлын зохион байгуулалтын талаар судалжээ.

Хонин сүргийн бэлчээрийн маллагаа, өсөлт хөгжилт

Амьтны бие махбодын өсөлт хөгжилт гэдэг нь хоорондоо нягт холбоотой нэгдмэл ойлголт бөгөөд өсөлт хөгжилтийн харилцаа холбоо нь амьтны хөгжлийн явцад бие махбодод явагдах тооны ба чанарын өөрчлөлтийн харилцан холбоо юм. Эдгээр нь салгаж болшгүй нягт холбоотой, харилцан уялдсан үйл ажиллагаа юм.

Л.Балданням, Я.Нямаа нарын судалгаагаар ердийн маллагааны нөхцөлд өвөлжсөн эр төлөг, эр хонины жин өвөл, хаврын 180 хоногийн хугацаанд 12-7.1 хувь буюу 4.38- 3.6 кг-аар буурсан байхад хоногт 0.5 тэжээлийн нэгжээр (ногоон өвс 0.5кг + хошуу будаа 0.3кг) нормлон нэмэгдэл тэжээл өгч бэлчээрээр малласан эр төлөгний жин 5.2 кг буюу хоногт 29 граммаар нэмэгдэж 14.2 хувиар өсжээ. Үүнээс үзэхэд хургыг намар оторлож таргалуулаад өвөл, хавар нэмэгдэл тэжээл өгч онд оруулбал түүний өсөлт хөгжилтийн эрчмийг бууруулахгүй байх боломжтойг илрүүлсэн байна.

1977 онд Ж.Тогтох, Ч.Бат-Очир нар Сэлэнгэ аймгийн Найрамдал САА-д нарийн ноост Хангай үүлдрийн хонины бэлчээр болон тэжээл ашиглалтын үр ашгийг дээшлүүлж, нэмэгдэл

тэжээлээр тэжээх ашигтай жор, тэжээх арга боловсруулах судалгааны ажлыг явуулжээ. Туршлагад 40 эм, 40 эр хурга сонгон авч 05-р сарын 15-аас 07 сарын 01-нийг хүртэл 200 гр хивэг, 200 гр багсармал тэжээл, 10 гр давс нэмэгдэл болгон өгч өсөлтөд нь нөлөөлөх нөлөөллийг 15 хоног тутамд жигнэж тодорхойлоход туршлагын эр хурганы жин 06-р сарын 01-нд 8.4 кг, охин хурганых 9 кг байсан бол 08-р сарын 01-ний байдлаар эр хурга 26.9 кг, охин хурга 27.8 кг болж хяналтынхаас эр хурга 6.4, охин хурга 7.7 кг илүү жинтэй болсон байна.

А.В.Заморывшев, И.И.Кузнецова нарын судалгаагаар маллагаа тэжээллэгийн сайн нөхцөлд байсан 8-9 сартай хурганы жин 36.8 кг байхад тэжээллэгийн хангалтгүй нөхцөлд байсан 9 сартай хурга 28.5 кг жинтэй байжээ. Тэжээлийн хэмжээ ихсэх, багасах зэргээр өөрчлөгдөх нь хурганы хэвийн өсөлт хөгжилтөд муугаар нөлөөлөөд зогсохгүй мах булчин, өөх, ясны эдийн өсөлтийн харьцаанд нэгэн адил нөлөөлнө. Сүүн болон өвсөн тэжээлийн үед хурганы тэжээл дутагдвал өсөлт хөгжилт нь саатаж, удаашрах бөгөөд цаашдаа тэжээллэгийг хэчнээн сайжруулсан ч өсөлт нь гүйцэд нөхөгддөггүй юм. Малын биеийн өсөлт хөгжилтийн зүй тогтлыг тодорхой танин мэдсэнээрээ мал амьтны амьдралын тодорхой үе шатанд түүнийг жолоодон зохицуулах замаар өсөлт хөгжилтийг түргэсгэх боломжтой.

С.В.Буйлов, В.М.Курганский нарийн ноост хонинд мах-ноосны үүлдрийн хуцаар хэрэгцээний эрлийзжүүлэг явуулах нь нарийн ноост хонины үндсэн чиглэлийг алдагдуулахгүйгээр үржүүлэх, улмаар зохистой тэжээлээр бордож түргэн өсөлттэй хурга бойжуулан маханд бэлтгэх ажлыг хослон явуулах боломжтой болохыг тэмдэглэжээ.

М.М.Санников хонины аж ахуйд хэрэгцээний эрлийзжүүлэг явуулах нь хурганы мах, кроссбред ноос үйлдвэрлэх чухал эх булгийн нэг мөн гэжээ.

Р.Г.Гусев, линколын ширүүн ноост хонины эрлийз хурганы өсөлт эхээс төрсөн үеэсээ 12 сартай болтлоо нарийн ширүүн ноостын эрлийзээс илүү эрчимтэй байдгийг дурдаад эхээс ялгах хүртэл хоногийн дундаж нэмэгдэл 215 гр байдаг гэжээ. Мөн мах-өөх, мах-ноосны чиглэлийн эрлийз хурганд махны хэвшил илүү тод илэрсэн, биеийн өргөний хэмжээнүүд илүү, ялангуяа бие нь урт, лагс зузаан байдаг байна.

С.В.Буйлов, В.М.Курганский бүтээлдээ нарийн ба ширүүн ноост хонинд хэрэгцээний эрлийзжүүлэг явуулж түргэн өсөлттэй хурга бойжуулж маханд бэлтгэхэд юуны өмнө эцэг үүлдрийг зөв сонгоход онцгой анхаарна. Эрлийз хурганы өсөлтийн хурд сайжруулагч үүлдрийн том багаас ихээхэн хамаарч байна. Эрлийзжүүлгэнд мах ноосны үүлдрийн хуцыг ашиглах нь илүү үр дүнтэй байна.

Б. Пүрэвийн тодорхойлсноор баруун монголын мах, өөх, ноосны чиглэлийн ширүүвтэр ноост ууцан сүүлт хонины 7 сартай хурганы нядлагын жин 14.7 кг, 1.5 настай төлөгнийх 24.7 кг эм хониных 27.2 кг, нядлагын гарц нь 45.7, 51.1, 46.6% байдаг. Эм хонины төлөрхөг чанар 100.9-104.6% байдаг.

Д.Эргашов, А.К.Амиров нар хургыг сүүн тэжээлийн үед нь сайн чанарын тэжээлээр хангалттай тэжээвэл махны гарцыг нэмэгдүүлэхээс гадна түүний таваарын болон биологийн үнэт чанарыг улам дээшлүүлдэг болохыг тэмдэглэжээ.

Бэлчээрээр оторлож таргалуулсан 30-аас дээш жинтэй хурганы нядлагын жин 13.9 кг, нядлагын гарц 42,1% оторлосны дараа бордсон 37,3 кг жинтэй хурганы нядлагын жин 18,2 кг, нядлагын гарц 48,8%, орой төрсөн 34,9 кг жинтэй хурганы нядлагын жин 16,5 кг, нядлагын гарц 47,4% хүрдэг.

1972-1974 онуудад Х.Дорж Завхан аймгийн Алдархаан, Ч.Пүрэвсүрэн Хөвсгөл аймгийн Ринчинлхүмбэ, Д.Номин Увс аймгийн бэлчээрийн маллагааны горим, өдөрт бэлчээрээс идэх ногоо хагдны хэмжээ, шингэцийг судалсан юм.

2. ҮХРИЙН МАХНЫ ЧИГЛЭЛЭЭР ҮРЖҮҮЛЭН ӨСГӨХ, МАЛЛАХ, ТЭЖЭЭХ, БОРДОХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ ТОЙМ

Нутгийн монгол үхэрт:

Д.Гончиг (1953), М.Наваанчимэд (1955), Д.Цэдэв (1956), Р.Жавзмаа (1962), Б.Баатар (1962), Д.Дагдаа (1972), Д.Больхорлоо (1975), Т.Цэдэндамба (1975), Б.Хөхүү (1983), Да.Алтангэрэл (1994), Ц.Булгаа (1996), Н.Бэгзжав (1995), Ё.Доржбат (2005), А.Эрдэнэчимэг (2021) нар

Сарлагт:

Ж.Пүрэвжав (1968), Т.Бат-Эрдэнэ (1988), Ч.Гомбожав (2003), Л.Эрхэмбаяр (2005) нар

Сэлэнгэ үүлдрийн үхэрт:

Р.Жавзмаа, Д.Нэргүй (1988), До. Алтангэрэл (1989), Г.Бадарч (1992), В.Бямбаа (1993), Д.Ринчиндорж (1996), Р.Бүрэнбаяр (1981), Т.Балдан (2006), П.Түмэнбаяр (2008), Б.Нарантуяа (2021) нар

Дорнод монголын талын улаан үхэрт:

Н.Наваанчимэд (1969-1972), С.Дугаржав(1975), Б.Лувсаншарав (1983) нар

МУ-ын хэмжээнд үржүүлж буй гадаадын өндөр ашиг шимт болон тэдгээрийн эрлийз үхэрт:

Монгол казахын цагаан толгойт, лимузингийн эрлийз үхэрт У.Рагчаа (1957), Д.Гончиг (1973), Ж.Гомбодорж (1978), Д.Дашдондог (1980), Д.Буянхишиг (1980), Ж.Нямаа (1981), Ц.Бат-Эрдэнэ (1992), В.Дагвийхорол (1999), Д.Зоригтбаатар (2003), Г.Сувдаа (2002) нар

Монгол малын үрийн биологи, биохимийн үзүүлэлт, нөхөн үржихүйн чадавхыг дээшлүүлэх, түүнд биотехнологийн дэвшилтэд аргыг ашиглах чиглэлд:

Д.Больхорлоо (1964), Т.Цэдэндамба (1975), Д.Нина (1975), Ё.Загдсүрэн (1980), Н.Бэгзжав (1995), Б.Эрдэнэбаатар (1998), Д.Бадамдорж П.Галрагчаа (1993), Ц.Булгаа (1996), Д.Буяндалай (2000), М.Даваа, Г.Энхманлай (2017)

Сүүний чиглэлийн үхэрт: Алатау үүлдрийн үхэрт Б.Мяхдадаг (1999), М.Цэгмид (1996), Хар тарлан үхэрт Ш.Хашбат (1999)

Судлаач М.Наваанчимэд (1965-1977)

Монгол өсвөр үхрийг эрчимтэй өсгөн бойжуулж, биеийн өсөлт, бэлчээрээр таргалах чадвар, махны чанарыг өвлийн тэжээллэг маллагаатай холбон судалсан цуврал туршлага явуулахад:

- Бэлчээрийн маллагааны нөхцөлд 3-р сард 18.2 кг амьдын жинтэй төрсөн монгол тугал 8 сартайдаа 180 кг, 26 сартайдаа 101.8-104.8 кг-аар амьдын жингээ нэмэгдүүлж байна.
- Анхны жилдээ байран тэжээсэн бярууны амьдын жин дан бэлчээрээр өвөлжсөн бярууныхаас 50.0-60.0 кг, бэлчээрээр нэмэгдэл тэжээлтэй өвөлжүүлэхэд 10-12 кг-аар илүү байна.
- Монгол үхрийн тугалыг эхлээр бойжуулаад бяруунд нь үр тарианы холимог зонхилсон тэжээлээр 210 хоног эрчимтэй бордоход биеийн өсөлт махлаг чанараар зарим махны ба мах, сүүний үхрийн бяруунаас дутахгүй байсан байна.
- Монгол үхрийг бяруунд нь засаатай бордоход хоног тутам 740-750 гр өсөж, 14 сартайдаа 330-350 кг жинтэй, засаж бордоход хоног тутам 700 гр өсөж мөн насанд 320 кг болж байгааг тодорхойлжээ. Харин махны гарц чанараар засаатай бяруунаас засаж бордсон бяруу давуу, 14 сартайд нь нядлахад зассан бяруу 61.3%-ийн махны гарцтай байхад бухан бяруу 58.0-59.3%-ийн махны гарцтай байжээ.

- Тэрээр судалгааныхаа үр дүнд үндэслэн монгол үхрийн тугалыг эрчимтэй бойжуулж 7-8 сартайд нь 180 кг-аас доошгүй жинд хүргээд бордож эхэлбэл биеийн өсөлт, махлаг чанар сайтай, эдийн засгийн үр ашгаар давуу болохыг бүтээлдээ тэмдэглэсэн байна.

Судлаач Р.Цэрэндулам (1980)

- Хар тарлан үүлдрийн эр бярууг сүрэл 3 кг, хивэг 3 кг, багсармал тэжээл 2 кг орсон жор дээр 60 гр мочевины нэмж өгч 60 хоног тэжээхэд хоногийн нэмэгдэл жин 706.0 гр болж, хяналтын хэсгээс 70 хувиар илүү, нэг кг нэмэгдэл жинд зарцуулсан тэжээлийн өртөг мочевиныгүй тэжээсэн хэсгийнхээс 52.1 хувь, өвстэй жороор тэжээсэн хэсгийнхээс 84.6 хувиар буурсан байна.
- Эндээс үзэхэд тэжээлийн жорд шингэх протеины хэмжээ нэмэгдэх тусам нэмэгдэл жинд зарцуулах тэжээлийн хэмжээг багасгаж болно гэж дүгнэжээ.

Судлаач Ж.Гомбодорж (1973-1982)

- Монгол, хасгийн цагаан толгойтын 1,2-р үеийн эрлийз тугалыг эхлээр өсгөн бойжуулж байран тэжээллэгийн нөхцөлд бүдүүн, хүчит тэжээлт жороор өсгөн бойжуулахад 12 сартайдаа 259.3-275.0 кг амьдын жин татаж, 1 кг нэмэгдэл тэжээлд 7.04-8.2 тэжээлийн нэгж хоногт 608.6-779.0 г жин нэмжээ.
- Нэмэгдэл тэжээлтэй өвөлжүүлсэн бярууг 18 сартай болтол бэлчээрээр 150 хоног маллаж таргалуулахад хоногийн нэмэгдэл жин 510-713 гр болж, 264-276 кг жинд хүрч улмаар 24 сартай болтол бүдүүн тэжээл 34.6%, хүчит тэжээл 25.1%, багсармал тэжээл 39.3% орсон тэжээлийн жороор байран тэжээхэд үнэмлэхүй өсөлт нь 93.7- 109.9 кг, 1 кг амьдын жин 7.2-8.0 тэжээлийн нэгж зарцуулжээ.

Судлаач Д.Нэргүй (1988)

- Сэлэнгэ, хасгийн цагаан толгойт үүлдрийн өсвөр үхэр дээр хийсэн судалгаандаа 7 сарын настай 209.8 кг амьдын жинтэй тугалыг хүчит тэжээл /28.0-30.0%+бүдүүн тэжээл /20.2-25%/+шүүст тэжээл /8-10.0%/-бэлчээрийн ногоо /33.0-47.0% бүхий тэжээлийн жороор тэжээж нэмэлтээр карбоамид, давс, манган, иод, кобальт өгч тэжээн 18-20 сарын настай болтол нь өсгөн бойжуулж, бордоход 378-419 кг амьдын жинд хүрч, 1кг нэмэгдэл жинд 329.73-390.06 төгрөгийн өртөг үйлдвэрлэж, ашигтай ажиллагааны түвшинг 20-28% хүргэж болохыг тогтоожээ.
- Сэлэнгэ үхрийн гулуузны мах үе чацуутан казахын цагаан толгойтоос 3.8-4.6% илүү нядалгын гарц 55.9-58.5% байжээ.

Судлаач Д.Ринчиндорж (1986-1990) Заамар сумын наранцэцэг+хошуу будаа+вандуйн холимог дарш бэлтгэн үхэр бордох ажил явуулсан байна:

- Тухайн холимог даршны органик бодис 89.26, нийт протеин 8.24, тослог 4.48, эслэг 20.86, АХБ 55.68, үнс 10.74 хувь, ерөнхий шимт чанар нь 3.08 мДж солбилцлын энергитэй, 21.29 гр шингэх протеинтэй байна.
- Эрлийз тугалыг шүүст-хүчит-бүдүүн хэв шинжит жороор өсгөн бойжуулж бордоход хоногийн нэмэгдэл жин хяналтын (хүчит-бүдүүн тэжээл) хэсэгтэй харьцуулахад 5.8-11.0 хувь, энэ үед 1 кг нэмэгдэл жинд зарцуулах тэжээлийн зардлыг 5.4-10.5 хувь багасгаж болохыг тогтоожээ.
- Махны чиглэлийн эрлийз тугалыг өвөл хаврын улиралд байран маллагаанд 13 сарын настай болтол 180 хоног шүүст болон хүчит тэжээл, өвсний хэв шинжит тэжээлийн жороор тэжээж, байгалийн бэлчээрт 120 хоног, таримал бэлчээрт 30 хоног маллаж, шүүст+хүчит+бүдүүн хэв шинжийн тэжээлээр 45 хоног эрчимтэй бордоход шимт бодисын шингэц дээшлэн, хоногийн нэмэгдэл жин 5.79-11%-аар нэмэгдэж, тэжээл зарцуулалтыг 10-23.2%-аар хямдруулан, хүчит тэжээлийн зарцуулалтыг 48.8%-аар багасгах боломжийг бүрдүүлсэн байна.

- Түүнчлэн байгалийн цеолитыг тэжээлийн жорын хуурай бодисын 3,5,8 хувиар тооцож нэмэгдэл болгон ашиглахад шимт бодисын шингэц 1.27-6.38%, хоногийн нэмэгдэл жин 15.22-23.48%-аар нэмэгдэж, тэжээл зарцуулалт 14.86-19.57%, тэжээлийн зардал 12.29-19.13%-аар тус тус буурсан байна.
- Тэрээр өсгөн бойжуулж, бордох тэжээлийн жорын зохистой хэв шинжийг тогтоож, байгалийн цеолит, уураг эрдсийн нэмэгдлээр баяжуулан, ургамлын гаралтай амьдын жин нэмэгдүүлэгч хэрэглэснээр ашигт ажиллагааны түвшинг 29.4-31.7%-д хүргэх боломжийг илрүүлж, үйлдвэрлэлд өргөн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
 - Монгол орны нөхцөлд мал бордож, мах үйлдвэрлэлийг явуулахад энгийн 3 талт саравч тохиромжтой.
 - Хэлбэр нь: өсгөн бойжуулах+оторлох+бордох
 - Бордооны тэжээлийн хэв шинж: шүүст + өвс + хүчит тэжээл, хүчит тэжээл + өвс
 - Бордооны хэсэгт: Өрхийн аж ахуйд 5 толгой, фермд 20 толгой, мах комбинатад 50 толгойгоор бүлэглэх нь тохиромжтой болохыг зөвлөсөн.

3. МОНГОЛ ОРНЫ БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН УРГАМЛЫН ХИМИЙН НАЙРЛАГА, ШИНГЭЦ, ШИМТ ЧАНАРЫГ СУДАЛСАН ТОЙМ

Монгол орны бэлчээрийн ургамлын химийн найрлагыг судлах ажил 1940-өөд оноос эхэлсэн гэж үзэх үндэстэй бөгөөд А.А.Юнатовын бичсэн “БНМАУ-ын хадлан бэлчээр дэх тэжээлийн ургамлууд” гэдэг бүтээлд 400 орчим ургамлын идэмж, 135 зүйл ургамлыг хамарсан агрохимийн 235 задлан шинжилгээний дүн орсон байна.

ЗХУ-ын судлаач А.В.Калинина (1948-1950) Монгол орны байгалийн янз бүрийн бүсийн бэлчээрийг хагас суурин байдлаар судалж ургац, химийн найрлагын зарим үзүүлэлтийг өөрийн бүтээлд оруулжээ. Тухайлбал, түүний судалгаа хийсэн уулын хээрийн алаг өвс-жижиг үетэнт бэлчээрийн ургамалд хавар протеин 10.59, тослог 3.05, эслэг 31.7, үнс 5.18, намар протеин 7.5, тослог 3.3, эслэг 34.8 хувь агуулагдаж байсан тухай тэмдэглэсэн байна.

Л.Дугар (1952-1955) Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг Бургалтай ба Зүүнхараагийн сангийн аж ахуйн нутгуудад янз бүрийн хугацаанд бэлтгэж байгаа хангайн бүсийн алаг өвс-үетэн, үетэн-алаг өвс, улалж зонхилсон өвсний шингэцийг монгол хонин дээр туршин тодорхойлсон. Судалгааны дүнгээс үзэхэд 8-р сард хадсан улалж-алаг өвст хадлангийн өвсний протеины шингэц нь 7-р сарынхаас 19 хувь доогуур байна.

Ш.Гомбо (1953-1955) Жаргалантын сангийн аж ахуйн нутагт үетэн-янз бүрийн ургамал зонхилсон бэлчээрийн ногооны шингэцийг монгол хонин дээр тодорхойлохын зэрэгцээ уг бэлчээрийн ургац, зонхилгогч ургамлын химийн найрлага, шимт чанар, эрдэс бодис, каротин зэргийг тодорхойлсон. Үүнд: хангайн бүсийн үетэн-янз бүрийн ургамалтай бэлчээрийн ногооны 1 кг нь бутлалт түрүүлэлтийнхээ эхэн үед 0.23 тэжээлийн нэгж, 43 гр шингэх уурагтай, цэцэглэлтийн сүүлч үр боловсролтын үедээ 0.20 тэжээлийн нэгж, 25 гр шингэх протеинтой, тэжээлийн ургамлын 1 кг хуурай бодист 185 мг каротинтой болохыг тодорхойлжээ.

Л.М.Матвеев (1960-1963) Үетэн-агьт, үет ургамалтай бэлчээрийн ногооны шингэцийг 5 удаа янз бүрийн насны үхэр дээр туршихад үхэр бэлчээрээс харилцан адилгүй хэмжээтэй ногоо иддэг болохыг судлан тогтоосон.

1960 оноос эхлэн төрөл бүрийн бэлчээрийн ногоо, хадлангийн өвс бэлтгэж буй тэжээлийн шингэц, шимт чанар тодорхойлох судалгааг бүс нутгийг хамруулан хийж эхэлсэн.

Р.Цэрэндулам (1957, 1962, 1965) Монгол орны байгалийн янз бүрийн бүсийн бэлчээрийн ургамал болон төрөл бүрийн тэжээлийн химийн найрлага, шингэц шимт чанар, үлэмж ба бичил язгуур махбод, лигнин-нүүрс усны бүлгийг тодорхойлох ажил хийсэн юм. Түүний

туурвисан БНМАУ-ын малын тэжээл, Малын тэжээллэгийн дадлага, Төрөл бүрийн тэжээлийн шимт чанар, Тэжээлийн шимт чанарын хүрд, Мал сүргийн бэлчээрийн маллагаа, тэжээллэг, зэрэг бүтээлүүдэд бэлчээрийн ургамлын химийн найрлага, шингэц, шимт чанарыг байгаль газар зүйн бүс, ургамлын бүрэлдэхүүн түүний хөгжлийн үе шат, хадаж бэлтгэх, хурааж хадгалах зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж ихээхэн хэлбэлзэлтэй байдгийг тодорхой дурдсан байдаг.

1961 онд ХААДС-ийн багш Х.Гэндарам, оюутан Нгуен-майг нар Төв аймгийн Эрдэнэ сумын үетэн-янз бүрийн ургамалтай бэлчээрийн ногооны шингэц тодорхойлох туршлагын ажлыг хонин дээр явуулахад уг бэлчээрийн 1 кг ногоо 0.36 тэжээлийн нэгж, 24 гр шингэх протеинтой болохыг нь тодорхойлжээ.

Ж.Очир (1959-1960) Хэнтийн уулархаг бүсийн баруун хэсгийн бэлчээрийн зонхилгогч болон дэд зонхилгогч 28 зүйл ургамлын тэжээллэг чанар, химийн найрлагыг судалснаас үзэхэд шар царгас 23.37 хувь, шувуун хөл 20.65, тарваган шийр 17.75 хувьтай байгаа нь хамгийн их, саман ерхөг 21.0, хазаар өвс 9.99-10.46 хувь буюу дунд зэрэг, шивээт хялгана, агь зэрэг ургамлын хагд 1.81-5.36 хувь буюу хамгийн бага протеинтэй байжээ.

Ж.Тогтох (1964-1972) уулын, хээрийн бэлчээрийн ногоо зун 0.21-0.37 тэжээлийн нэгж, 24-56 гр шингэх протеин, намар 0.39-0.47 тэжээлийн нэгж, 6-29 гр шингэх протеинтой, өвөл, хавар 0.18-0.37 тэжээлийн нэгж, 6-29 гр шингэх протеинтэй байдаг гэж дүгнэжээ.

Б.Мөнх (1969) Төв аймгийн Заамар сумын нутагт 5 төрлийн бэлчээрийн ургамлын шингэц, шимт чанарыг хөдлөл зүйг судлаад үетэн алаг өвст бэлчээрийн ногоо цэцэглэлтийн үедээ 0.35 тэжээлийн нэгж, 20.2 гр шингэх протеин агуулж байсан бол хагдрах үедээ шимт чанар нь буурч, шингэх протеин багасдаг гэж дүгнэсэн байна.

Б.Хөххүү (1969-1983) тал хээрийн хялгана-жигжиг үетэн-агьт, хялгана-алаг өвс-харганат бэлчээрийн ургамлын химийн найрлага, шингэц, шимт чанарыг судлан уг бэлчээрийн 1кг ургамал зун 0.44, намар 0.27-0.31, өвөл 0.22-0.27 тэжээлийн нэгжтэй, шингэх протеин дээрх дарааллаар 26-51, 26-29, 17-31 гр байгааг тогтоожээ.

Р.Цэрэндулам (1970) Агь ургаж эхлэх үеийн хуурай бодист 16.27 хувь протеин, 26.34 хувь эслэг агуулагдана. Агьны 100 кг үнэмлэхүй хуурай бодис нь зуны улиралд хөгжлийн үе шатны байдлаас шалтгаалж 44.7-90.5 тэжээлийн нэгж, 6.6-9.7 кг шингэх протеин, хагд нь 0.43 тэжээлийн нэгж, 3.2 кг шингэх протеинтой байна.

4.МОНГОЛ ОРНЫ БЭЛЧЭЭРИЙН УРГАМЛАН НӨМРӨГИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Монгол орны ургамлын нөмрөгийг (1921-1955) Оросын эрдэмтдээс В.И.Лисовский (1921), Н.В.Павлов (1925,1926,1929), Б.Б.Полынов 1925-1929), Я.И.Проханов (1929), В.И.Баранов (1930-1931), Е.Г.Победимова (1933-1955), Н.Л.Десяткин 1936), Д.А.Симуков (1936) онуудад тус тус судалжээ.

1940-өөд оноос Монгол орны бэлчээр хадланг судлах ажил улам эрчимжиж, ЗХУ-тай хамтарч зохион байгуулсан хөдөө аж ахуйн шинжилгээний экспедиц манай орны бүх нутгийг хамруулан явуулын болон суурин судалгаа хийсэн байна.

А.А. Юнатов (1950) тус орны говь ба хойт хэсэгт хийсэн өөрийн судалгаандаа тулгуурлан бичсэн “БНМАУ-ын ургамлан нөмрөгийн үндсэн шинжүүд” номондоо үетэнт, үетэн-алаг өвст, агь бүхий бэлчээрийн нэг га-ийн ургац 6-8 ц/га, агь-алаг өвс бэлчээрийнх 8.0 ц/га орчим байна гэжээ.

А.В.Калинина (1948-1950) ойт хээрийн болон говийн алаг өвс-үетэнт, ерхөг-хазаар өвс- хялганат, царгас-согооворт хиаг-жигжиг үетэнт, таана-хялганат бэлчээрийн ургац хаврын эхэнд 2.3, сүүлээр 3.0, зуны эхэнд 3.6, дунд үед 4.3, сүүлээр 6.6, намар 4.0, өвөл 1.1-2.3 ц/га болдог гэжээ.

Ю.М.Мирошниченко (1958-1960) Ойт хээр (Жаргалант), хээр (Мааньт, Өндөрхаан, Чойр), цөлийн хээр (Дэлгэрхангай), цөл (Номгон)-ийн бүсэд хагас суурин судалгаа хийж 5-р сарын сүүлчээр бэлчээрт байх ногоон ургамлын хэмжээ жилийн дээд ургацын дөнгөж 3-10 хувийг эзэлдэг бөгөөд ургац 8-р сард дээд хэмжээндээ хүрч ойт хээрт 10-14 ц/га, хуурай хээрт 4.8-10.5 ц/га, цөлийн хээрт 2.03-5 ц/га, говьд 0.5-2 ц/га болдог гэжээ.

Ц.Даваажамц (1954-1980) Өвөрхангай аймгийн хойд хэсэгт хадлан бэлчээрийн судалгаа хийж, уулын хээр, хуурай хээр, цөлөрхөг хээрт хамаарах бэлчээрийн ургац, тэнд тохиолдох зарим ургамлын тэжээлийн үнэлгээ, тархац, экологийг тодорхойлж, ашиглах хэлбэрийг тогтоожээ. Энд тохиолдох бүлэг эвслүүдээс хамгийн их нь 53.0-79.0 хувийг ботууль-элдэв өвст уулын хээр эзэлдэг. Ургамалшилтын ерөнхий бүрхэц 35.0-65.0 хувь га-гийн дундаж ургацтай 3.0-6.9 цн байна гэж тодорхойлжээ.

Ш.Гомбо (1955) Төв аймгийн Жаргалантын САА-н орчимд алаг өвс-үетэнт бэлчээрийн ногооны зуны ургац, хадах аргаар 45.7 ц/га, зоотехникийн буюу эргүүлэн тооцох аргаар тодорхойлоход 42.7 ц/га байсан байна.

Р.Цэрэндулам (1955) ойт хээрийн алаг өвс-үетэнт бэлчээр зуны улиралд 10.5 хувь үетэн, 63.6 хувь алаг өвс, 8.8 хувь буурцагтан, 17.4 хувь улалжтайн дээр 1 га-ийн ургац 11 ц/га байсан боловч намар үет ургамал сайн хадгалагддаг учир ургацад эзлэх хувийн жин нь 58.1 хувь болон өсөж, алаг өвс 27.3 хувь болон буурч, ургац 3 ц-ээр хорогдсоныг тогтоосон.

Д.Дашням (1957-1958) Дорнод аймагт хээрийн үндсэн хэв шинжийн бэлчээр болох хялгана-хиагт бэлчээрийн 1 га-ийн ургац 10-16 ц, хялганат бэлчээрийнх 10-13 ц, хазаар өвс- агьт бэлчээрийнх 9-14 ц, хиагт хээржүү нугынх 20-22 ц байгааг илрүүлсэн.

Ж.Очир (1959-1963) Хэнтийн уулархаг орны баруун хэсэгт судалгаа хийж алаг өвс-үетэнт бэлчээрт үетэн 38.1, улалж 8.92, буурцагтан 10.3, алаг өвс 43.4 хувийг эзэлж 1 га-д биологийн 5-7 ц, аж ахуйн 3-4 ц, алаг өвс-үетэн-шарилжит бэлчээрт үетэн 42.6, улалж 52, буурцагтан 11.5, алаг өвс 40.7 хувь оролцсон биологийн 5-6 ц, аж ахуйн 3-4 ц ургац байгааг тодорхойлсон байна.

Д.Банзрагч (1961-1965) Ойт хээрийн агь-жигж үетэн-хялганат эвшлийн бэлчээрийн 1 га-ийн ургац 8-р сарын эхний 10 хоногт 11.2 ц болж дээд хэмжээндээ хүрсэн бөгөөд 5-р сард үүний 11, 6-р сарын эцэст 48, 7-р сарын эцэст 83 хувь нь хуримтлагдаж 9-р сард 70 хувь нь хадгалагддаг.

Ж.Тогтох (1964-1972) Төв аймгийн Жаргалантын САА-н нутгийн алаг өвс-үетэнт бэлчээрт үетэн 39.27, алаг өвс 55.8, буурцагтан 1.83, улалж 3.1 хувийг эзэлдэг бөгөөд ургац нь зуны улиралд 11 ц/га байна.

М.Бадам, Ч.Оюунцэцэг (1969-1971) нар Хэнтийн төв хэсэгт судалгаа хийж ботууль хээр уулын өмнөд энгэрээр зонхилон ургах бөгөөд уулын хормой руу буух тусам алаг өвст ботууль, жигж үртэн ботууль эвсэлд шилжинэ. Ботууль алаг өвст эвшлийн зуны дээд ургац 7-р сарын 3-р хоногт 8.8 ц/га хүрч ургац өгнө. Ургацын 27.2 хувийг нь ботууль дангаараа бүрдүүлнэ. Умард хангайд ботууль хээр 1400 метрээс доош буудаггүй бол Хэнтийд 1200-1300 метрт тохиолдсоныг тэмдэглэсэн байна.

С.Цэрэндаш (1972-1975) Алаг өвс-хялганат бэлчээрийн ургацыг судлахад зуны дээд ургац 8-р сарын хоёрдугаар арав хоногт 19.4 ц/га болж дээд хэмжээндээ хүрч байгаа бөгөөд үүний 72 хувь нь 5-р сард, 50 хувь нь 6 дугаар сард, 82.5 хувь нь 7 дугаар сард хуримтлагдаж намар 41.3 ц/га буюу зуны дээд ургацын 74.6 хувь, хавар 9.5 ц/га буюу 49.0 хувь нь хадгалагдаж байжээ. Уг бэлчээрт хавар үетэн 42.8, улалж 8.9, алаг өвс 44.7, зун үетэн 29.53, улалж 10.06, алаг өвс 43.63, намар үетэн 43.3, улалж 11.33, алаг өвс 36.63, өвөл үетэн 80, алаг өвс 20 орчим хувийг тус тус эзэлж байсан нь ургамлын улирлаар хадгалагдах байдал харилцан адилгүй болохыг харуулна.

Х.Гэндарам (1972-1977) Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт хээрийн бүсийн хялгана-хазаар өвст бэлчээрийн ургац, ургамлын бүрэлдэхүүнийг судалжээ. Энэ бэлчээр 8-р сард 16 ц/га ургацтай үетэн 72, алаг өвс 17.5 харгана 9.6 хувийг эзэлж байсан бол 10-р сард 6.4 ц/га ургацтай үетэн 74, алаг өвс 14, харгана 11, өвөл 01-р сард 2.7 ц/га ургацтай үетэн 80.7, алаг өвс 8.3, харгана 11 хувь, хавар 4-р сард 1.7 ц ургацтай үетэн 85.9, алаг өвс 6.8, харгана 7.3 хувь болж өөрчлөгдсөн байна.

Б.Хөххүү (1969-1980) Төв аймгийн Заамар, Хэнтий аймгийн Дархан суманд судалгаа хийж хялгана-жижиг үетэн-шарилжит, хялгана-алаг өвс-харганат бэлчээрийн ургац хадгалагдах байдлыг тодорхойлжээ. Түүний судалснаар зун хялгана-жижиг үетэн-шарилжит бэлчээрийн ургац 13.3 ц/га байснаа намар 61.7, өвөл 42.1, хавар 24.1 хувь нь, харин хялгана-алаг өвс-харганат бэлчээрийн зуны ургац 12.3 ц/га байснаа намар 78.9, өвөл 43.9, хавар 28.5 хувь тус тус хадгалагдан үлдсэн байна.

Н.Лхагважав (1970-1980) Төв аймгийн Заамар сумын нутагт хээрийн бүсийн алаг өвс үетэнт бэлчээрийн ургацыг судалсан дүнгээс үзвэл зун 21.4, намар 16.2, өвөл 12.8, хавар 10.2 ц/га байсан бөгөөд зуны ургацын 75.6 хувь намар, 60 хувь өвөл, 48 хувь хавар хадгалагдаж байна.

С.Тусивахын (1971-1985) Хуурай хээрийн алаг өвс-дааган сүүлт, алаг өвс-жижиг үетэнт, алаг өвс-шарилжит бэлчээрийн ургац хэнзлэх чадвар, хагдны хадгалагдах байдлыг улирлаар судалжээ. Судалгааны дүнгээс үзэхэд алаг өвс дааган сүүлт бэлчээрийн ургац зун 10.4, намар 7.9, өвөл 5.8, хавар 5.0 ц/га, алаг өвс-шарилжит бэлчээрийнх дээрх дараалалаар 5.4, 4.3, 3.9, 2.9 ц/га тус тус байна гэж дүгнэсэн.

Б.Лувсаншарав (1980-1983) Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутагт харгана-хиаг-хялганат бэлчээрийн ургац, түүний ургамлын бүрэлдэхүүнийг судалжээ. Энэ бэлчээрийн ургац 7 дугаар сард 6.5 ц/га байснаа намар 45.3, өвөл 55.7, хавар 63.3 хувиар буурч, өвөл хаврын ургацад үетэн 81.5-83.5, алаг өвс 6.3-7.2, буурцагтан 9.2-10.2, улалж 1.0-1.2 хувийг эзэлж байхад зуны ургацад дээрх дарааллаар 68.4, 19.1, 11.8, 0.9 намар 72.5, 16.4, 10.3, 0.8 хувийг тус тус эзэлж байна.

Д.Ринчиндорж (1980-1985) Булган аймгийн Орхон сумын уулын хээрийн үетэн-алаг өвст бэлчээрийн ургац ургамлын бүрэлдэхүүнийг жилийн дөрвөн улирлаар судалжээ. Зуны ургац 15.8 ц/га байхад намар 72.1 хувь, өвөл 64.5 хувь, хавар 49.3 хувиар тус тус хадгалагддаг болохыг тогтоожээ. Тухайн бэлчээр нь зун, намрын улиралд үетэн 47.7-53.2, буурцагтан 3.2-6.8, алаг өвс 29.1-36.1, улалж 2.6-5.8 хувь, өвөл, хаврын улиралд үетэн 50.7-44.7, буурцагтан 0.1-3.6, алаг өвс 38.2-43.0, улалж 0.8-1.8 хувийг тус тус эзэлж байна.

Д.Нэргүй (1985-1990) Булган аймгийн Ингэттолгойн САА-н нутагт алаг өвс-үетэнт бэлчээрийн зуны ургац, ургамлын бүрэлдэхүүнийг тодорхойлоход 8 дугаар сард 14.8 ц/га ургацтай байсан бөгөөд түүнд үетэн 9.0 хувь хагд 6.0 хувь байжээ.

Ш.Хашбат (1986-1990) Улаанбаатар хотын Жаргалант дүүргийн нутаг “Мухрын амны” ойролцоох бэлчээрийн хэв шинж, ургамлын бүрэлдэхүүн, ургацыг тодорхойлоход буурцагтан 1.58, үетэн 19.95, улалж 36.48, алаг өвс 41.73 хувь байсан ба ургац нь зуны улиралд 19.5-35.5 ц/га байжээ.

Д.Ринчиндорж (1986-1990) Төв аймгийн Заамар сумын үетэн-алаг өвст хэв шинжийн бэлчээрт ургамалшилтын судалгаа хийхэд 6-р сарын дунд үед үетэн 42.7, алаг өвс 38, улалж 4.5, буурцагтан 2.8, хагд 12 хувийг эзэлж байсан бол 8-р сард дээрх дарааллаар 45.6, 39.9, 5.9, 3.6, 5.0 хувь тус тус байж ургац нь агаарын хуурайд 6-р сард 7.2 ц/га, 7-р сард 10.37 ц/га, 8-р сард 11.92 ц/га, 9-р сард 9.91 ц/га болж, 9-р сараас эхлэн ургац буурч байна.

Н.Тогтохбаяр (1990-1995) ойт хээр болон хээрийн бүсийн алаг өвс-үетэнт бэлчээрийн ургамлын ургац, ургамлын бүрэлдэхүүнийг тодорхойлжээ. Судалгаанаас үзэхэд ойт хээрийн бүсийн алаг өвс-үетэнт бэлчээрийн ургац зуны улиралд 12.33 ц/га, намар 6.42 ц/га, өвөл 4.35 ц/га, хавар 2.76 ц/га байгаа бол хээрийн бүсийн алаг өвс-үетэнт бэлчээрийнх зун 9.19 ц/га, намар 5.3 ц/га, өвөл 3.85 ц/га, хавар 1.85 ц/га байжээ.

Д.Ринчиндорж (1991-1995) Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын хээрийн бүсийн зонхилох бэлчээрт хийсэн судалгаагаар зун, намрын улиралд хялгана-ерхөг-шарилжит, хялгана-ерхөг-дааган сүүл-ямаан шарилжит, ботууль-дааган сүүл-ерхөг-алаг өвст хээрийн болон уулын хээрийн үетэн алаг өвст голын ширэгт бэлчээрт 18-23 зүйлийн ургамал ургаж гайин ургац 3.8-8.9 цн, өвөл, хаврын улиралд хялгана-үетэн-алаг өвст, хялгана-ерхөг-алаг өвст, хялгана-жигжиг үетэн, алаг өвст, үетэн-алаг өвс-агьт бэлчээрт 24-28 зүйл ургамал ургаж гайин ургац 1.5-5.1 ц/га байсныг тодорхойлжээ.

Ч.Оюунцэцэг (2000) Өмнөд хангайн өндөр уулын чулуурхаг хээрийн ботууль алаг өвст бэлчээр зун, намар 7.4-3.7 ц/га, өвөл, хавар 1.3-0.6 ц/га алаг өвст уулын нугын бэлчээр зун, намар 9.5-4.4 ц/га, өвөл хавар 2.5-1.4 ц/га ургац өгдөг ажээ. Өндөр уулын бэлчээрийн даац өвөл 100 га эдэлбэр газар, зун-намар 106, өвөл-хавар 35 хонь толгой малын даацтай байдаг болохыг тодорхойлсон байна.

Г.Цэрэнбалжид (2002) Монгол орны хөл газрын ургамлын зүйлийн тархацын байнгашил-тогтворжилтын ангилааны зэрэг нэмэгдэхэд түүнд оролцох ургамлын зүйлийн тоо, тэдгээрийн амьдралын хэлбэр, биологийн бүрэлдэхүүний тоо цөөрөх, ангилааны зэрэг буурахад эдгээр нь нэмэгддэг харилцан хамаарал бүхий тодорхой зүй тогтлоор бэлчээрт хөл газрын ургамал, ургамалжилт бүрэлдэн тогтож байна. Монгол орны бэлчээр дэх хөл газрын 440 зүйлийн ургамлыг амьдралын хэлбэр ба биологийн бүлгээр ангилахад нэг наст 150 зүйл буюу 34.1 хувь, өвлийн ба хоёр наст 40 зүйл буюу 9.1 хувь, олон наст өвслөг ургамал 220 зүйл буюу 50.0 хувь, сөөг сөөгөнцөр 18 зүйл буюу 4.1 хувь, шимэгч ургамал 12 зүйл буюу 2.7 хувь тус тус эзэлдэг болохыг тодорхойлжээ.

С.Жигжидсүрэн (2003) Агь нь 8-р сарын дундаас 9-р сарын эхний арав хоногт цэцэглэх ба үр боловсролтын шат нь 10-р сарын эх хүртэл үргэлжилдэг болохыг П.Санжид тэмдэглэсэн байдаг.

Д.Болормаа (2004) Хустайн Байгалийн цогцолборт газрын 4 төрлийн бэлчээрийн ургацыг судалсан дүнгээс үзвэл бэлчээрийн зуны дээд ургацын 73.4-77.1 хувь нь 10-р сард, 53.8-68.4 хувь нь 2-р сард, 42.6-46 хувь нь 4-р сард хагд хэлбэрээр хадгалагдахын зэрэгцээ нийт хагдны 64.2-80.6 хувийг үет ургамал эзэлдэг болохыг тогтоожээ.

А.Отгонжаргал (2005) ойт хээрийн бүсийн хялгана-алаг өвст, ерхөг-алаг өвст, үетэн-алаг өвст бэлчээрийн ургацыг тогтоожээ. Үүнд: Ургамал ургаж эхлэх үед 5.98-7.09 ц/га байснаа цаашид аажмаар нэмэгдэж үр боловсролтын шат буюу 8-р сарын дундуур 26.88-27.23 ц/га болж хамгийн дээд хэмжээндээ хүрч байна. Харин цаашид буурч ургамал хагдарч эхлэх үе буюу 9-р сарын дунд 10 хоногт 12.05-12.72 ц/га болж байгаа нь ургамлын хөгжлийн үе шатны дагуу өөрчлөгддөг байна.

Б.Баасанжалбуу (2006) Хустайн Байгалийн цогцолборт газрын уулын хээрийн үетэн-алаг өвст хэв шинжийн бэлчээрийн ургац, ургамлын бүрэлдэхүүний хөдлөл зүйг сар улирлаар тогтоожээ. Үүнд: Хустайн нурууны уулын хээрийн үетэн-алаг өвст бэлчээрт 30 овог, 67 төрөл, 89 зүйлийн ургамал ургадаг бөгөөд 75 хувь нь хуурайсаг, 25 хувь нь хуурайсуу-чийгсэг бүлгийн ургамалд хамаарах ба зуны улиралд бодит бүрхэц нь 65 хувь байна гээд бэлчээрийн ургамлын бүрэлдэхүүн улирлаар өөрчлөгдөх боловч жилийн турш үетэн давамгайлах бөгөөд намар, өвөл, хаврын хагданд *Agropyron cristatum* (L.) P.B., *Achnatherum splendens* (Trin.)

Nevsk., *Koeleria macrantha* (Ldb.) Schult., *Eragrostis cilianensis* (All.) Vign. -Lut., *Stipa Krylovii* Roshev. зэрэг үетнүүд зонхилж байна гэжээ. Мөн бэлчээрийн ургац зун 14.13 ц/га, намар 8.85 ц/га, өвөл 6.3 ц/га байгаа ба намар зуны ургацын 62.77, өвлийн 44.68, хаврын 35.79 хувь нь бэлчээрт хадгалагдан үлддэг гэжээ.

С.Цэрэндаш (2008) “Нийтийн эзэмшлийн байгалийн нөөцийн тогтвортой менежмент” төсөл хэрэгжиж байгаа Дэлүүн, Хотонт, Лүн сумдын мал аж ахуйн тэжээлийн баазын үндсийг судлан, газар зүйн байршил, бүс бүслүүржилтийн илрэл, хөрс цаг уурын хүчин зүйлсээс хамааран бэлчээрийн экосистемийн төрөл, түүний ургац, даац харилцан адилгүй болохыг илрүүлжээ.

С.Золзаяа (2010) Уулын хээрийн бэлчээрийн ургац 6-р сард хялганат бэлчээрт 6.5, хазаар өвст бэлчээрт 5.9, хиагт бэлчээрт 6.9, өвөлжөө орчмын хиагт бэлчээрт 10.9, уулын хээрийн улалжит бэлчээрт 6.2, нугын улалжит бэлчээрт 13.1, агьт бэлчээрт 10.8, 8-р сард хялганат бэлчээрт 11.8, хазаар өвст бэлчээрт 9.3, хиагт бэлчээрт 13.5, өвөлжөө орчмын хиагт бэлчээрт 21.7, уулын хээрийн улалжит бэлчээрт 11, нугын улалжит бэлчээрт 13.6, агьт бэлчээрт 14.6 ц/га байна гэжээ.

А. Отгонжаргал (2012) Үетэн-алаг өвст бэлчээрийн ургацын судалгаа хийсэн 2 жилийн дунджаар 5-р сард 3.46 ц/га, 8-р сард 8.62 ц/га, 10-р сард 5.9 ц/га, 01-р сард 4.2 ц/га, 4-р сард 3.45 ц/га, хиагт бэлчээрийн ургамлын ургац 5-р сард 3.09 ц/га, 8-р сард 7.63 ц/га, 10-р сард 5.16 ц/га, 01-р сард 3.7 ц/га, 4-р сард 2.4 ц/га болж өөрчлөгдсөнөөр тэдгээрийн зуны дээд ургацыг 100 хувь гэвэл намар 73-75, өвөл 51-52, хавар 42 орчим хувь нь бэлчээрт хадгалагдан үлдэж байна гэжээ.

Д.Гүрбазар (2016) Өвөрхангай аймгийн Өлзийт сумын зонхилох бэлчээр болох уулын хээр, уулс хоорондын хөндийн үетэн-алаг өвст бэлчээрт судалгаа хийсэн уулын хээрийн үетэн-алаг өвст бэлчээр зун наймдугаар сард 45 хувийн ургамлын бүрхэцтэй, уулс хоорондын хөндийн үетэн-алаг өвст бэлчээр 60 хувийн бүрхэцтэй байжээ. Уулын хээрийн бэлчээрт *Stipa Krylovii* Roshev., *Agropyron cristatum* (L.) P.B., *Cleistogenes squarrosa* (Trin.) арвиар зонхилж, *Arenaria capillaris* Poir., *Artemisia frigida* Willd., *Saussurea salicifolia* (L.) DC, *Sibbaldianthe adpressa* (Bge.) Juz., *Carex duriuscula* C.A. Mey дэд зонхилогчийн үүрэг гүйцэтгэж, уулс хоорондын хөндийн бэлчээрт *Stipa Krylovii* Roshev., *Agropyron cristatum* (L.) P.B., *Cleistogenes squarrosa* (Trin.) *Elymus chinensis* (Trin.) Keng арвиар зонхилж, *Arenaria capillaris* Poir., *Artemisia Adamsii* Bess., *Potentilla strigosa* Pall.ex Pursh, *Chenopodium album* L., *Carex duriuscula* C.A. Mey, *Allium anisopodium* Ldb дэд зонхилогчийн үүрэг гүйцэтгэж байна. Уулын хээрийн үетэн-алаг өвст бэлчээрийн зуны дээд ургац 867 кг, уулс хоорондын хөндийн үетэн-алаг өвст бэлчээрийнх 743 кг ургацтай байна.

Д.Гүрбазар (2016) хөл газрын зарим зүйл ургамал болох лууль, шарилж, халгай зэргийг хөгжлийн үе шатны дагуу химийн найрлага, шимт чанарыг судлан тодорхойлоход олслиг халгайн нэг бутны ургац дунджаар 4.2-5.6 кг, луулийн нэг ам.метрийн дундаж ургац 6.4-7 кг байв.

5.БАГСАРМАЛ ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ ТОЙМ

Д.Цэдэв (1960) багсармал тэжээлийн түүхий эдийн нөөц, төрлийн талаар судалгаа явуулж, эх орны түүхий эдийг ашиглан багсармал, холимог тэжээл бэлтгэх анхны үйлдвэрийг 1968 онд Өвөрхангай аймгийн Хархорины сангийн аж ахуйн гурилын үйлдвэрийг түшиглэн байгуулж шинжлэх ухаан үйлдвэрлэлийн туршилтаар хивэг 25-40, арвай, хошуу будаа 8-30, вандуй 8-10, сүрэл 32-68, цагаан зэгс 50-69, мах, ясны болон шилмүүсний гурил 2-4, таана 4-8, давс, ясны үнс 1-2 хувиар оролцуулсан холимог багсармал тэжээлийн 53 төрлийн жор боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. Холимог багсармал тэжээл нь жорын бүтцээс

хамаарч органик бодисын шингэц 54.37-75.97, нийт эслэг 8.3-25.8 хувь, ерөнхий шимт чанар 5.14-10.12 мДж солбилцлын энергитэй, 44-117 г шингэх протеинтой байна.

А.Брост (1970) үр тарианы холимгийг янз бүрийн харьцаатайгаар бэлтгэж, бордооны туршилт хийсэн дүнгээс үзэхэд арвай 50, хошуу будаа 25, буудай 25 хувиар оруулсан жорын протеин 14 хувь, арвай 45, хошуу будаа 35, хивэг 20 хувиар оруулсан жорынх 12.4 хувь, арвай 60, хошуу будаа 35, шар буурцгийн шимэлдэг 5 хувиар оруулсан жорынх 12.7 хувь, арвай 40, хошуу будаа 60 хувиар оруулсан жорынх 12 хувь, хошуу будаа 65 хивэг 25, шар буурцгийн шимэлдэг 10 хувиар оруулсан жорынх 12.5 хувь байсан бөгөөд 30-40 хувийн уурагтай, эслэг багатай тэжээл болсон гэжээ.

Ц.Отгоо (1972) холимог багсармал тэжээлийн бүтцэд өвс 20-40, сүрэл 20-50, таримал өвс 40-50, шимт ургамлын өвс 13-30, харгана 40, модны навч 30-50, үр тариа 23-48, лай 30-48, амьтны гаралтай тэжээл, таанын зоодой, таанын өвс зэргийг тус бүр 10, давс шүү 2 хувиар оролцуулсан холимог багсармал тэжээлийн ерөнхий шимт чанар 5.72-6.93 мДж солбилцлын энергитэй, 55-70 г шингэх протеин агуулж байна гэжээ.

Д.Асүрэн, Ч.Санчир (1980) нар төрөл бүрийн харганатай ногоон өвсийг багсармал тэжээлийн найрлаганд 40-70 хувиар, үр тариа 23-30 хувиар, таана, шаваг бударгана, халтар хомоолыг 5-16 хувиар тус тус оруулахад шимт чанар нь 0.69-0.70 тэжээлийн нэгж, 60-75 г шингэх протеинтэй байжээ.

Д.Асүрэн говийн аймгуудад тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор эгэл нишингийг холимог багсармал тэжээлийн найрлагад 50-68 хувьд нь оруулан туршихад нийт протеин 6.63- 9.68 хувь, нийт эслэг 14.7-23.43 хувь болсон байна.

Х.Гэндарам, Н.Тогтохбаяр нар улиасны навч 50-60, халгай 10-38.5, буудайн хивэг 10-20, гурил, үр тариа 8-20, сүрэл 30-50, аммонийжуулсан сүрэл, хомоол 20, хужир, цемент 2-11.5 хувиар тус тус оруулсан багсармал тэжээлийн жор боловсруулжээ. Холимог багсармал тэжээл нь жорын бүтцээс хамааран 2.84-10.66 мДж солбилцлын энергитэй, 9.46-18.93 хувийн нийт эслэг, 10.38-13.99 хувийн нийт протеин тус тус агуулагдаж байжээ.

Д.Ринчиндорж, Д.Бямбасайхан (2004) нар улсын фондод бэлтгэгдсэн багсармал тэжээлийн химийн найрлагыг тодорхойлоход нийт протеин 10.54-19.24, нийт тослог 1.59-4.54, нийт эслэг 4.85-8.45, АХБ 62.23-73.08, нийт үнс 3.55-8.77 хувь, органик бодисын шингэц 82.66-85.83 хувь, тэжээлийн ерөнхий шимт чанар 11.91-12.84 мДж солбилцлын энергитэй байжээ

Д.Гүрбазар (2016) хөл газрын зарим зүйл ургамал болох лууль, шарилж, халгай зэргийг ургамлын хөгжлийн үе шатны дагуу химийн найрлага шимт чанарыг судлан түүхий эд бэлтгэх зохистой хугацааг тодорхойлон багсармал тэжээлийн жор боловсруулан туршиж, хөл газрын ургамлаар багсармал тэжээл бэлтгэх технологийг боловсруулсан байна. Судалгааны дүнгээс үзэхэд багсармал тэжээлийн ерөнхий шимт чанар 8.81-9.11 мДж солбилцлын энергитэй, нийт протеин 14.6-16.1, нийт эслэг 11.65-12.8 хувь тус тус байжээ. Түүнчлэн орон нутагт олдоц ихтэй хөл газрын зарим зүйл ургамлаар багсармал тэжээл бэлтгэхэд гарах зардлыг тооцож тэжээл бэлтгэлийн зардлыг 20-40 хувиар бууруулах боломжтойг тогтоожээ.

Ж.Рэнцэнханд (2017) өндөглөгч тахианд зориулсан багсармал тэжээлийн жорд улаанбуудай 40, буудайн хивэг 15, царгас 5, арвай 25, вандуй 7.5, мах ясны гурил 7.45, премикс 0.05 хувь оролцуулан туршихад түүний 100 гр-д 1.2 мДж солбилцлын энерги, 15.6 гр нийт протеин, 4.7 гр нийт эслэг, 0.5 гр лизин, 0.4 г метионин+цистин, 4.2 г кальц, 1.1 гр фосфор агуулагдаж байна. Иймээс багсармал тэжээлийг цеолит, глицерин, дрожжор баяжуулснаар өндөглөгч тахианы тэжээлийн үнийг 1 кг тутамд 34.1-109.2, 10 өндгөнд оногдох тэжээлийн зардлыг 23.32-555.52 төгрөгөөр бууруулах боломжтой бол тэдгээрийг жорын 12 хувьд хослуулан оролцуулахад 1 кг тэжээлийн үнийг 210-219, 10 өндгөнд оногдох тэжээлийн зардлыг 575.96-735.97 төгрөгөөр

бууруулж байгаа тул орон нутгийн олдоц ихтэй түүхий эдийг ашиглан өндөглөгч тахианы тэжээлийн жорыг цеолит, глицерин, дрожжор баяжуулж, чанар сайтай, үнэ хямдтай тэжээлийг эх орондоо үйлдвэрлэх нь зүйтэй байна гэжээ.

А.Эрдэнэчимэг (2021) Монгол үхэрт зориулсан багсармал тэжээлийн жор боловсруулж тэдгээрийг орон нутгийн гаралтай эрдэс түүхий эд болох цеолит болон глицеринээр баяжуулан малын бие махбодод үзүүлэх нөлөө, махан ашиг шимийн зарим үзүүлэлтийг тодорхойлох туршилт явуулжээ. Судалгааны дүнгээс үзэхэд хүчит багсармал тэжээлийг байгалийн цеолит 2%-аар баяжуулахад нийт үнс 4.5%-аар нэмэгдэж, нийт эслэг 1.2%-аар буурч байгаа бол цеолит 2%+глицерин 6%-ийн холимгоор баяжуулахад нийт үнс 2.7%-аар нэмэгдэж, нийт эслэг 1.3%-аар буурч, органик бодисын шингэц 3.7%-аар нэмэгдэж, ерөнхий шимт чанар 1 мДж солбилцлын энергиэр илүү болж байжээ.

Хүчит багсармал тэжээлийг цеолитоор баяжуулахад үндсэн жороос хоногийн нэмэгдэл жин 184 гр-аар нэмэгдэж, 1 кг нэмэгдэл жинд зарцуулах тэжээл 32.2%-аар буурч байгаа бол цеолит, глицеринийг тодорхой хувиар баяжуулахад хоногийн нэмэгдэл жин 59.4 гр-аар нэмэгдэж, 1 кг нэмэгдэл жинд зарцуулах тэжээл 20.9 %-аар буурахын зэрэгцээ үхрийн цусанд агуулагдах хүчилтөрөгчийн хэмжээ нэмэгдэж, бодисын солилцооны хэвийн үйл ажиллагааг бүрдүүлж байна гэжээ.

6.ДАРШНЫ СУДАЛГАДСАН БАЙДАЛ

А.М.Михин (1929-1932) гандуу нөхцөлд тэжээлийн ургамал илүү сайн даршлагдаж байгааг ажиглаад, өвсөн дарш [сено-силос буюу сенаж] бэлтгэх онолын үндсийг анх боловсруулжээ. Өвсөн дарш бэлтгэх онолын үндэслэл нь сүүний хүчлийн хэмжээ ч биш, рН-ийн нөхцөл ч биш харин физиологийн хуурай орчин болохыг тогтоожээ.

А.А.Зубрилин (1934) Тэжээлийн ургамлууд нь харилцан адилгүй хэмжээний сахар агуулдаг болохоор тэдгээрийн даршлагдах чадвар мөн тийм байх ёстой. Даршлагдах чадвар нь рН-ийг 4.0-4.2 хүртэл буурахад зайлшгүй шаардагдах сахарын хамгийн бага хэмжээ “сахарын миннимум”-аас хамаардаг болохыг тогтоожээ.

1943-1944 онд Төв аймгийн Сөгнөгөр, Баянголд наранцэцгийн 6 сорт тарьснаас түргэн болцтой Омский, Пионер, Саратов-169 сортууд үрээ, Круглик, Ждановский-8885, Финксинк сортууд 285-320 ц/га ногоон ургац өгч байсныг дурджээ.

С.Дүгэрсүрэн (1976-1980) Төв аймгийн Борнуур суманд байгалийн хадлангийн ногоогоор өвсөн дарш бэлтгэх судалгааг явуулж эдийн засгийн хувьд ач холбогдолгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Тэрээр наранцэцэг+хошуу будаа+вандуй, наранцэцэг+хошуу будаа+арвай+вандуйн холимгийг даршинд хэрэглэхээр сонгон шалгаруулж, тэдгээрийг даршлах технологийн горимыг тогтоож, химийн найрлага, шингэц, шимт чанарыг үнэлэн, саалийн үнээний сүүн ашиг шимд дарш, өвсөн даршны нөлөөллийг судалсан байна.

Д.Ринчиндорж (1986-1990) Төв аймгийн Заамар, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумдад наранцэцэг+хошуу будаа+вандуйн холимог дарш бэлтгэн үхэр бордох ажил явуулсан байна. Тухайн холимог даршны органик бодис 89.26, нийт протеин 8.24, тослог 4.48, эслэг 20.86, АХБ 55.68, үнс 10.74 хувь тус тус байсан ба ерөнхий шимт чанар нь 3.08 мДж солбилцлын энергитэй, 21.29 гр шингэх протеинтэй байна. Эрлийз тугалыг шүүст-хүчит-бүдүүн хэв шинжит жороор өсгөн бойжуулж бордоход хоногийн нэмэгдэл жин хяналтын хэсэгтэй (хүчит-бүдүүн тэжээл) харьцуулахад 5.8-11.0 хувь, энэ үед нэг кг нэмэгдэл жинд зарцуулах тэжээлийн зардлыг 5.4-10.5 хувь багасгаж болохыг тогтоожээ.

Ш.Хашбат (1992) Байран маллагааны үед ашиглаж ирсэн дарш-хүчит-бүдүүн тэжээлийн хэв шинжийн жорыг дарш, манжин-хүчит-бүдүүн тэжээлт жор болгон өөрчилж, азот-эрдсийн нэмэгдлээр баяжуулахад 1 литр сүүнд зарцуулагдах хүчит тэжээл 128-148 гр-аар буурч, жорын шүүслэг чанар дээшлэн шингэц нь сайжрав гэжээ.

С.Дүгэрсүрэн (2000) даршинд зориулан тариалсан наранцэцэг+хошуу будаа+вандуй, наранцэцэг+хошуу будаа+арвай+вандуйн хольц дан наранцэцэгээс илүү дунджаар хуурай бодис 19.3, тэжээлийн нэгж 2.0, шингэх протеин 22.5 хувь илүү байна. Хольцоор бэлтгэсэн сайн чанартай даршны 1 кг 0.18-0.23 тэжээлийн нэгж, 21-28 гр шингэх протеинтэй, 1 тэжээлийн нэгждээ 108-137 гр шингэх протеин ногдож, идэмж дээшлэн 71.1-80.7 хувь байна гэжээ.

Н.Тогтохбаяр, Х.Гэндарам, Э.Уянга нар (2009) судан өвс, төмс, хүнсний ногоо ашиглан 4 хувилбараар жор бүрдүүлж, дарш бэлтгэж туршсан байна. Даршны органик бодис 13.1-29 хувь үүнээс нийт протеин 2.7-4.1, нийт тослог 0.4-0.8, нийт эслэг 2.6-7.5, АХБ 6.1-17.6, нийт үнс 2.6-5.4 хувь тус тус байна. Эндээс судан өвс+байцаа+луувангийн холимог дарш бусад хувилбараас эслэг 0.7-4.9 хувиар их байна гэж дүгнэжээ.

Г.Ононтуул, Б.Баасанжалбуу нар (2011) Төв аймгийн Аргалант суманд хийсэн даршны органик бодисын шингэцийн үзүүлэлт хужиртай даршинд 45.9, давстай даршинд 51.26 хувь, нийт протеин дээрх дарааллаар 2.83, 3.2 хувь, мөн эслэг 3.9, 3.61 хувь тус тус байсан бол ерөнхий шимт чанар хужиртай даршинд 1.73, давстай даршных 1.78 мДж солбилцлын энергитэй байгааг тодорхойлжээ.

Ө.Пүрэвсүрэн, Д.Ринчиндорж, Т.Балдан нар (2012) Төв аймгийн Борнуур сумын Нартын аманд үетэн-алаг өвс, холимог дарш (эрдэнэшиш+арвай+хошуу будаа), улаанбуудай арвайн хольц, улаанбуудайн хивэг бүхий тэжээлээр хар тарлан үүлдрийн үнээг байран маллагааны нөхцөлд тэжээхэд амьдын жин 2.4 хувиар, сүүний гарц 1.32 литрээр буюу даршны нөлөөгөөр 24.26 хувиар нэмэгдсэн байна.

М.Энхжаргал, Д.Ринчиндорж нар (2012) Төв аймгийн Алтанбулагт эрдэнэшиш, хошуу будааг даршилж, химийн найрлага, шимт чанарын үнэлгээг судалжээ. Эрдэнэшишийн даршны чийг 73.8 хувь, нийт протеин 3.24, тослог 0.76, эслэг 6.44, АХБ 12.54, үнс 3.5 хувь, кальци 0.12, фосфор 0.74 хувь, харин хошуу будааны даршинд дээрх дарааллаар 64.5, 6.27, 1.37, 10.9, 12.58, 4.35, 0.26, 1.7 хувь тус тус байна. Органик бодисын шингэц эрдэнэшишийн даршинд 84.43 хувь, 3.15 мДж СоЭ-тэй, хошуу будааны дарш 80.58 хувь, 3.89 мДж солбилцлын энергитэй, эрдэнэшишийн даршны сүүний хүчил 83.3, цуу хүчил 16.7, хошуу будааны даршны сүүний хүчил 68.51, цууны хүчил 31.49 хувь тус тус байна гэжээ.

Монгол оронд даршны ургамлыг тариалах арга, технологи болон түүхий эдийн химийн найрлага, шингэц, шимт чанарыг судалсан дүнгээс үзэхэд шимт чанар нь 1.21-3.89 мДж солбилцлын энергитэй, 21-85 г шингэх протеинтой байв. Гэвч хөл газрын ургамлаар дарш бэлтгэсэн судалгаа туршлага ховор байна.

Иймд орон нутагт арвин, олдоц ихтэй халгай, лууль зэрэг хөл газрын ургамлаар дарш бэлтгэн малын тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх, тэжээлийн өөрийн өртгийг бууруулах чиглэлээр туршилт судалгааны ажил хийх асуудал чухлаар тавигдаж байна.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга тайлан 2020
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны веб сайтын мэдээ <https://www.mofa.gov.mn/exp/>
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн мэдээ
- Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980.10.27
- Үндэсний статистикийн хороо <https://www.1212.mn/>
- Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв <https://www.muz.gov.mn/news/view/60>
- Гаалийн ерөнхий газрын мэдээ <https://www.customs.gov.mn/>
- Өнөөгийн монгол орны ургамлын аймгийн зүйлийн бүрдэл, олон янз байдал, М.Ургамал, О.Энхтуяа, Н.Хэрлэнчимэг, Э.Энхжаргал Ц.Бөхчулуун, Г.Бүрэнбаатар, С.Жавхлан 2016
- Монгол Улсад махны үхрийн чиглэлээр явуулсан судалгааны тойм, Д.Гүрбазар (Ph.D), 2019

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**СУМЫН ТӨВИЙН НЭГДСЭН ХАЛААЛТ, СУРГУУЛЬ,
ДОТУУР БАЙРНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХОЛБОГДОХ БОДЛОГЫН БАРИМТ
БИЧИГ, ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ТАЛААРХ
ТОЙМ МЭДЭЭЛЭЛ**

*Г.Билгээ, П.Уранчимэг, Ц.Ариунаа,
Б.Туул, Б.Мөнгөнсүвд*

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

СУМЫН ТӨВИЙН НЭГДСЭН ХАЛААЛТ, СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХОЛБОГДОХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ТАЛААРХ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

НЭГ. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

1.1.Улсын Их Хурлаас батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийн тойм

1.2.Засгийн газраас батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийн тойм

ХОЁР. СУМДЫН ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1.Сумдын инженерийн хангамжтай холбоотой хэрэгжсэн төслийн тойм

2.2.Сумдын инженер, шугам сүлжээ, нэгдсэн халаалт

2.3.Сумдын ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрны тохижилт

2.4.Улсын тэргүүний сумдад сумын хөгжилтэй холбоотой хэрэгжсэн төсөл

ГУРАВ. ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

3.1.Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2019 оны төсвийн жилд хэрэгжүүлсэн төсөл

3.2.ТИКА-ийн Улаанбаатар дахь Хөтөлбөр зохицуулалтын газар

3.3.Монгол дахь Канад сан

3.4.Бусад төсөл хөтөлбөрүүдийн товч тойм


АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Сумын төвийн нэгдсэн халаалт, сургууль, дотуур байрны асуудлаар УИХ-аас баталсан хөгжлийн бодлогын баримт бичиг

Хавсралт 2. Сумын төвийн нэгдсэн халаалт, сургууль, дотуур байрны асуудлаар Засгийн газраас баталсан хөгжлийн бодлогын баримт бичиг

Хавсралт 3. Сумдын ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрны тохижилтын зарим үзүүлэлт (бүсээр, аймгаар, 2022 он)



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. УИХ-аас батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийн жагсаалт
- Хүснэгт 2. Засгийн газраас батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийн жагсаалт
- Хүснэгт 3. Сумдын хүн амын бүтэц
- Хүснэгт 4. Улсын төсвийн хөрөнгөөр (19 сум)
- Хүснэгт 5. ОУБ-ын төсөл хөтөлбөрөөр (12 сум)
- Хүснэгт 6. Хэрэгжиж буй болон төлөвлөсөн төсөл (16 сум)
- Хүснэгт 7. 2014-2020 онд төсөл хэрэгжсэн 16 сумын ажлын явц
- Хүснэгт 8. 2020-2022 онд төсөл хэрэгжиж буй 5 сумын ажлын явц
- Хүснэгт 9. ЕБС-ийн тоо (бүсээр, нийслэлээр, 2015-2021 он)
- Хүснэгт 10. ЕБС-д өдрөөр суралцагчдын тоо (бүсээр, нийслэлээр, 2015-2021 он)
- Хүснэгт 11. Суралцагчдын дундаж тоо, өссөн хувь (бүсээр, аймгаар, 2015-2021 он)
- Хүснэгт 12. ЕБС-ийн суралцагчдын дундаж тоо бага буюу 600 хүртэл байгаа аймгуудын үзүүлэлт
- Хүснэгт 13. ЕБС-ийн суралцагчдын дундаж тоо их буюу 800-аас дээш байгаа аймгуудын үзүүлэлт
- Хүснэгт 14. Сумдын ЕБС-ийн барилга байгууламжийн насжилт (2022 он)
- Хүснэгт 15. Сумдын ЕБС-ийн хичээлийн байрны тохижилтын зарим үзүүлэлт (бүсээр, аймгаар, 2022 он)
- Хүснэгт 16. Инженерийн шугам сүлжээтэй, халаалттай, эрчим хүчинд болон интернэтэд холбогдсон ЕБС-ийн хичээлийн байрны жагсаалт (бүсээр, аймгаар, 2022 он)
- Хүснэгт 17. Сумдын ЕБС-ийн барилга байгууламжийн насжилт (2022 он)
- Хүснэгт 18. Сумдын ЕБС-ийн дотуур байрны тохижилтын зарим үзүүлэлт (бүсээр, аймгаар, 2022 он)
- Хүснэгт 19. Инженерийн шугам сүлжээтэй, халаалттай, эрчим хүчинд болон интернэтэд холбогдсон ЕБС-ийн дотуур байрны жагсаалт (бүсээр, аймгаар, 2022 он)

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Инженерийн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоо (аймгийн төвийн сумдаас бусад сумдаар)
- Зураг 2. Сумын төвийн инженерийн дэд бүтцийн хангамж (2020 онд)
- Зураг 3. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цомхон цогц төлөвлөлт-нийгэм-эдийн засаг-экологийн хувьд хож-хож-хож загвар
- Зураг 5. Нэгдсэн халаалтын зуухтай сумын тоо
- Зураг 6. Нэгдсэн халаалтын зуухгүй сумын тоо
- Зураг 7. Суралцагчдын дундаж тоо, өссөн хувь (улсын дундаж, 2015-2021 он)

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн хөгжлийн банк
БНПУ	Бүгд Найрамдах Польш Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ЕБЛС	Ерөнхий боловсролын лаборатори сургууль
ЕБЛЦС	Ерөнхий боловсролын лаборатори цогцолбор сургууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕБЦС	Ерөнхий боловсролын цогцолбор сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
КСОНС	Канад сангийн Орон нутгийн санаачилга
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЦ	Хилийн цэрэг
ЦБСЦ	Цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ИТА	Инженер техникийн ажилтан

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Сумын төвийн нэгдсэн халаалт, сургууль, дотуур байрны өнөөгийн байдал, холбогдох бодлогын баримт бичиг, олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн талаарх тойм мэдээлэл”-ийг УИХ-ын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Сумын төвийн нэгдсэн халаалт, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрны тохижилттой холбоотой:

- Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүд;
- хэрэгжсэн улс, орон нутгийн төсөв болон олон улсын төсөл, хөтөлбөрүүд;
- сумдын нэгдсэн халаалтын талаарх өнөөгийн байдал;
- сумдын ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрны өнөөгийн байдлын талаарх мэдээлэл

Хамрах хүрээ: Сумын төвийн нэгдсэн халаалт, ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрны тохижилтын талаарх Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүд, хэрэгжсэн улс, орон нутгийн төсөв болон олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн нээлттэй эх сурвалжийн хүрээнд судалсан.

Судалгааны бүтэц: Судалгаа нь удиртгал, судалгааны хураангуй болон дэлгэрэнгүй хэсэг, ашигласан эх сурвалжийн жагсаалт, хавсралт гэсэн бүтэцтэй.

Судалгааны дэлгэрэнгүй хэсэг нь дараах гурван дэд хэсэгтэй:

- 1) Хөгжлийн бодлогын баримт бичиг хэсэгт Улсын Их Хурал болон Засгийн газраас батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийн тойм мэдээлэл;
- 2) Сумдын инженерийн хангамжийн өнөөгийн байдал хэсэгт сумдын инженерийн хангамжтай холбоотой хэрэгжсэн төслийн тойм, ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрны тохижилт, улсын тэргүүний сумдад сумын хөгжилтэй холбоотой хэрэгжсэн төслийн талаарх тойм мэдээлэл;
- 3) Олон улсын төсөл хөтөлбөр хэсэгт ТИКА-ийн Улаанбаатар дахь Хөтөлбөр зохицуулалтын газар, Монгол дахь Канад сан болон бусад төсөл хөтөлбөрүүдийн товч мэдээлэл зэргийг багтаасан.

Түлхүүр үг: Сум, орон нутаг, бүс нутаг, сумын төвийн тохижилт, дулаан, халаалт, нэгдсэн халаалт, эрчим хүч, боловсрол, ерөнхий боловсролын сургууль, хичээлийн байр, дотуур байр

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Монгол Улс нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 21 аймаг, 333 сум, 9 дүүрэг, 1808 баг, хороонд хуваагдах ба 3.2 сая хүн амтай үүнээс орон нутагт хүн амын 50 орчим хувь нь ажиллаж амьдарч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “...эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байнга буюу түр оршин суух газраа сонгох, сурч боловсрох...” эрхтэй гэж заасан. Мөн хуулийн 19 дүгээр зүйлд “...төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх..., үүргийг иргэнийнхээ өмнө хариуцна” гэж заасан. Энэ хүрээнд төр, засгийн байгууллагаас иргэдийнхээ амьдрах, сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд боловсруулан батлаж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2-т “Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг нь 30 хүртэл жилийн хугацаанд хэрэгжүүлэх “Алсын хараа” байна.” гэж, 6.3-т “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтийн үндэс байна.” гэж тус тус заасан. Иймд дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын хувьд, Монгол Улсын Их Хурлаас гаргасан урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан сумын төвийн халаалт, сургууль, дотуур байрны тохижилтын асуудлыг судлан үзлээ. Судалгааны эх сурвалжийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлтэй Монгол Улсын Их Хурлын 2132 тогтоолоос шүүн бэлтгэв. Урт хугацааны 4 хөгжлийн бодлогын баримт бичиг, дунд хугацааны 17 хөгжлийн бодлогын баримт бичигт сумын төвийн халаалт, сургууль, дотуур байрны асуудлыг тусган хэрэгжүүлж байна. Эдгээр баримт бичгүүдийн зарим нь одоо хүчингүй (урт хугацааны 3, дунд хугацааны 6 хөгжлийн бодлогын баримт бичиг хүчингүй) болсон ч судалгаанд хамруулсан шалтгаан нь тухайн бодлогын баримт бичгүүдийг дахин шинэчлэн боловсруулж баталж байсан, мөн тэр цаг үедээ эдгээр асуудлыг хэрхэн тусган хэрэгжүүлж байсан талаарх мэдээллийг авахад чухал ач холбогдолтой гэж үзсэн болно.

УИХ-аас богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г (1992-2020 хүртэл Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, 2021 оноос Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө нэртэй болсон) баталж байна. Тус бодлогын баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичиг юм.

Хүснэгт 1. УИХ-аас батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийн жагсаалт²⁰³

(Хүснэгтэд хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг сүүлд батлагдсан он дарааллаар байрлуулав)

Урт хугацааны (30 хүртэл жил)		Дунд хугацааны (10 хүртэл жил)	
Батлагдсан огноо, дугаар	Баримт бичгийн нэр	Батлагдсан огноо, дугаар	Баримт бичгийн нэр
Улсын Их Хурлын тогтоол			
Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн	Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол	Шинэ сэргэлтийн бодлого

²⁰³ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15403>

	бодлого		
Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 ХҮЧИНГҮЙ	Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоол	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоол	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого ХҮЧИНГҮЙ	Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоол	Эдийн засгийг сэргээх хөтөлбөр
Улсын Их Хурлын 1996 оны 26 дугаар тогтоол	Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал ХҮЧИНГҮЙ	Улсын Их Хурлын 2015 оны 63 дугаар тогтоол	Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого /2015-2030/ ХҮЧИНГҮЙ
		Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоол	"Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр
		Улсын Их Хурлын 2007 оны 10 дугаар тогтоол	Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр ХҮЧИНГҮЙ
		Улсын Их Хурлаас 2005 оны 32 дугаар тогтоол	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр ХҮЧИНГҮЙ
		Улсын Их Хурлаас 2005 оны 25 дугаар тогтоол	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт ХҮЧИНГҮЙ
		Улсын Их Хурлаас 2003 оны 24 дүгээр тогтоол	Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги
		Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоол	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал
		1996/61 тогтоол 2000/33 тогтоол 2004/24 тогтоол 2008/35 тогтоол 2012/37 тогтоол 2016/45 тогтоол 2020/45 тогтоол	ЗГҮАХ 1996-2000 ЗГҮАХ 2000-2004 ЗГҮАХ 2004-2008 ЗГҮАХ 2008-2012 ЗГҮАХ 2012-2016 ЗГҮАХ 2016-2020 ЗГҮАХ 2020-2024

Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хувьд, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем цахим хуудсанд байршуулсан 4922 тогтоол²⁰⁴-оос шүүлт хийж, Шинэ сум, Сумын төвийн шинэчлэл, сумын төвийн нэгдсэн халаалт, сургууль, дотуур байрны тохижилт зэрэгтэй холбоотой дараах зургаан тогтоолыг сонгон авч харьцуулан үзлээ. Үүнд:

- 1) Удирдлагын шуурхай байдлыг хангах, үйл ажиллагаагаа бие дааж явуулах боломжийг бүрдүүлэх үүднээс аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн харьяалалд байсан төрийн болон төрийн өмчийн оролцоотой сумдын дизелийн цахилгаан станц, халаалтын зуухнуудыг 1996 оны 01 дүгээр сарын 01-ээс сумын Засаг даргын Тамгын газрын мэдэлд шилжүүлэх зорилгоор **“Сумдын дизелийн цахилгаан станц, халаалтын зуухнуудын тухай”** Засгийн газрын 1995 оны 236 дугаар тогтоолыг баталсан.
- 2) "Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолын 2.1-д заасныг үндэслэн **“Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай”** Засгийн газрын 2012 оны 120 дугаар

²⁰⁴ Засгийн газрын тогтоолууд,
<https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=33&active=1&page=1&sort=enacteddate&page=1>

- тогтоолыг баталсан. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хугацаанд нь шуурхай хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллан, хэрэгжилтийн явцад жил бүрийн 6, 12 дугаар сарын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна.
- 3) Улсын Их Хурлын 2012 оны 60 дугаар тогтоол, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор **“Сумдын хөгжлийн загвар болон түүнд хамаарах нэг маягийн загвар зургийн жагсаалт батлах тухай”** Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол баталсан. Нэг маягийн загвар зургийн даалгаврыг гаргах, зураг боловсруулах компанийг нэгдсэн байдлаар сонгон шалгаруулах ажлыг 2013 оны 7 дугаар сард зохион байгуулж, зураг боловсруулах зардлыг "Улсын хэмжээнд 2014-2015 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах" зардлаас гаргасан байна.
- 4) Монгол Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 72 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төв, суурин газрын дулаан хангамжийг сайжруулах зорилтыг богино хугацаанд шийдвэрлэх, төрийн хөрөнгө оруулалтыг багасгах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор **“Зарим аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийг эрчимжүүлэх тухай”** Засгийн газрын 2014 оны 29 дүгээр тогтоолыг баталсан.
- 5) Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор **“Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийх ажлын жагсаалтыг шинэчлэн батлах тухай”** Засгийн газрын 2015 оны 265 дугаар тогтоолыг баталсан. Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийх ажлын технологийн шийдэл, гүйцэтгэлийн явц, чанар байдал, үр дүн, хөрөнгийн зарцуулалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд болон холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна. Мөн энэ тогтоол гарсантай холбогдуулан **“Сумын төвийн шинэчлэл”** төслийн хүрээнд хийгдэх ажлын жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 309 дүгээр тогтоолыг хүчингүй болсон юм.
- 6) Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6.2.7.2-т заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор **“Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж төсөл, арга хэмжээг батлах тухай”** Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолыг баталсан. Энэ тогтоолын хавсралтаар баталсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсөв, гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Сангийн сайдад, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайд нарт тус тус даалгасан байна. "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээний хүрээнд сумдын Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт даалгажээ.

*Хүснэгт 2. Засгийн газраас батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийн жагсаалт*²⁰⁵

(Хүснэгтэд хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг сүүлд батлагдсан он дарааллаар байрлуулав)

Дунд хугацааны (10 хүртэл жил)		Богино хугацааны (1 жил)	
Батлагдсан огноо, дугаар	Баримт бичгийн нэр	Батлагдсан огноо, дугаар	Баримт бичгийн нэр
Засгийн газрын тогтоол			
Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоол	Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай	Засгийн газрын 1995 оны 236 дугаар тогтоол	Сумдын дизелийн цахилгаан станц, халаалтын зуухнуудын тухай
Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол	Сумдын хөгжлийн загвар болон түүнд хамаарах нэг маягийн загвар зургийн жагсаалт батлах тухай		
Засгийн газрын 2014 оны 29 дүгээр тогтоол	Зарим аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийг эрчимжүүлэх тухай		
Засгийн газрын 2015 оны 265 дугаар тогтоол	Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийх ажлын жагсаалтыг шинэчлэн батлах тухай		
Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоол	Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж төсөл, арга хэмжээг батлах тухай		

Сумдын инженерийн хангамжтай холбоотой хэрэгжсэн төслийн хувьд, 2020 оны байдлаар иж бүрэн инженерийн шугам сүлжээнд холбогдсон 70 сум байгаа бөгөөд төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг 11.267 өрх бүртгэлтэй байна.

Улсын төсвөөр 19 суманд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн санхүүжилтээр 12 суманд, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилтээр 16 суманд, нийт 30 суманд инженерийн шугам сүлжээг сайжруулах төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна. Эдгээр төсөл, арга хэмжээний хүрээнд сумын цэвэрлэх байгууламж, усан хангамж, халаалтын зуух, халуун усны шугамыг хэсэгчлэн, эсхүл иж бүрэн байдлаар шийдсэн байна.

Засгийн газрын тогтоолоор батлагдсан “**Сумын төвийн шинэчлэл**” төсөл 2014-2016 онд 16 суманд, 2020-2022 онд 5 суманд хэрэгжиж байна. Эдгээр 17 аймгийн 21 суманд инженерийн шугам сүлжээ шинэчлэх, шинээр барих, цэвэрлэх байгууламж, усан сан, гүний худаг, авто зам барих ажлууд хийгдсэн байна.

Дээрх 16 суманд хэрэгжсэн “Сумын төвийн шинэчлэл” төслийн давуу тал нь:²⁰⁶

- төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсоноор орон нутгийн иргэдийн амьдрах нөхцөл боломж сайжирсан;
- төсвийн байгууллага, айл өрхийг хангахаас гадна орон нутагт жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх үүднээс үйлдвэрлэл үйлчилгээний гудамж бий болгож, тэр дагуух бизнесийн байгууллагуудыг холбох хэрэгтэй.

²⁰⁵ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15403>

²⁰⁶ Барилгын хөгжлийн төв Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл 2020 он

Дутагдалтай тал нь:

- байршлаа оновчтой сонгоогүй, жижиг сумдыг сонгосон;
- инженер-геологийн онцлог нөхцөлийг сайн харгалзаагүй;
- дулаан, цэвэр, бохир ус хэрэглэх үнэ тариф шийдэгдээгүй;
- тухайн орон нутгийн хэрэглэгчид тохируулсан хүчин чадал, технологитой цэвэрлэх байгууламжийг сонгох;
- цэвэрлэх байгууламжийг ашиглалт хариуцах инженер, техникийн ажилтан (ИТА)-ыг орон нутагт бэлтгээгүй, боловсон хүчин дутмаг;
- орон нутгийн саналыг авч зургийн даалгаварт эхний ээлжинд шаардлагатай ажлуудыг тусгаагүй;
- түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй, зураг төсөлгүйгээр ажил эхлүүлсэн;
- сумын төвийн ерөнхий төлөвлөгөө болон одоо байгаа байршлаар төрийн байгууллагууд болон айл өрхүүд хоорондоо харьцангуй алс хол байршилтай.

Засгийн газар **“Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж”** төслийг 2021 оны 6 дугаар сараас эхлүүлэн хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд Монгол Улсын 19 аймгийн 59 сумдад инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг шинэчлэх, шинээр барих, сумын иргэдэд нийтийн аж ахуйн үйлчилгээг иж бүрнээр хүргэх, тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой юм.

2022 оны байдлаар нийт 219 сумыг нэгдсэн халаалтад шилжүүлсэн боловч нэгдсэн халаалтад шилжээгүй буюу объектын галлагаатай²⁰⁷ 97 сум үлдсэн байна. Тодруулбал, 12 аймгийн 150 сум нэгдсэн халаалтад шилжсэн байна. Үүнээс Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Увс зэрэг 6 аймаг нэгдсэн халаалтын зуухыг бүрэн шийдсэн байна. Мөн Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Төв, Ховд, Хэнтий зэрэг 6 аймгийн ихэнх сумд нэгдсэн халаалтын зуухаар хангагдаад байна. Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Хөвсгөл зэрэг 5 аймагт сумдыг нэгдсэн халаалтад шилжүүлэх ажлын хэрэгжилтийг харвал тухайн аймгуудын газар зүйн байршил, аймгийн төвөөс сумдад хүрэх хүчин чадал тодорхой нөлөө үзүүлдэг байна.

Сумдын ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрны тохижилтын хувьд, Суралцагчдын сурч боловсрох эрхийн баталгааг хангах, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч байгаа хэдий ч хүн амын хурдацтай өсөлт, шилжилт хөдөлгөөн, барилгын насжилт өндөр, ашиглалтын хугацаа дууссан зэрэг шалтгаанаас үүдэн сургуулийн суудлыг нэмэгдүүлэх хэрэгцээ улам бүр өсөж байгаа аж. ЕБС-ийн суралцагчдын тоо 2024 онд 800 мянга, 2030 онд 900 мянга болж өсөх төлөвтэй байна.²⁰⁸

Монгол Улсад 2021 оны байдлаар ерөнхий боловсролын нийт **848 сургууль**²⁰⁹ үйл ажиллагаа явуулж байгаагийн 34 хувь нь нийслэлд, 21 хувь нь хангайн бүсэд, 19 хувь нь төвийн бүсэд, 18 хувь нь баруун бүсэд, 8 хувь нь зүүн бүсэд тус тус байрлаж байна.

Өдрөөр **712353 суралцагч**²¹⁰ сурч байгаагийн 48 хувь нь нийслэлийн, 17 хувь нь хангайн бүсийн, 15 хувь нь төвийн бүсийн, 13 хувь нь баруун бүсийн, 7 хувь нь зүүн бүсийн ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-уудад тус тус суралцаж байна.

Эндээс харахад 2021 оны ЕБС болон суралцагчдын тоог 2015 оныхтой харьцуулахад ЕБС-ийн тоо 10 хувиар өссөн байхад өдрөөр сурч байгаа суралцагчдын тоо **33 хувиар** өсөж, улсын хэмжээнд ЕБС-уудын ачаалал, нягтрал нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

²⁰⁷ Объектын галлагаа гэдэг нь тухайн байгууламжийг зуухаар галлахыг хэлнэ.

²⁰⁸ УИХ-ын намрын ээлжит чуулганы 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн хийсэн мэдээллээс. Эх сурвалж: www.parliament.mn

²⁰⁹ Үндэсний статистикийн хороо. <https://www.1212.mn>

²¹⁰ Үндэсний статистикийн хороо. <https://www.1212.mn>

Улсын хэмжээнд ЕБС-д сурч байгаа суралцагчдын дундаж тоог авч үзвэл, 2015 онд дунджаар 594 суралцагч оногдож байжээ. Энэ тоо жил бүр тогтмол 1.0-5.2 хувиар өссөөр 2021 онд 697 (нийт 17.3 хувь) болж нэмэгдсэн байна.

Хүн амын хурдацтай өсөлт, шилжилт хөдөлгөөн зэрэг шалтгаанаас үүдэн сургуулиудын ачаалал, нягтрал харилцан адилгүй байна. Тухайлбал, ЕБС-д суралцаж байгаа суралцагчдын дундаж тоог бүсээр нь авч үзвэл, 2021 онд баруун бүсэд хамгийн бага буюу дунджаар 588 суралцагч, зүүн бүсэд 686, төвийн бүсэд 669, хангайн бүсэд хамгийн их буюу дунджаар 707 суралцагч тус тус оногдож байна.

8 аймагт ЕБС-ийн суралцагчдын дундаж тоо бага буюу 600 хүртэл байна. Үүнд: Говь-Алтай (422), Дундговь (452), Булган (513), Завхан (526), Баянхонгор (560), Баян-Өлгий (577), Төв (580), Архангай (595) зэрэг аймгууд байна.

6 аймагт ЕБС-ийн суралцагчдын дундаж тоо их буюу 800-аас дээш байна. Үүнд: Орхон (942), Дархан-Уул (940), Хөвсгөл (849), Сүхбаатар (837), Ховд (822), Говьсүмбэр (818) зэрэг аймгууд байна.

Сургуулийн барилга байгууламжийн насжилтыг авч үзвэл, 2022 онд сумдын бүх өмчийн 2584 сургуулийн²¹¹ ашиглаж байгаа нийт 1448 барилга байгууламжийн 42 хувь нь 29 хүртэлх жилийн, 48 хувь нь 30-49 жилийн, 10 хувь нь 50-аас дээш жилийн насжилттай байна.

Сумдын ЕБС-ийн нийт **604 хичээлийн байрны** 82.1 хувь нь стандартад нийцсэн, 23.0 хувь нь инженерийн шугам сүлжээтэй, 77.5 хувь нь халаалттай, 75.5 хувь нь эрчим хүчинд, 50.0 хувь нь интернэтэд тус тус холбогдсон байна. Харин 20.4 хувь нь инженерийн шугам сүлжээ, халаалт, эрчим хүч болон интернэтийн асуудлаа бүрэн шийдсэн байна.

Нийт **409 дотуур байрны** 88.5 хувь нь стандартад нийцсэн, 9.0 хувь нь инженерийн шугам сүлжээтэй, 76.8 хувь нь халаалттай, 65.3 хувь нь эрчим хүчинд, 14.2 хувь нь интернэтэд тус тус холбогдсон байна. Харин 7.6 хувь нь инженерийн шугам сүлжээ, халаалт, эрчим хүч болон интернэтийн асуудлаа бүрэн шийдсэн байна.

Олон улсын төсөл хөтөлбөрийн хувьд, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын байгууллагууд сум, орон нутагт амьдарч байгаа иргэдийг дэд бүтэц хөгжсөн, тохь тухтай орчинд амьдрах, эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагаас 1991-2017 онд нийт 4.38 тэрбум ам.долларын гадаад зээл, 2.62 тэрбум ам.долларын тусламжийг авч ашиглажээ. 2017 онд төсвийн дэмжлэгийн зориулалттай зээлийг оруулаагүй төслийн зээлийн ашиглалт 752.1 тэрбум буюу 309.4 сая ам.доллар байна. 2018 оны төсөвт гадаад төслийн зээлийн ашиглалт 835.9 тэрбум төгрөг, тусламжийн ашиглалт 110.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагаас 2019 онд 1,242.3 тэрбум төгрөгийн зээл, тусламж ашиглахаас 525.7 тэрбум төгрөг буюу 42.3 хувийг Азийн хөгжлийн банк, 254.9 тэрбум төгрөг буюу 20.5 хувийг БНХАУ-ын зээл, тусламж эзэлж байна.

Судалгааны ажилд дараах төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд мэдээллийг бэлтгэлээ. Үүнд:

1. Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2019 оны төсвийн жилд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр;
2. ТИКА-ийн Улаанбаатар дахь Хөтөлбөр зохицуулалтын газраас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр;
3. Монгол дахь Канад сангаас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр болон бусад төсөл.

²¹¹ Үндэсний татистикийн хопоо. https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L20_1&type=tables

Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн төслүүдээс харахад сумдын нэгдсэн халаалт болон сургууль, дотуур байрны тохижилтын ажил (баруун 5 аймаг болон Баянхонгор аймагт цэцэрлэгийн барилга шинээр баригдаж, сургуулийн дотуур байр, анги танхимын тохижилтын ажлууд) түлхүү хийгдсэн байна. Баян-Өлгий, Завхан, Сүхбаатар, Говь-Сүмбэр, Дорнод зэрэг аймгуудад элэгдэж хуучирсан бохир ус цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх, шинээр барих болон хүн амын ундны усны хэрэгцээг хангах төсөл хэрэгжсэн байна.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

СУМЫН ТӨВИЙН НЭГДСЭН ХАЛААЛТ, СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХОЛБОГДОХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ТАЛААРХ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

НЭГ. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

1.1. Улсын Их Хурлаас батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийн тойм

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “...эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байнга буюу түр оршин суух газраа сонгох, сурч боловсрох...” эрхтэй гэж заасан. Мөн хуулийн 19 дүгээр зүйлд “...төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх..., үүргийг иргэнийнхээ өмнө хариуцна” гэж заасан. Энэ хүрээнд төр засгаас иргэдийнхээ амьдрах, сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд боловсруулан батлаж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улсын Их Хурал (УИХ)-аас гаргасан урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан сумын төвийн халаалт, сургууль, дотуур байрны тохижилтын асуудлыг энд судлан үзлээ. Судалгааны эх сурвалжийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршсан УИХ-ын нийт 2132 тогтоолоос шүүн бэлтгэв.

Сумын төвийн халаалт, сургууль, дотуур байрны асуудлыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4, дунд хугацааны хөгжлийн бодлогын 17 баримт бичигт туссан байна. Эдгээр баримт бичгүүдийн зарим нь одоо хүчингүй (урт хугацааны 3, дунд хугацааны 6 хөгжлийн бодлогын баримт бичиг хүчингүй) болсон ч гэсэн судалгаанд хамруулсан шалтгаан нь тухайн бодлогын баримт бичгүүдийг дахин шинэчлэн баталсан, мөн тэр цаг үедээ эдгээр асуудлыг хэрхэн тусган хэрэгжүүлж байсан талаарх мэдээллийг авахад чухал ач холбогдолтой гэж үзсэн болно.

2020 онд батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2-т “Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг нь 30 хүртэл жилийн хугацаанд хэрэгжүүлэх “Алсын хараа” байна” гэж, 6.3-т “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтийн үндэс байна.” гэж тус тус заасан. Иймд дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдаг.

2020 оноос өмнө батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгүүд

УИХ-ын 1996 оны 26 дугаар тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан.

Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх арга замыг эдийн засаг, нийгмийн хөгжлийн дунд хугацааны болон жил, жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нарийвчлан тусгасан байх шаардлагатай гэсэн байна. Мөн энэхүү баримт бичиг нь “ойрын ирээдүйд улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг

бататган бэхжүүлэх, хүний чөлөөт хөгжил, нийгмийн дэвшлийг хангах талаар төрөөс баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон баримт бичиг юм”.

Иймээс уг хөгжлийн баримт бичиг нь 1996-2016 оны хооронд хүчин төгөлдөр үйлчилж, бусад дунд болон богино хугацааны хөгжлийн баримт бичгүүдийн үндэс суурь нь болж байсан.

Тус үзэл баримтлалд зөвхөн “Эдийн засгийн хөгжлийн стратеги”-ийг 3 үе шаттайгаар (**I үе шат** (1996-2000), **II үе шат** (2001-2010), **III үе шат** (2010-2020)) хэрэгжүүлэхээр тусгасан.

Үүний зэрэгцээ УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор “*Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого*” (цаашид “Үндэсний хөгжлийн цогц бодлого”) батлагдсан.

Үндэсний хөгжлийн цогц бодлогод хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм дэх монгол хүний хөгжлийг хангах, тус улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологи, соёл иргэншлийг эрчимтэй хөгжүүлэхэд чиглэсэн ирэх 14 жилийн бодлогыг дэлхий нийт, бүс нутгийн хөгжилтэй нягт уялдуулан цогцоор тодорхойлсон байна.

Үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилт нь “хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлт, монгол хүний хөгжил, түүний дотор боловсрол, эрүүл мэнд, түүнчлэн шинжлэх ухаан, технологи, байгаль орчны тогтвортой хөгжлийг тэргүүлэх чиглэл болгож, хүнийг оюунжуулж, чадваржуулах замаар Мянганы хөгжлийн зорилтын биелэлтийг хангах, өндөр технологи, байгаль орчинд халгүй үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэмлэн өсөлтөө хангадаг мэдлэгт суурилсан эдийн засагтай болох, иргэддээ үйлчилдэг, хүний эрх, эрх чөлөөг хангадаг, авлига, хүнд суртлаас ангид ардчилсан төрийн тогтолцоог төлөвшүүлэх замаар Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлж, дундаж хөгжилтэй улс болгоход оршино” гэжээ.

Үндэсний хөгжлийн цогц бодлогод Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүнг 2007-2015 онд Мянганы хөгжлийн зорилтыг хангах, эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх, 2016-2021 онд мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих хоёр үе шаттай авч үзсэн байна.

УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “*Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030*” бодлогын баримт бичиг батлагдсанаар дээрх хоёр бодлогын баримт бичиг хэрэгжилтийн явцдаа хүчингүй болсон.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган үе шаттайгаар хэрэгжүүлэх үүргийг Монгол Улсын Ерөнхий сайдад үүрэг болгосон байна.

Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно гэж тодорхойлсон байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийг 3 үе шаттайгаар (**I үе шат (2016-2020)**, **II үе шат (2021-2025)**, **III үе шат (2026-2030)**) хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2020 оноос өмнө батлагдаж байсан урт хугацааны бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтыг дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдийн суурь үзүүлэлт, үндсэн чиглэл болгон тусгаж, үе шаттайгаар хэрэгжүүлж байсан.

2020 оноос хойш батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгүүд

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдөр УИХ-аас баталсан. Энэ хуулийн зорилт нь “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд оршино.” гэж заасан.

Иймээс 2020 оноос хойш батлагдсан урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бусад баримт бичгүүдийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, батлаад байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг батлагдсан. Тус бодлогын баримт бичгийн “Хүний хөгжил” хэсгийн Зорилго 2-т “Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ.” гэж, “Эдийн засаг” хэсгийн Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан эдгээр зорилго, зорилтод нийцсэн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүд батлагдан мөрдөгдөж байна. Тухайлбал: Дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор, “Засгийн газрын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр”-ийг УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор тус тус баталсан.

Эдгээр дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтыг нарийвчлан тусган хэрэгжүүлж байна.

УИХ-аас баталсан хөгжлийн бодлогын баримт бичгийг Хавсралт 1-т үзүүлэв.

1.2.Засгийн газраас батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийн тойм

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем цахим хуудсанд байршуулсан Засгийн газраас баталсан 4922 тогтоолоос²¹² шүүлт хийж, сумын төвийн нэгдсэн халаалт, ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрны тохижилттой холбоотой дараах зургаан тогтоолыг сонгон авч харьцуулан үзлээ. Үүнд:

1) Удирдлагын шуурхай байдлыг хангах, үйл ажиллагаагаа бие дааж явуулах боломжийг бүрдүүлэх үүднээс аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн харьяалалд байсан төрийн болон төрийн өмчийн оролцоотой сумдын дизелийн цахилгаан станц,

²¹² Засгийн газрын тогтоолууд,

<https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=33&active=1&page=1&sort=enacteddate&page=1>

халаалтын зуухнуудыг 1996 оны 01 дүгээр сарын 01-нээс сумын Засаг даргын Тамгын газрын мэдэлд шилжүүлэх зорилгоор “Сумдын дизелийн цахилгаан станц, халаалтын зуухнуудын тухай” Засгийн газрын 1995 оны 236 дугаар тогтоолыг баталсан.

2) “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолын 2.1-д заасныг үндэслэн “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолыг баталсан. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хугацаанд нь шуурхай хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллан, хэрэгжилтийн явцад жил бүрийн 6, 12 дугаар сарын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна.

3) УИХ-ын 2012 оны 60 дугаар тогтоол, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Сумдын хөгжлийн загвар болон түүнд хамаарах нэг маягийн загвар зургийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоолоор баталсан. Уг тогтоол нь дараах хавсралттай:

- “Сумдын хөгжлийн загвар”-ыг 1 дүгээр хавсралт;²¹³
- “Сумдын нийгмийн үйлчилгээний болон үйлдвэрлэл, бизнесийн барилга байгууламжийн нэг маягийн загвар зургийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт;²¹⁴
- “Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх болон нэг дор байрлан үйл ажиллагаа явуулах байгууллагуудын барилга байгууламжийн жагсаалт”-ыг 3 дугаар хавсралт.²¹⁵

Нэг маягийн загвар зургийн даалгаврыг гаргах, зураг боловсруулах компанийг нэгдсэн байдлаар сонгон шалгаруулах ажлыг 2013 оны 7 дугаар сард зохион байгуулж зураг боловсруулах зардлыг “Улсын хэмжээнд 2014-2015 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” зардлаас гаргасан байна.

4) УИХ-ын 2010 оны 72 дугаар тогтоолын 1.5, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7.2-ийг үндэслэн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төв, суурин газрын дулаан хангамжийг сайжруулах зорилтыг богино хугацаанд шийдвэрлэх, төрийн хөрөнгө оруулалтыг багасгах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Зарим аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2014 оны 29 дүгээр тогтоолыг баталсан. Тогтоолын хүрээнд:

- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд тусгагдсан Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Архангай, Дундговь, Хэнтий, Говь-Алтай, Төв, Говьсүмбэр аймгийн төвд шинээр дулааны станц, дулааны шугам барих, сумдын төвлөрсөн дулаан хангамжийн ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулагчийг сонгон шууд гэрээ байгуулан хэрэгжүүлэх;
- аймгийн төвүүдэд шинээр баригдах дулааны станцын зуухны сонголтыг орон нутгийн нүүрсний шинж чанар, онцлогт тохируулан байгальд ээлтэй технологийг сонгон, станцын цаашдын найдвартай ажиллагааг хангах үүргийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээнд тусган хэрэгжүүлэх;
- төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжих дээрх төслүүдийг амжилттай хэрэгжүүлж эхлүүлэх, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд тусгагдсан холбогдох зардлыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээнд тусгасан нөхцөлөөр санхүүжүүлэх;

²¹³ Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=205932&showType=1>

²¹⁴ Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=205934&showType=1>

²¹⁵ Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=205936&showType=1>

- орон нутгийн дулаан хангамжийн системүүдийг үр ашигтай ажиллуулах, тэдгээрийн ашиглалт, засвар үйлчилгээний талаар болон боловсон хүчин, цалин хөлс, үнэ тарифын нэгдсэн бодлогоор хангаж, дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болгосон байна.

5) Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийх ажлын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2015 оны 265 дугаар тогтоолыг баталсан. Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийх ажлын технологийн шийдэл, гүйцэтгэлийн явц, чанар байдал, үр дүн, хөрөнгийн зарцуулалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд болон холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна. Мөн энэ тогтоол гарсантай холбогдуулан “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийгдэх ажлын жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 309 дүгээр тогтоол хүчингүй болсон.

6) Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6.2.7.2-т заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж төсөл, арга хэмжээг батлах тухай” Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолыг баталсан. Энэ тогтоолын хавсралтаар баталсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсөв, гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Сангийн сайдад, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайд нарт тус тус даалгасан байна.

“Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд сумдын Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт даалгажээ.

Жич: Судалгааны явцад нийт 9 тогтоол илэрсэн ба 1 нь хүчингүй болсон байсан бол нөгөө 2 нь захиалагчийн эрэлтээс гадуур харилцааг зохицуулж байсан тул судалгаанд хамруулаагүй болно.

Засгийн газраас баталсан хөгжлийн бодлогын баримт бичгийг Хавсралт 2-т үзүүлэв.



ХОЁР. СУМДЫН ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1. Сумдын инженерийн хангамжтай холбоотой хэрэгжсэн төслийн тойм

Монгол Улс нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 21 аймаг, 333 сум, 9 дүүрэг, 1808 баг, хороонд хуваагдах ба 3.2 сая хүн амтай үүнээс орон нутагт хүн амын 50 орчим хувь нь ажиллаж амьдарч байна.

Хүснэгт 3. Сумдын хүн амын бүтэц

	Суурин хүн амын тоо	Сумын тоо	Нийт сумдын эзлэх хувь
1.	1000 хүртэлх	200	64
2.	1001-2000 хүртэлх	78	25
3.	2001-ээс дээш	31	11

Зураг 1. Инженерийн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоо (аймгийн төвийн сумдаас бусад сумдаар)



Эх сурвалж: YCG

2020 оны байдлаар иж бүрэн инженерийн шугам сүлжээнд холбогдсон 70 сум байгаа бөгөөд төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг 11.267 өрх бүртгэлтэй байна.

Зураг 2. Сумын төвийн инженерийн дэд бүтцийн хангамж (2020 онд)



Барилга хот байгуулалтын яамны 2022 оны тайланд дурдсан сумын төвийн хөгжилтэй холбоотой төслүүдийн явцаас дурдвал:²¹⁶

- 1) 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Сумын төвийн шинэчлэл” төслийг 5 аймгийн 5 сумын төвд хэрэгжүүлэх ажил эхэлсэн байна. Үүнээс:
 - Архангай аймгийн Эрдэнэмандал, Баянхонгор аймгийн Өлзийт, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумдын ажил дуусаж, 2021 онд ашиглалтад оруулсан;

²¹⁶ Барилга хот байгуулалтын яам 2022 он

- Завхан аймгийн Отгон сумын болон Хэнтий аймгийн Батноров сумын төслийн ажлын гүйцэтгэл 75 хувьтай байна.
- 2) 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2 аймгийн 3 сумын төвд хэрэгжүүлэх ажил эхэлсэн байна. Үүнээс:
- Хэнтий аймгийн Галшар, Баянхонгор аймгийн Галуут сум, Эрдэнэцогт сумын ажлын гүйцэтгэл 10-40 хувьтай байна.
- 3) 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8 аймгийн 10 сумын төвд хэрэгжүүлэх ажил эхэлсэн байна. Үүнээс:
- Архангай аймгийн Ихтамир, Баянхонгор аймгийн Баацагаан, Говь-Алтай аймгийн Алтай, Дорнод аймгийн Дашбалбар, Дундговь аймгийн Луус, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Уянга, Хужирт, Төв аймгийн Дэлгэрхаан, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумдын инженерийн дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийг барьж байгуулах ажлын даалгаврыг боловсруулж батлуулан, ажил гүйцэтгүүлэх нээлттэй тендерийг зарлаад байна;
 - дээрх 10 сумдын инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж батлуулан, тендерийг зарлаад байна.
- 4) АХБ-ны техник туслалцааны хүрээнд 2022 онд нэг сая ам.долларын хөрөнгөөр ТЭЗҮ хийгдэхээр шийдвэрлэгдсэн бөгөөд үүний үр дүнд 2023 онд АХБ-ны санхүүжүүлэлтийн асуудал шийдвэрлэгдэх юм байна.
- 5) Төрийн өмчийн Концессын зүйлийн жагсаалтад “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн төсөл, арга хэмжээ”-г хэрэгжүүлэхээр ЭЗХЯ-нд санал хүргүүлсэн байна.

Зураг 3. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цомхон цогц төлөвлөлт – нийгэм-эдийн засаг-экологийн хувьд хож-хож-хож загвар



Сумын төвд хэрэгжсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслийн байршлууд

Улсын төсөв, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн санхүүжилт, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилтээр 2012-2020 онд нийт 30 суманд инженерийн шугам сүлжээг сайжруулах төсөл арга хэмжээ хэрэгжсэн байгааг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 4. Улсын төсвийн хөрөнгөөр (19 сум)

	Аймгийн нэр	Сумын нэр	Хэрэгжүүлсэн он	Тайлбар
“Сумын төвийн шинэчлэл” төсөл				
1.	Архангай	Тариат	2014-2020	3000 хүртэл хүнтэй сумд цэвэрлэх байгууламж 100м3, ус хангамж 75м3 (1-2 ш), зуух 1мвт-3 ш, халуун усны шугам 1.3 км
2.	Баян-Өлгий	Цэнгэл		
3.	Булган	Хутаг-Өндөр		
4.	Говь-Алтай	Дэлгэр		
5.	Дорнод	Баян-Уул		
6.	Дундговь	Өлзийт		
7.	Завхан	Тосонцэнгэл		3000-5000 хүнтэй суманд цэвэрлэх байгууламж 150м3/хон, ус хангамж 118 м3/хон, зуух 1мвт-4 ш, халуун усны шугам 1,6 км
8.	Өвөрхангай	Богд		
9.	Өмнөговь	Цогт-Овоо		
10.	Сүхбаатар	Эрдэнэцагаан		
11.	Сэлэнгэ	Цагааннуур		
12.	Төв	Лүн		5000-с их хүнтэй суманд цэв/ бай 250 м3/хон, ус хангамж, 220м3/хон 1-3 ш, зуух 1мвт-6 ш, халуун усны шугам 2,5 км
13.	Увс	Тэс		
14.	Ховд	Зэрэг		
15.	Хэнтий	Биндэр		
16.	Хөвсгөл	Цэцэрлэг		
“Шинэ сумын төв” төсөл				
17.	Баянхонгор	Баянлиг	2012-2014	Зуух 902 вт, 1.1 км шугам, 65м3 цэвэрлэх байгууламж
18.		Бууцагаан		
19.		Замын-Үүд		

Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам

Хүснэгт 5. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөр (12 сум)

Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн /мон13-302 төсөл/ НҮБХХ-ийн санхүүжилт				
20.	Дундговь	Гурвансайхан	2014-2016	1,2 мвт зуух 1.4 мвт зуух Усан сан 25м3-2 ш, цэвэрлэх байгууламж 50м3/хон, Бүрэгхангай, Тэшиг – 50м3/хон
21.		Дэлгэрцогт		
22.		Сэргэлэн		
23.	Төв	Зүүндэлгэр		
24.		Бүрэн		
25.	Булган	Бүрэгхангай		
26.	Өвөрхангай	Тэшиг		
27.		Баянгол		
28.		Сант		
Инженерийн шугам сүлжээг сайжруулах /g0204 төсөл/ АХБ-ны санхүүжилт				
29.	Өмнөговь	Ханбогд	2016-2018	100м3 усан сан 2, 200м3 цэвэрлэх байгууламж, Ханбогд 600м3/хон цэвэрлэх байгууламж
30.		Цогтцэций		
31.		Гурвантэс		
32.	Дорноговь	Замын-Үүд		

Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам

Хүснэгт 6. Хэрэгжиж буй болон төлөвлөсөн төсөл (16 сум)

	Аймгийн нэр	Сумын нэр	Хэрэгжүүлсэн он	Тайлбар
Сумын төвийн шинэчлэл төсөл				
1.	Архангай	Эрдэнэмандал	2020-2021	50м3 цэвэрлэх байгууламж, 50м3/60м3/100м 3 усан сан, одоо байгаа халаалтын зуухаас авах шинэчлэх, 700 м зам, айл өрх байхгүй, төсвийн байгууллага бусад
2.	Завхан	Отгон		
3.	Баянхонгор	Өлзийт		
4.	Говь-Алтай	Дэлгэр		
5.	Өвөрхангай	Хайрхандулаан		
6.	Хэнтий	Батноров		
Инженерийн шугам сүлжээ				
7.	Ховд	Булган	2019-2021	Иж бүрэн шугам сүлжээ, иж бүрэн цэвэр, бохир, шугам сүлжээ цэвэрлэх байгууламж
8.	Дорноговь	Алтанширээ		
9.		Хатанбулаг		
10.		Даланжаргалан		
11.	Өмнөговь	Манлай		
12.		Мандал-Овоо		
АХБ-ны төсөл				
13.	Увс	Өмнөговь	2020-2021	Аймаг, сумын бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл
14.	Баян-Өлгий	Дэлүүн	2021-2022	
15.	Дундговь	Эрдэнэдалай	2021-2022	Цэвэр ус, бохир, цэвэрлэх байгууламж
16.	Өвөрхангай	Хужирт	2021-2022	Гадна цэвэр ус хангамж

Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам

“Сумын төвийн шинэчлэл төсөл” 2014-2016 онд 16 суманд, 2020-2022 онд 5 суманд хэрэгжиж байна. Эдгээр 17 аймгийн 21 суманд инженерийн шугам сүлжээ шинэчлэх, шинээр барих, цэвэрлэх байгууламж, усан сан, гүний худаг, авто зам барих ажлууд хийгдсэн байна.

Хүснэгт 7. 2014-2020 онд төсөл хэрэгжсэн 16 сумын ажлын явц²¹⁷

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Гүйцэтгэгч компани	Гэрээний дүн /сая төгр/	Санхүүжилт		Гүйцэтгэлийн хувь %/
				Дүн /сая төгр/	Хувь %/	
1	Архангай аймаг Тариат сум	“Эх голомтын илч” ХХК	4800	4800	100	100
2	Баян-Өлгий аймаг Цэнгэл сум	“Агайын” ХХК	4900	4900	100	100
3	Булган аймаг Хутаг-Өндөр сум	“Эрхэт наран” ХХК, “Илчиг хутаг” ОНӨААТҮГ, “НKB international holding” ХХК	5001.7	5001.7	100	100
4	Говь-Алтай аймаг Дэлгэр сум	“Мандал голомт” ХХК	5000	3500	70	70
5	Дорнод аймаг Баян-уул сум	“Монгол дайван” ХХК	5000	5000	100	100
6	Дундговь аймаг Өлзийт сум	“Санкат” ХХК	5000	5000	100	100
7	Завхан аймаг Тосонцэнгэл сум	“Тэнгэрийн тэмдэг” ХХК	4996	4996	100	100
8	Өвөрхангай аймаг Богд сум	“Одхон холдинг” ХХК	4800	4800	100	100
9	Өмнөговь аймаг Цогт-Овоо сум	“Монгол дайван” ХХК	5000	5000	100	100
10	Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сум	“Монгол дайван” ХХК	5000	5000	100	100
11	Сэлэнгэ аймаг Цагааннуур сум	“Бумбод” ХХК	5000	5000	100	100
12	Төв аймаг Лүн сум	“Ану сервис” ХХК	4978	4978	100	100
13	Увс аймаг Тэс сум	“Сантех Увс” ХХК	4980	4980	100	100
14	Ховд аймаг Зэрэг сум	“Алтайн буйлаас” ХХК	5000	5000	100	100
15	Хөвсгөл аймаг Цэцэрлэг сум	“Сан” ХХК	5000	5000	100	100
16	Хэнтий аймаг Биндэр сум	“Монгол дайван” ХХК	5000	5000	100	100
	Нийт дүн		79 455.7	77 955.7	98.1%	98.1%

Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам

²¹⁷ <https://gazar.gov.mn/storage/reports/March2022/qTiIRNxm5Sjh7dml7Y6c.pdf>

Хүснэгт 8. 2020-2022 онд төсөл хэрэгжиж буй 5 сумын ажлын явц²¹⁸

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Гүйцэтгэгч компани	Гэрээний дүн /сая төг/	Санхүүжилт		Гүйцэтгэл-ийн хувь /%/
				Дүн /сая төг/	Хувь /%/	
1	Хэнтий аймаг Галшар сум	"Цагаан зуун" ХХК	4000.0	1600	40	40
2	Хэнтий аймаг Батноров сум	"Грийн ресурс констракшн" ХХК	4000.0	2529.2	65	70
3	Завхан аймаг Отгон сум	"Сэрвэн овоот" ХХК	4000.0	3343.9	83	83
4	Өвөрхангай аймаг Хайрхан дулаан сум	"Цагаан зуун" ХХК	3077.0	3077.0	100	100
5	Баянхонгор аймаг Өлзийт сум	"Бурхант хясаат" ХХК	3990.0	3990.0	100	100
	Нийт		19067.0	14540.1	89.8	91.4

Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам

"Сумын төвийн шинэчлэл" төсөл хэрэгжсэн 16 сумын сургаамж²¹⁹

Давуу тал:

- төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсоноор орон нутгийн иргэдийн амьдрах нөхцөл боломж сайжирсан;
- төсвийн байгууллагууд, айл өрхийг хангахаас гадна орон нутагт жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх үүднээс үйлдвэрлэл үйлчилгээний гудамж бий болгож, тэр дагуух бизнесийн байгууллагуудыг холбох хэрэгтэй.

Дутагдалтай тал:

- байршлаа оновчтой сонгоогүй, жижиг сумдыг сонгосон;
- инженер-геологийн онцлог нөхцөлийг сайн харгалзаагүй;
- дулаан, цэвэр, бохир ус хэрэглэх үнэ тариф шийдэгдээгүй;
- тухайн орон нутгийн хэрэглэгчид тохируулсан хүчин чадал, технологитой цэвэрлэх байгууламжийг сонгох;
- цэвэрлэх байгууламжийг ашиглалт хариуцах ИТА-ыг орон нутагт бэлтгээгүй боловсон хүчин дутмаг;
- орон нутгийн саналыг авч зургийн даалгаварт эхний ээлжинд шаардлагатай ажлуудыг тусгаагүй;
- түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй, зураг төсөлгүйгээр ажил эхлүүлсэн;
- сумын төвийн ерөнхий төлөвлөгөө болон одоо байгаа байршлаар төрийн байгууллагууд болон айл өрхүүд хоорондоо харьцангуй алс хол байршилтай.

Сүхбаатар аймагт сумын хөгжилтэй холбоотой хэрэгжсэн төсөл²²⁰

Эрдэнэцагаан сумын төвд хэрэгжсэн "Сумын төвийн шинэчлэл төсөл"-ийн хувьд:

- Уурын зуухны барилга, тоног төхөөрөмж, дулаан хангамжийн шугам сүлжээг 2020 онд байнгын ашиглалтад оруулж, өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулж байна (төсөвт байгууллагууд төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон).
- Усан сангийн барилга байгууламж, гүний худгууд, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж (төсөвт байгууллагууд төвлөрсөн ус дулаан,

²¹⁸ Мөн тэнд

²¹⁹ Барилгын хөгжлийн төв Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл 2020 он

²²⁰ Сүхбаатар аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс 2022 он

ариутгах татуургын хангамжид холбогдох боломжтой болсон)-ийг тавьж ашиглалтад оруулсан, мөн 540 метр авто замын далан, явган зам гэрэлтүүлэг, төв талбайн тохижилт, газар чөлөөлөлт зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

- Эрдэнэцагаан сумын төвд цэвэр ус дулаан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг хариуцаж “Чоногол” ОНӨҮГ ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолоор батлагдсан “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж”-ийн хүрээнд Онгон, Дарьганга, Мөнххаан, Баяндэлгэр сум хамрагдсан.

- Тогтоолын хүрээнд сумдын төвд бий болох инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлыг төлөвлөх, төвлөрсөн ус дулаан хангамжийн систем, ариутгах татуургын шугам, уурын зуух, цэвэрлэх байгууламж, усан сан, түгээх байр, гүний худаг, гэрэлтүүлэг, нийтийн халуун ус, хотын цэгийн менежмент гэх мэт ажлууд хийгдэх юм.
- Баяндэлгэр сумын ТЭЗҮ, ажлын зураг төслийг Барилга хот байгуулалтын сайдын багцын хөрөнгөөр 2022 онд хийж гүйцэтгэхээр инженерийн шугам сүлжээний зураг төслийн “DMT” ХХК, орон нутгийн төсвөөр Дарьганга сумын ТЭЗҮ, ажлын зургийг “Дөрвөн гүн” ХХК-ууд шалгараад тус тус ажлаа эхэлсэн байна.
- Онгон, Мөнххаан сумын ТЭЗҮ, ажлын зургийн даалгаврыг боловсруулж, батлуулаад байна.

2.2. Сумдын инженер, шугам сүлжээ, нэгдсэн халаалт

Монгол Улсын Засгийн газар “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төслийг 2021 оны 6 дугаар сараас эхлүүлэн хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд Монгол Улсын 19 аймгийн 59 сумдад инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг шинэчлэх, шинээр барих, сумын иргэдэд нийтийн аж ахуйн үйлчилгээг иж бүрнээр хүргэх, тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой юм.

2022 оны байдлаар Монгол Улсын 21 аймгийн 333 сумдаас нийт 219 сумыг нэгдсэн халаалтад шилжүүлсэн боловч нэгдсэн халаалтад шилжээгүй буюу объектын галлагаа²²¹тай 97 сум байна.


Улсын төсвөөс аймаг, сумдын инженерийн байгууламжийг сайжруулах зорилгоор дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

- Ховд аймгийн төвийн дулааны станцын суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх өргөтгөлийн төсөл;
- Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт байрлах Бэрх тосгонд 21 МВт-ын хүчин чадалтай дулааны станц шинээр барих;
- Хэнтий аймгийн Хэрлэн сум, Тахилгат тосгонд нэгдсэн халаалтын шугам сүлжээ;
- Дархан-Уул аймгийн Дархан баг, Шарын гол чиглэлийн дулааны шугамын өргөтгөл хийх;
- Ховд аймгийн Зэрэг сумын халаалтын зуухны өргөтгөл хийх;
- Хэнтий аймгийн Баян-Овоо сумын төвийн байгууллагуудын дулаан хангамжийн системийг байгуулахаар ажиллаж байна.

Монгол Улсын 21 аймгийн нэгдсэн халаалтад шилжүүлсэн байдлыг дараах графикаар харууллаа. Аймаг бүрийн сумын тоо харьцангуй ялгаатай учир 60 ба түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй аймгуудыг түүвэрлэн авав.

²²¹ Объектын галлагаа гэдэг нь тухайн байгууламжийг зуухаар галлахыг хэлнэ.

Зураг 5. Нэгдсэн халаалтын зуухтай сумын тоо




Дээрх зургаас үзвэл, нийт 12 аймгийн 150 суманд нэгдсэн халаалтын зуух²²²-ыг өөрөөр хэлбэл нэгдсэн халаалтад шилжүүлсэн байна. Үүнээс Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Увс зэрэг 6 аймаг нэгдсэн халаалтын зуухыг бүрэн шийдсэн байна.

Мөн Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Төв, Ховд, Хэнтий зэрэг 6 аймаг ихэнх сумдаа нэгдсэн халаалтын зуухаар хангаад байна.

Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Хөвсгөл зэрэг 5 аймагт сумдыг нэгдсэн халаалтад шилжүүлэх ажлын хэрэгжилтийг харвал тухайн аймгуудын газар зүйн байршил, аймгийн төвөөс сумдад хүрэх хүчин чадал тодорхой нөлөө үзүүлдэг байна.

Зураг 6. Нэгдсэн халаалтын зуухгүй сумын тоо



2.3.Сумдын ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрны тохижилт

Монгол Улсад 2021 оны байдлаар ерөнхий боловсролын нийт **848 сургууль**²²³ үйл ажиллагаа явуулж байгаагийн 34 хувь нь нийслэлд, 21 хувь нь хангайн бүсэд, 19 хувь нь төвийн бүсэд, 18 хувь нь баруун бүсэд, 8 хувь нь зүүн бүсэд тус тус байрлаж байна.

²²² Нэгдсэн халаалтын зуух гэдэг нь хэд хэдэн айл өрх эсхүл жижиг тосгон дунд нэг нам даралтын зуух ашиглахыг хэлнэ.

²²³ Үндэсний статистикийн хороо. <https://www.1212.mn>

Хүснэгт 9. ЕБС-ийн тоо (бүсээр, нийслэлээр, 2015-2021 он)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Улсын дүн	767	777	797	802	820	838	848
Баруун бүс	154	156	156	156	157	157	157
Зүүн бүс	68	68	68	68	69	69	70
Төвийн бүс	158	156	159	158	159	159	158
Хангайн бүс	172	172	173	175	177	177	178
Улаанбаатар	215	225	241	245	258	276	285

2021 оны байдлаар **712353 суралцагч**²²⁴ өдрөөр сурч байгаагийн 48 хувь нь нийслэлийн, 17 хувь нь хангайн бүсийн, 15 хувь нь төвийн бүсийн, 13 хувь нь баруун бүсийн, 7 хувь нь зүүн бүсийн ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-иудад тус тус суралцаж байна.

Хүснэгт 10. ЕБС-д өдрөөр суралцагчдын тоо (бүсээр, нийслэлээр, 2015-2021 он)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Улсын дүн	535055	551953	572752	593150	640449	680837	712353
Баруун бүс	84171	83922	85090	85355	88046	91158	92309
Зүүн бүс	38015	38964	40370	41323	44136	46038	48053
Төвийн бүс	85090	87284	89121	90884	98222	102462	105729
Хангайн бүс	106275	107980	109920	111056	117306	122892	125916
Улаанбаатар	221320	233545	247960	264240	292458	318287	340346

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

а) ЕБС-уудын ачаалал, нягтрал

2021 оны байдлаар Монгол Улсад ерөнхий боловсролын нийт **848 сургуульд** өдрөөр **712353 хүүхэд** суралцаж²²⁵ байгааг 2015 оны үзүүлэлттэй харьцуулахад, ЕБС-ийн тоо 10 хувиар өссөн байхад өдрөөр сурч байгаа суралцагчдын тоо **33 хувиар** өсөж улсын хэмжээнд ЕБС-уудын ачаалал, нягтрал нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд ЕБС-д сурч байгаа суралцагчдын дундаж тоог авч үзвэл, 2015 онд дунджаар 594 суралцагч оногдож байжээ. Энэ тоо жил бүр тогтмол 1.0-5.2 хувиар өссөөр 2021 онд 697 (нийт 17.3 хувь) болж нэмэгдсэн байна.

Зураг 7. Суралцагчдын дундаж тоо, өссөн хувь (улсын дундаж, 2015-2021 он)



²²⁴ Үндэсний статистикийн хороо. <https://www.1212.mn>

²²⁵ Үндэсний статистикийн хороо. https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L20_1&type=tables

Хүн амын хурдацтай өсөлт, шилжилт хөдөлгөөн зэрэг шалтгаанаас үүдэн сургуулиудын ачаалал, нягтрал харилцан адилгүй байна.

Тухайлбал, ЕБС-д суралцаж байгаа суралцагчдын дундаж тоог бүсээр нь авч үзвэл, 2021 онд баруун бүсэд хамгийн бага буюу дунджаар 588 суралцагч, зүүн бүсэд 686, төвийн бүсэд 669, хангайн бүсэд хамгийн их буюу дунджаар 707 суралцагч тус тус оногдож байна.

Хүснэгт 11. Суралцагчдын дундаж тоо, өссөн хувь (бүсээр, аймаар, 2015-2021 он)

Бүс / Аймаг	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Улсын дундаж	594	603	609	619	651	679	697
Баруун бүс	547	538	545	547	561	581	588
Баян-Өлгий	526	525	536	539	554	568	577
Говь-Алтай	418	403	406	407	403	425	422
Завхан	486	486	489	484	506	518	526
Увс	580	579	585	588	599	618	626
Ховд	761	725	739	744	776	808	822
Зүүн бүс	559	573	594	608	640	667	686
Дорнод	534	551	574	591	617	645	673
Сүхбаатар	652	670	703	723	768	804	837
Хэнтий	527	535	546	553	584	606	610
Төвийн бүс	539	560	561	575	618	644	669
Говьсүмбэр	660	668	680	689	759	804	818
Дархан-Уул	689	731	745	770	836	874	940
Дорноговь	541	585	578	591	635	697	722
Дундговь	414	424	425	420	444	445	452
Өмнөговь	549	570	562	577	610	642	678
Сэлэнгэ	542	553	541	560	598	605	614
Төв	452	465	479	492	533	559	580
Хангайн бүс	618	628	635	635	663	694	707
Архангай	506	524	523	521	551	568	595
Баянхонгор	537	542	553	541	564	585	560
Булган	426	442	470	455	485	506	513
Орхон	823	844	795	827	894	940	942
Өвөрхангай	707	707	717	717	696	727	770
Хөвсгөл	710	708	726	730	776	831	849

8 аймагт ЕБС-ийн суралцагчдын дундаж тоо бага буюу 600 хүртэл байна. Үүнд: Говь-Алтай (422), Дундговь (452), Булган (513), Завхан (526), Баянхонгор (560), Баян-Өлгий (577), Төв (580), Архангай (595) зэрэг аймгууд байна.

*Хүснэгт 12. ЕБС-ийн суралцагчдын дундаж тоо бага буюу 600 хүртэл
байгаа аймгуудын үзүүлэлт*

Аймаг / сум	Суралцагчдын дундаж тоо
Говь-Алтай аймаг	422
Халиун	90
Тайшир	117
Жаргалан	154
Бугат	167
Тонхил	224
Шарга	245
Дэлгэр	276
Хөхморьт	330
Төгрөг	338
Цогт	345
Дарви	369
Эрдэнэ	405
Чандмань	407
Бигэр	416
Цээл	444
Баян-Уул	554
Есөнбулаг	914
Дундговь аймаг	452
Цагаандэлгэр	93
Луус	135
Дэлгэрцогт	142
Өлзийт	169
Говь-Угтаал	183
Баянжаргалан	186
Хулд	193
Өндөршил	194
Сайхан-Овоо	263
Дэрэн	268
Гурвансайхан	308
Адаацаг	329
Дэлгэрхангай	400
Сайнцагаан	917
Эрдэнэдалай	1148
Булган аймаг	513
Орхон	162
Бугат	181
Хүрээмарал	225
Жинст	233
Заг	282
Баяннуур	318
Хутаг-Өндөр	331
Бүрэгхангай	383
Хангал	385
Могод	394
Эрдэнэцогт	425
Шинэжинст	441

Сэлэнгэ	446
Жаргалант	505
Өлзийт	514
Сайхан	514
Баян-Агт	534
Хишиг-Өндөр	596
Дашинчилэн	631
Гурванбулаг	651
Тэшиг	655
Рашаант	756
Завхан аймаг	526
Алдархаан	85
Яруу	99
Цагаанхайрхан	113
Завханмандал	167
Эрдэнэхайрхан	171
Ургамал	212
Цагаанчулуут	215
Дөрвөлжин	224
Цэцэн-Уул	255
Асгат	274
Баянхайрхан	278
Түдэвтэй	328
Шилүүстэй	329
Нөмрөг	340
Сантмаргац	341
Сонгино	344
Отгон	417
Идэр	479
Тэлмэн	496
Баянтэс	546
Тэс	638
Тосонцэнгэл	1243
Их-Уул	1466
Баянхонгор аймаг	560
Баян-Овоо	231
Галуут	245
Бууцагаан	288
Баянбулаг	305
Баацагаан	352
Гурванбулаг	355
Баянлиг	391
Баян-Өндөр	402
Баянговь	467
Бөмбөгөр	498
Богд	570
Баянцагаан	658

6 аймагт ЕБС-ийн суралцагчдын дундаж тоо их буюу 800-аас дээш байна. Үүнд: Орхон (942), Дархан-Уул (940), Хөвсгөл (849), Сүхбаатар (837), Ховд (822), Говьсүмбэр (818) зэрэг аймгууд байна.

Дээр дурдсан суралцагчдын дундаж тоо бага болон их байгаа зарим аймгуудыг дэлгэрүүлэн авч үзье.

Хүснэгт 13. ЕБС-ийн суралцагчдын дундаж тоо их буюу 800-аас дээш байгаа аймгуудын үзүүлэлт

Аймаг / сум	Суралцагчдын дундаж тоо	Цэцэрлэг	412
Орхон аймаг	942	Бүрэнтогтох	293
Баян-Өндөр	958	Сүхбаатар аймаг	837
Жаргалант	545	Эрдэнэцагаан	1421
Дархан-Уул аймаг	940	Баяндэлгэр	1080
Дархан	1041	Мөнххаан	998
Шарын гол	803	Онгон	742
Орхон	393	Түвшинширээ	689
Хонгор	337	Дарьганга	583
Хөвсгөл аймаг	849	Түмэнцогт	560
Тариалан	1376	Сүхбаатар	481
Цагаан-Уул	1249	Уулбаян	450
Жаргалант	1090	Асгат	295
Их-Уул	962	Наран	277
Тосонцэнгэл	882	Халзан	208
Улаан-Уул	870	Ховд аймаг	822
Баянзүрх	839	Жаргалант	1273
Ринчинлхүмбэ	828	Булган	1185
Рашаант	706	Үенч	755
Чандмань-Өндөр	638	Манхан	718
Төмөрбулаг	630	Алтай	696
Түнэл	621	Дарви	649
Эрдэнэбулган	613	Цэцэг	643
Алаг-Эрдэнэ	609	Зэрэг	641
Ханх	579	Мөст	588
Шинэ-Идэр	573	Дөргөн	570
Цагаан-Үүр	560	Буянт	477
Галт	555	Чандмань	461
Цагааннуур	541	Мянгад	427
Арбулаг	527	Мөнххайрхан	421
		Эрдэнэбүрэн	279
		Дуут	186

б) Сумдын ЕБС-ийн хичээлийн байрны насжилт, тохижилт

2022 оны байдлаар Монгол Улсын 333 сумын бүх өмчийн 2584 сургуулийн²²⁶ ашиглаж байгаа нийт 1448 барилга байгууламжийн 42 хувь нь 29 хүртэлх жилийн насжилттай, 48 хувь нь 30-49 жилийн насжилттай, 10 хувь нь 50-аас дээш жилийн насжилттай байна.

²²⁶ Үндэсний татистикийн хөрөө. https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L20_1&type=tables

Хүснэгт 14. Сумдын ЕБС-ийн барилга байгууламжийн насжилт (2022 он)

Насжилт	Ашиглалтад орсон он	Нийт	Хичээлийн байр		Дотуур байр	Бусад
			Тоо	Үүнээс их засварт орсон тоо		
0-9 жилийн	2022-2013	300	104	-	82	114
10-19 жилийн	2012-2003	246	85	15	55	106
20-29 жилийн	2002-1993	63	29	19	10	24
30-39 жилийн	1992-1983	309	133	79	94	82
40-49 жилийн	1982-1973	384	170	117	146	68
50-59 жилийн	1972-1963	104	60	41	16	28
60-аас дээш жилийн	1962 оноос өмнө	42	23	13	6	13

Сумдын ЕБС-ийн **604 хичээлийн байрны** 284 буюу 47.0 хувьд нь их засвар хийгдсэн,

- 50-аас дээш жилийн насжилттай 83 хичээлийн байрны 65.1 хувьд нь;
- 30-49 жилийн насжилттай 303 хичээлийн байрны 64.7 хувьд нь;
- 29 хүртэлх жилийн насжилттай 218 хичээлийн байрны 34.0 хувьд нь тус тус их засвар хийгджээ.

Сумдын ЕБС-ийн нийт 604 хичээлийн байрны 82.1 хувь нь стандартад нийцсэн, 23.0 хувь нь инженерийн шугам сүлжээтэй, 77.5 хувь нь халаалттай, 75.5 хувь нь эрчим хүчинд, 50.0 хувь нь интернэтэд тус тус холбогдсон байна. Харин 20.4 хувь нь инженерийн шугам сүлжээ, халаалт, эрчим хүч болон интернэтийн асуудлаа бүрэн шийдсэн байна.

Хүснэгт 15. Сумдын ЕБС-ийн хичээлийн байрны тохижилтын зарим үзүүлэлт (бүсээр, аймагаар, 2022 он)

Бүс / Аймаг	Стандартад нийцсэн	Дараах бүх асуудлаа бүрэн шийдсэн	Инженерийн шугам сүлжээтэй	Халаалттай	Эрчим хүчинд холбогдсон	Интернэтэд холбогдсон
НИЙТ	496	123	139	468	456	302
Баруун бүс	162	27	32	151	140	92
Баян-Өлгий	36	10	12	37	31	22
Говь-Алтай	29	2	2	29	24	18
Завхан	41	5	6	35	36	17
Увс	27	5	5	24	22	14
Ховд	29	5	7	26	27	21
Зүүн бүс	56	23	26	63	65	44
Дорнод	18	14	14	19	19	16
Сүхбаатар	17	4	5	16	18	11
Хэнтий	21	5	7	28	28	17
Төвийн бүс	125	46	51	114	115	75
Говьсүмбэр	-	-	-	1	2	-
Дархан-Уул	7	6	6	7	6	6
Дорноговь	22	7	7	19	19	11
Дундговь	17	2	4	12	17	9
Өмнөговь	20	10	10	19	18	13
Сэлэнгэ	30	15	16	29	32	25
Төв	29	6	8	27	21	11

Хангайн бүс	153	27	30	140	136	91
Архангай	33	5	5	32	32	16
Баянхонгор	24	4	6	22	21	18
Булган	26	4	5	20	24	18
Орхон	1	1	1	1	1	1
Өвөрхангай	34	9	9	28	26	22
Хөвсгөл	35	4	4	37	32	16

Хүснэгт 16. Инженерийн шугам сүлжээтэй, халаалттай, эрчим хүчинд болон интернэтэд холбогдсон ЕБС-ийн хичээлийн байрны жагсаалт (бүсээр, аймаар, 2022 он)

		Аймаг	Сум	Хичээлийн байр
1.	Баруун бүс	Баян-Өлгий	Алтанцөгц	Ахлах сургууль (Хичээлийн байр 1)
2.			Алтанцөгц	Ахлах сургууль (Хичээлийн байр 2)
3.			Баяннуур	Ахлах сургууль №1
4.			Булган	Ахлах сургууль №1
5.			Дэлүүн	Бага сургууль №2
6.			Ногооннуур	Бага сургууль №4
7.			Сагсай	Ахлах сургууль №1
8.			Толбо	Ахлах сургууль
9.			Цэнгэл	Ахлах сургууль №1
10.			Цэнгэл	Ахлах сургууль Руханият
11.		Говь-Алтай	Тонхил	Ахлах сургууль
12.			Цээл	Ахлах сургууль
13.		Завхан	Асгат	Ахлах сургууль
14.			Баянтэс	Ахлах сургууль (Хичээлийн байр 1)
15.			Баянтэс	Ахлах сургууль (Хичээлийн байр 2)
16.			Түдэвтэй	Ахлах сургууль (Хичээлийн байр 1)
17.			Түдэвтэй	Ахлах сургууль (Хичээлийн байр 2)
18.		Увс	Баруунтуруун	Ахлах сургууль
19.			Давст	Дунд сургууль
20.			Зүүнговь	Ахлах сургууль
21.			Наранбулаг	Ахлах сургууль
22.		Ховд	Цагаанхайрхан	Дунд сургууль
23.			Алтай	Ахлах сургууль
24.			Булган	ЕБЦС Минжит булган
25.			Мөст	Ахлах сургууль (Хичээлийн байр 1)
26.			Мөст	Ахлах сургууль (Хичээлийн байр 2)
27.			Эрдэнэбүрэн	Ахлах сургууль
28.	Зүүн бүс	Дорнод	Баян-Уул	Ахлах сургууль
29.			Баяндун	Ахлах сургууль
30.			Баянтүмэн	Дунд сургууль
31.			Булган	Дунд сургууль
32.			Гурванзагал	Дунд сургууль
33.			Дашбалбар	Ахлах сургууль
34.			Матад	Дунд сургууль (Хичээлийн байр 1)
35.			Матад	Дунд сургууль (Хичээлийн байр 2)
36.			Сэргэлэн	Дунд сургууль (Хичээлийн байр 1)
37.			Сэргэлэн	Дунд сургууль (Хичээлийн байр 2)
38.			Хөлөнбуйр	Дунд сургууль
39.			Цагаан-Овоо	Ахлах сургууль

40.	Төвийн бүс		Чойбалсан	Ахлах сургууль
41.			Чулуунхороот	Ахлах сургууль
42.			Түмэнцогт	Дунд сургууль
43.		Сүхбаатар	Дарьганга	Ахлах сургууль
44.			Мөнххаан	Ахлах сургууль
45.			Наран	Дунд сургууль
46.		Хэнтий	Батширээт	Дунд сургууль
47.			Биндэр	Ахлах сургууль
48.			Бор-Өндөр	Бага сургууль Их ирээдүй
49.			Өмнөдэлгэр	Дунд сургууль
50.			Цэнхэрмандал	Дунд сургууль
51.		Дархан-Уул	Орхон	Ахлах сургууль
52.			Хонгор	Ахлах сургууль №11 (Хичээлийн байр 1)
53.			Хонгор	Ахлах сургууль №11 (Хичээлийн байр 2)
54.			Хонгор	Ахлах сургууль №14
55.			Шарын Гол	Ахлах сургууль №2
56.			Шарын Гол	Ахлах сургууль №6
57.		Дорноговь	Айраг	Ахлах сургууль (Хичээлийн байр 1)
58.			Айраг	Ахлах сургууль (Хичээлийн байр 2)
59.			Даланжаргалан	Дунд сургууль
60.			Дэлгэрэх	Дунд сургууль
61.			Замын-Үүд	Ахлах сургууль №3
62.			Сайншанд	Ахлах сургууль
63.		Дундговь	Эрдэнэ	Дунд сургууль
64.			Луус	Дунд сургууль
65.			Өндөршил	Дунд сургууль
66.		Өмнөговь	Баян-Овоо	Дунд сургууль (Хичээлийн байр 1)
67.			Баян-Овоо	Дунд сургууль (Хичээлийн байр 2)
68.			Баяндалай	Ахлах сургууль
69.			Булган	Дунд сургууль
70.			Манлай	Дунд сургууль
71.			Ноён	Дунд сургууль
72.			Ханхонгор	Ахлах сургууль
73.			Хүрмэн	Дунд сургууль
74.			Цогт-Овоо	Дунд сургууль
75.			Цогтцэций	Ахлах сургууль №2
76.		Сэлэнгэ	Алтанбулаг	Ахлах сургууль (Хичээлийн байр 1)
77.			Алтанбулаг	Дунд сургууль (Хичээлийн байр 2)
78.			Баруунбүрэн	Ахлах сургууль
79.			Баянгол	Ахлах сургууль
80.			Ерөө	Ахлах сургууль
81.			Зүүнбүрэн	Ахлах сургууль
82.			Мандал	Ахлах сургууль №1
83.			Мандал	Ахлах сургууль №4
84.			Мандал	Ахлах сургууль №3
85.			Мандал	Ахлах сургууль №2
86.			Орхонтуул	Ахлах сургууль (Хичээлийн байр 1)
87.			Орхонтуул	Ахлах сургууль (Хичээлийн байр 2)
88.			Сайхан	Ахлах сургууль
89.			Түшиг	Ахлах сургууль
90.		Төв	Шаамар	Ахлах сургууль
91.			Баянцогт	Ахлах сургууль
92.			Баянчандмань	Ахлах сургууль

93.	Хангай бүс		Борнуур	Ахлах сургууль
94.			Бүрэн	Ахлах сургууль
95.			Заамар	Ахлах сургууль №1
96.			Эрдэнэсант	Ахлах сургууль
97.		Архангай	Их Тамир	Ахлах сургууль
98.			Их Тамир	Ахлах сургууль
99.			Хангай	Дунд сургууль
100.			Цэцэрлэг	Ахлах сургууль (Хичээлийн байр 2)
101.			Цэцэрлэг	Ахлах сургууль (Хичээлийн байр 2)
102.		Баянхонгор	Баянлиг	Ахлах сургууль
103.			Баянцагаан	Ахлах сургууль
104.			Бууцагаан	Ахлах сургууль
105.			Эрдэнэцогт	Ахлах сургууль
106.		Булган	Дашинчилэн	Ахлах сургууль (Хичээлийн байр 2)
107.			Дашинчилэн	Ахлах сургууль (Хичээлийн байр 2)
108.			Хангал	Ахлах сургууль
109.			Хишиг-Өндөр	ЕБЛС
110.		Орхон	Жаргалант	Ахлах сургууль
111.		Өвөрхангай	Баян-Өндөр	Ахлах сургууль
112.			Богд	Ахлах сургууль
113.			Бүрд	Ахлах сургууль
114.			Уянга	Ахлах сургууль №2
115.			Уянга	Ахлах сургууль №1
116.			Хархорин	ЕБЦС Орхон (Хичээлийн байр 2)
117.			Хархорин	ЕБЦС Орхон (Хичээлийн байр 2)
118.			Хархорин	Ахлах сургууль
119.			Хархорин	Ахлах сургууль №2
120.		Хөвсгөл	Бүрэнтогтох	Бага сургууль - ЦБСЦ
121.			Рашаант	Ахлах сургууль
122.			Тариалан	Ахлах сургууль
123.			Тосонцэнгэл	Ахлах сургууль

в) Сумдын ЕБС-ийн дотуур байрны насжилт, тохижилт

Сумдын ЕБС-ийн **409 дотуур байрны** 157 буюу 38.4 хувьд нь их засвар хийгдсэн:

- 50-аас дээш жилийн насжилттай 22 дотуур байрны 50.0 хувьд нь;
- 30-49 жилийн насжилттай 240 дотуур байрны 56.7 хувьд нь;
- 29 хүртэлх жилийн насжилттай 147 дотуур байрны 10.0 хувьд нь их засвар хийгджээ.

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 17. Сумдын ЕБС-ийн барилга байгууламжийн насжилт (2022 он)

Насжилт	Ашиглалтад орсон он	Дотуур байр	
		Тоо	Үүнээс их засварт орсон тоо
0-9 жилийн	2022-2013	82	-
10-19 жилийн	2012-2003	55	7
20-29 жилийн	2002-1993	10	3
30-39 жилийн	1992-1983	94	58
40-49 жилийн	1982-1973	146	78
50-59 жилийн	1972-1963	16	8
60-аас дээш жилийн	1962 оноос өмнө	6	3

Сумдын ЕБС-ийн нийт 409 дотуур байрны 88.5 хувь нь стандартад нийцсэн, 9.0 хувь нь инженерийн шугам сүлжээтэй, 76.8 хувь нь халаалттай, 65.3 хувь нь эрчим хүчинд, 14.2 хувь нь интернэтэд тус тус холбогдсон байна. Харин 7.6 хувь нь инженерийн шугам сүлжээ, халаалт, эрчим хүч болон интернэтийн асуудлаа бүрэн шийдсэн байна.

Хүснэгт 18. Сумдын ЕБС-ийн дотуур байрны тохижилтын зарим үзүүлэлт (бүсээр, аймагаар, 2022 он)

Бүс / Аймаг	Стандартад нийцсэн	Дараах бүх асуудлаа бүрэн шийдсэн	Инженерийн шугам сүлжээтэй	Халаалттай	Эрчим хүчинд холбогдсон	Интернэтэд холбогдсон
НИЙТ	362	31	37	314	267	58
Баруун бүс	107	8	10	99	81	15
Баян-Өлгий	24	2	2	26	20	2
Говь-Алтай	19	-	-	18	9	-
Завхан	22	1	3	20	17	6
Увс	25	4	4	23	21	6
Ховд	17	1	1	12	14	1
Зүүн бүс	45	1	1	42	37	5
Дорнод	16	1	1	17	17	3
Сүхбаатар	12	-	-	11	10	-
Хэнтий	17	-	-	14	10	2
Төвийн бүс	83	14	26	62	57	20
Говьсүмбэр	-	-	-	-	-	-
Дархан-Уул	4	1	1	4	2	1
Дорноговь	11	1	2	7	11	3
Дундговь	14	1	2	9	9	4
Өмнөговь	15	6	6	15	14	6
Сэлэнгэ	17	3	3	11	11	4
Төв	22	2	2	16	10	2
Хангайн бүс	127	8	10	111	92	18
Архангай	26	2	2	22	18	2
Баянхонгор	23	-	-	19	6	2
Булган	20	4	6	18	23	9
Орхон	1	-	-	1	1	-
Өвөрхангай	28	1	1	26	25	4
Хөвсгөл	29	1	1	25	19	1

*Хүснэгт 19. Инженерийн шугам сүлжээтэй, халаалттай, эрчим хүчинд болон интернэтэд холбогдсон ЕБС-ийн дотуур байрны жагсаалт
(бүсээр, аймгаар, 2022 он)*

		Аймаг	Сум	Дотуур байр
1.	Баруун бүс	Баян-Өлгий	Цэнгэл	Дунд сургууль №2
2.			Ногооннуур	Дунд сургууль
3.		Завхан	Нөмрөг	Ахлах сургууль
4.		Увс	Өмнөговь	Ахлах сургууль №1
5.			Баруунтуруун	Ахлах сургууль
6.			Наранбулаг	Ахлах сургууль
7.			Малчин	Дунд сургууль
8.		Ховд	Алтай	Ахлах сургууль
9.	Зүүн бүс	Дорнод	Булган	Дунд сургууль
10.	Баруун бүс	Дархан-Уул	Хонгор	Ахлах сургууль №11
11.		Дорноговь	Даланжаргалан	Дунд сургууль
12.		Дундговь	Луус	Дунд сургууль
13.		Өмнөговь	Гурвантэс	Ахлах сургууль
14.			Цогтцэций	Ахлах сургууль №2
15.			Баян-Овоо	Дунд сургууль
16.			Сэврэй	Дунд сургууль
17.			Мандал-Овоо	Дунд сургууль
18.			Хүрмэн	Дунд сургууль
19.		Сэлэнгэ	Алтанбулаг	Ахлах сургууль
20.			Цагааннуур	Ахлах сургууль
21.			Баянгол	Ахлах сургууль
22.		Төв	Баянцогт	Ахлах сургууль
23.			Баяндэлгэр	Дунд сургууль
24.	Хангайн бүс	Архангай	Хашаат	Ахлах сургууль (Дотуур байр 1)
25.			Хашаат	Ахлах сургууль (Дотуур байр 2)
26.		Булган	Хутаг-Өндөр	Ахлах сургууль (Дотуур байр 1)
27.			Хутаг-Өндөр	Ахлах сургууль (Дотуур байр 2)
28.			Хангал	Ахлах сургууль
29.			Орхон	Дунд сургууль
30.		Өвөрхангай	Уянга	Ахлах сургууль
31.		Хөвсгөл	Тосонцэнгэл	Ахлах сургууль

2.4.Улсын тэргүүний сумдад сумын хөгжилтэй холбоотой хэрэгжсэн төсөл

“Улсын тэргүүний сум шалгаруулах болзол батлах тухай (Тэргүүний сум шалгаруулах)”-Засгийн газрын 193 дугаар тогтоол 2009 онд батлагдаж, хоёр жил тутамд бүс тус бүрээс нэг сум шалгаруулж гэрчилгээ, 100 сая төгрөгөөр шагнахаар тогтсон.

Бүс нутаг дахь аймгийн удирдлагууд буюу Бүсийн зөвлөл нь тухайн бүсээс шилдэг сумаа шалгаруулж Засгийн газарт санал болгодог. Засгийн газраас тухайн дөрвөн бүсээс шалгарсан сумдын үйл ажиллагаатай танилцаж ажлыг нь нийгэм, эдийн засаг, хөгжлийн гэсэн гурван ангиллын 19 үзүүлэлтээр шалгаруулдаг байна.

2022 онд улсын тэргүүний сумаар дараах сумд шалгарсан. Үүнд:

- 1) Төв аймгийн Алтанбулаг сум;
- 2) Булган аймгийн Хутаг-Өндөр сум;
- 3) Завхан аймгийн Тэс сум;
- 4) Дорнод аймгийн Халхгол сум.

Төв аймгийн Алтанбулаг сум нь 2017-2021 онд төр, хувийн хэвшлийн түншлэлээр төвлөрсөн халаалтад холбогдож, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13.7 км хатуу хучилттай авто зам, спорт заал, аймаг, сумын хөрөнгө оруулалтаар 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга зэрэг томоохон бүтээн байгуулалтууд хийснээс гадна аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудтай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээгээр орон нутагт шаардлагатай олон бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

Мөн Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөлд хамрагдах 11 сумын нэг, төвлөрсөн халаалтын системд холбогдсон 25 сумын нэгээр шалгарсан.²²⁷

Сүүлийн 3 жилд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аж ахуйн нэгжийн 100 хувийн хөрөнгө оруулалтаар сумын төвийг төвлөрсөн халаалтын системд холбох, төрийн албан хаагчид, залуу гэр бүлд зориулсан 12 айлын хаус хорооллын барилгын ажил, Улаанбаатар хоттой сумын төвийг холбосон 13.7 км хатуу хучилттай авто зам барих, шинэ суурьшлийн бүс болон захын гэр хороололд 472 сая төгрөгийн эрчим хүчний шинэчлэлийн ажил, хүүхэд залуусын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн, спорт заал, 75 хүүхдийн цэцэрлэг, сумын төвийн 980м хатуу хучилттай зам, гэр хорооллыг жишиг хашаагаар жигдрүүлэх, автобусны буудал, гэрэлт цамхаг, угтах хаалга зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг улс, аймаг, сумын хөрөнгө оруулалтаар болон ААН-тэй байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээгээр хийж гүйцэтгэсэн байна.²²⁸

Булган аймгийн Хутаг-Өндөр сум нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн “Сумын төвийн шинэчлэл” төслийг 2014 онд амжилттай хэрэгжүүлснээр сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбогдох боломж бүрдсэн. Улмаар 2015 онд хоногт 10-25 тонн бохир усыг 95.0 хувь хүртэл цэвэрлэх хүчин чадал бүхий бохир ус ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийг ашиглатад оруулж одоогоор 43 харилцагчийн 39 объектыг төвлөрсөн дулаанаар ханган ажиллаж байна.²²⁹

Сүүлийн хоёр жилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 240 хүүхдийн хичээлийн байр, 120 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөл, үерийн далан, түр буудаллах цэг, орон сууцны барилгын дэд бүтэц, шугам сүлжээний ажлууд хийгдэж байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар сумын төвд шинээр 0.4 кв цахилгаан дамжуулах агаарын шугам татах, төвлөрсөн дулаан хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлэх чиглэлд 1.4 мкв хүчин чадалтай халаалтын зуух шинээр суурилуулах, улмаар айл өрхийг дулаанаар хангах, боловсролын салбарт хүүхдүүдийн хичээлийн хоцрогдлыг арилгах зорилгоор “Цахим анги” төсөл хэрэгжүүлж байна.

Суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэхээр Тээл багт Зуны цэцэрлэгийн байр, Уньт багийн цэцэрлэгийн байрны засвар, 120 хүүхдийн цэцэрлэгийн барилга, хоёр багийн цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, найман төрлийн хичээлийн кабинетын тохижилт, үйлчилгээний автобус, гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмж, цахим ангийн хэрэглэгдэхүүн, Хантай багийн бага сургуулийн хичээлийн байрны засвар зэрэг боловсролын салбарт 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, цаашид нэн шаардлагатай байгаа 150 хүүхдийн дотуур байр барих санхүүжилтийг 2022 оны улсын төсөвт тусгуулсан байна.²³⁰

Завхан аймгийн Тэс сум нь Ерөнхий боловсролын 11 жилийн сургуулийн 24 бүлэгт 666 хүүхэд өдрөөр суралцаж, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн

²²⁷ <https://montsame.mn/mn/read/298410>

²²⁸ “Улсын тэргүүний (загвар) сум шалгаруулах болзол”-ыг хангасан сумдын танилцуулга ЗГХЭГ 2022 он

²²⁹ Мөн тэнд

²³⁰ Өдрийн сонин цахим хувилбар <https://dnn.mn/n-лхагва-очир-2021-онд-байнгын-болон-түр-230-ажлын-байр-бий-болгосон-dnn-mn/>

дунд боловсрол нөхөн олгох сургалтанд 18 иргэн суралцаж байна. Бага ангийн хамран сургалт 100 хувь, суурь боловсролын хамран сургалт 100 хувь, мэргэжлийн багшийн хангалт 100 хувь байна. Мэргэжил дээшлүүлэх сургалтанд багш нараа 100 хувь хамруулан суралцуулж байна. Төрийн өмчийн “Одод” цэцэрлэгт 146, гэр цэцэрлэгт 80 хүүхэд хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын хамралт 94,0 хувьд хүрсэн.²³¹

Тэс сумын Хүүхдийн цэцэрлэг нь 1973 онд анх үүсгэн байгуулагдсан, одоо 6 бүлэгт 186 хүүхэдтэй 22 орон тоотойгоор сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. Мэргэжлийн багш нараар 100 хувь хангагдсанаас нийт багш нарын 70 хувь нь мэргэжлийн зэрэгтэй, 2012 оноос Арц суурийн хилийн боомт дээр салбар бүлэг нээн ажиллуулж, үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

Мөн хүүхдийн тоглоомын талбайг 8000.0 төгрөгийн өртөг бүхий тоглоомоор шинэчилж, орон нутгийн хөгжлийн сангийн 3000.0 төгрөгийн санхүүжилтээр гадна талын 80 м хайсыг, НҮБ-ын ХИС-ийн 1365.0 төгрөгийн санхүүжилтээр 1 бүлгийн ширээ сандал тавиурыг тус тус шинэчилсэн.

Тус сумын ерөнхий боловсролын сургууль нь 2016-2017 онуудад үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээгээрээ аймгийн 29 сургуулиас 3 дугаар байр, 2018 онд аймгийн 3 “Шилдэг сургууль”-ийн нэгээр шалгарсан байна.²³²

Дорнод аймгийн Халх гол сумын төв нь 2009 оноос БНХАУ-аас импортоор эрчим хүч авч ашигладаг. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах XXI-р талбай хүртэл 35 квт-ын өндөр хүчдэлийн ажил хийгдэж байгаа ба Халх гол сумын Ялалт баг хүртэл зураг төслийг гарган цаашид дотоодын эрчим хүчинд холбох төлөвлөгөөтэй. ЗДТГ, Ялалт музей, Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв, цагдаагийн тасаг, ЗХ-ний 329-р анги, ХЦ-ийн 0198-р анги, хүн эмнэлэг зэрэг байгууллагууд нийт 9 нам даралтын халаалтын тогоогоор дулааны хэрэгцээгээ хангаж байна.

Ерөнхий боловсролын 480 суудалтай сургуульд 390 хүүхэд суралцаж байна. Бага ангийн хамран сургалт 94.8 хувь, суурь боловсролын хамран сургалт 99.5 хувьд хүрсэн.²³³

“Шинэ сум” төслийн бүтээн байгуулалтын хүрээнд 640 хүүхдийн хүчин чадалтай шинэ сургууль, 180 хүүхдийн хүчин чадалтай дотуур байр, спорт заал бүхий сургуулийг 2019 онд байгуулсан ба 430 сурагч суралцаж байна.

Тус сургууль нь Дэлхийн банкнаас санхүүжилттэй Японы Хүүхдийг ивээх сан, БСШУЯ-тай хамтран хэрэгжүүлсэн “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төсөлд хамрагдан, төслийн үйл ажиллагаа, үр дүнгээрээ бүсийн хэмжээнд тэргүүн, үндэсний хэмжээнд II байранд шалгарсан. Сумын орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн хөрөнгө оруулалтаар 277.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шинэ сум хуучин сум”-ыг холбосон засмал замыг хүлээн аваад байна. Мөн Ялалт багийн сургууль аймаг болон сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар спорт заалтай болсон байна.²³⁴

²³¹ Эдийн засаг, хөгжлийн яам Орон нутгийн хөгжлийн индекс Завхан Тэс http://ldi.nda.gov.mn/?province_id=12®ion_id=215

²³² “Улсын тэргүүний (загвар) сум шалгаруулах болзол”-ыг хангасан сумдын танилцуулга ЗГХЭГ 2022 он

²³³ http://ldi.nda.gov.mn/?province_id=10®ion_id=179

²³⁴ “Улсын тэргүүний (загвар) сум шалгаруулах болзол”-ыг хангасан сумдын танилцуулга ЗГХЭГ 2022 он

ГУРАВ. ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

3.1. Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2019 оны төсвийн жилд хэрэгжүүлсэн төсөл

Монгол Улсын Засгийн газар хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагаас 1991-2017 онд нийт 4.38 тэрбум ам.долларын гадаад зээл, 2.62 тэрбум ам.долларын тусламжийг авч ашиглажээ. 2017 онд төсвийн дэмжлэгийн зориулалттай зээлийг оруулаагүй төслийн зээлийн ашиглалт 752.1 тэрбум буюу 309.4 сая ам.доллар байна. 2018 оны төсөвт гадаад төслийн зээлийн ашиглалт 835.9 тэрбум төгрөг, тусламжийн ашиглалт 110.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагаас 2019 онд 1,242.3 тэрбум төгрөгийн зээл, тусламж ашиглахаас 525.7 тэрбум төгрөг буюу 42.3 хувийг Азийн хөгжлийн банк, 254.9 тэрбум төгрөг буюу 20.5 хувийг БНХАУ-ын зээл, тусламж эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газар 2019 оны төсвийн жилд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр нийт 111 зээлийн төсөл, 41 тусламжийн төслийг хэрэгжүүлсэн байна.²³⁵

Үүнээс судалгаанд хамаарах асуудлын хүрээнд “сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах”, сумын дэд бүтэц, бүтээн байгуулалт хийх” чиглэлээр дараах төслүүд хэрэгжсэн байна. Үүнд:

- Азийн хөгжлийн банкны 50.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2018-2021 онд Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар ба хүртээмжийг дэмжих төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү төслөөр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, Дархан-Уул аймгийн Дархан суманд нийт 2 шинэ сургууль, Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Налайх, Сонгинохайрхан дүүрэг, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, Дорноговь аймгийн Сайншанд суманд нийт 8 шинэ цэцэрлэг барих, Улаанбаатар хотын Баянгол, Хан-Уул, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэг, Говь-Алтай аймгийн Алтай суманд нийт 8 сургуулийн өргөтгөл, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт нийт 16 цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг хийхээр төлөвлөжээ. Эдгээр ажлуудын үр дүнд сургуулийн багтаамж 4500 суудал, цэцэрлэг 5500 хүүхдийн ороор тус тус нэмэгдэх;
- Япон Улсын 2.4 тэрбум иенийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2018-2021 онд ерөнхий боловсролын сургууль байгуулах төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт шинэ сургууль барих, Баянзүрх дүүргийн 53 дугаар сургууль болон Налайх дүүргийн 109 дүгээр сургуулиудын өргөтгөлийн ажлыг эхлүүлэх;
- БНХАУ-ын 300.0 сая юанийн ерөнхий боловсролын сургууль барих буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2018-2020 онд Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэгт нийт 5,720 хүүхдийн багтаамжтай 7 сургууль, Архангай аймгийн Цэцэрлэг суманд 120 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгийг шинээр барих;
- Тайшир-Алтай усан хангамж төслийг Австри Улсын Засгийн газрын 14.0 сая еврогийн санхүүжилтээр Говь-Алтай аймгийн төв Алтай хотод 2018-2020 онд хэрэгжүүлсэн. Энэхүү төсөл нь Говь-Алтай аймгийн Алтай хотын 20 гаруй мянган хүн амын ундны усны хэрэгцээг хангах;
- Аймгийн төвүүдийн бохир ус, цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл нь БНПУ-ын Засгийн газрын 17.5 сая долларын хөнгөлөлттэй зээлээр 2018-2020 онд хийгдэхээр тусгагдсан. Тус төсөл нь Баян-Өлгий аймгийн Өлгий сум, Завхан аймгийн Улиастай сум, Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Говь-Сүмбэр аймгийн Чойр сум, Дорнод аймгийн Чойбалсан сум, Сэлэнгэ аймгийн Хөтөл сум, Дархан-Уул

²³⁵ Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй болон шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй танилцуулга - <https://mof.gov.mn/files/uploads/Tusuv2019-ver2.pdf>

аймгийн Шарын гол сумдын 1970-1990 онуудад баригдсан, элэгдэж хуучирсан бохир ус цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх, шинээр барих юм.

Судалгааны захиалгад нийцүүлэн Монгол Улсын аймаг, сумдад гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хэрэгжсэн, хэрэгжиж буй дараах төсөл хөтөлбөрүүдийг судалсан болно.

3.2.ТИКА-ийн Улаанбаатар дахь Хөтөлбөр зохицуулалтын газар²³⁶

ТИКА-ийн Улаанбаатар дахь Хөтөлбөр зохицуулалтын газар нь нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх салбарт цэвэр ус, усны эрүүл ахуй, эрүүл мэнд, боловсрол, чадавхыг бэхжүүлэх зорилгоор Турк Улсын туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх, Монгол Улсын төрийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, олон салбарт мэргэжлийн сургалтуудыг төсөл, хөтөлбөрөөр дамжуулан зохион байгуулдаг.

Тухайн байгууллагаас Монгол Улсад хэрэгжүүлсэн сумын хөгжил, сургууль, дотуур байрны тохижилттой холбоотой төслүүдийг авч үзлээ. Үүнд:

2019 онд хэрэгжсэн төсөл:

- Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Тува бага сургуулийн дотуур байрны тохижилтын ажил 41.805 ам.доллар;
- Налайх дүүрэг дэх сургуулийн дотуур байрны тохижилтын ажил 32.172 ам.доллар;
- Баян-Өлгий аймгийн 7 дугаар цэцэрлэгт 2 бүлэг бүхий өргөтгөлийн байр барих ажил 72.686 ам.доллар;
- Нийслэлийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн "Спорт заал" төсөл 88.298 ам.доллар;
- Өвөрхангай аймгийн Хужирт сумын сургуулийн техник-технологийн ангийн тохижилтын ажил 21.750 ам.доллар;
- Ховд аймгийн 32 цэцэрлэгийн гал тогоог тохижуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 64.400 ам.доллар;
- Архангай аймгийн Батцэнгэл сумын цэцэрлэгийн "2 бүлэг" болон "Урлаг-спортын заал"-ны өргөтгөлийн байр барих ажил 89.870 ам.доллар;
- Архангай аймгийн Батцэнгэл сумын цэцэрлэгийн "2 бүлэг" болон "Урлаг-спортын заал"-ны өргөтгөлийн байрны тохижилтын ажил 7.790 ам.доллар;
- Дорноговь аймгийн 5 сургуульд эрүүл мэндийн кабинет байгуулах болон эмчийн өрөөг тохижуулах ажил 43.636 ам.доллар;
- Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын цэцэрлэгт 2 ангитай өргөтгөл барих ажил 67.844 ам.доллар;
- Баян-Өлгий аймгийн Зайд бүрэн дунд сургуульд 2 ширхэг бага оврын автобус нийлүүлэх ажил 52.000 ам.доллар.

2020 онд хэрэгжсэн төсөл:

- Баян-Өлгий аймгийн 7 дугаар цэцэрлэгийн 2 бүлэг бүхий өргөтгөлийн байрны тохижилтын ажил 11.890 ам.доллар;
- Баян-Өлгий аймгийн Сагсай сумын 1 дүгээр сургуулийн технологийн ангийн засвар, тохижилтын ажил 19.050 ам.доллар;
- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 11 дүгээр цэцэрлэгт хоёр ангийн өргөтгөлийн байр шинээр барих ажил 68.882 ам.доллар;
- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 11 дүгээр цэцэрлэгийн хоёр ангитай өргөтгөлийн байранд тавилга, эд хогшил худалдан авах ажил 10.250 ам.доллар;

²³⁶ ТИКА., <https://www.tika.gov.tr/upload/2015/Prestij/T%C4%B0KA%20ile%2020%20Y%C4%B1.pdf>

- Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын сургуулийн хөгжмийн ангийн засварын ажил 5.422 ам.доллар;
- Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын сургуулийн хөгжмийн ангийн тохижилтын ажил 25.207 ам.доллар;
- Баян-Өлгий аймгийн Хилийн цэргийн 0165 дугаар ангийн дэргэдэх цэцэрлэгийн тохижилтын ажил 21.090 ам.доллар.

2021 онд хэрэгжсэн төсөл:

- 2021 онд Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 10 дугаар хороонд цэцэрлэг барих ажил 95.0 ам.доллар;
- Баян-Өлгий аймгийн Алтанцөгц суманд санхүүжилтээр цэцэрлэгийн завсар, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 32.0 ам.доллар;
- Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 10 дугаар хороон дахь цэцэрлэгт тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 14.9 ам.доллар;
- Говь-Алтай аймагт цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл 77.947 ам.доллар;
- Төв аймгийн Эрдэнэ сумын бага сургуулийн хоёр ангийг засварлан тохижуулах төсөл 36.996 ам.доллар;
- Говь-Алтай аймгийн 10 дугаар цэцэрлэгт 2 анги шинээр байгуулан, тохижуулах ажилд 15.0 ам.доллар;
- Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 6 дугаар сургуульд Химийн лаборатори байгуулах ажил 21.160 ам.доллар.

3.3.Монгол дахь Канад сан²³⁷

Канад сангийн Орон нутгийн санаачилга (КСОНС) нь Канадын Засгийн газраас хөгжиж буй орнуудын хөгжлийг дэмжсэн тусламжийн хөтөлбөр юм. Монгол Улсад 420 гаруй жижиг, дунд хэмжээний төслүүдийг санхүүжүүлсэн ба тэдгээрийн дийлэнх нь Улаанбаатар хотын захаар амьдардаг нийгмийн хамгийн их хэрэгцээтэй бүлгүүдэд чиглэсэн байна. Дараах асуудлаар төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

2012-2020 оны хооронд хэрэгжсэн төсөл:

- Баруун 5 аймаг, 11 сум, нийслэлийн 3 дүүрэг, 6 хороонд нийт 7,2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийж, 1348 хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр 18, 3411 хүүхдийн цэцэрлэгийн хуучин барилга 21-ийг тус тус засварласан байна.

2020-2021 оны хооронд хэрэгжсэн төсөл:

- Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд хүүхдийн хөгжлийн танхим байгуулах, сурагчдын ур чадварыг сайжруулах, сурах хөгжих боломжийг бүрдүүлэх зэрэг хөтөлбөрийг зохион байгуулсан;
- Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ЕБС-ийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг дэмжих зорилгоор сургуулийн тохижилтыг сайжруулсан;
- Сэлэнгэ аймгийн тусгай сургуулийн сонсголгүй эмэгтэй сурагчдад зориулсан эрүүл мэндийн жендэрийн тэгш байдал, хууль эрх зүйн сургалт зохион байгуулж, өөрсдийгөө хүчирхийллээс сэргийлэх мэдлэг боловсролыг олгох, энэ сэдвээр дохионы хэл дээрх сургалтын материал боловсруулж, орчныг сайжруулсан;
- Дорнод, Сүхбаатар аймаг болон Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн номын сангуудыг тохижуулан, цахим брайл NVDA программ хангамжаар тоноглогосноор харааны бэрхшээлтэй болон хараагүй иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэж ажилласан.

²³⁷ <https://canadafundmongolia.mn/2021/05/09/2019-2020/>

3.4.Бусад төсөл хөтөлбөрүүдийн товч тойм²³⁸

БНХАУ-ын Өвөр Монголын И-Пү Ин групп нь 2020 оны жилийн эцсийн байдлаар 4 аймаг (Архангай, Өвөрхангай, Булган, Төв аймаг), 18 сум, нийслэлийн 6 дүүрэгт боловсрол, эрүүл мэнд, ажлын байр нэмэгдүүлэх, оюутан, сурагч, мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд тэтгэлэг олгох, бага дунд орлоготой өрх, өнчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, өрх толгойлсон ээжүүд гэх мэт зорилтод бүлгүүдэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг нийт 38,4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлээд байна.

Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг нь 1998-2021 оны хооронд 21 аймаг, 126 сум, нийслэлийн 9 дүүрэгт “Тогтвортой хөгжлийн боловсрол” төсөл хэрэгжүүлж байна. “Тогтвортой хөгжлийн боловсрол” төсөл нь ерөнхий боловсролын 628 бага, дунд сургууль, төрийн ба бизнесийн салбар, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Дэлхийн банк, АНУ-ын иргэн Байра били нь 2019-2020 онд 1 аймаг, 6 суманд нийт 3,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр бага сургууль 6, хүүхэд хөгжлийн төв 2, эмэгтэйчүүдийн мэргэжлийн баримжаа олгох төв 1-ийг тус тус байгуулсан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

²³⁸ Монгол Улсын Сангийн яам - <https://mof.gov.mn/>

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол Улсын хууль:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, 2020

Улсын Их Хурлын тогтоол:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15406>
- “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр. УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=7037>
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. УИХ-ын 1996 оны 61 дүгээр тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6047>
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. УИХ-ын 2000 оны 33 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6051>
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6036>
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл. УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15584>
- Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги. УИХ-ын 2003 оны 24 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6288>
- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6299>
- Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр. УИХ-ын 2008 оны 35 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6187>
- Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр. УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8722>
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр. УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12120>
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр. УИХ-ын 2020 оны 45 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15586>
- Монгол Улсын мянганы хөгжлийн зорилт. УИХ-ын 2005 оны 25 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6252>
- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого. УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203282&showType=1>
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030. УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11725>
- Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 1996 оны 26 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6283>
- Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн шинэчилсэн хөтөлбөр. УИХ-ын 2007 оны 10 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6206>
- Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр. УИХ-ын 2005 оны 32 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6485>
- Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого. УИХ-ын 2015 оны 63 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail/11130>
- Шинэ сэргэлтийн бодлого. УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082532431>
- Эдийн засгийг сэргээх хөтөлбөр. УИХ-ын 2016 оны 71 дүгээр тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12291>

Засгийн газрын тогтоол:

- “Аргачлал шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2018 оны 20 дугаар тогтоол
- “Болзол батлах тухай” (Тэргүүний сум шалгаруулах) Засгийн газрын 2009 оны 193 дугаар тогтоол
- “Зарим аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2014 оны 29 дүгээр тогтоол
- “Сумдын дизелийн цахилгаан станц, халаалтын зуухнуудын тухай” Засгийн газрын 1995 оны 236 дугаар тогтоол
- “Сумдын хөгжлийн загвар болон түүнд хамаарах нэг маягийн загвар зургийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол
- “Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийгдэх ажлын жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2014 оны 309 дүгээр тогтоолын хавсралт
- “Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийх ажлын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2015 оны 265 дугаар тогтоол
- “Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийх ажлын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоол
- “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2014 оны 42 дугаар тогтоол
- “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоол

Бусад:

- “Улсын тэргүүний (загвар) сум шалгаруулах болзол”-ыг хангасан сумдын танилцуулга. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар. 2022 он.
- Барилга хот байгуулалтын яамны цахим хуудас (2022 он) - <https://mcud.gov.mn/home>
- Барилгын хөгжлийн төв (2020 он) - <http://barilga.gov.mn/#/home/home>
- Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй болон шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй танилцуулга. <https://mof.gov.mn/files/uploads/Tusuv2019-ver2.pdf>
- Сангийн яам - <https://mof.gov.mn>
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан - <https://www.1212.mn>
- Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж хэлэлцүүлгийн материал., <https://gazar.gov.mn/storage/reports/March2022/qTiIRNxm5Sjh7dml7Y6c.pdf>
- Сүхбаатар аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс. 2022 он.
- Эдийн засаг, хөгжлийн яам. Орон нутгийн хөгжлийн индекс. http://ldi.nda.gov.mn/?province_id=18®ion_id=354
- <https://www.tika.gov.tr/upload/2015/Prestij/T%C4%B0KA%20ile%2020%20Y%C4%B1l.pdf>
- <https://canadafundmongolia.mn/2021/05/09/2019-2020/>

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Сумын төвийн нэгдсэн халаалт, сургууль, дотуур байрны асуудлаар УИХ-аас баталсан хөгжлийн бодлогын баримт бичиг

1.1. УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого – УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол

Зорилго	Зорилт	Хөгжлийн бодлого	2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ Зорилго 2. Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ	<u>Боловсрол</u> Зорилт 2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.	1.Салбарын хүрээнд судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын тогтолцоо болон олон талт түншлэл бэхэжсэн байна.	2.1.1.Боловсролын чиглэлээр суурь болон хавсарга судалгааг тогтмол хийж хэвших ба бүх шатны боловсролын сургалтын байгууллагын байршил, хүчин чадал, нөөц, нормативын нэгдсэн зураглал, судалгаа, шинжилгээний мэдээллийн санг бий болгон, судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын тогтолцоог сайжруулна. 2.1.12.Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ. 2.1.19.Сургуулийн дотуур байр, ногоон хөгжлийн байгууламж, спортын болон урлагийн заал, цайны газар, мэдээлэл зүйн сургалтын танхимыг тохижуулж, сургалтын байгууллагын орчны стандартыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тохируулгат орчныг бүрдүүлж, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг хүүхэд, хэрэглэгчдэд ээлтэй болгох ажлыг үе шаттайгаар төлөвлөж хэрэгжүүлнэ. 2.1.24.Сургуулийн дотуур байрны менежментийг сайжруулан багш нарын ажлын ачааллын 10 хүртэлх хувьд дотуур байранд сурагчдын хөгжлийг дэмжих чиглэлээр хийсэн сургалт, хөгжлийн үйл ажиллагааны цагийг тооцдог байх зохицуулалт хийж, дотуур байрны хүүхэд хамгааллыг сайжруулна.

	<p><u>Хүнд ээлтэй амьдрах орчин</u></p> <p>Зорилт 2.5. Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.</p>	<p>1.Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг мөрдөж, эрүүл баталгаат амьдрах орчныг бий болгоно.</p>	<p>2.5.12.Төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглэгчийг хэсэгчилсэн бие даасан инженерийн хангамжид холбох, бичил дэд төвүүдийг байгуулах төслийг үе шаттай хэрэгжүүлнэ.</p>
<p>ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ</p> <p>Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.</p>	<p>Зорилт 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.</p>	<p>I үе шат (2021-2030):</p> <p>7.Эдийн засгийн хөгжлийг дэмжих эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлсэн байна.</p> <p>8.Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна.</p>	<p>4.2.39.Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор дулааны эх үүсвэр, дулааны шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл хийнэ</p>
		<p>II үе шат (2031-2040): 3.Эрчим хүчний хөндлөн гол тэнхлэгийн болон бүсийн босоо тэнхлэгийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж байгуулан, зарим дулааны цахилгаан станцыг өргөтгөж нэгдсэн системийг бүрдүүлнэ</p>	<p>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа батлагдах хугацаа болоогүй</p>
<p>ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ</p> <p>Зорилго 9. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.</p>	<p><u>Хүн төвтэй хот</u></p> <p>Зорилт 9.1.Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч,</p>	<p>I үе шат (2021-2030): 1.Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд</p>	<p>9.1.1.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, засварлах зэргээр суудлын тоог нэмэгдүүлж бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ.</p> <p>9.1.2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт орчны</p>

	оюунлаг иргэдтэй хот болно.	хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлж, бүтээн байгуулалт хийж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана.	стандарт мөрдүүлнэ.
--	-----------------------------	--	---------------------

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 – УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол (2020 оны 52 дугаар тогтоолоор **ХҮЧИНГҮЙ** болсон)

Зорилт		I үе шат (2016-2020)	II үе шат (2021-2025)	III үе шат (2026-2030)
Хоёр. Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд 2.2. НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ 2.2.3. Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн	2. Зорилт Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна.	Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд /PISA/ хамрагдах бэлтгэлийг хангаж, нийт ерөнхий боловсролын сургуулийг хоёроос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх, уламжлалт нүүдлийн ахуйд зохицсон боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлэх. Бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүүхэд бүр мэргэжлийн чиг баримжаатай болсон байх.	Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд хамрагдах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 30 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 25-аас илүүгүй байлгах.	Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд эзлэх байрыг 5-аар урагшлуулж, сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүх сургуулийг 100 хувь хангах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 50 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 20-оос илүүгүй байлгах.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого – УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол (2016 оны 19 дүгээр тогтоолоор **ХҮЧИНГҮЙ** болсон)

Чиглэл	Бодлого	Үйл ажиллагаа
ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ХИЙГЭЭД	4.4. Боловсролын хөгжлийн бодлого Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг	Нэгдүгээр үе шат (2007-2015 он): Стратегийн зорилт 1. Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ: ... 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах; хөвгүүдийн

НИЙГМИЙН ХӨГЖИЛ	болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ. 2021 он гэхэд олон улсын жишигт нийцсэн боловсролын тогтолцоонд шилжинэ.	боловсролын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх; ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тохилог орчинг бүрдүүлж, дотуур байранд суух хүүхдийн тоог 2.1 дахин нэмэгдүүлэх; ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын “Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлэх; 2010 он гэхэд хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшинг 99.0 хувьд хүргэх. Хоёрдугаар үе шат (2016-2021 он): Стратегийн зорилт 3. Сургууль төвтэй менежментийг хөгжүүлж, сургалтын байгууллагын бүтэц, хэв шинж, байршлын зураглалыг шинэчлэн зохионо. Боловсролын салбарын захиргааны болон мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох; хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургуулийн бүтэц, хэв шинж, хэмжээ, байршлыг оновчтой болгосон цэцэрлэг, сургуулийн зураглалыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх.
ТАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО	5.3. Дэд бүтцийн хөгжлийн бодлого Дэд бүтцийг хүн ам, хэрэглэгчдийн болон эдийн засгийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.	5.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого Нэгдүгээр үе шат (2007 – 2015 он): Стратегийн зорилт 2. Сум, суурин газрын болон малчдын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулна: Төвлөрсөн системд холбогдоогүй сум, суурин газруудыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбохын зэрэгцээ сэргээгдэх эрчим хүч болон бусад эх үүсвэрүүдийг ашиглан байнгын цахилгаанаар хангах; "Буман нарны гэрэл" хөтөлбөрийн хүрээнд бүх малчин айл өрхийг нар, салхины эрчим хүчний эх үүсвэртэй болгох; нүүрсний ордуудад ойрхон байрлалтай сум, суурин газарт нүүрсний хийн түлшээр ажилладаг бага оврын цахилгаан станц барьж ажиллуулах. 5.4. Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого Бүсчилсэн хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлж, хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг эрс багасгана. Нэгдүгээр үе шат (2007-2015 он): Стратегийн зорилт 1. Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгож, бүс нутгийн хөгжлийг түргэсгэнэ: Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн 2015 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх; бүсийн тулгуур төв болох Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуунмод, Өндөрхаан, Чойбалсан хотуудын болон аймаг, бичил бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд, суурин газруудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх; бүс нутгуудын удирдлагын оновчтой тогтолцоо, бүтцийг бүрдүүлж ажиллуулах. Стратегийн зорилт 2. Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн эдийн засгийн өсөлтийг хөгжлийн хүчин зүйл болгож, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлнэ. "Хөдөөгийн хөгжил" үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ:

Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал – УИХ-ын 1996 оны 26 дугаар тогтоол (2016 оны 19 дүгээр тогтоолоор ХҮЧИНГҮЙ болсон)

Чиглэл	Үйл ажиллагаа
II.Хөгжлийн эх сурвалж-хүний хөгжил	Монгол хүнийг элбэг хангалуун, амгалан тайван, эрүүл аж төрөх, бүх талаар боловсрон хөгжих нөхцөлөөр хангахад хөгжлийн шинэ зурвас үеийн гол зорилт оршино. Боловсрол нь иргэн бүрийг бүх талаар хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, баялгийг бүтээх эх сурвалж учраас түүнийг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ. Хот, хөдөөгийн соёл, ахуйн нөхцөлийн ялгааг багасгаж, хөдөөгийн хүн амд

	үзүүлэх үйлчилгээг жигд сайжруулна.
III.Шинжлэх ухаан, технологи - хөгжлийн хурдасгуур	6/Эрчим хүчний шинэ эх үүсвэр. Эрчим хүчний сэргээгдэх эх үүсвэрийг ашиглах техник, тоног төхөөрөмжийг зохион бүтээж үйлдвэрлэх, цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах технологийг эзэмших бэлтгэлийг хангах.
V.Эдийн засаг-хөгжлийн тулгуур	<p>1 дүгээр үе шат (1996-2000 он). 1 дүгээр үе шатанд эдийн засгийг тогтворжуулан сэргээж, цаашдын өсөлтийн үндсийг тавина. Энэ нь хөгжилд шаардлагатай хуримтлалыг нэмэгдүүлэх эхний үе шат юм.</p> <ul style="list-style-type: none"> 1/дэд бүтцийн хөгжлийг эрчимжүүлэх замаар эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгох, юуны өмнө эрчим хүч, харилцаа холбоо, иргэний агаарын тээвэр, төмөр зам, авто зам зэрэг дэд бүтцийн салбарт тэргүүлэх ач холбогдол өгч хөгжүүлэх; <p>2 дугаар үе шат (2001-2010-аад оны эхэн үе).</p> <ul style="list-style-type: none"> 4/хөдөөд эрчим хүч, зам, тээвэр, холбоо, мэдээлэлжүүлэлтийн салбарыг эрчимтэй хөгжүүлэх үндсэн дээр дэд бүтцийн нэгдсэн сүлжээ бий болгох; <p>3 дугаар үе шат (2010-2020-оод он). 3 дугаар үе шатанд эдийн засгийн голлох салбаруудад үндэсний болон дэлхийн өндөр зэргийн технологи нэвтрэн Монгол Улсад өрсөлдөх шинэ давуу талууд бий болж, экспортод баримжаалсан оновчтой бүтэц бүхий харьцангуй бие даасан эдийн засаг бүрдэнэ.</p>

1.2. ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл – УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол

Зорилго	Зорилт	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төсөл
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.	Зорилт 2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ:	2.1.8.газар зүйн мэдээллийн системд үндэслэн сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүчин чадал, ашиглалт, бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан хүртээмжийг нэмэгдүүлэн, тэгш байдлыг хангах тогтолцоог бэхжүүлнэ.	- 200 сургууль, 273 цэцэрлэг барих төсөл
ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын	Зорилт 4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:	4.2.12.улс, орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүй төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> - Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-аар өргөтгөх - Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл, 90МВт - Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл - Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл

чадавхаа дээшлүүлсэн улс болно.			<ul style="list-style-type: none"> - Оюутолгой-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Концессын эргэн төлөлт/ - Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц
НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ Зорилго 8. Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ.	Зорилт 8.1. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно:	8.1.8.бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд эхний ээлжинд алслагдсан зарим аймгуудад гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийг Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод аймгуудад хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> - 10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл - Увс аймгийн цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам барих төсөл - Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг Тэвшийн говийн цахилгаан станц төсөл - Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Концессын эргэн төлөлт/ - Чойр-Сайншандын 230 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл

Эдийн засгийг сэргээх хөтөлбөр – УИХ-ын 2016 оны 71 дүгээр тогтоол

Зорилт, арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга зам	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах этгээд
СТРАТЕГИ 2. ДУНД ХУГАЦААНД ЭДИЙН ЗАСАГТ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙЖ, ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ, ӨРИЙН ДАРАМТЫГ БАГАСГАХ				
2.2.Бодит салбарын өсөлтийг дэмжих томоохон төслүүдийг эхлүүлж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх:	Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол	Дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслийг эрчимжүүлж, эдийн засгийн бодит өсөлтийг 2018 онд 5.1 хувь, 2019 онд 7.1 хувьд хүргэх, шинэ ажлын байр олноор бий болгох замаар ажилгүйдлийг бууруулах.	2017-2018 оны эхний хагас жилд	Засгийн газар
2.2.3.Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах хүрээнд цахилгаан станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг шинээр барих, өргөтгөх ажлыг хэрэгжүүлэх				

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого (2015-2030) – УИХ-ын 2015 оны 63 дугаар тогтоол (2021 оны 89 дүгээр тогтоолоор **ХҮЧИНГҮЙ** болсон)

Зорилго	Зорилт	Хэрэгжүүлэх үе шат
Гурав.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах стратегийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх зорилт Байгаль орчны тогтвортой байдлыг	3.2.1.4.хот, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах, дулаан хангамжийн дэд бүтцийг хөгжүүлэх; 3.2.1.5.бүс нутгийн эрчим хүчний системийг дамжуулах чадал өндөр цахилгаан	Нэгдүгээр үе шат /2015-2023 он/: түлш, эрчим хүчний эх үүсвэрийн чадлын нөөцийг бүрдүүлж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх суурийг бий болгох, эрчим хүчний нормативын баримт бичгийн тогтолцоог төгөлдөржүүлж, олон

хангах, ногоон хөгжлийг дэмжих тэргүүлэх чиглэлийн хүрээнд:	дамжуулах шугамаар холбож, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах; 3.2.1.6.цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагааг дээшлүүлэх, хэрэглэгчид хүргэх эрчим хүчний чанарыг сайжруулах.	улсын стандартыг нутагшуулах, эрх зүйн орчныг сайжруулах үе. Хоёрдугаар үе шат /2024-2030 он/: Цахилгаан эрчим хүч экспортлох, сэргээгдэх эрчим хүчийг тогтвортой хөгжүүлэх үе
--	--	---

“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр – УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол

Зорилт	Хамрах хүрээ	Үйл ажиллагаа
4.1.1.Хот байгуулалт, төлөвлөлтийн чиглэлээр:	4.1.1.1.хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалтын оновчтой бодлого хэрэгжүүлэх замаар хот, суурины газар ашиглалтыг сайжруулж, эрчим хүч, авто зам, инженерийн дэд бүтцийг шинэ түвшинд хөгжүүлэх;	4.4.1.1.хотууд болон бүсийн тулгуур төвүүдийг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж мөрдүүлэх, 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг газар зохион байгуулалт, барилгажилт, газар хөдлөлийн мужлал, нийтийн тээврийн сүлжээний оновчтой шийдлийг харгалзан боловсруулах; 4.4.1.2.улсын, бүсийн, аймгийн, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг бусад холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, байгаль орчинд ээлтэй, үргүй зардлыг багасгасан, эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд чиглэсэн байдлаар боловсруулж мөрдүүлэх;
4.1.2.Дэд бүтцийн чиглэлээр:	4.1.2.1.Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймаг, орон нутагт эрчим хүчний төвлөрсөн болон бие даасан эх үүсвэрийг бий болгох; 4.1.2.2.аймгийн төвүүдийг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбох, сэргээгдэх эрчим хүчний шинэ техник, технологийг нэвтрүүлэх.	4.4.2.1.шинээр болон шинэчлэн баригдах суурин газар, орон сууцны цогцолбор хорооллыг байгаль орчинд ээлтэй, бие даасан дулаан, цэвэр, бохир усны инженерийн дэд бүтцийн хамтаар бүтээн байгуулах; 4.4.2.1.шинээр болон шинэчлэн баригдах суурин газар, орон сууцны цогцолбор хорооллыг байгаль орчинд ээлтэй, бие даасан дулаан, цэвэр, бохир усны инженерийн дэд бүтцийн хамтаар бүтээн байгуулах;
4.1.3.Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр:	4.1.3.1.хөтөлбөрийн 2.2-т заасан "100 мянган айлын орон сууц" төслийг Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймаг, сумын төвүүдэд хэрэгжүүлэх; 4.1.3.2.орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, худалдаа, үйлчилгээний төв, ногоон байгууламжийн хамт цогцоор нь барих;	4.4.3.1."100 мянган айлын орон сууц" төслийн хүрээнд Улаанбаатар хотын батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 35 байршилд 80 мянгаас доошгүй айлын орон сууцны цогцолбор хороолол, бүсийн тулгуур төв, аймгийн төвүүдэд 25 мянга хүртэлх айлын орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, бие даасан болон төвлөрсөн эх үүсвэртэй инженерийн дэд бүтэц, ногоон байгууламжийн хамтаар барих;

Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн хөтөлбөр – УИХ-ын 2007 оны 10 дугаар тогтоол (2015 оны 63 дугаар тогтоолоор ХҮЧИНГҮЙ болсон)

Зорилт	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат	Сумдын цахилгаан эрчим хүчний хангамж
1.2.2.улсын нийт нутаг дэвсгэр дээр цахилгаан станцуудыг зөв байршуулсны үндсэн дээр эрчим хүч экспортлох; 1.2.3.эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг тодорхойлох, үр ашигтай шинэ техник, технологи нэвтрүүлэх, сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах замаар эрчим хүчний эх үүсвэрийн бүтцийн шинэчлэлт хийж төв, орон нутгийн цахилгаан хангамжийг найдвартай болгох; 1.2.4.усан цахилгаан станц шинээр барьж өндөр хүчдэлийн шугамаар холбох замаар бүс нутгийн эрчим хүчний хангамжийг найдваржуулах, цаашид эдийн засгийн үр ашигтай горим, ажиллагааг бүрдүүлэхийн тулд баруун бүсийн эрчим хүчний системийг бэхжүүлж, төвийн эрчим хүчний системтэй холбох замаар Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем байгуулах;	2.1.1.нэгдүгээр үе шат буюу ойрын хугацаа /2007-2012 он/-нд бүс нутгийн эрчим хүчний хангамжийг найдваржуулах, эрчим хүчний шинэ эх үүсвэр болон цахилгаан дамжуулах шугамуудыг барьсны үндсэн дээр нийт сум, суурин газрыг төвлөрсөн эрчим хүчээр болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангаж байнгын цахилгаан эрчим хүчтэй болгох; 2.1.2.хоёрдугаар үе шат буюу дунд хугацаа /2012-2022 он/-нд бүс нутгийг эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор эрчим хүчний эх үүсвэр болон цахилгаан дамжуулах шугамуудыг шинээр барьж баруун, зүүн болон төвийн бүсийн эрчим хүчний системийг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаар холбож эрчим хүчний нэгдсэн систем байгуулах нөхцөлийг бүрдүүлэх; 2.1.3.гуравдугаар үе шат буюу хэтийн хугацаа /2022-2040 он/-нд төвийн бүсийн эрчим хүчний системийг баруун бүсийн эрчим хүчний системтэй өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаар холбож эрчим хүчний нэгдсэн системийг байгуулах.	5.1.Монгол Улсын хэмжээнд 331 сум, суурин байгаагийн 200 сумыг нь эрчим хүчний төвлөрсөн хангамжид холбоод байгаа бөгөөд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр 12 сумын төвийг цахилгаанаар хангаж, 2009 он гэхэд 90 гаруй сумыг төвлөрсөн эрчим хүчний системд холбоно. 5.2.Төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдох боломжгүй алслагдсан сумдыг бага оврын нүүрс хийн цахилгаан станц, нар, салхи, дизель-ус, дизель-салхи гэх мэт эрчим хүчний бусад эх үүсвэрээр ойрын хугацаанд хангана. 5.3.Төвлөрсөн системд холбох нь сумдыг найдвартай цахилгаан хангамжтай болгож, орон нутаг хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ. Сумдад жижиг дунд үйлдвэр болон үйлчилгээний салбар хөгжүүлэх замаар сумын цахилгааны хэрэглээг нэмэгдүүлж шугамын хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх бодлого баримтална.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр – УИХ-ын 2005 оны 32 дугаар тогтоол (2015 оны 63 дугаар тогтоолоор ХҮЧИНГҮЙ болсон)

Зорилт	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат		Хөтөлбөрийг дэмжих бодлого, арга хэмжээ
	I үе шат – 2005-2010 он (ойрын хугацаа)	II үе шат – 2011-2020 он (дунд хугацаа)	
1.Сэргээгдэх эрчим хүчийг түлхүү ашиглах замаар эрчим хүчний төвлөрсөн систем, бүс нутгийн эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа, бие даан үр ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. 4.Эрчим хүчний төвлөрсөн сүлжээнд холбоход үлэмж	3.Хөдөөгийн малчин айл, өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах "100 000 нарны гэрэл" үндэсний хөтөлбөрийн зорилтыг бүрэн хэрэгжүүлж, нийт малчин айл, өрхийг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангана. 4.Эрчим хүчний төвлөрсөн системээс алслагдсан салхины эрчим хүчний нөөц	2.Хөдөөгийн эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж эрчим хүчний төвлөрсөн системд холбогдоогүй нийт сум, суурин газрыг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр бүрэн хангаж дуусгана.	1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх, олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас олгож байгаа урт хугацааны хөнгөлөлттэй зээл, техникийн болон

зардал шаардагддаг алслагдсан бүх сум, суурин газрыг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр ашиглах замаар цахилгаанжуулна. 5.Сумын эмнэлэг, сургууль, нийтийн үйлчилгээний газруудыг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангах, худгаас ус татах болон бэлчээр, газар тариаланг усжуулахад нар, салхины эрчим хүчийг өргөн ашиглах дэд хөтөлбөрүүдийг гарган, үе шаттайгаар хэрэгжүүлж, орон нутагт цахим засаглал, мэдлэгт тулгуурласан үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. 6.Хөдөөгийн малчин айл, өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах "100 000 нарны гэрэл" үндэсний хөтөлбөрийн зорилтыг бүрэн хэрэгжүүлж, нийт малчин айл, өрхийг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангана.	сайтай нь тогтоогдсон 8-аас доошгүй сумын төвийг салхи-дизель болон салхи-нар-дизель хосолсон цахилгаан станц, 5-аас доошгүй сумын төвийг нар-дизель хосолсон цахилгаан станц барьж байгуулан эрчим хүчээр хангана. 5.Усны эрчим хүчийг ашиглахаар сонгосон 16 сумын төвийг бага чадлын усан цахилгаан станцыг байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулж, Баян-Өлгий аймгийн Булган, Хэнтий аймгийн Батширээт, Ховд аймгийн Мөст, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган, Увс аймгийн Баруунтуруун, Завхан аймгийн Тосонцэнгэл, Цэцэн-Уул, Завханмандал гэсэн 8 сумын төвд усан цахилгаан станц байгуулж, эрчим хүчээр хангана. 7.Алслагдсан сумын төвүүдийг хэрэглээний халуун усаар хангахад нарны илчээр ус халаах тоног төхөөрөмжийг өргөнөөр ашиглана	3.Хөдөөгийн эрчим хүчний хангамжийг сайжруулахад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах цар хүрээг өргөжүүлж фермерийн аж ахуй, хилийн цэрэг, батлан хамгаалахын анги салбар, аялал жуулчлалын бааз болон нийтийн үйлчилгээний газруудын эрчим хүчний хангамжийг сайжруулахад сэргээгдэх эрчим хүчийг өргөнөөр ашиглана. 6.Говийн бүсэд өндөр хүчин чадалтай нарны цахилгаан станц байгуулах олон улсын хамтарсан судалгааны хүрээнд туршилтын нарны цахилгаан станц байгуулах төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	буцалтгүй тусламж, хувийн хөрөнгө оруулалтыг түлхүү ашиглах бодлого баримтлан, хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авна. 2.Агаарын бохирдлыг багасгах, хөдөө орон нутгийн хөгжлийг сайжруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүчийг ашиглах явдалд тэргүүлэх ач холбогдол өгч хөгжүүлэх, энэ чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага сэргээгдэх эрчим хүчний зах зээлд өргөнөөр оролцох таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.
---	--	--	--

Монгол Улсын мянганы хөгжлийн зорилт – УИХ-ын 2005 оны 25 дугаар тогтоол (2008 оны 13 дугаар тогтоолоор **ХҮЧИНГҮЙ** болсон)

Зорилго	Зорилт
Зорилго нэг. Ядуурал, өлсгөлөнг бууруулах	Зорилт 4: Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжигсдийн эрх ашгийг хамгаалах, эрх зүйн хамгаалалтыг бий болгох, ажлын байраар хангах, орон сууц, эмнэлэг, боловсрол, соёлын болон нийгмийн бусад үйлчилгээнд хамруулах тогтолцоог бүрдүүлэх.

Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)
– Монгол Улсын Их Хурлаас 2003 оны 24 дүгээр тогтоол

Нийтлэг үндэслэл	Нийтлэг зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх чиглэл
4. Эдийн засгийн бүсүүдийн хүрээнд хөгжлийн ирээдүй сайтай байрласан хот, тосгоны сүлжээнд үндэслэн Баруун бүсэд Ховд, Улиастайг; Хангайн бүсэд Хархорин, Эрдэнэтийг, төвийн бүсэд Дархан, Зуунмодыг, зүүн бүсэд Чойбалсан, Өндөрхааныг бүсийн хөгжлийн тулгуур төв хотоор тогтоож, тэдгээрийн хөгжлийн ерөнхий		

<p>төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлж эхлэх, бусад аймгийн төв хотуудыг орон нутгийн хөгжлийн төв хотын жишгээр хөгжүүлж, хөдөө орон нутагт сум дундын төвүүдийг үүсгэн байгуулах замаар зах зээл өргөжин хөгжих хот байгуулалтын таатай орчин бүрэлдэх эхлэлийг тавина.</p>		
<p>5.Бүсүүдийн хөгжлийн тулгуур төвийн дэд бүтцийн таталцлын чадавхид түшиглэн аймаг, сум, хот, тосгон хоорондын үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилт, нийгэм, соёлын уялдааг хөгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан нийтлэг зорилтыг бүс бүрт тавьж хэрэгжүүлнэ.</p>	<p>1/ Эдийн засаг, дэд бүтцийн салбарт улс орны хөгжилд эн түрүүнд үр ашгаа өгөх салбар, бүс нутагт хөрөнгө санхүүгийн нөөцийг төвлөрүүлэх үндсэн дээр нийт бүсийн дотоод, гадаад зах зээлд өрсөлдөн, бие даан хөгжих эдийн засаг, дэд бүтцийн чадавхыг дээшлүүлнэ.</p>	
	<p>2/нийгмийн салбарт аймаг, сум, хот, тосгон хоорондын хамтын ажиллагааны хүч нөөцөд тулгуурлан хүн амын боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлыг тухайн бүс дотроо бие даан шийдвэрлэх боломжийг өргөжүүлнэ.</p>	<p>а/ Боловсрол, соёл, шинжлэх ухааны талаар: -бүсийн хөгжлийн тулгуур төв хотод ерөнхий боловсролын цогцолбор сургууль, орон нутгийн болон сум дундын төвүүдэд ахлах сургууль, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийг шатлан хөгжүүлэх;</p>
<p>11.Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймаг, аймгийн төвүүд байрласан сумд болон бусад аймаг, сумдын хоорондын зохистой харьцаа, хамаарлыг тогтоох, бие дааж хөгжих чадвар султай сум, багуудыг зэргэлдээх сум, багтай нь хоршин нэгтгэж, орон нутгийн чадавхийг дээшлүүлэх, Бүсийн зөвлөлүүд, нутгийн удирдлагын байгууллагуудын харилцан дэмжлэгийг хөгжүүлэх замаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын харилцан уялдаа, эдийн засгийн нэгдмэл байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн эрэмбэ дараалсан арга хэмжээ авна.</p>		
<p>Гарах үр дүн: 4/хот, хөдөөгийн хүн амын бөөгнөрөл, шилжих хөдөлгөөний зохистой хүрээгээр эрүүл мэнд, боловсрол, соёл, худалдаа, мэдээлэл, ахуйн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, аймаг, сумд хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлыг бүс дотроо шийдвэрлэх боломж нэмэгдэн, хүн амын амьжиргааны бүс нутгийн ялгаа аажмаар буурах хандлага бий болох; 5/бүсүүдийн хөгжлийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв, сум дундын төвүүдийн зах зээлд хөдөө нутгууд татагдан хөгжих зохистой хүрээ, чиглэл тодорч, үүнд түшиглэн тус улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн одоогийн бүтэц, зохион байгуулалтыг бүсчилсэн хөгжлийн зарчимд ойртуулан боловсронгуй болгох эдийн засаг, нийгэм, сэтгэл зүйн таатай орчин бүрдэж эхлэх.</p>		

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал – УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол

Үндэслэл, үзэл санаа, зохицуулалт	Үйл ажиллагаа
Хоёр. Бүсчилсэн хөгжлийн үндэслэл	<p>2.3.1. төрийн байгуулалтын хүрээнд: бүс нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх үндэсний нийтлэг эрх ашгийг, аймаг, нийслэл, хот, тосгон, сум, аж ахуйн нэгж, байгууллагын хууль ёсны ашиг сонирхолтой хосолж, засаг захиргаа-нутаг дэвсгэрийн байгууламжийг цаашид боловсронгуй болгох эдийн засаг, зохион байгуулалт, нийгэм-сэтгэл зүйн орчныг бүрдүүлэх.</p> <p>2.3.3. нийгэм, соёлын хүрээнд: хүн ам тухайн нутагтаа тогтвор, суурьшилтай ажиллаж, амьдрах, сурч боловсрох, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх, мэдээлэл авах эрхээ чөлөөтэй эдлэх, аймаг, орон нутгийнхаа амьдралд идэвхтэй, эрх тэгш хамтран оролцох, улмаар хөдөөгийн хүн амын хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, соёл, урлаг, мэдээлэл, ахуйн үйлчилгээний тогтолцоог бэхжүүлж, бүс нутгийн харьцангуй жигд хөгжлийг хангах нөхцөлийг бүрдүүлэх.</p>
Гурав. Гол үзэл санаа	<p>3.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилго, зорилтыг хангах үндсэн арга зам нь Монгол Улсад эдийн засгийн бүсчлэл тогтоож, түүгээр дамжуулан бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийн нэгдмэл болон харьцангуй бие даасан тогтолцоонд суурилсан бүс нутгийн эдийн засаг, нийгмийн цогцолборуудыг бүрдүүлэх явдал мөн.</p> <p>3.4. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэхийн тулд улсын хэмжээнд, эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харилцан уялдсан нэгдмэл тогтолцоо, эдийн засгийн бүсүүдийн хэмжээнд, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даасан тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай бөгөөд энэ үйл явцыг төрөөс нэгдсэн болон нутаг дэвсгэрийн ялгавартай бодлогоор дэмжин зохицуулна.</p> <p>3.5. Бүсүүдийн хүрээнд эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даасан тогтолцоог бүрдүүлэхдээ, алслагдсан, говийн түүнчлэн сул хөгжилтэй бүс нутгийн хөгжлийг дэмжихийн хамт бүс нутгийн аж ахуйн бие даасан байдал, үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот сууринг тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлж, түүнд ойр байгаа бусад нутгийг татан оролцуулах чиглэл баримтална.</p>
Дөрөв. Бүсчилсэн хөгжлийг дэмжих төрийн зохицуулалт	<p>4.7. Бүсчилсэн хөгжлийн зорилго, зорилтыг дараахь бодлогоор дэмжин хэрэгжүүлнэ:</p> <p>4.7.2.д. сумын хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;</p>

1.3. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРҮҮД (1996-2020)

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 1996-2000 – УИХ-ын 1996 оны 61 дүгээр тогтоол

Хүрээ	Үйл ажиллагаа, чиглэл
1.Төрийн байгуулалтын хүрээнд хийх өөрчлөлт	<ul style="list-style-type: none"> - Төрийн байгуулалтын хүрээнд Засгийн газраас дэвшүүлж буй гол зорилт нь төрийн захиргааны төв байгууллагын бүтцийг шинэчлэх, нутгийн захиргааны байгууллагыг бэхжүүлж бүс нутгийг хөгжүүлэх, нийгмийн удирдлагын үр нөлөөг дээшлүүлэх, мэдээллийн үнэн бодит байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах, цэргийн болон цэрэгжсэн байгууллагуудад тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд оршино. - Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг бэхжүүлж, тэдгээрийн орлогыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, нэмэгдэл нөөц бололцоог ашиглах замаар орон нутгийн төсвийн бие даасан

	<p>байдлыг нэмэгдүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Бүс нутаг, аймаг, сумдын эдийн засгийн чадавхыг тодорхойлж, үүний үндсэн дээр үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой бүтэц бүрдүүлэх, нутаг усандаа ая тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг хангахын тулд бүс нутгийн зохион байгуулалтаар хөгжих бодлого баримтална. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд Засгийн газраас авах арга хэмжээ, бүсийн эрх зүйн байдал, бүсийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг боловсруулж мөрдүүлнэ. - Аймаг, орон нутгийн хөгжлийн ялгааг жигдрүүлэх зорилгоор зарим бүс нутаг, аймагт дэд бүтцийн төсөл хэрэгжүүлж эхэлнэ. - Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд түлхэц үзүүлэх зорилгоор эргэж төлөх нөхцөлөөр улсын төсвөөс зээл олгож, "Сумын хөгжлийн сан"-г туршилтын журмаар байгуулан, улмаар хөгжлийг дэмжих сан болгоно. Сумын хөгжлийн сангийн хөрөнгийг тэргүүн ээлжинд тухайн сумын хоршоо, бөөний худалдааны болон ахуйн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг сэргээхэд зарцуулна. - Бүс нутгийн жигд хөгжлийг хангах зорилгоор бүс нутаг, аймаг, орон нутгийн хөгжлийн чиглэлийг тогтоож, тэргүүлэх ач холбогдол бүхий төслийг санхүүжүүлэх, татвар, төсөв, гааль, хөрөнгө оруулалт, зээлийн талаар хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлнэ.
2.Эдийн засгийн хүрээнд хийх шинэчлэлт	<p>Төсөв</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн бие даасан байдлыг хангах үүднээс тэдгээрийн төсөв нь орлогоороо зарлагаа нөхөх механизм бүрдүүлэхэд онцгой анхаарч, зарим төрлийн татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох эрхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгоно. <p>Хувьчлал</p> <ul style="list-style-type: none"> - Төвийн болон бүс нутгийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд багтах нам хүчдэлийн шугам сүлжээ, цахилгаан, дулааны зарим станцыг хувьчлах чиглэлийг боловсруулж хэрэгжүүлнэ. <p>Хөрөнгө оруулалт</p> <ul style="list-style-type: none"> - Нутаг дэвсгэрийг бүсчлэн хөгжүүлэх, дэд бүтцийн хөгжлийг эрчимжүүлэх, эн тэргүүнд эрчим хүч, харилцаа холбоо, зам, тээврийг хөгжүүлэх, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжихэд тэргүүлэх ач холбогдол өгч, төвлөрсөн төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг эдгээр салбарт түлхүү хуваарилна. <p>ДЭД БҮТЭЦ Түлш, эрчим хүч</p> <ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний найдвартай эх үүсвэрт хөрөнгө оруулж хөгжлийн бүс, аймаг, сумын төв, суурин газрыг эрчим хүчний шинэ эх үүсвэрээр хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ. - Хөдөөд эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд Засгийн газар эрчим хүчний үнэ, тарифыг бүс нутгийн онцлог, эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих бодлоготой уялдуулан зохицуулна. - Хэрэглэгчийн дулаанаар найдвартай хангах, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын шинэ тогтолцоог бий болгоно. - Малчид, зарим сум, суурин газрыг сэргээгдэх эрчим хүчээр хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. - Төв, баруун болон зүүн бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд 40 шахам сум, сууринг холбоно. <p>Барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж ахуй</p> <ul style="list-style-type: none"> - Нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалт, хүн амын нутагшил, суурьшлын чиглэл, нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах улсын хөгжлийн дэд бүтцийн гол хэвтээ тэнхлэг, бүсийн хөгжлийн тулгуур босоо тэнхлэгүүдийг тогтооно. - Орон сууцны хэрэгцээ, шаардлагыг улс, бүс нутаг, нийслэл, аймгийн хэмжээнд тодорхойлж, орон нутгийн барилгын материал, нөөц бололцоонд түшиглэн орон сууцны төрөл, хэв, загварыг боловсруулж хэрэгжүүлнэ.
3.Нийгмийн хүрээнд хийх өөрчлөлт	<p>Ажилгүйдэл</p> <ul style="list-style-type: none"> - Ерөнхий боловсролын сургуулийн 8, 10 дугаар анги төгсөгчдийн 10-аас доошгүй хувийг мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд сургаж, ажил

	<p>эрхлэлтийг дэмжих сан болон бусад сангаас санхүүжүүлэх арга хэмжээ авна.</p> <p>Боловсрол</p> <ul style="list-style-type: none"> - Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого нь боловсролын салбарын хөгжих нөхцөлийг бүрдүүлсэн, хүн бүрт өөрсдийн авъяас, сонирхол, чадварын хэрээр боловсрол эзэмших боломжийг хангасан тогтолцоог төлөвшүүлэхэд оршино. - Бүх шатны сургуулийн бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой болгоно. Бүс нутгийн хүрээнд суурь боловсрол олгох, төрөлжсөн сургалт явуулах сургуулийн тогтолцооны шинэ хэв шинжийг бүрдүүлнэ. - Бүх түвшний боловсролын стандартыг боловсруулж мөрдүүлнэ. - Боловсролын салбарт техник, технологийн шинэчлэлт хийх, бүх шатны сургууль, цэцэрлэгийн хичээлийн болон дотуур байрыг засварлахад зориулсан хөрөнгийг нэмэгдүүлнэ.
--	---

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2000-2004 - УИХ-ын 2000 оны 33 дугаар тогтоол

Бодлого	Зорилт	Үйл ажиллагаа
Нэг. Нийгмийн бодлого. Нийгмийн салбарт баримтлах үндсэн зорилт нь хүний хөгжлийг хангах орчинг бүрдүүлэх, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдэнэ.	1.Хүн амын боловсролын хэрэгцээг жигд хангах орчин бүрдүүлж бүх нийтээр суурь боловсрол эзэмших, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог хувь хүний сонирхол, нийгмийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлж, орчин үеийн мэдлэг олгох тогтолцоог бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> - Боловсролын салбарт хийгдэх хөрөнгө оруулалт, их засварын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. - Ачаалал ихтэй сургуулийн барилгыг өргөтгөх, шинээр барихын зэрэгцээ хөдөөгийн сургуулиудын барилгыг засварлаж, сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангана. - Боловсролын салбарт хувийн хэвшлээс хийх хөрөнгө оруулалтыг дэмжин урамшуулна. - Дунд сургуульд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны зардлыг төр хариуцдаг болно.
Гурав. Бүс нутаг, хөдөөгийн бодлого	Эдийн засгийг нутаг дэвсгэрээр бүсчлэн хөгжүүлж, бүс нутагт дэд бүтэц бүрдүүлэх, хөдөөд чиглэсэн татвар, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогыг хэрэгжүүлэх замаар иргэд тухайн нутагтаа суурьшин амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> - Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, эрхзүйн зохицуулалтыг бий болгож бүс нутаг, аймаг, орон нутгийн хөгжлийн стратегийг тодорхойлж, тэдгээрийн харьцангуй жигд хөгжлийг хангах дэс дараатай арга хэмжээ авна. - Цахилгааны төвлөрсөн эх үүсвэрт 2 аймгийн төв, 40 гаруй сумын төвийг холбож, 80 гаруй сумын дизель станцыг шинэчилнэ. - Сумын төвийн томоохон хэрэглэгчдийг сэргээгдэх эрчим хүчээр ээлж дараатай хангана. - Хөдөөгийн малчин зуун мянган өрхийн нэн тэргүүний хэрэглээг нар, салхины эрчим хүчний эх үүсвэрээр хангах арга хэмжээ авна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2004-2008 - УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоол

Бодлого	Зорилт	Үйл ажиллагаа
